

Заан залуудай роман

ОРШИЛ

Үүрийн туяа гэдэг түүхэн роман анх үүсгэн бичихдээ, улсын сайн малчин Ширчин гэгчийн туулж өнгөрүүлсэн явдлыг нь сонинд бичихийн улмаас, сонины товч мэдээнээ цухас гаргасан зүйлд тэр зоригт өвгөний насан туршийн сонин явдлыг яахин багтааж болох ажээ. Чингээд, сэтгэлэг адил Зөвлөлтийн хөхдөөс зоригжуулсанд урам орж, үүрийн туяаг бичин гүйцэх үе, надад нэгэн санаа төрсөн нь :

Манж дайчин улс, олноо өргөгдсөний Монгол улс, Монгол ард улс ын энэ гурван төрийн нүүр үзсэн өвгөдийн хорьдугаар зууны эхэн хагасыг бараг шувтаргал үзэж өнгөрүүлсэн явдлыг нь дүрслэн үзүүлсэн. Үүрийн туяанаас цаашлаж, түүх юүгээн бүтээгч ард түмнийхээ үе үеийн байдлаас нэг нэг роман бичиж, эртнээс Үүрийн туяа хүртэл үргэлжилсэн нэгэн цуврал роман бичиж үзвэл зүгээр юмсан гэж бодогдлоо. Зөвлөлтийн алдарт эрдэмтэн, академич, профессор багш нар минь , монгол хэл бичгийн шинжлэлд насаа зориулан оролдох хүн , дан ганц монгол хэл бичгээр хязгаарлавал, учир дутагдалтай болно. Зорин эрхэлсэн хэл бичгийн шинжлэлд гүйцэд гүнзгий оролдох гэвэл , хэл бичигтэй салшгүй холбоотой бөгөөд харилцан шүтэн барилдсан шинжлэлийн зүйлийг уйгагүй оролдож, аман зохиолын зүй, угсаатны зүй, эртний судлал, түүх зэрэг зүйлийг судлалцах хэрэгтэй. Чингэвээс, сая учир бүрдээд, хэл бичгийн судлалд нэмэр оруулж болохын дээр , бас уг судалсан зүйлээс өөр төрлийн юм бичихэд хэрэглэх зүйл бүрдэнэ гэж чин сэтгэлээс сурган соёсон нь , надад одоо л их тус болж, миний зохиолч сэтэртэй болсон нь ч мөн түүнээс үндэслэсэн билээ. Чингээд, өдгөө үсэн буурал болж, насны наран хэлбийж буй үе, эрдэмтэн багш нарыг шүтэн олсон хэлний шинжлэл, аман зохиол, угсаатны зүйн талаар гучин илүү жил оролдон цуглуулсан зүйлээ бие баахан танагтай байгаа дээр боловсруулан, амжиж авдаг бол, дуусган бичихийг мэрийхийн хажуугаар , тэдгээр цуглуулсан зүйлээс уран зохиолын зүйлд хэрэг болох юм өдий төдий гарахыг тэвчин үл түвдэх тул, цуврал роман бичих гэсэн санаагаа амжихын хирээр оролдож үзье хэмээн, хөндий цээжинд ургасан үзэгдлээ цааснаа буулгахдаа мөхөс биеийн алжаахыг хатуужин бичиж, хэдэн эхт юм үүсгэснээс, эхнээс нь дэс дараагаар нухаж үзье хэмээн , балар эртний чулуун зэвсгийн үеэс сэдэвлэсэн энэ Заан Залуудай гэдгийг урьдаар дуусгахаар зориллоо. Чулуун зэвсгийн үеийн манай дээдэс, өндөр өвгөс, байгалийн түмэн эрхшээлийн дунд чадал мөхөс, мэдлэггүйхэн, зэвсэг хэрэглэл нэн ядуу асан авч, харш зовлонгоос ангижирч, жаргалтай сайхан амьдрахын хүсэл мөрөөдөл байсан учир, орчин тойрны байгалийн аугаа хүчин үзэгдлийн үнэн учрыг мэдэхгүй боловч, хөдөлмөрийн хүчээр мичнээс хүн болж, бидний олоогийн үед зүглэсэн анхны мөр гаргасан тэр үеийг лүрслэн үзүүлэхэд надад сонин санагдсан билээ. Эртний чулуун зэвсгийн үеийн хүний эдийн боловсролыг эртний судлалч нар нээн үзүүлж, аман зохиол, угсаатны зүйч хүмүүс, олон угсаатны утга соёлын зүйлийг харшуулан гаргаж, дэлхийн олон улсын дунд бусдын адил шатны хөгжилд хүрч завдаагүй аймаг угсаатны соёл боловсролын зүйлийг судалсан нь , чулуун зэвсгийн үеийн хүний эдийн боловсрол, утга соёлын хир хэмжээ тодорхой болсон үүнд , тэдгээр зүйлийг баримжаалан , монгол аман

зохиол, угсаатны зvйн сэдвээс бас хэрэглэж найруулан бичсэн vнээ, зохиолчын хувьд надад санаа байвч, чадал хvрэлцээгvй зvйл байж болох юм. Тийм зvйлд уучлахыг өчмvв.

Балар эртний тvмэн харанхуйн вeд бас буман мэдэхгvйн дунд оршиж байсан балрын хvмvвс, тэр мөртөө мөн ч хатан зоригтой тэмтэрч тэмтэрсээр одоогийн хөгжлийн зvг чадан ядан, унан дусан зvтгэж явсны нь уран саналгын vвднээс дvрслэн вэvvлж, тэр балар эртний хvмvвсийн дунд Европ зvгийн германы Неандерталын хөндийн балрын хvн, Дундад улсын Бээжингийн хvн гэж хvн судлалтан эрдэмтэн мөн эртний судлалтан эрдэмтэнд алдаршсан Ази, Европын хvний зэрэгцээгээр, мөн тэр хавилцаа вeд нь манай энэ тунгалаг урсгалт Туул голын хавьд ч бидний өндөр өвгө, чулуун зэвсгээ барин , аж төрж, амь зууж явсны баримтыг Зөвлөлтийн эртний судлалч эрдэмтэн олж, Зайсан толгойн зvнн урд хормойд нь хvртэл чулуун зэвсгийн хvний орогнож байсан газар, чулуугаар вйлдвэрлэж байсан зэвсгий нь олсон тул, би германы Неандертал ч оролгvй, Бээжингийн балрын хvний орогносон газар чхvрч очилгvй, хаяанд маань тvмэн жилийн тэртээ оршиж байгсдын байдлаас дvрсэлж, vзье гэж зорин бодоод, сурах бичигтээ члуун зэвсгийн хvн гэж вэдэг манай сургуулийн багацуулд ч энэ зvйл сонин байж юуны магад гэж бодож бичсэн хэрэг. Уншигч нөхөд, та бvхнээ ийнхvв зориулан бичсэн vвнийг юун гэж болгоосон сэтгэгдлээ надад харамгvй, шуудангийн 119 дvгээр хайрцагт бичиж, цаашдаа vвний хойд дахь цуврал болох вйлд минь тусална уу. Yвний тул, эл оршлын хэдэн vг бичин нуржлаа.

Улаанбаатар, харагчин туулай жилийн хаврын тэргvнн сарын сайн өдрөө .

Эргийн бургасанд суун чагнаваас
Yелзэн урсах Туул голын ус нь
Эртний домог шивнэн ярих мэт
Yймцэх сэтгэлээ тогтоон,
Наран гэрэлд нvдэн аниваас,
Балар вейн вээгдэл ургаад
Надаар хэлмэрч хийж, тvвхээ
Багацуулд уламжлах гэсэн мэт ...

Өгvвлэх нь : Тэр аюултай том амьтан, гэв гэнэт, цов цочмог шугуйн өтгөн бургасан дотроос аягvй муухай урхиран гарч, галзуу мэт дайран оржээ. Тvргэн урсгалт, тунгалаг уст голын уудам нуга, дээр мангир тvвж байсан эмэгтэйчvвд, хvвхэд багачууд сочин эмээж, сандран бархиралдаад, хойд уулын энгэрт, өндөр сайхан дэнж дээр харагдаж байгаа өрх гэрийн зvг улаа бутран гvйлдтэл, хамар дээрээ урт богино хоёр эвэрт, бараан шар урт встэй тэр хирис , хойноос нь газар донсолтол пижигнэн хөөгөөд, Туулай хvвг том тавхайгаараа мэлхий гишгэсэн шиг няц даржээ. Хөөрхий жаалын амь тасран, элээнд шvврvвлсэн бөжин шиг аягvй муухай часхийтэл бархирсан дуунд нь Залуудай хvвгийн хуйх нь хөндийрч, вc нь сөхvйн босоод ирэх шиг боллоо. Айж сочсондоо, эргэж Туулайхvвгийн яасныг харах завгvй урагш ухас хийх зуур, дэнж дээрх хэдэн өрх гэрийн гадаа , наранд ээж суусан өтгөс эмгэд

сандан мэндэн, унан дусан босож, вймэлдэн арваганах нь харагдтал, муухай заар ханхлаад, нэг их ширvvн vстэй юм араас нь лvс хийтэл мөргөж, уул дайвалзан, газар дээшээ, тэнгэр доошоо гарах шиг болоод, бургасны орой нь уруугаа унжиж байх шиг хачин сонин vзэгдээд, гэнэт нvд харанхуйлжээ. Хирисийн хөлд дайруулаад, тахийн хомоол шиг эргэлдэн vсэрч, газар мөргөж ойчихдоо, хурамхан зуур ухаан алдсанаа төдхөн сэхэж, яаран өндийн харваас, зугтаасан эмс xvvxдийн тvrvvч нь , наад захын өрх гэрт хvрэх шахасхийж, хойноос нь тэр муухай догшин амьтан уулнаас өнхрөн буух vхэр чулуу мэт vсрэн давхиж, xvvxэд багацуулыг тоохгvй, эмэгтэйчvvдийн хойноос хөөж явах ажээ. Залуудайн айн эмээн, дэмий л ширтэн хартал, тэр махан овоо шиг том амьтан, толгойгоо өчvvхэн төдий хоёр нэг хөдөлгөсхиймэгц, дэргэд нь нэг нь арвайн сарвайн, аргал хоргол чавхдах адил, дээшээ ойн vсрэх нь vзэгджээ. Чингэсээр, Поодой бөөгийн өрх гэрийн зvг , хурдан хөлт Паалиагийн хойноос нэхэн давхиж яваа нь Залуудайн гvдэнд жигтэйхэн тод харагджээ. Поодой бөөгийн өвгөн ав Оодой дархан, өрх гэрээсээ жад барин гарч, Паалиа тэр бяцхан бор толгой шиг өрх гэрийнхээ оройо дээр гvйн гарахтай зэрэг, хирис, хойноос нь гvйцэн, нохой хуцуулж, өрх гэр дээр эрчээрээ давхин гарахыг Залуудай зvvдэлсэн юм шиг, айн эмээн, хөдлөх дуугарах тэнхэл тасран, харж байтал, улаан шороо манараад, Паалиа, Оодой, хирис цөм далд орж, гагцхvv тэр муухай том амьтны хөндий цээжнээс гарч байгаа архирах svрт дуу, нохой шуугилдан хуцах, эмэгтэйчvvд чарлалдан хашхилдах чимээ дуулдан авай. Залуудай хvv сочин сандарсандаа хярсан бөжин адил, газар наалдан хэвтээд, хирист мөргvvлж өвдсөнөө ч мартаж, өвсний завсраар дэнж дээрх өрх гэрийн зvг юу болж байгааг эмээн ширтвээс зарим өрх гэрийн өрх нvхээр дотор нь байсан эмэгтэй, ганц нэг эмгэд цухуйн гарч, хэдэн нохой, Доодойн өрх гэрийн тэнд хуцан гvйлдэх нь vзэгдэв. Эргэж харахад , хирист дайруулан гишгvvлсэн Туулайхvvгийн шилэн хvзvv таталдсан юм шиг , толгойгоо өлийж, ангайсан ам нь хашгирч байгаа юм шиг боловч, завжаар нь цус гоожин, өрөөсөн гарт нь хэдэн мангир тас атгаастай, сvvжин бие нь няц гишгvvлчихсэн харагдаж, цаана нь эмгэн Мангина алдлан хэвтэж, бас хирисийн давхисан замд дайралдаж мөргvvлсэн ганц нэгэн эмэгтэй тэвдэж байгаа нь , бие агшиж, жижиг бичил болсон адил, их л svргvй, бас огт хөдлөхгvй байгаа нь айдас хvрэм аягvй vзэгдсэнд , Залуудай уйлах дур хvрэвч, хээр газар уйлж, чимээ гаргаж болдоггvй юм. Ан араатан халдана гэж эмэг эхийн сургадгийг санаад, шvдээ зуужээ. Поодойн гэрийн тэндэх улаан тоос ч тэр завсар замхарч амьтан тойрон бужигнаж, нохой хуцаж, хирисийн буйлах муухай дуу ve ve гарч байхыг чих тавин хартал, тэр амьтан бараа туруугvй болсон мэт. Бас олон хvний овооролдсоны завсраар Поодойн өрх гэр vгvй болсон мэт. Учир байдал мэдэгдэхгvй хачин болсон тэр зvг гайхан харваас, олны дунд эмэг эх нь vзэгдэх шиг болоход хайртай эмгээгээ танимагц, өндийн босож, ухасхийн гvйж орхилоо. Хирисээс тутаах ves, торж унасан гавраа хярж, хэвтсэн ганц нэг багацуул, Залуудайн гvйхэд, хойноос нь дагаж, бас гvйлдэх чимээ сонсоглоо. Хирист дайруулагсдын хажуугаар гарахад, цөм эвгvй хэвтэж, огт vl хөдлөх байдал нь vxсэн ан гөрөө, хvн харыг хэдий нас бага боловч, олон vзсэн Залуудайн нvдэнд тусаж, босохоосоо өнгөрсөн ажээ гэж бодон гvйтэл нэг эмэгтэй хөдлөх шиг боллоо. Бие биедээ тусалж байхыг vргэлж хэлvvлж, ахас ихсээ харилцан туслалцау байдгийг vзэн хvmvvжсэн тул Залуудай, тэр хэвтэж байгаа эмэгтэйг хөдөлмөгц, дэргэд нь гvйж очоод, хажууд нь явган суутал, хойноос нь дагаж гvйсэн Алцгар, Арваалж, Чулуун гурав гvйцэж

ирээд, дөрвүүлээ үзвээс, Алцгарын эгч Пентуу ажээ. Бие чийрэг хүдэр тэр эмэгтэй, нүдээ нээн, өндийх гэснээ ёолж, өнөө дөрвөн жаалыг хармагц, алмайрсан мэт хачин харц нь ухаан сэхээ орсон шинжтэй болж, сулхан дуугаар

- Өнөөх хэцүү нэрт амьтан хайчив? Гэж шивнэн асуугаад, багацуулын хариу хэлэхээс урд, бас нэг ёйлсхийгээд хоёр хөл мэдээ байхгүй, зоо нуруу их өвдөж байна гээд, дахин нүдээ анив.

- Алцгар чи эгчийгээ харж бай. Бид хүн дуудаж ирье гээд Арваалж, Чулуун хоёрыг дагуулан, өрх гэрийн зүг гүйсээр ойртон очтол, Поодойн цөмөрсөн өрх гэр дотроос хирисийн хилигнэн буйлах дуу гарсаар ажээ. Эхийн зүг гүйн очиж, суганд нь наалдан тэврээд, утаа өөх тосны үнэр шингэсэн сармай дээлийн их л дадсан үнэр авмагц, дотор нь онгойж,

- Пянтуу эгч, хирист мөргүүлэн бэртчихлээ. Бид үүрээд даахгүй яадаг билээ гэхэд нь, Поодойн цөмөрсөн гэрийн тэнд байсан эмэгтэйчүүдийн дундаас солонго сонсох сонор чихтэй эмэг эх нь, хэдийн тэр үг сонсоод,

- Ээ бид энд хирис өрх гэр цөмөлсөнд авигтаж сандраад мартчихлаа. Цэцэг, Балт, Хүрнэ, Мөндөл та дөрөв очиж Пянтууг дамжилж ир. Хормойгий нь зөрүүлээд, ханцуйгаар нь мод шургуулж дамжилдаг юм шүү.

Мод аваад яв гэж дөрвөн чийрэг эмэгтэйг тэр суурин өрх айлын хамгийн эгчмэд хашир хүний хувиар тушааж явуулав.

Залуудай, эмэг эхийн хамт, Поодойн цөмөрсөн өрхийн дэргэд очиж, доошоо эмээн харваас, хирис, өрхийн дээврийг махаараа цөм дарж ойчихдоо, нарийвтар сургааг унин дээр хар модны долон холтос дэвсэж, дээрээс нь ширэг жигдлэн өрж хийсэн дээврий нь цөм дарж ойчихдоо, өрхийн тооно тулсан дөрвөн баганын нэг нь цав гарсан газраа цуурч, шор мэт хурц үзүүртэй болсон нь, тэр нүсэр том амьтны гэдсий нь нэвт хатгаад, бөөрөн тушаа нь цус бултайн цухуйжээ. Хирисийн зантайсан том толгой нэн хүнд тул, цээжин бие нь доошоо унжиж, урд хоёр хөлөөрөө газар самран, байн байн сүртэй муухайгаар урхирах ажээ. Оодой дархан Паалиа хоёр, нэг буланд, хирисийн эвэр хараахан үл хүрэх газар хоргодон суугаад, шороо тоос болчихсон тэр хоёрыг өчүүхэн хөдөлмөгц, хирис догшин нүдээ улаанаар эргэлүүлэн, эврээрээ өлгөж авах гэж урхиран тэмүүлэх тул, хярсан бөжин шиг, буланд бие биедээ шахалдан оцойж суух ажээ. Баганыг газар сайн зоосон боловч, том амьтан өлгөлдөж, тарчлахад нь баахан холхих байдал орж, өвгөн дархан, жаал хүн хоёрын зүг хазайсхийжээ. Залуудайн эмэг эх Булжуухай, Оодойн булан тушаа нүх ухуулж, хүн багтах хиртэй болмогц, нэг мушгиа сураар Паалиа хүн урдаар татуулж гаргаад, хирисийн уурлан урхирах нь баахан завсарламагц, өвгөн дархныг гаргаж эхэллээ. Тэгтэл хирис ахин буйлан урхирч, хамар амнаасаа өвгөний биед цус нөж тургин зүтгэсээр, баганыг ганхуулж, Оодойн дээлийн хормойноос эврээрээ дэгээдэн татсанд, эмэгтэйчүүд, тэр догшин сүрт амьтны гэнэт хөдөлж ухасхийснээс айн цочиж, мушгиагаа алдсанд, ганц чийрэг Хойлог чинэрэн улайтлаа угз татаад, өвгөний цээж биеийг нүхээр цухуйтал суга татсанд, хирисийн эвэрт өлгүүлсэн сартай дээлийн хормой цуу буугаад өвгөн, хирисийн эвэрт гэдэргээ татуулсандаа тэсгэлгүй айж магнайд нь хөлс агшин зуур бурзайн гараад, дэмий л ам ангалзан, нүхний амсрын ширэгнээс хуруугаа шигдтэл зууралдан тогтосхийв. Хирисийн цус, шороо тоос болсон царай, бүлтийсэн нүднээ үхмээр сандарч хэлмэгдсэн байдал тодорсонд, Булжуухай эмгэн,

- Татаач . гэж хашгираад, залуу хvvхэн шиг всрэн , Хойлгийн барьж байсан мушгианы vзvvрээс шvvрэн, Оодойг угз татан гаргалаа. Өвгөн нvхний амсарт суга татуулан хэвтээд, сандарч тэвдсэндээ өндийх чадалгvй , дэмий л хэнхдэгээ оволзтол амьсгаадан нэгэн хэсэг хэвтэв. Булжуухай, Залуудайг ус аваад ир гэж тушааж, жаалхvv яаран гэртээ ороод, шавар ваарт байсан уснаас бvдvvн хийцтэй шавар том аяганд хийж, өвгөнд авцарч өгөхөд нь гуд гуд залгиад дотор нь сая онгойж, магнайн хөлс арчин сармай дээлийнхээ цуу татуулсан хормойг барьж vзээд :

- Үхлээ гэж бодсон. Хойлгийн шөрмөстэй Булжуухайн бушууд л амь гарлаав шvv. Ёх доо, айгаагvйгээ айж, сандраагvйгээ өнөөдөр ганцхан сандарлаа даа. Айсандаа ам хатчихлаа. Ус ууж, дотор онгойх шиг боллоо. Насы минь аваарай, хvv минь гэж Залуудайд аянаа өгөөд өндийж, өнөөх цөмөрсөн өрх гэрийн нvхний зvг шагайж vзвээс хирис , Оодой өвгөнийг дайрах гэж дошгирон тийчлэхдээ гэдсэнд нь шаасан багана биед нь чулам шигдэж, эцсийн тамир тасарч, мундаг том бие нь чичив, татав хийж амь тавьж байгаа ажээ. Шилэн хvзvvнд нь цус бялтаж, лав нэг шарх олсон амьтан бололтой. vгvй тэр юу цухуйж байна. Жадны хугархай иш байх шив дээ. Энэ лав нөгөө гөрөөчинтэй дайралдаж шарх олоод, тvvнээсээ болж, тэнэг уур нь хөдлөөд, манайхныг дайрч, уршиг төвөг чирсэн бололтой. Манай гөрөөчин загасанд явсан шvv дээ. Энэ амьтан хаа , ямар улстай дайралдав аа. Аль вэ хvv минь, авынхаа жад аваад ир гэж Залуудайгаар анч Бодонгийн чулуун гилбэртэй, жад ацруулаад, хирисийн зоог хэд хэд сайн чичээд vзтэл, тэр том амьтан ер хөдөлсөнгvй. Өрхийн минь эвдэн цөмөлсөн энэ хирис манайх боллоо. Анчин ирэхээс өмнө бид амаа тосдож, гэдэс гарлаа. Булжуухай чи чи хэдэн хvнтэй энvvнийг vнэр орохоос нь өмнө эвдэн аргалж, идээ хоол хийж vз л дээ. Би нэг хэдэн хvнийг дагуулж, наадах чинь амь хохирсон хvнээ оршуулж vзсvv гэж бослоо. Бяцхан суурин өрх айлын нэг хэсэг, эмэгтэйчvvд Оодой өвгөнийг дагаж, дэнж дээрээс буугаад, голын бургас улиаснаас Оодой өвгөний чулуун сvхээр огтолсоныг дамнуурга шиг юм хийж, хирист дайруулан vхэгсэдийг отгийнхоо нөхцөгчдийн хvvр тавьдаг газар дамнан аваачих боллоо. Туулайхvvгийн эх догшин хирисийн хөлд няц гишгvvлсэн жаалынхаа амнаас гарсан цусы нь өвсөөр арчаад, тэсгэлгvй гашуудаж, всээ задлан, нvvрээ маажилж,

Алгын чинээ жаал хvvгээ
 Анчин болохыг vзэхээс өнгөрлөө
 Эрхийн чинээ жаал хvvгээ
 Эр хvн болохыг vзэхээс өнгөрлөө
 Эвий хонгор минь эвий
 Эх нь гашуудан дууднам
 Дайрах хирисийн хэлд осолдоно гэж
 Даанч бодсонгvй чамайгаа хvv минь
 Ууртай хирисийн хөлд осолдоно гэж
 Ухаанд минь ч орсонгvй чамайгаа, эвий
 Хөөрхий хонгор минь хөөрхий
 Хөгшин эх чинь гаслан уйлнам
 Алаг vрийнхээ амнаас гарсан цусы нь
 Арчин арчин аюулт хирисийг зvхнэм
 Хайрт vрийнхээ няц гишгvvлсэн биеийг

Харан харан хар хирисийг хараанам
Эвий хонгор минь эвий
Эх чинь гашуудан дууднам
Өглөөний өөд улаан нарнаар сэрээд
Өндийж намайгаа хардаг асан хvv минь
Үдшийн шар нарнаар намайгаа тэврээд
Үнсээд нойрсдог асан vр минь
Хөөрхий жаал хvv минь хөөрхий
Хөгшин эх чинь гаслан уйлнам
Эвий эвий эвий эвий,
Элэг минь эмтэрнэм

гэж уйлан гашуудах нь даанч өрөвдөлтэй тул, Оодой өвгөн дэргэд нь хврч, ирэн тайтгаруулах хэдэн vг хэлж, Туулайхvvгийн ясыг дамнуурганд тавиулан, отгийн хvний яс тавьдаг газар зvглэн цував. Уулын энгэрт Оодойн заавраар эмэгтэйчvvд мол чулуугаар хэдэн гvйхэн нvх ухаад, өвгөн дархан нөгчигсдийн хувцсыг энд тэнд нь чулуун хутгаараа эсгэж, чархи гэдэг тvvхий ширийг нойтонд нь хөлийнхөө шагайд хvртэл хумин тааруулж хатаасан шаахай гутлын зуузай хавьд бас эсгэж,

Эд нь эзнээ дагаж,
Элэгдэлгvй мөнх
Ханзралгvй бөх
Хагаралгvй бат
Үvрд эдлvvлж
Хэзээд хэрэглvvл

Гэж шившин , эмэгтэйчvvдийн хvзvvний сондор чимгийн соёо чулууг маажин, Туулайхvvгийн тоглоом авч ирvvлснийг бас хутгаараа маажив.

Залуудай баахан гайхаж,

- Оодой аваа, та юунд ингэж байгаа юм бэ? Гэж асуухад нь, Оодой дархан сурган өгvvлрvvн :

- Эзнээ эд нь дагаг гэж байна, хvv минь .Эд нь бvтэн бол, сvнс нь эзнийхээ сvнс дагахгvй, нэг хэсэг зовооно. Эзэн хvний сvнс нь бие нvцгэн гар хоосон, хөл нvцгэн явах болно. Туулайхvvгийн сvнс ч гэсэн, тоглоомд нь шарх оруулж эс авбал, бvтэн тоглоомоо ялзартал нэгэн хэсэг тоглоомгvй уйдаг болно шvv дээ. Эртэс дээдсийн маань ёс эзнээ дага, эзнээ дага. Гэж тоглоомы нь тамталсхийж гvйцэв. Тэгээд, Мангина эмгэний хvvрийг амьд ахуй ves дэвсэж хэвтдэг адасган дээр нь баруун гары нь дэрлvvлэн, хөл нугалсхийн хэвтvvлээд, дэргэд нь ясан зvv, шөвөг, томсон шөрмөс, шавар ваартай хирисийн мах, шөл тавьж, бусдыг мөн тэр ёсоор хэвтvvлэн, Туулайхvvгийн тоглоомыг хажууд нь өрж, нэг нэг атга улаан зоос хvvр дээр цацсанд, Туулайхvvгийн эх, хvvгийнхээ сармай дээлийн хормойг аятайхан засаад, нvдэндээ нулимас мэлтэгнvvлэв. Оршуулах ёслолд ирэлцсэн эмэгтэйчvvд хишгээ хуваалцлаа гэж вснээсээ vгтээн, хvvр дээр тавьцгаав.

- Туулайхvvгийн эх, нэн гашуудаж, вснээсээ чулуун хутгаар нэгэн хэсэг огтолж аваад, хvvгийнхээ всэн дээр тавингуут, биеэ барьж ядан , маш гашуунаа уйлсанд, Оодой дархан тайтгаруулах vг хэлж, шавар саванд авцарсан цогоор хvvрийн дээд талд баахан гал асааж, агь ганга хийгээд утуу уугих завсар бvгдээрээ булшийг шороо чулуугаар дарав. Тэгээд булш бvрийг тойруулан чулуун хvрээ хийж, хооронд нь

зайтай зайтай өрж гүйцэхэд, Оодой өвгөн, омгийн дээдсийн хувр булшинд хиншvv өргөж, аман дотроо юм шивнээд, галд агь ганга нэмж, их утаа уугиулан , өндөр дуугаар уншин дуудруун,

Чоо - чоо - чоо , Сонсон хайрла
Өрх гэрт төрсөн Мангина нар
Өвөр энгэрт орших цаг боллоо
Мах ясанд төрсөн Мангина нар
Манаас салан хагацлаа, та нар
Хий бие биелэн одлоо, та нар
Хиншvv идээтэн боллоо, та нар
Хилин дүрээ атаатандаа хандуулж
Хишиг ээлээ халуундаа хайрла
Чоо - чоо - чоо , сонсон тогтоо
Харанхуй шөнийг далимдуулж
Халууныхаа манийг хорлох гэвэл
Хашмал чулуун хврээ битvv шvv
Хагуучид онгодын хилэн хэцvv шvv
Саргвй шөнийг далимдуулан
Садан манийг хорлох гэвэл
Сахиусан чулуун хврээ давшгвй,
Сайн онгон авын ээл барагдашгвй
Чоо - чоо - чоо сонсон тогтоо
Хашмал чулуун хврээг мялаамуу,
Ханан хад мэт, тэнгэр тулан хашиж
Хайр чулуу болон элэгдтэлээ
Хамгаалан харж бай, Чоо - чоо - чоо
Сахиул чулуун хврээг мялаамуу
Сарьдаг уул мэт тэнгэр тулан хашиж,
Сайр чулуу болон элэгдтэлээ
Сахин харж бай, чоо -чоо - чоо

гээд , хирисийн өөхөөр булш тус бvрийн чулуун хврээний дөрвөн зvгийн чулууг мялааж, уг оршуулах ёс гвйцмэгц, бvгдээрээ,

- Чоо - чоо - чоо гэж өндөр дуугаар гурвант хашгиран , гэдрэг эргэж харалгвй, өрх гэрийн зvг буцан одов. Ар гэрийн газар тэр завсар Булжуухай эмгэн удирдаж, өнөөх хиррисийг чулуун сvх хутгаар эвдээд гадаа хэдэн газар гал твлж, хирисийн мах шарахы нь шарж, шавар ваар саванд чанахы нь чанаж, чоно шиг нохойдоо идvvлэхий нь идvvлж, багацуул нvvр ам нь цус болчихсон гвйлдэж,

- Манайхан уулын энгэрээс айсуй, гэж шуугилдахад, Булжуухай эмгэн яаран хоёр гал твлvvлж, ганга твлvvлж, ганга уугиулан, ганга буцалгасан устай хэдэн ваар тэр хоёр галын тэнд тавиулав. Хирист дайруулагсдыг оршуулж ирэгсэд, тэр хоёр галын хоорондуур орж, биеэ ариутган, тvрvvн нvvрээ маажиж гашуудал илэрхийлсэн цусаа гангатай усаар угаацгаалаа. Тэгээд, тvvдэг галын тэнд очиж, галын зvvн талаар эмэгтэйчvvд, баруун талд нь Оодой өвгөн тэргvvтэй хөvvд сууцгаан шарсан, чанасан махны сайхан vнэр ханхлахад, швлсээ зуун хвлээвээс, Булжуухай эмгэн, хvн бvрийн оногдол хувийг сайхан тааруулж хоёр залуу эмэгтэйгээр тэвштэй ваартай хоол

тавиуллаа. Туулайхvvгийн эхийг өрөвдөж, аль амттай махнаас тэвш дvvргэн тавиулсанд саяхан гашуудан уйлж байсан тэр хөөрхий эмэгтэй, сайхан элбэг хоол хараад, сэтгэл нь сээгэж, тун жаргасан байдалтай идэж суув. Үвнд одоо цагийн хvн, эрт цагийн тэдгээр хvнийг буруушаахын арга чvгvй, ёс ч vгvй гэж бодууштай чадал муутай, зэвсэг муутай, vргэлж хоосон нойтон шахуу явдаг хоёр хөлт хөөрхий балар цагийн хvн, хоёр чихнээс нь хойш орох вm л олдвол, цадахаа мэдэхvй идэж аваа, тvvнийгээ жаргалын дээд гэж vздэг байжээ. Идэх юм эс олдвол, өл даахдаа нэн ч тэсвэртэй, ер өлсөх, даарах, ангах цангахыг жирийн хэрэг гэж vздэг цаг байжээ. Туулайхvvгийн эх , Булжууай эмгэний сонгож тавиулсан махыг маш амтархан идэж, хааяа хааяа эмгэний зvг талархан мишээж, хоёр завжаараа өөх төо элгэн дээрээ гоожтол зажилж год год залгилан идэх нь маш шамдуу. Бусад хvн, мөн нэгэн адил амтархан идэж, ясаа тун чадамгай мөлжөөд, чоно лугаа адил төсөрхөг нохойд хаяж өгөхөд нь хирисийн гэдэс дотроос хэдийн идэж цадсан тул, ганц нэг долоогоод, тоохvй хэвтэцгээж байснаа баруун зvгээс салхи татах зvг шиншилсэнд, Булжуухай эмгэн ч тэдгээр нохойноос дутуугvй,

Солонго мэт

Сонсох тул

Үен мэт

Үзэх тул

бас л алсын vнэр хэдийн мэдэж, галын баруун зvн зvг суусан хvmvvст анхааруулж, - Голын зvгээс гөрөөлсөн загасны vнэр, манайхны vнэр, бас нэг өөр харь хvний vнэр гарч байна гэхэд нь бvгд яаран босоцгоож, дэнжийн захад очин харваас, усны тохойд гурван урт онгоц зогсож, арван хэдэн эрэгтэйчvvд, том том загас бургасаар холбосноо модонд дамнан, дэнжийн зvг айсуу. Нэг хэсэг нь сэрээ , жадаа vврцгээн явнам.

- Өөдөө гартал, Оодойн өрх гэр цөмөрчихсөнийг хирдхийн харж бас эмэгтэйчvvдийн нvvрт гашуудан маажсан ор тэмдэг илэрхийн дээр , нэг хэдэн хvн бас дутуу байхыг vзээд, учрыг яаран асуужээ. Ар гэрийн газар гэнэтийн аюул зовлон тохиолдсоныг сонсож, анчин эрсийн царай барайж, хөмсөг зангидацгаав. Ирэгсдийн дунд уранхай, навтархай, сармай хувцастай, эцэнхий, аяншиж зvдэрсэн байдалтай боловч сvрхий шөрмөслөг бяртай нэг эр, загас vврэлцэн зогсож байхыг Залуудай ажиж, Булжуухай эмээгийн хамар харь хvний ханхлав гэж тийм холоос таних яасан сvрхий хамар вэ? Гэж гайхан, тэр хvнийг сэм харваас царай зоримог бөгөөд шулуун. Бvснээ нэг vл таних сонин судалт модон иштэй сvх, нэг эрээн амьтны всээр ороон зvvж, бас нэг сvх ширэн гэр углаж бvснээсээ хавчуулаад, ахар жад нэг гартаа барьжээ. Анчныг тэргvvлж явсан Мазаалай, өтгөн дуугаараа хvнгэнэн ,

- Манай Булжуухай эмээн хvv, Залуудайн эцэг Шонхолой, энэ зvн урд уулын нэг чулууны нvхэнд шар махчингуудаас хоргодож байна гэж энэ ихэрэс омгийн хvн бидэнтэй дайралдан хэл хvргэжээ. Энэ шөнө очиж Шонхолойг гаргаж авахvй бол шар махчин биднээс тvрvvлж магадгvй гэнэ. Хvний тоогоор манайхнаас олон гэнэ. Харанхуйг далимдуулан дайрвал бид дийлж магад. Оодой ав, Булжуухай эмээ, та хоёр өрх айлаа мэдэж, сэргийлж бай. Дийлбэл бид маргааш vдээс хойш ирэх байх. Дийлдвэл, шар махчныг өрх гэрээсээ холдуулан, өөр зvг буруулж, уван цуван нуугдаж ирнэ. Шар махчинтай одоо л нэг vзэлдэх цаг боллоо гэхэд нь хvн ер vг дуугарсангvй. Хэдэн жилийн өмнө, урлах уулын зvн урдах аманд Оодой авын

суурин айлыг үгвй хийсэн Шар махчинтай тулсан тулаанд Шонхолой сураггвй болж, Поодой бөө хвүгийн хамт амь гарсан. Оодой өвгөн ураг төрлийн барилдлагатай Чонос омгийнхоо өрх айлд багтан хамжсан явдал Чоносын бяцхан суурин айлын эрэгтэй эмэгтэйн сэтгэлд ургаж, өнөөх Шар махчны сүрэг дахин үзэгдсэнд цөм сэтгэл зовнижээ. Олны чимээгвй байтал, Залуудай өндөр дуугаар

- Би явалцаж, авыгаа шар махчнаас салгаж ирнэ, гэхэд нь өнөөх үл таних хвн, тэр үг монсмогц, бүснээсээ урт ишт сүхээ яаран суга татаж аваад хоёр гараар Залуудайд барьж,

- Авын чинь чамд явуулсан сүх. Хвүд минь гардуулж өгөөрэй гэсэн юм. Зорьсон хэрэг чинь бүтэх болтугай, гэж өгсөнд, Залуудай тэр сүхий нь авч, гэрий нь мулталж үзвэл, жигтэй сайхан мөлгөр ногоон чулуугаар хийсэн хурц сүх байжээ. Энэ ямар чулуугаар хийсэн сүх вэ? Гэж Оодой дархны гайхан асуухад, тэр харь хвн,

- Хас тэнигэр гэдэг чулуу. Тун хатуу. Их цөлийн тэртээх нангиа омгийн урцуул хийдэг зэмсэг дээ. Шонхолой тэднээс сурч, хвүдээ өөрөө хийсэн юм гэхэд нь Залуудай

- Эмээ, би ах нартайгаа явалцаж, Шар махчинтай тулна. Авын энэ сүх шар махчны цусаар мялаана гэхэд Мазаалай, өтгөн дуугаараа

- Эмээ залуудайг явуул аа, явуул. Бидэнд нэг хвн чгэсэн нэмэр. Шар махчинтай эцгийнхээ төлөө тулалгвй яахав. Гэхэд нь Булжуухай эмгэн,

- Эр хвнийг явуулан хэлдэг ёстой юм даа. Хвү минь явж, атаатнаа даралцаад автайгаа мэнд буцаж ирээрэй гээд Залуудайн баруун хацрыг үнэсээд, зүүн хацры нь илэв. Анчингууд, яаран хирисийн чанасан шарсан махнаас идэж аваад, ундаа хариулан, зэр зэмсгээсээ аль сайныг шилэн автал, нар ч жаргах шахаж, одоо явалгвй горьгвй гэж эрцүүл цөмөөрөө шаламгайлан хөдлөв. Өрх гэрийн газар эр хвйстээс ганц поодой өвгөн тэргүүлэнхэн үлдэж хоцров.

Чонос омгийн бяцхан өрх суурин айлын дайчин эрс Шонхолойгоо Шар махчингуудын гараас салгах гэж онгоцондоо сууцгаан гол гатлаад, бургасан дунд онгоцоо далдлан сойгоод, яаран алхав. Бүгдийн өмнө өнөөх эцэнгир эр, том том алхмаар газар хорооцтой алхаж, хойноос Мазаалай бусдаа дагуулан явав. Жаргаж байгаа нарны гэрэлд үүлс ягаан шар туяа татаж өвсөн дунд гөрөөсний том ийш тийшээ зурайн, зарим нь голын зүг ус уухаар явдаг зам нь байжээ. Агаар маш тунгалаг бөгөөд, зүйл бүрийн цэцэг навчны сайхан үнэр анхилан, үдшийн сэрүү татаж тогоруун сүрэг өндөр тэнгэрийн хөхөд цувран нисэх нь тов тодхон. Өргөн талд тахь хулан билчиж зээр оронго жирэлзэн давхиж, хойноос нь ямар нэгэн эрээтэн хөөж явааг үзээд Залуудай сүхээ атгаж аавынхаа дүүгүүр бүснээсээ зүүснээ сугалж, гөрөөсний хойноос хөөцөлдмөөр санагдав. Мазаалай, Залуудайг эргэж хараад, толгой дохин дэргэдээ ирүүлж, шивнэн өгүүлрүүн :

- Ан харалтгвй, авыгаа шар махчингаас мулталж авахыг зориглож яв. Бид удахгвй модны захад хврч, дайсанд харагдахгвй нууцтайгаар дөтөлж, харанхуй болоход дайрна. Шар махчин, биднээс олон юм гэнэ. Цочмог дайран, хэдий нь хороовол, хвч тэнцүү болох бий. Ав чинь тэр жил Шар махчинд баригдаад, оргож зугатаасаар олоэ омог дамжиж, их мөрний цаана нангиа омогтон суудаг газар хврч, тэндээс энэ Шарнууд омгийн хвнтэй нийлэн наашаа буцаж яваад, Шар махчингийн сүрэгтэй дайралдан хадан хонгилд хоргодсон юм байна. Ихэрсийн энэ Бух өвгөнийг тэднүүд харсангвй. Аав чинь, өрх сууриндаа дайсан дагуулж ирэхгвй гэж хадан хонгилд

нуугдаад, Бухыг манайханд явуулж хэл хвргүүлсэн нь яг бидний загасны ангаас буцаж явахтай дайралджээ. Чи гөрөө хийж чадах боловч, хоёр хөлт дайсантайтулж үзээгвй. Биеэсээ давуу дайсантай битгий тулаарай. Миний ойр байж үзээрэй гэж сурган хэлсээр, ойн захад ойртсон тул, бvгд модонд шурган орж, зvнн урд зvгийг чиглэн явтал, төдхөн харанхуй болов. Олон хvн явах vнэрий нь ойн араатан гөрөөс хэдийн авсан тул урдуур хойгуур нь зэрлэг гахай зайлан одох чимээ гарч, хааяа хааяа араатны vнэр ханхлан Чоносын дайчин, чархи гутлаараа огт чимээ гаргалгвй цуван алхсаар нэгэн хэсэг явтал, тvрvвлэн газарчилж яваа ихэрэс Бух өвгөн гэнэт зогсож, модон завсар тэртээ хол гал гялалзахыг зааж шивнэрвvн :

- Өнөөх Шар махчин тэр байна гэж шивнэв. Чонос, тэр зvг ширтэн харцгаагаад , шивнэн зөвлөлдөж, салхины доод талаас гэтэн ойртохоор тогтож, хvн бvр дvвгvврээ барьцгааж, Мазаалай тvрvвлэн бусад нь хойноос нь дагалдан, мөр мөрөө гишгэж, чив чимээгвй явав. Харанхуй модон дотор уруудаж бугаад , урт нарийн ам модны хаяагаар өгсөж, дайсны зvг ойртох тусам , галын хажууд суух нь сууж, хэвтэх нь хэвтэж байгаа хvн улам тодхон харагдах болов. Тvвдэг галын гэрэлд босоо хvний мөрөн тушаа өндөр харлан харагдах нvх сахисан хэдэн хvн, хааяа тэр нvх рvв чулуу хаях , цучил шидэх үзэгдэн, цучил нь нvхэн хонгил дотроос хvн эргvвлж хаясан юм шиг гэдэргээ суунаглан унах байдал илэрхий үзэгдэх болсонд Залуудай хvв , ав минь тэр нvхэн хонгилд байгаа юм байна гэж дотор нь онгойж, эцгийнхээ явуулсан урт ишт сvхийн бариулыг чанга чанга атган , дайсны толгой руу буулгаж байгаа мэт сэтгэн алхтал, Мазаалай гэнэт зогсож, шивнэн захисан нь :

- Одоо ойртоов шvв. Нэг нэг дvвгvврдээд, хашгиран дайрч орно шvв. Би тэр дунд нь сууж байгаа том Шар махчныг дvвгvврдэнэ. Бух тэргvвтэй таван хvн доод талд нь сууж байгаа тавыг дvвгvврд. Дээд талын тавыг бусад нь дvвгvврд. Би тэрнийг, чи тэрнийг гэж сайн оноож ав. Намайг дохио өгмөгц дvвгvврдэнэ шvв. Одоо тун чимээгвй, салхин дороос нь ойртоно шvв. Шар махчны хамар нь манай Чоно аваас дутуугвй шvв, гээд огтхон ччимээ гаргалгвй салхин дороос сэм ойртож, нэг хэсэг яваад, харанхуйд их тvвдэг галын дэргэд шарсан мах идэж байгаа Шар махчны ойр дvвгvврийн чулуу хvрэм газар гэтэж, зулзаган модон дундуур дөтлөөд, , арын хvнийг гараар тvлхэн дохио өгмөгц, цөм сэм урагш давшин эгнэж зогсоод, Мазаалайн дvвгvврийн чулуу дvнгэнэх чимээ гарахыг хvлээв. Тvвдэг тойрсон дайсны зvгээс шарсан махны vнэр, Шар махчны хөлс хулмасны vнэр ханхлан, хvн бvр дvвгvвртээ чулуу зуулган , дохио хvлээтэл, Мазаалайн дvвгvврийн чулуу хvнгэнэнгvвт бусад Чоносын дvвгvврийн чулуу хvнгэнэж, тэр чулууны чимээгээр Шар махчингууд ухасхийн бостол, зургаа долоон хvн ойчих шиг боллоо. Тэгтэл , Мазаалайн бvдvвн дуу гарч, Чонос чоно өвгөө дууриан ульж, дайран орвол Шар махчин гэнэт дайруулсандаа хоромхон зуур сочин сандарснаа жад, сvх, бороохойгоо далайцгаан , дайсантай тулах гэж жагстал, Мазаалай шуугин орж, нэг том шар махчны хэнхдэг жадлан унагаад, сvхээ далайн бас нэг махчинтай авалцтал , хажуунаас эь нэг сагсгар Шар махчин Мазаалайг дайрсанд Залуудай хашгиран цавчмагц, эгмийг тас цавчиж, тэр махчныг унагаав. Их тvвдэг тойрон тулалдагсад урхиран хашгиран хашгиралдаж, сvх жад тачигнан, иш хугарах, ёйлох, урайлах дуу маш сvртэй бөгөөд гал тойрон сvвдэр жирэлзэн, нvдээ улаанаар эргvвлэн, амаа ангайн , урхиран хvрхэрч, байлдах эрцvвлийн дуу хаданд цуурайлан, жигтэйхэн юм боллоо. Шар махчин цочмог дайруулсан боловч, сvрхий тулж, гэнэт дайрсан дайсны

тоо амьд влдсэн тэднээс нэг их илвүгйг вээд, бвр ч дошгирон тулалдаж, Мазаалайн дvvгvрийн чулуунд шилэн хvзvvгээ цохиулан унасан том Шар махчин, ухаан сэхээ ороод, бянтай гараараа Залуудайн сvхний ишээс шаравтал нь шvvртэл, гэнэт хадан хонгилын зvгээс шурдхийх чимээ гарч, тэр том шар махчны суганд вvvртэй шувууны өдтэй, нэг урт нарийн юм бараг тэр өдөндөө тултал шигдэн орж, нөгөө вvvр нь бөөрөөр нь чулуун вvvрээ цухуйлгав. Шар махчин алдлан ойчиж, Залуудай тэр сум шуугин ирсэн зvг харваас эцэг нь хонгилын зvгээс нэг матгар мод татан, өдтэй урт нарийн бяцхан жад шиг юмаар дайсныг холоос унаган айсуй. Махчин ч гэсэн Чонос ч гэсэн тэр вес нум сум вээгvй тул холоос харваж байгаа Шонхолойн зvг дайрсан гурван махчин төдхөн харвуулан ойчоод, тоо нь цөөрсөн боловч тулах зориг нь мохсонгvй. Үхэх нь зайлшгvй болсноо мэдээд, улам ч ширvvлэн тулалдав. Чоносын хvч давуу болсон тул Шар махчин зугтаан зайлах аргагvй нэг нэг чоностой тулалдан, зарим шар махчныг хошоод хошоод Чонос ээрэн байлдаж, Шар махчин зугтан зайлж чадахгvй, гагцхvv амиа сул өгөлгvй, нэг дайсныг дэрлэн унах юмсан гэж улайран тулжээ. Мазаалай нvvр хэнхдэг нь дайсны улаан цус болж, гуяа сvхэнд халт цавчуулавч, шархаа огт тоохгvй, зvс царай нь учиргvй сvртэй болоод нэг бvдvvн махчинтай гардан ноцолдож, Залуудай нэг балтгар Шар махчинтай сvхдэлцэж, бяраар тэр балтгар илvv боловч Залуудайн сvхийн иш арай урт, махчны сvхийн иш арай богино тул тэнцvv тулалдаж байтлаа Мазаалайн эсэргvvцэл, махчин санамсаргvй Залуудайд ойртсон тул сvхээр ширвэн, тэр махчны хөлийн булчин тас цохисонд, Мазаалай дайснаа даран, ойчингуут Залуудайн эсэргvvцэл махчны борвиос шvvрэн унагасанд Залуудай дайснаа цохин даржээ. Тулалдаанд хэн дийлж, хэн дийлдэх нь илэрхий болсон боловч Шар махчны амьд влдсэн хэдэн нь галзуу догшин болсон юм шиг урхиран байлдаж, галын гэрэлд шуухинан амьсгаадаж, сөөнгө хоолойгоор хашгиралдан, жад, сvх, мөргөлдөх цавчилдах чимээ vргэлжилж, унасан нэг нь цус нөжөө цувруулан тэсгэлгvй хорссондоо Чонос эрцvvлийн хөлий нь гартаа дайралдсан мод чулуугаар цохиулж байв. Шонхолой хэдэн сумаа унасан дайсны биеэс суга татан тvvж аваад, тулалдаж байгаа махчныг харван унагаж, эхэлсэнд Мазаалайн том сvх лvс лvс бууж, Чонос дайчны байлдааны уриа улам чангаар дуурьсаж, удалгvй сvvлчийн Шар махчин, Ихэрэс Бухын сvхэнд толгойгоо хага цохиулан ойчлоо. Дайсан дарагдаж гагцхvv хvнд шарх олж, газар унасан хэдэн Шар махчин амьд влдсэнийг тулалдаанд халж хорссон эрцvvл цохин алж гvйцээд, хагас цагийн өмнөхөн их тvvдгийн дэргэд хэвтэх нь хэвтэж, суух нь сууж байсан Шар махчин цөм алагджээ. Дайснаа дарсан Чонос, Шонхолойг амьд гарсанд нь баярлацгаан, цус нөж болсон Шар махчны хvvрийг тvvдгээс баахан зайдуу нэг газар чирч аваачаад, зэр зэмсэгээс нь бvтэн влдсэн сvх бороохой, жадны нь зарим нь галын дэргэд хурааж, зарим нэг нь шарх олсон нөхдөө сувилж, Чонос дайчны вхсэн хvнийг бvртгэвээс хоёр хvн амь алдаж, нэг хvн маш хvнд шарх олжээ. Поодой бөө шарх ологсодыг сувилж, аман дотроо юм шивнэн, нэг уутан дотроос эмийн навч vдэш амжиж тvvснээ гаргаж, шарх нь дээр нь тавин, өвс жийрэглэж, нэг Шар махчны сармай дээлийг зvсэж ороов. Тулалдаанд халсан эрцvvл дэргэдэх нэг горхины усаар нvvр гараа угааж сэрvvцээд, тvvдэгт тvlээ нэмж, гал тойрон сууцгаагаад Шар махчны идэж бараагvй, тураг гөрөөсний махнаас эвдэж шарцгаан, дайсны биеэс хураасан сав саалийн дунд хэдэн гавал аяга байсныг сонирхон вztэл, Поодой нэг тос шингэж, шарласан гавал аягыг гартаа эргvvлж, гадна дотроос нь ажигрлан вээд,

- Тэр жилийн намар манай өрх айлыг Шар махчинд идэгдэхэд дайсанд автагдсан манай авгын толгойгоор хийсэн аяга байна. Хөмсгөн дээрээ шархтай хvн байсан юм. Тэр шархны сорви энэ байна гэж сэтгэл хөдлөн дуугарав. Шонхолой тэр гавал аягы нь Поодойгоос аваад
- Нээрээ , Тэх авгайн толгойгоор хийсэн аяга байна шvв. сорвиний нь ором ёсоороо байна. Одоо ч хөөрхий Тэх авгайн өшөө авлаа даа бид гээд тэр аягыг Поодойд эргvвлж өгөв.
- Одоо, яахав гэж Залуудайн асуухад, Дайсны зvрх сугалж, Тэх авгайн хорслыг тайлан өргөөд, Буурал ав, ээж сахиусаа тайх сав болгоно гэж цахиур хутгаа барин дайсны хvвр тавьсан газар очоод, баахан удасхийж, цус болсон гавал аягаа бариад эргэж ирэхдээ
- Нэг муужиртал цохиулсан Шар махчин ухаан ороод, мөлхөн зайлжээ. Та нар мэдсэн байтал гаргаж битгий тэр амьтанд сэжиг авхуул. Галаа тойрсон хэвээрээ сууцгаа. Нэг бодвол Шар махчны өвгөд, эмс эндээс асар холгvй байж магад. Гурван хvн сэмхэн мөрөөр нь мөлхөж, гэтээд чухам хаа хvрдгий нь мэдээд ирвэл таарна. Саяны тулааны дуу чимээ арай хvрэхгvй газар бас нэг отог Шар махчин байж магадгvй юм байна. Хэн гурав явах вэ? гэхэд Шонхолой би явъя гэв. Залуудай бас би автайгаа явъя гэхэд Поодой бөө
- За тэгвэл бид гурав тvлш дөхvвлэх байдал vзvвлж , нэг нэг тэвэр гишvв авцарсан болоод тэр Шар махчны хойноос мөрдөө. Тэр лав биднийг яадаг бол гэж ажиглаж байгаа байх гээд гурвуул шугуйд орж, нэг нэг тэвэр гишvв авцраад, дахин шугуйд тvлш тvvx дvрэм vзvвлэн , сэм өнөөх дутаасан Шар махчны мөрөөр мөшгөн, одвоос удалгvй харанхуйд хуурай мөчир тас тасхийж, хvн алхах чимээ гарч, Шар махчны нялуун vнэр мэдэгдэв. Залуудай vнэрий нь авмагц , урт гартай, богинохон хөлтэй, бvх биеэр нь шар vс ургасан ёнхойсон Шар махчинтай саяхан тулалдсан нь санаанд нь орж, дайралдсан дайснаа иддэг заншилтай тэр омогтныг дотроо дургvйцдэг боловч саяын байлдаанд анх удаа өөртэйгөө адил хvн дvрстэй амьтныг алалцсан нь сэтгэлд их л эвгvй. Анх гөрөөс алснаас нь бvр аягvй санагдаж, нvдэнд нь тугаарын vхсэн Шар махчингуудын цус нөж болсон амь тавих вес мэсийн яр, бэрд зовон , муухай ярвайсан царай нь vзэгдэх мэт, ойн харанхуйд тов тодхон , шөнийн тvмэн хард ив илхэн, нvд анивч харагдаад эцгийн хойноос дэмий л алхаж явахад нь эцэг нь хvвгийн санааг тааж, гараас нь атгаад,
- Хатуужиж яв аа хvв минь гэхэд дотор онгойж зориг орох шиг боллоо. Чингээд өнөөх шарван найгаж, хааяа амсхийн зогсож, аяархан гэлдэрч яваа, тэр амьтны хойноос vнэрээ авхуулахгvй гэтэн дагаж явтал гэнэт нэг юм тэр Шар махчныг дvвлэн дайрч амь алдан муухай ёолох дуу гараад, газар хvнд юм пидхийж ойчих чимээ гарав. Чингээд, харанхуйд хоёр том ногоон гал харагдах шиг болсонд
- Хутган соёот бар гэж Залуудайн ав нь шивнээд, бvгдээрээ зогсож, яахыг ч шийдээгvй байтал сvртэй урхирах дуу гарч, сvвлээрээ пид пад гуядах анир гарсанд, Шонхолой, Поодой хоёр Залуудайг урдаа гарган, яаран ухарч маш болгоомжлон буцав. Тэр аюулт араатан, хvний зайлсан чимээ сонсоод олзоо харамлахаа байжээ. Шар махчны хойноос дагасан гурван хvн одоо горьгvй боллоо гэж гал тvвдэг дээрээ хvрэх гэж анир чимээгvй яаран алхалсаар хvрвэл галын гэрэл холоос харагдаж, өнөөх Шар махчны хvвр тавьсан газраас ойн араатны нvд ногоон гал шиг гялалзан архиран, урхиран хvвр зулгаах чимээ дуулдаж, хvн ойртож дуу гарахад, галын тэнд

сууж байсан хvн хариу чимээ өгч, өөдөөс нь тосон ирсэнд хvвр дээр овооролдсон чоно, нохой, чононцор, цөөвөр их л дургvй архиран зайлж өглөө. Шар махчны нэхvвл хийсэн манай гурван хvн мөрөөр нь мөшгөж яваад, хутган шvдтэд бариулж орхихыг нь vзсэнээ ярьж, бvгдээрээ тvвдэг тойрон суугаад, одоо яахыг зөвлөн хэлэлцлээ.

- Маргаашийн өглөөний өөд улаан нар гартал, эндээ галаа тvлээд хоноё гэж Мазаалай санал гаргав. Манай Шонхолойг барих гэж овооролдсон Шар махчингаас нэг нь ч амь гарсангvй. Хамгийн сvвлчийнх нь хутгган соёотын аманд орж саллаа. Бусдыг нь идэж байгаа энэ араатан нэг ёсондоо бидний манаа догшин араатан буюу Шөр махчин ирвэл бидэнд дохио өгнө. Идэх улай байгаа цагт бидэнд бас халдахгvй. Галаа сахих нэг хvн vлдээгээд унтаж амрая. Харанхуйд хаа явах вэ? Гэхэд нь бvгдээрээ зөв гэж нэг манаа гаргаж цөм унтацгаажээ. Чоносын дайчин эрс vврийн шөнө шувтарч, уул завсарлах вес сэрвээс, ойн агаар маш сэрvvн чийгтэй. Шөнө ээлжлэн манаж байсан хvн, нөхдийнхөө сэрцгээсэнийг vзээд, галдаа тvлээ нэмсэн нь, босоод галын дэргэд дулаацан суух нь Залуудайд жигтэй сайхан санагдлаа. Шар махчны хvвр чирч урж шөнө тавьсан газрын зvг харваас, юу ч vзэгдэхгvй. Бас шөнө нойр дунд архирах, уралдах, юм химлэх, зулгаах чимээ гарч байсан нь дуулдахгvй болжээ. Мазаалай тэр газры нь эргэж vзээд,

- Урд шөнийн Шар махчингаас vнэг шинших яс, vхэр шинших сэвгvй боллоо. Галаа манадаг ваар савы нь буцах замдаа усанд хая. Тэгвэл, хойноос нь энд ирэх махчин чтvрvvчийнхээ хvнийг хаа очсоны нь мэдэхгvй болно гээд, тvвдэг галын захад байсан нэг бургасан сvлжээтэй vнстэй шавар ваар заасанд Залуудай

- Шар махчингууд цахиур хавирч гал асаадаггvй юм уу? гэж гайхан асуулаа.

- Үгvй, цахиур хэрэглэх аргы нь олоогvй, явсан газраа шавар вааранд гал манаад авч явдаг юм. Ганцаараан ч холддоггvй бөөн бөөнөөрөө явдаг амьтан. Зарим цагт эмэгтэйчvvд, хvvхэд багацуул, настангууд нь нэг бөөн, чийрэг эрцvвл нь нэг бөөн явдаг ч цаг бий. Чадал нь олноороо явдагт нь байгаа юм. Эмс нь эрцvвлигээ бараадасхийж бvлэг цvлгээр явдаг заншилтай. Бие биеэ иддэггvй. Бусад хоёр хөлтөн амьтныг хэнийг ч хамаагvй, дийлбэл иддэг муухай улс гэж Ихэрэс Бух өвгөн, Залуудайд хариулав. Энэ бидэнд хядуулсан Шар махчны эмс хvvхэд нь эндээс асар холгvй яваа байх. Биднийг тэдэнтэй тулсныг арай мэдээгvй байх. Ан гөрөө хийж яваа л гэж бодож байгаа байх. Энэ горхины ус уруудан буцъя. Тэгвэл усан дотор бидний ор мөр vлдэхгvй. Шар махчин ч энд биднийг тэдний нэг хэсгийг vгvй хийснийг мэдэхгvй болно гэж Поодой бөө санал гаргав. Чингээд, шөнийн тулалдаанд шархатсан нөхдөө тvшилцэн, Чоносын дайчин эрсийн бяцхан баг хvмvvс, горхины усанд орж уруудан нилээд яваад голд хvрч, тэндээс уруудан онгоцоо бургасан дунд сойсон газар амсхийгээд өрх гэрийн зvг чиглэв.

Онгоцоороо гол гатлаад, өрх гэрийнхээ зvг алхаж явахад Залуудай хvvд их л сайхан санагдаж, Поодой бөө, Мазаалай хоёрын дунд алхаж, тэдэнтэй юм ярилцаж яваа эцгийнхээ чийрэг биеийг араас нв харахдаа, олон ахын хамт авыгаа Шар махчин дайсны гараас салгаж авсан, байлдан тулснаа санан, одоо ч би эрийн насанд хvрлээ гэж бодож явлаа. Шонхолой ав нь гэдэргээ хvvгийнхээ зvг нэг эргэж хараад, магнай тэнийн, ахмад нөхдийнхөө дунд мөр зэрэгцэн алхаж яваа хvvгээ энхэрлэн мишээж, гараа сунган дэргэдээ ойртуулаад,

- Эцэг хvн, ийм хvvтэй байхад зvгээр биз. Мазаалай? Гэж багаасаа сvрхий верхдэг нөхөртөө баярлан өгvvлэв.

- Манай Чоносын нэг сайн эр болноо гэж мазаалай хvнгэнэн дуугарав. Чингээд, чийрэг гараа сунган манай өрх айл хэвээрээ байгаа биз? Ганц Оодой дархны гэр нь саяны миний хэлсэн хирисийн хөлд цөмрөөд, засаж амжилгвй, бид чинийхээ хойноос өчигдөр одсон билээ. Одоо л өвгөн дархныхаа өрхий нь засаж өгнө дөө гэхэд Залуудай,

- Одоо бид, яг л тэр хирисийн довтолсон газраар явж байна. Тэрvvхэнд намайг дайрч унагаад, Туулайхvvг тэнд гишгэж орхисон юм. Мангина эмгэн тэнд дайруулсан юм гэж , өвс шороо нь нөжинд харласан газар зааж, тэр хирист дайруулсан өглөөний явдал сэтгэлд нь ургав. Поодой бөө, Залуудайн царайг ажиглан,

- Хvv минь, чи сэтгэлээ дарж яв. Үзсэн харсан юмандаа сэтгэл чинь хэт догдолбол муу шvv. Би чам шиг байхдаа айсан баярласан юмаа мартдагвй, санах бvр сэтгэлд ургаад, хожим зvvдэлдэг болсон . Зvvдлээд өрхөөсөө гарч уулаар хэсэж явдаг болсоон. Яаж тэгж яваад догшин араатанд идvvлчихээгvйгээ одоо гайхдаг. Нэг шөнө модон дээр гарчихаад, дор минь хээрийн зэрлэг нохой улилдаж байсан. Хожим унадаг болсон. Тэгээд нэг унаад ухаан орж өгөхгvйд, манай ав Хэрээдийн Хэрээ удган залж, намайг бөө болгосон гэдэг. Тэрнээс хойш унах минь зогсоод, шинийн есөн, дундын есөн, хуучны есөнд л нэг их бөөлдөг боллоо. Чи бас унадаг дусдаг болж очих бий гэхэд нь,

- Үгvй, би унах ч vгvй, дусах ч vгvй. Бөө ч болохгvй, Мазаалай авгын хэлсэн ёсоор Чоносын нэг сайн эр болно гэж инээв. Чингэтэл, дэнжийн өрхvvдийн эмэгтэйчvvд Оодой өвгөн тэргvvлэн, бvгдээрээ дайчин эрсийн бяцхан багийг тоо бvрэн буцаж ирснийг баярлан vзэж, бахдан угтлаа. Эрэгтэй, эмэгтэй, хvvхэд багацуул цөм баярлалдавч жаргасан зовсон байдлаа ил гаргах заншил vгvй тул, амь мэнд , бvтэн бvрэн буцаж ирхийг vl мэдэх аянд одсон хvv, нөхөр, ах нараа угтан тосож, эцэг, эх, vр эхнэртэйгээ уулзаж байгаа тэдгээр хvmvvсийн байдлыг өрнө зvгийн хvн харвал, гадагшаа тvр зугаацахаар гараад ирсэн хvн уулзаж байна гэж бодмоор айван тайван боловч, гагцхvv нvдэнд баярын шинж тодорсон байдлыг ажиглагсад, голын захад загачлаад ирсэн улс биш, хэцvv шиг юманд яваад, олзтой омогтой буцаж ирсэн юм байх гэмээр байдал илэрхий ажээ. Шонхолой Булжуухай эхдээ баруун хацраа vнэсvvлээд, ээжийнхээ баруун гары нь илж, эхнэр Хойлгийнхоо гары нь барин илж, баярлан инээмсэглэсэнд , хойлог нөхрийнхөө аяншиж зvдэрсэн царайд баярын инээмсэглэл тодорсонд сэтгэл зvрх дvvрэн баясгалан төрж, нөхрийнхөө шөрмөслөг чанга гарыг аяархан хариу илж, нөхрийнхөө хvрэн улаан царайг дахин vзэж баярласнаа тvvгээр илэрхийллээ. Тэгээд Залуудайгаа хацры нь илжээ. Ноход , Шонхолойг таньж , ялангуяа нэг хөгшин гичий баярлан гийнаж, элэг өөд нь асан нvvрий нь долоох гэж эрхлэхэд, толгойгий нь илээд

- Хөөрхий , энэ Марал намайг мартаагvй байна шvv гэхэд нь тэр гичий, нэрээ дуулаад, бvр ч баярлан, нар зөв тойрон, всрэн дэвхчиж, нэг цаашаа давхин, нэг өөдөөс нь давхиж эрхэллээ. Эмэгтэйчvvд гадаа задгай гал тvлж, загас чанах нь загас чанаж, хирисийн мах чанах нь хирисийн мах чанаж, шарах нь шарж, хоол унд хийж гарав. Эрэгтэйчvvд , Поодойн хирист цөм гишгvvлсэн өрх гэрийг очин vзэж, хоолны сvvлээр засахаар хэлэлцлээ. Өрхийн эмэгтэйчvvд, аль хэдийн шинэ багана, сургааг, унь, гишгvvрийн мод, хар модны долон холтос авчирч гvйцээд байсан юм байж. Өрхийн доторхийг бас цэвэрлэж амжсан ажээ. Балар эртний хvн, хоол олдвол, идэхдээ сайн, эс олдвол өл даахдаа сайн тул, элбэг хоолтой ve дайралдсан цаг

асанж, бас хэдэн жил алга болоод нэг хvн нь буцаж ирсэн асанж. Булжуухай эмгэн тэргvвлэн, аль сайн хоол хийж, бvгдээрээ наранд сууцгаан , хоолоо маш амтархан идэцгээжээ. Чингээд, хоолны сvвлээр өрх айлын эрэгтэй эмэгтэй цөм Шонхолойн хавчаахай нум сумыг их л гайхан сонирхоцгоож, хvний чулуудах дvвгvврдэж хvрэмгvй газар юм онон тусаж байх ийм сонин сайхан зэмсэг байх гэж бас байдаг юмаа? Гэж найхан тагнажээ.

- Манай энд ийм сvрхий зэмсэг хийж болдог билvv? Манайхны хэн ч гэсэн, энэ зэмсэг хэрэглэж болдог болов уу? Ойр хавьд ийм зэмсэгтэй омог байна уу? гэж бvстэй бvсгvй цөм их л сонирхож, Шонхолойн харвахы нь тун ч таашаан харцгааж, ийм зэмсэг одоо манай Чонос өрхийн эрэгтэйчvвд цөм хийн хэрэглэх болно гэхэд нь , араатан дайснаас амиа хаацайлж, ан агнахад хөл хурдсаж, гар уртассан шиг сонин сайхан зэмсэгтэй боллоо гэж баяр хөөр болцгоожээ. Амьтан хvний гар хөл нь хөнгөн болж, бvгдээрээ Оодой дархны өрхийг сэлбэн засаж гарлаа. Хугарсан баганыг шинэтгэж зоогоод, газар шалы нь чигжээд, дөрвөн багана дээр дөрвөлжин тооно тавьж, дөрвөн талаас нь сургааг унь тvшvвлэн тогтоогоод, өрх дотор орох гарах гишгvврт модны доод vзvврий нь газар бөхлөн тогтоож дээд vзvврий нь дөрвөлжин тоонын зvнн урд булан хавьд хөдлөхгvйгээр авалцуулаад, хар модны шинэ долон холтсоор өрхийн дөрвөн талыг бvтээж, ширэг зузаалан тавьж өнгөлөөд, өрх дотор нь хоймор талд өнөөх гайтай хирисийн сахлаг vстэй шириийг чулуун сvхээр цавчиж, Оодой өвгөнд дулаахан зөөлөн гудас хийсэнд , өвгөн их л баярлан, хоёр эврээр нь анчиндаа жадны гилбэр, шинэ зэвсэг хавчаахай нумын суманд хэрэглэх зэв хийж өгнө гэж амлажээ. Нар жаргахаас өмнө Оодой дархны өрх нь шив шинэхэн болж, Чоносын бяцхан суурин өрхийнхөн, өвгөний өрх шинэтгэсэн баяр , Шонхолойн буцаж ирсэн баяр хосолж, идээ хоол элбэгтэйн учир бас найр хийжээ. Эмэгтэйчvвд , Булжуухайн удирдлагаар сараана, мангина, гоньдтой холин амт оруулсан загас хирисийн махаар аль амттай гэдэг хоолоо хийж, сулхирын гурил хирисийн өөхийн тосонд багсарч, шавар модон тэвшээр овоолон хоол, гадаа зvлгэн дээр тавьцгааж, бэлтгээд, бvгдээрээ тойрон сууж, идэн цэнгэжээ. Хирист мөргvвлж бэртсэн эмэгтэй Пянтуугийн бие чийрэг тул, хvнээр тvшvвлэн ирээд, олны дунд сууж тэр элбэг хоол идэх цэнгэлд оролцон, ямар ч эрvвл хvнээс дутуугvй идэлцэж суув. Ан амьтан, хvний оршин суудаг газраас зайлдаг тул, Чонос омгийн бяцхан суурин өрхийн хавьд ер огтоно зурмаас өөр зэрлэг амьтан байхгvй. Элдэв гөрөөс араатан чөрх айлын хавьд vзэгдэхгvй болсоор удаж, урин дулааны цаг санаа амар суудаг ажээ. Гагцхvв саяын хирис, огт санамсаргvй vзэгдэж вймvвлсэн ажээ. Өмнөх голыг зун цаг бас араатан гаталж ирдэггvй, зэлvвд бөглvv, айван тайван нутаг ажээ. Чингээд, тэр орой Чоносын өрх айлынхан санаа амар, сав дvврэн, vдэш дулаан. Гадаагаа бvгдээрээ зvлгэн дээр сууцгааж, Шонхолойг хаа явж, сонин юу vзсэнээ ярьж өгнө vv гэж тойрон суужээ. Садан олонтойгоо дахин нvвр золгосондоо ихэд баярласан Шонхолой дуртай, олны хvслийг дагаж, vзэж өнгөрvвлсэн юмаа ярьсан нь :

- Голын зvнн урдах Эзэн толгойн аманд Оодой ахын өрх сууриныг Шар махчин дайран идэхэд би бороохойгоор цохиулаад, ухаан алдчихсан билээ. Хичнээн болтол хэвтсэнээ бvv мэд. Нэг мэдэхнээ, хоёр гар хvлээстэй хэвтэж байлаа. Сэм ажиж харвал Оодой өвгөн чvзэгдэхгvй, манайхны хэдэн хvн ч vзэгдэхгvй Шар махчингууд л өрх сууриныг эзлээд, хvний мах идэн жаргаж суух нь харагджээ. Таньдаг хvнийхээ толгойгий нь сvхээр хага цохиулж, тархий нь идvвлж байхыг харахад эвгvйг хэлэх

vv? Гэхэд сонсогчид махчныг их л зэввүрхэн шуугилдав.

- Хvний махаар найрлаж цадаад, vхсэн махчнаа Эзэн толгойн энгэрт амы нь хvний өөхөөр тостоод тавьж, олзны хэдэн хvнийг, идэж бараагvй мах vврvвлэн туугаад явахад, би ч бас , гар хвлээстэй, хvний өрөөл мах ачаастай туугдлаа шvv.

- Их уул давж, хоёр хоног яваад, бас нэг бвлэг махчинтай нийлж, найр хийхэд , олзны хоёр залуу алуулж, махчинд идvвллээ. Их уулын модон дундуур явахад, Шар махчингууд модонд ургадаг улаан цоохор мөөг их тvvж, нөгөө бвлэг махчинтай найрлахдаа тэр цоохор мөөгнөөсөө идэж, жигтэйхэн согтжээ.

- Согтохдоо яадаг байж вэ? гэж Поодойн сонирхон асуухад, согтохдоо vг их олонтой сайхан зантай болоод, царай зvс нь улаан зээрд болдог юм билээ. Босоод явахдаа шарваж туйвдаг тийм болчихдог юм билээ. Тэр шөнөдөө согтоод, их бөх унтсанд нь би амьд влдсэн хэдэн шарнуудынхаа хвлээсий нь тайлаад, цөмөөрөө орголоо. Оргож яваад vврээр алмаст баригдчихлаа. Унд хоол муутай яваад, хол зугтааж чадсангvй. Дороо гvйцэгдлээ. Зэр зэмсэгvй оргож гарсан болохоор улаан гараар тулаад дийлсэнгvй, баригдлаа. Алмас гэдэг сонин амьтан юм байна. Зарим отгийн эм алмас эь жнддаа бвлэглэн нийлээд явдаг юм байна. Бид тийм нэгэн бвлэг эм алмаст баригрдаж орхилоо. Хор хийхгvй боловч, биднийг бас тавих дургvй дагуулаад урагшаа их цөлийн зvг явжээ. Хэл мэдэхгvй, буйлахаас өөр дуу гарч чадахгvй. Гал гэж мэдэхгvй. Унхтахдаа, биднийг дундаа хавчаад унтдаг, хөдөлбөл сэрчихдэг. Гурав хонохын даваан дээр Шар махчинд хөөгдөөд, сарын гэрэлд шөнөжин дутааж, vврийн гэгээ шарлахад нэг их уулын ам өгсөж, орой дээр нь гармагц, бөөн алмас дээр орж ирлээ. Манай алмасуудын сандарсан байдлаар тэр уулын алмас, дайсан биднийг хөөснийг мэдээд, шуугилдаж, чулуу мод шvvрэн тулахаар шийдсэн бололтой. Манай хойноос хөөж яваа Шар махчны барааг хараад, дайсан гэж таньсан шинжтэй, шар vс нь сөхийж, урхирцгаан, адуун чулууны ард нуугдацгаан, дайсны ойртохыг амдан тослоо. Би ч хэдэн шарнуудтайгаа бас нэг нэг мод бариад , алмастайгаа нийлж, Шар махчинтай тулахаар шийдлээ. Бидний хойноос хөөсөн Шар махчин амаад гараад ирэхийн хамт, алмасууд урхиран дайрч, том том чулуугаар чулуудлаа. Хэдэн махчин тэдний чулуунд цохиулж уналаа. Алмас баярлаж, дайран ороод, махчинтай ноцолдлоо. Манай шарнууд ч зоригжиж , бороохойгоороо цохилон орлоо. Цочмог дайруулсан махчин, хэдэн хvнээ хороолгоод , ухирч алмас гардан тулахдаа их бяртай, шарх даахдаа сvрхий тул, ноцолдлоо. Алмас эмс ч мөн бяртай зоригтой байж, том том чулуу шидлэн, сvрхий туллаа. Шарнуудын маань хоёр хvн, нэг том махчинтай тулаад, , жаданд нь чичvvлж унаад доошоо чирvвллээ. Хойноос нь би хэдэн алмастай гvйж, мөрөө жадлуулаад ойчиж , одоо л хвлээ гэж бодсон. Алмас олон байсан төлөөдөө амь гарч, махчин уруудан дутаалаа. Тэгтэл алмас эргэж ирээд, намайг vврэн, бас нэг шархтсан шарнуудыг тvшин, уулынхаа орой дээр гарлаа. Тэндээс алмастайгаа хамт , навч шарлаж, намар болтол явлаа. Амьд влдсэн ганц шарнууд маань , шарх нь эдгэрэвч, бие нь муудаад шар навчнаар нас элэгдээд би ганцаараа алмасын дунд влдлээ. Тэднээ орхиод явах гэхэд , надаас салдаггvй. Шөнө болоход би цахиур хавирч гал тvлдэг. Тэд маань гал тvлж чадахгvй. Дулаацахыг л мэддэг. Дагасан алмасаа цохиж унагаад оргох гэхэд, бас аминд минь орсон амьтныг алах нь бас тусгvй шиг санагдаад, салъя гэхэд тавихгvй бас хэцvv. Тэгэж байтал, намар их цөлд нэг хэсэг сvхтэй жадтай гөрөөчинтэй дайралдаад, алмас маань зугатааж , би юу ч болсон өөртэйгөө төстэй хvнтэй нийлж vзнэ гэж

зугатаалгвй хоцроод, тэдэнд баригдлаа.

- Достум, гелъ мандаа гээд, тэдний тэргүүлэгч нэг хвдэр эр, намайг алмаст олзлуулсан хвн гэж сүрхий найрсаг байлаа. Хэл сайн мэдэлцэхгвйд, хоорондоо шулганалдаад, нэг хижээлхэн анчин, харин манай вг бага зэрэг мэддэг байж, намайг баарин уу? гэж асууж. Биш, Чонос гэхэд, танайхантай вг нэгтэй баарин омогтон бидэнтэй найртайсайн байдаг. Тэдэнд чамайг хвргэнэ гэж биеэ Теке омогтон гэлээ. Тэдэнтэй явах болж, хамт өвөлжөөд, хавар тийшээ нэг хэсэг Теке гөрөөчнийг дагаж, Баарины газар хврлээ. Нээрээ ч манайхантай вг төстэй омгийн улс байлаа. Тэндээс хорчин омгийн газар хврлээ. Бас л манайхантай вг нийлдэг омогтон. Тэдний хэрэглэдэг зэмсэг нь миний энэ нум даа. Нангиа гэдэг омгийнхонтой арилжаа хийдэг улс байж, тэр хорчин нутгаас Нангиа омгийн газар хврэлцэж, энэ Ихэрэс Бух ахтай дайралдан танилцлаа. Хойд звг, Бай-кул- баян нуур гэдэг их усны хөвөө нутагтай гэж, хөл газраас Нангиа омгийн гавар хэл нэгтэйгээ хвнтэйгээ дайралдаж, газрын холыг вээж, сонсоогвй юмаа сонсож, вэээгвй юмаа вээж ирлээ дээ .

- Нангиа омогтон чулууны эзэн юм байна. Тэдний урчуулаас их юм сурч ирлээ. Тэгээд, хоёулаа ууган нутагтаа буцах гэж хэлцээд, алсын замд зорьж бэрхийг туулсаар, өрх омгийнхоо олон та бвхэн дээр мэнд хврч ирлээ. Ганц ганцаараа бол, ийм хол аянд бэрх аюул давж ирэхийг санашгвй хэрэг. Бие биеэндээ туслалцаж, нэг нь нэгэндээ твшиг болж явсны ачаар л бас та бвгдийн тэнхрүүлсний ачаар махчны аманд оролгвй гэртээ эсэн мэнд ирлээ дээ. Хорчноос нум хэрэглэн харвах арга сурснаа та бвхэнд зааж өгнө. Нангиа нараас чулуу засаж өнгөлөх арга сурснаас бас Оодой дархан ахдаа вэвүлж өгнө. Чонос омогтоо хэрэгтэй юм энэ хэдэн жил олзлогдон, баригдан явахдаа сурч ирлээ. Дэлхий юутай уудам олон омгийн хвн юутай сонин бэ? гээд, нвдэн өмнө нь вээж өнгөрүүлсэн твмэн сонин юм вээгдэх адил нвдээ анисхийн чимээгвй боллоо.

- Шонхолойнхоо сурч ирсэн сонин юмы нь бид хийж сураад, халдах дайсан, аюцлт араатнаас айхгвй, чадал ихтэй аж төрөх сайтай болох маань болтугай даа гэж Оодой өвгөн Шонхолойн яриаг бахдан дуугарч, за одоо вдшийн сэрвү татлаа. Твүдэг галын твлээ твлш, хвүхээд, твүж бэлтгэ гэхэд, залуу эмэгтэйчвүд твлээнд явлаа.

Шонхолой, алс газар сурч ирсэн сонин юмнаас нум сум хэрэглэх арга Чоносуудтаа зааж, Хорчин омогтон энэ модон двүгвүрээ нум гэдэг юм. Нумаа харвадаг бяцхан жадыг хор гэж нэрлэдэг юм билээ. Бас зарим нь годоль гэж ч хэлдэг юм ыилээ гэж сумын байдлыг танилцуулан, нэг вэвүрт нь зэв гэж чулуу буюу ясаар хурц ирт юм хийдэг юм . Нөгөө вэвүрт нь нумын хөвчинд годлио тогтоохоор они гэж хөвч зуух ам гаргаад, онины хавьд нь шувууны өдөөр өдөлдөг юм. Тэгвэл, харавсан хор гэдэг годоль нисэхдээ шарвахгвй, эгцээрээ шуугин очиж харван шаана гэж, нум сум хийхийг зааж, Оодой өвгөн, Поодой бөө, Залуудай, Мазаалай нум дархлаж, ойн олон модноос онцгой шулуун сүхээрээ тайран засаж, Шонхолойгоор заалган, бие биедээ таарсан нум хийж, нумынхаа хэмжээнд тааруулсан гдлийн мод хатааж, Оодой өвгөн, өнөөх хирисийн эврээр сумын зэв хийжээ. Ихэрэс Бух өвгөн чулуугаар сумын зэв дархалж, заримы нь цахиур чулуун хасуураар галт уулын шил чулуу засаж, хожим бас ирмэгтэй том цахиур дөшийн тушаа хөндий шиг барьж байгаа, тун чадамгайгаар няцлан, ир ирмэгий нь засаж боловсруулсан нь, таатай гоё зэв

болжээ. Зарим зэвийг шар цахиур, улаан хврэн цахиур, ногоовтор маш хатуу хас тэнигэрээр хийсэн нь алсын замд тvvж авсан зарим чулууг хэрэглэж, зарим нэгэн чулуу нь Оодой дарханд байсан ажээ. Оодой дарханд ооны хvзvv байснаар хөвч хийж, Чонос омгийн өрх айлын анхны харваач нар, Шонхолойгоор заалган харваж сурцгаалаа. Хирисийн махыг урт нарийн зvсмээр наранд хатааж, анчны байрьсан тул, хилим, цурхайн зэрэг том загас бас давслан хатааж, хоол элбэгтэй байгаа учир эмэгтэйчvvд янз бvрийн төмс ногоо тvvж базаан, идэх юмаар тасалдаагvйн жавшаанд Чонос өрхийн эрэгтэйчvvд харвах сургууль өдөр бvр хийн сонирхож, холын харвалд Мазаалай, онолд Залуудай, дараа нь Паалиа орж, ясан булцуу хийсэн сумаар тулын арьсан бай өдөржин харавдаг байлаа. Чингээд нэгэн өглөө эртэлж Залуудай, Паалиа, Алцгар гурав хавчаахай нумаа хэдэн годольтой аваад голын зvг очжээ. Нэг тохойд галуу нугас олон байсныг ойртосхийн очоод гурвуул зэрэг харваж, нэг галуу хоёр нугас унагаж, тэр олзондоо омогшоод бас явсаар арваан галуу, нугас харваж, хvзvvгээр нь дурсаар холбоод, бургасан дундуур өрхийн зvг чиглэсхийн явтал, Алцгар гэнэт цочиж, нөхдvvдтээ уснаас гарч яваа нэг аварга могой заан, тэсгэлгvй эмээжээ. Хvний дайтай бvдvvн аварга могой голын уснаас гулдран гарч, өглөөний хvйтэн ус туулж, гарсан тул, царцуу юм шиг хөдлөх нь хөшvvн маш яаралгvй ажээ. Гурван залуу ерөөс тийм том могой байдаг гэж сонсохоос биш, бараагий нь ч урьд өмнө vзээгvй тул тэр муухай том амьтны гулдарч явахыг хараад, айдас нь хврэвч хvч хурды нь мэдэхгvй. Гагцхvv, бяцхан толгойтой, муухай хvйтэн харцтай нvдий нь бургас өвсний завсраар харахдаа, дотор нь аягvй болж, огт чимээ анир гаргалгvй, сэм эмээн ажиглаж байв. Тэгтэл, нэг бор гөрөөс өндөр өвсөн дотроос хөөрхөн толгойгоо цухуйлган, нарийн жимээр усны зvг салхинд гэнэт хvний vнэр авч сэжиглэн зогстол аварга могой агшин зуур ухасхийж, тэр бор гөрөөс рvv дайран орлоо. Шур хийх чимээгээр нь бор гөрөөс vсрэн дvvлтэл, аварга могой сvvлээрээ гөрөөсийг гавар буухаас өмнө цохин унагаж эвхрэн орооход, хөөрхий гөрөөсний яс нь шажигнан хэмхрэх чимээ дуулдаж, амин лугаа хагацах дуу нь гурван залуугийн чихэнд хангинав. Чингээд, аварга могой, амаа нэг ихээр ангайж нуруу хавиргы нь хуга ороосон гөрөөсийг толгойноос нь залгиж эхлэв. Залуудайн дотор тэрнийг хараад арзасхийж, урд дvvгvvрээр гөрөөс чулуудан унагаж алахыг ч vзсэн, чоно, цөөвөр, олон шарнуудын хөөж гөрөөс барихыг vзсэн боловч ийм жигшvvртэй муухай аварга могой, тийм хөөрхөн амьтныг дvvлэх хооронд нь сvvлээрээ цохиж унагаад, яс усы нь нажигнатал ороож алахыг vзээгvй тул, хөөрхий гөрөөсийг тэсгэлгvй өрөвдөж, өөрийн эрхгvй шилдэг годлио онилоод, гөрөөсний тэгэн дундуурыг залгиж амжсан аварга могойн хvйтэн харцтай муухай нvд рvv нь харваж орхилоо. Сайн шагайсандаа ч тэр билvv, азаар оносондоо ч тэр билvv, сум нь шав хийгээд, тэр аюулт аварга могойн нvд рvv ороод, шилэн хvзvvгээр нь цухуйжээ. Хэвлээр явагч тэр vлэмж биет амьтан, сvvлээрээ шуугитал шарваж, бургас хайлс хуга цохин том эрэн бие нь нэг эвхрэн зангирч, нэг задран тэнийхдээ ойр хавийн мод чулуу булгалж, сvртэй юм боллоо. Гурван залуус ухаа алдан сандарч дэмий л ухран зайлсхийж, аюун харваас, тэр аварга могой ийш тийш өнхрөн сvvлээрээ өвс мод саваhad нь их муухай vнэр ханхлан, толгой сvvл нь нийлэн, дээшээ дэгдэж, хажуу тийшээ савж өнхрөх нь маш сvртэй. Ойр хавийн усны шувуу тэр чимээгээр vргэж, нугас галуу, тогоруу, цахлайн сандран шуугилдах, ганганах дуу шуу гарч сvрхий юм боллоо. Аварга их могойн өнхөрч байсан газрын бургас мод ч хуга нуга

цохиулж, үндэс орвонгоороо сугарч нэг хэсэг шугуй, өвс ногоо, олон бодонгийн онгичсон буюу сүрэг арслан заан ухсан газар шиг боллоо. Эвхрэлдэн тарчилж байгаа тэр аварга могойг дахин харвах гэснээр, хаана нь ч харвахыг гайхан, бас сумаа эвдүүлнэ гэж хайрлан, дэмий л харж байтал, тэр том амьтны догшин хөдлөх нь намдасхийж, бие нь чичигнэх болсонд үхэж байгаа юм байна гэж сая л ухаараад, айж сандрах нь баахан гайгвй боллоо. Аварга могойн ангайсан амнаас гөрөөсний бөгс нь цухуйсан хэвээр, могойн эрвн нь зуурч, аюултай их хвчтэй сүүл нь мод чулуу ховх цохин ширвэх нь намдсаар, тэр аварга амьтны бүдүүн урт бие нь сунан, хөдлөхөө байж, гагцхүү сүүлийн үзүүр чичив таталдах боллоо. Залуудай зориг орж, хавчаахай нумандаа бас нэг сум онилон могойн элэг үрвн нь нэг харваад үзтэл, лүсхийгээд сум шаавч, могой хөдөлсөнгүй. ХОёр нөхөд нь бас зүрх орж нэг нэг харваад үзсэн, бас хөдөлсөн үгүй. Тэгэхэд нь маш болгоомжлон ойртож үзвээс үхжээ. Сүүлээс нь татаад үзэхэд хөдлөхгүй тул, холуур тойрч толгойн урдаас очиж харваас бор гөрөөс хагас залгисан том ам нь зуугаастай. Өрөөсөн нүдэнд нь шигдээстэй сумны онь хавиас аяархан барьж татваас, могойн толгой хөдлөхгүй боловч, сум тийм амархан сугарах шинжгүй тул, Залуудай зүрх орж бүснээс зүүсэн аавынхаа бэлэглэсэн хас тэнигэр сайхан сүхээр могойн толгойг тас цавчин, гөрөөс залгисан тэр чигээр нь салгаж аваад, гурвуул, модонд арай чүү гэж дамжлан, өрх гэрийн зүг маш баяртай чиглэв. Гурван залууг нугас галуу харваж, бас аварга могойг ганц сумаар алсанд их гайхацгааж, бүгдээрээ шахуу тэр могойг үзэхээр очлоо. Чулуун сүхээр хэсэг хэсэг цавчин эвдэж, идшиндээ нийлүүлэх гэж үүрэн авч ирж бөөн их баяр хөөр болцгоолоо. Амьтан халдашгүй аварга их могойг ганц хор годлиор алсан Залуудай маань сайн анчин эр болох юм байна гэж Оодой өвгөн эрхий хуруугий нт хирисийн өөхөөр түрхэж,

Омог олондоо түшиг
Олон нөхөртөө жишиг
Өрх олондоо тэргүүн
Өвгөд настандаа тулгуур
Алжаахыг үл мэдэх биетэй
Айхыг үл мэдэх зоригтой
Энэрэх сайхан сэтгэлтэй
Элбэрэлт сайн хүү болоорой
гэж ерөөжээ.

Ахас дээдсийн сургаал ерөөл бат оршиг гэж Залуудай хариу ёсны үг хэлээд, омгийнхоо олны баярласан царайг харахдаа, өөрөө бас цээж дүүрэн баярлав.

Чонос омгийн өрх сууринд Ихэрэс Бух өвгөн бие сэтгэл амарч, аян замын чилээ гараад, элбэг хоолонд тэнхэрч, нутаг усандаа буцах асан гэж алс хойд зүг, Бай кул гэдэг Баян нуур их усандаа хүрэх хүсэлтэй болжээ. Сэрүүн хүйтэн улирал өдөр ирэх тусам ойртож байгаа тул, урин дулаан байгаа цагт алсыг зорин явсуу. Хойшоо чиглэсэн их ус дагавал, давдуу Бай кул их нуурт цутган орох мөрөн гол дагаж, нутгаа хүрнэ гэж ярьдаг болжээ. Хамт холхи Нангиа газраас бэрхийг туулан давалцаж ирсэн нөхрөө ганцаарангий нь яаж явуулахав? Би үдэлцэж өгнө гэж Шонхолой холын аянд зорилоо. Залуудай бас эцгийгээ дагаж явна гэсэнд, асар цааргалсангүй. Мазаалай явалцах гэсэнд, өрхийн хамгийн чийрэг бяртай эр олон хоногийн холын

аянд явбалр, араатан дайснаас хамгаалах твшигтэй чийрэг хвнгвй бэрхдэх бол уу? гэж Шонхолой татгалзаад, хашир өвгөн Шарнууд Оодойтой зөвлөн хэлэлцсэнд , өвгөн бас Мазаалайг өрх гэртээ өмөг болж байвал таарах бий. Өнөөх Шар махчны нэг отог нь гол гарч ирвэл , хвн бвлгвйдэж хэцвүдвэл яана? Гэж бвгдээрээ хэлэлцээд, Мазаалайгаа влдээхээр болжээ. Хойд өдөр нь эртлэн Ихэрэс Бух өвгөн, Чонос, Шонхолой, Залуудай умар звг чиглэн гарчээ. Бух , Шонхолой хоёр нэг нэг жад, нэг нэг хавчаахай нумтай, хэд хэдэн сумтай, бвснээсээ нэжээд сүх агсжээ. Залуудай хавчаахай нум сумтай, авынхаа өгсөн хас тэнигэр сүхтэй явжээ. Хойд звг чиглэн явсаар хэдэн даваа даваад, вдшийн бор хоногт нэг хадан хонгил олж, амсарт нь том чулуугаар хашлага хийгээд, дотор нь гурван хвний хэвтэх хэвтэш өвсөөр засаж бэлтгээд, өдөр харвасан хоёр тарвагаа боож оройн хоол хийлээ. Тэнгэр маш цэлмэг. Навч шилмвүсний внэр ханхалсан агаар тун айхан тул хадан хонгилын гадаа нь , галынхаа дэргэд хэвтэн амарч байтал, нар жаргаж харанхуй бврэнхий болсоор сэрвүн салхи татаж, модон дотроос хоёр бор гөрөөс гвйж гараад, гал харж баахан гайхан зогсосхийж, хвний внэр аваад, год хийн всэрч, дахин гвн ойд шурган далд орлоо. Модны захын шугуй сөөг дотроос бодон гахай гарч ирээд, галын гэрэл вээд гайхан зогсжээ. Аяганаас мод өвс асаж гал твймэр гарахыг вээж, галаас айдаг боловч, нэг байрандаа тогтуухан асаж байх гал мяралзан асаж байхыг сонирхож, ойртон дөхөсхийтлөө, хвний внэр авч твр нэг зогссоноо, хвнтэй урьд өмнө ер дайралдаж вээгвйн дээр , хир баргийн юмнаас айдагвй хөгшин бодон тул , хвний внэр авахдаа , нэг их аюултай амьтны внэр биш байна гэж хвр хар дуугаран галын звг ойртлоо. Галын гэрэл тусах газар хврч ирээд, нурууны нь ширхэг сэрүййн, махир шар соёогоо хяхнуулан зогсож, ууртай догшин улаан нүдээ эргвүлэн, вл танигдах хачин гурван амьтан галын хажууд ажиг сэжигвй хэвтэж байгааг харан, хамраа сарналзуулан харахад нь , Залуудай

- Хвүш гэж хашгиран бослоо. Бодон баахан цочиж гэдэргээ ухраад дуулдагвй сонин дуутай юм гонзогос гээд босож ирэхэд, танихгвй юм бвхэн аюултай байж магад гэж болгоомжлон , бас соёогоо хавиран, онигор улаан нүдээрээ Залуудайн звг гайхан харав.

- Хай , гээд Залуудайн гуяа пад хийтэл алгадахад, гахай эргээд зугатааж, шугуй уруу шурган орох гэтэл нэг алаг эрээн юм бутын цаанаас дүвлэн гарч гахайг нөмрөх шиг болтол, бодон ч ухас хийж , дотроос нь гартал, бөгсөө чирээд, , шугуй уруу шаравсаар оржээ. Тэр том эрээн юм нэг муухай урхираад газар өнхөрч өвс бут маажилсанд, галын хажууд хэвтэж байсан Бух , Шонхолой хоёр сандан босож, гурвуул харваас, бодонг дайраад нэг бар, гэдэс салтаагаа соёонд нь хага татуулжээ. Гэдсээрээ орооцолдон ноцолдож, аюумшигтай муухайгаар хврхрэхэд нь модон дотор ан гөрөөсний тэр чимээнээс айж дутаасан чимээ төвөргөөн дуулдаж, модны оройд хоноглосон махчин шувууны цочин хагших дуу гарлаа. Нум жадаа барин, тэр тарчилж байгаа барын звг болгоомжтой ойртвоос, гэдсээрээ ноцолдон тастаж байсан бар ч баахан муужирч, вл танигдах амьтан дэргэд нь ойртосхийхэд , тэнэг уур нь хврч, нүдний өмнө нь вээгдсэн шинэ дайсны звг дайрах гээд, бөгсөө чирэн архирч, ам юугаан ангайн свртэй дөрвөн соёогоо ярзайлган урд хоёр хөлөөрөө газар алгадан давштал, Шонхолой, Бух хоёр харваж, хоёр далаар нь сум өдөндөө хвртэл шаав. Барын толгой доошоо тонгосхийтэл, Залуудай урт ишт хас тэнигэр сүхээрээ хоёр нүдэн хооронд нь ишинд тултал цавчин буулгав. Догшин араатны чийрэг бие нь

суларсхийгээд, сvvлийн vзvvр годгонон, бvх бие нь чичигнэв. Гурвуул, сvх, сумаа суга татаад, бодонгийн шургасан шугуй уруу болгоомжлон ойртвоос, зоогоо тас шvvрvvлсэн гахай байгаа газраа мэдэгдэн хvр хар хийж, хэвтсэн газраасаа босоод бөгсөө чирч шарвалзан, шар хөөс гоожуулан, соёогоо хяхнуулж амиа зvгээр өгөхгvй, vзэлцэнэ гэсэн юм шиг гурван анчны өөдөөс муухай дуугарч, хурдалж чадахгvй боловч, хадрах санаатай гарч ирлээ. Шонхолой, Бух хоёр жадаараа хоёр бөөрөөр нь зэрэг жадалж, бөгсий нь өндөсхийтэл дайран чичсэнд, бодонгийн урд хоёр хөл нь нугарч газар мөргөж ойчлоо. Залуудай бас сvхээрээ хулхи уруу нь нэг сайн буулгаад, аяны явган гурван хvн, тэр том бодонгийн мах авч явах аргагvй тул, гуяы нь тас цавчиж авлаа. Шонхолой бас бодонгийн соёогий нь булга цохиж аваад, хvvгээ явуулж, галаас цучил авчруулан барын дэргэд гал асаалгаад, Бух өвгөнтэй хоёулаа чулуун хутгаар шаламгайлан өвчөөд, эхдээ барын цөсий нь аваачиж өгнө гэж салгаж авлаа. Бас соёогий нь сайхан зэв болно гэж тvv цохиж авлаа. Тэгээд, хадан хонгилынхоо тэндэх гал дээрээ очиж, галаа сэргээж, барын арьсаар гурвуулаа цахиур хутгаар эсгэж нумныхаа vйсэн саадаг, хор гэдэг годоль сум хийдэг vйсэн хоромсгоо бvрэх бvрээс бас хөлдөө тааруулан барын арьсан чархи гэдэг гутал хийж, нойтон дээр нь ясан шөвгөөр сvлбэж нvхлээд тасмаар хэлхэж шагайгаа тойруулан боогоод, хатахад яг хөлийн хэвээр хөнгөн гццутал болдог бар чархитай болцгоож, Бух Шонхолой хоёр, Залуудайгаар гал тvлvvлэн сахиулж, vйсэн саадаг хоромсгоо ясан шөвөг зvv, шөрмөс хэрэглэн, барын арьсаар төдхөн бvрж гvйцлээ. Тэр хооронд Залуудай, галдаа тvлээ хийж, харанхуйн зvг, тэр бодон бар хоёрын хэвтэж байгаа газар нvд чих тавин сууваас, цөөвөр ирээд, сvллээр нь чоно, дараагаар нь ийнэ гэдэг өндөр цээжтэй шовтон бөгстэй, хvн инээсэншиг муухай улин инээдэг цоохор араатан ирж, бар бодон хоёрын улай дээр архирах, урхирах, улих гийнах, ноцолдох, зуулцах, анир ёимээ гарч байхыг ажин соносж суув. Чингэж байтал, чоно зугатааж, ийнэ зам тавьж, цөөвөр гаслан бутартал нэг нь зайлж амжилгvй сvртэй том амьтны том тавхай дор ганц ган хийгээд няц даруулж, тэр том амьтан, бvх биеэр тэмээний зогдор шиг vстэй, багана шиг бvдvvн хөлтэй, хоншоор дээрээ дэлэм урт эвэртэй, тvvний ард нь бас нэг арай богино шиг эвэртэй, зантайсан муухай толгойтой тийм нэг сvртэй том амьтан алцганан гарч ирээд, замдаа бут шугуй, зулзган мод, бургас, боролжийг огт тоохгvй өвс мэт хага дайран замдаа ямар ч амьтан дайралдсаныг огт хайхрахгvй, найгалзан шогшсоор гал тvvдгийн зvг шулууухан чиглэхэд, Бух, Шонхолой, Залуудай гурав яаран сандран хадан хонгил уруугаа шургав. Том хирис, галын өмнө шогшиж ирээд, хуурай гишvvн тас няс хийж дvржигнэн дvрэлзэж байгаа галын яг урд нь зог тусаж, онигор нvдээ ууртайяа бvлтийлгэн, хамраа сарналзуулан, жигтэй сонин vнэр vнэрлэн, дэлэм хар эврээ галын зvг чиглvvлэн зогсоод, нэг хэсэг шуухинан амьсгалж, шиншлэн зогсож байснаа сөөнгө муухай сvртэй дуугаар буйлаад, урт хар эврийн vзvvр нь галын нөлөөнд халав уу яав, толгойгоо сэгсрэн ухарсанаа, яаралгvй эргээд дуртай дургvй цаашаа алхахад нь хадан хонгилд хоргодон хойноос нь харж байсан гурван хvн, хавчаахай нум сумтай, жадтай сvхтэй, хир өаргийн араатан дайсантай тулах чадалтай гэж бодож явсан улс, тэр лут том амьтны сvртэй байдлыг тулгаран харахдаа, хирисийн дэргэд хорхой шавьж шиг юмгvйгээ мэдэж, айн эмээн харж байтал, урамдах мэт чимээ гарч, хар модон дотроос бас нэг аймшигтай том амьтан гарч ирлээ. Тэр мундаг том амьтны нvд нь ногоон гал мэт vзэгдэж, бvрэнхvй дотор нэг том юм харлан, галын зvг айсуу. Тэр том

амьтныг хармагц өнөөх хирис эрчээрээ дайран орлоо. Ой дотроос гарсан тэр том амьтан хирисийн дайран орохыг харангуут зог тусаж, түүдгийн гэрэлд нүд нь ногоон гал гялсхийгээд, нэг урт хар могой шиг юм хирисийн эврийг ороож, шаравтал хажуу тийш нь зайлуулаад, матигар бүдүүн хоёр шар соёо хирисийн бөөр лүү шааж, өөд нь оволзтол хаямагц пид хийтэл газар ойчив. Тэр газар ойчиход нь гурван аянчин, хирисийн нүсэр том бие тонгорцоглон ойчсонд газар доргих шиг санагдаж, тэр хар шивэр модон дотроос гарсан сүртэй том амьтныг арслан заан гэж таниад тэр хоёр мундаг хвчтний тулахыг сүрдэн харж байваас хирисийг босохын чөлөөгүй, арслан заан дайран орж соёогоороо хатган чичиж, ургаа мод шиг хөлөөрөө хавиргы нь хамх гишгэхэд яс хугарах аягуй чмээ гурван аянчны чихэнд тов тодхон сонсдов. Хирис, сөөнгө муухай дуугаар хад цуриаттал урхирч, шархнаас нь цус олгойдон, нүсэр том бие нь чичив татав хийж, ургаа зулзган мод бургас, чоно нохойг огт тоохгүй дайрч ирсэн үлэмж хвчтэй хирисийн амин гол нь аянчны харсаар байтал тасарлаа. Тэнсэлгүй их хвчит арслан заан, дайран орсон дайснаа дараад урт хар могой шиг хушуугаа өргөж, орчин тойрны хөнлий хвнгэнэтэл урамдаад галын зүг ажиггүй ойртож, хадан хонгилын амсраас цухуйж байгаа гурван хвний зүг айх уурлах шинж огт үгүй сонирхон харж, галын дулаан илч нөлөөг их таашаасан бололтой дүржигнэн асахы нь том чихээ хөдөлгөн чагнаж, цэцэн нүдээр галын дөл харан зогсож саяхан хиристэй тулсандаа баахан амьсгаадсан мэт, гэдэс нь оволзож байснаа тайвширч, гэнэт галын дэргэд хэвтээд өглөө.

- За, одоо еид ч сайхан манаатай боллоо доо. Энэ арслан зааны энд байгаа цагт бидэнд ямар чараатан халдахгүй байх гэж хэлээд Шонхолой, хадан хонгилоос аяархан гарч

- Арслан заан, арслан заан чи бидэн битгий муу санаа, бид чамд хор хийх санаагүй. Галдаа түлээ нэмээд, чамд дулаахан, бидэнд саруулхан болгоё. Манийг сайхан манаж хоноо гэхэд нь арслан заан, хвний үг дуу сонсоод чихээ хөдөлгөн сонирхож сонсох мэт бөгөөд огт босох санаа үгүй. Гагцхүү цэцэн нүдээрээ битүүхэн ажиглан хэвтэх ажээ. Хирисийг дайран орж ирэхэд, бодон бар хоёрыг идэж байсан олон араатан зайлан зугатааснаа, одоо хирисийн цусны үнэрээр дахин цуглан ирж чоно нохой цөөвөр шарнууд ийнэ тэр гурван амьтны сэг дээр овооролдон жижиг араатан нь томоосоо хулчийж, хирисийн цус долоох нь долоож, томцуулын унагасан яс махнаас самбаачлан зулгааж идэх нь идэж шөнөжин бужигнав. Соргог нойртой гурван аянчин, шөнө ээлжлэн босоцгоож, галдаа үдшийн базааж бэлтгэсэн хуурай урт модноос хийж, үүрийн гэгээ шарлатал галтай, галын дэргэд хэвтсэн арслан заан манаатай хонолоо. Хвнийг аяархан галд түлээ шургуулахад тэр том амьтан хирийн дайсан халддаггүй тул, хүнээс огтхон ч айх ширвээдэхгүй, ажиггүй хэвтэн амарч байв. Чингээд үүрээр босоод хар мод руу идээлэхээр яваад өгсөнд Манай гурван анчин бас босоод, галдаа гахайн гуяны мах шарж идээд урд шөнө олон араатан бужигнаж байсан өнөөх бодон, бар, хирис гурвын сэг дээр очиж үзвэл, бодонгоос тас мөлжүүлсэн толгойн ясны төдий үлдэж, барын савар, толгой, тас мөлжүүлсэн хэдэн чөмөг яс үлджээ. Өнөөх махан уул шиг том хирисээс ганц араг яс нь үлдэж, гэдэс дотор % мах шир үгүй болсонд ийм том амьтныг ганцхан шөнийн дотор чоно нохой амархан идэн баржээ гэж гайхлаа.

Гурван аянчин тэндээс хойд зүгээ барин, өглөөний сэрүүнд алхваас шөнийн элдэв араатны дуу чимээ нам гүм, шүүдэртэй өвсөнд нэг ч амьд амьтан үзэгдэхгүй, гагцхүү богширго бялзуухайн жиргэх чимээ дуулдах ажээ. Зүүн зүг наран гарах шахаж, цувж явсан гурван хүний мөр нь шүүдэртэй өвснөө жигтэйхэн тод зурайн үзэгдэнэ. Эцгийн хамт анх удаа алсын аянд зорьсон Залуудайн сэтгэлд урд өдрийн тохиолдсон явдал, шөнийн хирис, арслан заан хоёрын тулалдсан тулаан зүүд шиг сонин санагдаж хүн хэрэв арслан заантай сайн ижилшиж дасгавал, элдэв араатнаас биеэ хамгаалахад ямар сайн ахньтай болох асан бол гэж бодож явлаа. Чингээд, өглөөний чимээгүй нам гүм цагаар нэгэн хэсэг алхтал, нар ч гарч их их сайхан боллоо. Энд тэндгүй хулан тахь, зээр талаар билчиж маш их том эвэртэй үхэр гөрөөс сүрэг сүргээр үзэгдлээ. Тогоруу тоодог, гурван аянчнаас огт айхгүй нар гарснаас хойш авулт махчин араатан далд орж, айван тайван болсон шинж илэрхий байлаа. Гурван аянчин, хааяа ганц нэг үг солилцон чимээгүй алхлан явсаар, үдийн алдад тэр талыг туулж, нэг хөндийд орлоо. Хөндийн баруун талаар модтой, зүүн талд нь сөхийсөн өндөр хадтай ёроолоор нь ганц нэг хайластай, энд тэндээ асгатай газар ажээ. Нилээд явж хөндийн эхэнд ойрттол, нэг өндөр дэнж дээр хэдэн өрх овойн үзэгдсэнд танихгүй гавар танихгүй омгийн улс байгаа нь дайсагнаж ч болно гэж, үхэр чулууны цаанаас тэр өрх гэрийн зүг ажин харваас, хүн бөайгаа шинж үгүй мэт. Сэмхэн дөтөлж очоод ыас ажин харваас, эзэнгүй болж орхигдоод эвдэрч нурсан ч шинж алга. Нум сумтайдаа найдаж бас, баахан ойртоход, ер нохой шувуу ч үзэгдэхгүй. хашгирч гуугалаад, нуугдан харваас, бас амьд амьтан байгаа шинж тэмдэг үгүй.

- Энэ лав нэг сөнөсөн өрх айл байна гэж Шонхолойн хэлэхэд, Бух өвгөн:

- Сөнөсөн бол учры нь магадалья. Ойртож үзнэ гээд гурвуул тэр өрхнүүдийн дэнж джжр гарваас, чив чимээгүй. Гагцхүү нэг баахан нялуун үмхий үнэр ханхалсхийх мэт. Баруун урд талын их өрхийн орой дээр гараад, доош нь шагайж үзвэл, хэдэн хүн зүүн баруун талд унтаж байсан шиг хэвтэж байв. Нэг чулуу аваад дотогш нь чулуудаад үзтэл, архийн доторх огт эс хөдлөв. Өрх дотроос ялзарч байгаа хүүрийн нялуувтар үнэр гарч байв. Амьд хүн нэг ч үгүй юм байна гээд, зэргэлдээ нэг өрх үрүү өнгийн харахад, бас л хэдэн эрэгтэй, хоёр нэгэн нүцгэн хүүхэд хэвтэж байхыг ажиглавал хүүхдийн нүүр бие нь хар цоохор болсон байв.

- Энэ өрхнүүдийн хүн булт бодоо тусчээ гэж Бух эмээн шивнээд, тэр аюулт бодоо буюу цээрлэж хожмын хүн цагаан бурхан цэцэг гэх зэргээр нэрлэх болсон өвчнөөс өрх айл нилээрээ сүйрч сөнөсөн тэр газраас яаран сандран зайлан одов. Цаашаа нилээд явтал бас нэг хэдэн өрх гэр үзэгдсэн нь мөн л хүн хар үзэгдэхгүй тул гурван аянчин тэр хөндийн өрхийн хүн амьтанд аргалах аргагүй хэцүү бодоо тусжээ гэж ойры нь дөтлөлгүй бушуухан тойрон өнгөрлөө. Тэр өрх айлын зүүн хойно нь налуу зоосон урт нарийн модонд янгир, бор гөрөөс, тахийн шириг толгой шийртэй нь зүүлттэй нь өлгөсөн үзэгдсэнд Ихэрэс Бух вгөн тэр зүг дохин,

- Манай Бай кул их нуур хавийн олон омогтны ёсон луугаа юутай адил юм бэ?

Бодоо өвчин тусахад цагаан бурхан заларч ирлээ гэж ангаар тахин тайж, арьсы нь толгой сүүл зүүлттэй нь яг ингэж өлгөж өршөөж өнгөр гэж зүхэж мөргөдөг юм шүү дээ. Энэ хэсэг айлд нэг бөө байж дээ. Зүхэж зүхэж, атаатан айл өрх, дайсан омог уруу зайлуулан явуулах гээд ядаж дээ. Хэцүү өвчин шүү. Нэг тусвал толгой тоолсон, өрх сөнөхөөс нааш өнгөрөхгүй. Манай газар бас ингэж өрхөөр баларсан суурин олон

байдага. Ганц нэг хvн , хувиа хvртээд амь гардаг ч ёс бий. Тийм хvн дахиж хvртэх гэж байхгvй. тэр өвчин гарсан газар ядаад хувиа хvртэж байгаа хvнтэй цуг суугаад, унтаад байсан ч гэм болдоггvй сонин юм гэдэг. Би тийм хvнийг хэд хэдийг vзсэн. Царай нь нэг насаараа цоохор болчдог юм билээ , хувиа хvртэсний нь шинж тэмдэг нь тэр юм гэнэ билээ гээд тэр сөнөсөн хоёр өрх гэрийнхний булш нь болсон хоёр суурин газрыг өнгөрсөн хойноо :

- Би мартаад нэрий нь нэрлэж болдоггvй гэж манай нутагт нэрээс нь хvртэл айдаг сvрхий өвчний нэрий нь эзний нь нэрийг нэрлэж орхилоо. Маныг дагавал яана ? гэхэд нь Шонхолой

- Бид өрхөөр нь ороогvй, юмнаас нь аваагvй, хоол унднаас нь идэж уугаагvй. Яалаа гэж бидэнд нэхэн халдахав? Гэлээ.

- Нэрээ дуулбал нэхэж дагаад ирдэг юм гэж манай нутагт хэлэлцдэг юм шvv дээ. Би харь газар олон жил тэнэж тэр ёс мартаж орхисноо, одоо санаад зовниж байна. Энэ даваан дээр гараад өчин залбирсуу , гэхэд нь Шонхолой

- Тэр цоохор юмны эзэн биднийг бар цоохор гуталтай, бар цоохор саадаг хоромсготойг vзээд , бас сvрдэж хамаагvй халдахгvй бий. Өчигдөр бидэнд бар алуулж арьсаар нь гутал хийж, зэмсгийнхээ савыг бvрх санаа төрсөн маань энэ сөнөсөн газраар дайран өнгөрхийн өмнө аюулгvй болгосон юм биш vv? Гэхэд өвгөний сэтгэл баахан тайтгарч ,

- Нээрээ ч тийм юм билvv дээ ? гэж баахан зоригжив. Чингээд даваан дээр гартал чулуугаар босгосон бяцхан овоо харагдлаа. Ангийн дал, буга, гөрөөсний эвэр, саарь сармайн өөдөс тасам мэтийг тавьсан байхыг vзээд Бух өвгөн барсын арьснаас нэг нарийн зурвас өргөж аман дотроо,

Сэ – э –эг, сэ – э – эг , сэ – э – эг

Дайд дэлхийн эзэн танд

Давшуулж тавьцанд тавинам

Орон дэлхийн эзэн танд

Олноосоо оршуулж тавинам

Барын цоохор арьснаас

Барьсанд тань барьж

Бай кул нуур нутагтаа

Баяртай хvрэхийн хутаг

Унасан газрынхаа шороонд,

Угаасан усныхаа саванд

Зовлон саадгvй хvрч

Золтой жаргалтай буцахын

Дэлгэр их хишиг гуйж

Дэлхийн эзэд танд мөрөгнөм.

гэж шивнэн дуудахад нv төрсөн нутгаасаа гараад он удаж мөрөөдөл болж яваа

Ихэрэс Бух өвгөний чингэж шившин залбирч байгааг Залуудай хараад внэхээр дотроо өвгөнийг өрөвдөж хол байгаа нутагтаа хортон араатанд хорлуулалгvй хvрэх нь болтугай даа гэж дотроо бодлоо.

Шонхолой, Бухын шившин залбирч гvйцсэн хойно өвгөнөөс царайг төв болгон :

- Өвгөн ах хэрэв энэ дайд дэлхийн эзэн нь , та бидний vг мэдэхгvй омогтон байвал яана ? гэхэд

- Хэл мэдэхгвй ч гэсэн ёс мэдэх байлгвй дээ. Хвний барьц барьж мөргөж байхыг даан ч мэдэх ёстой доо гэж внэн голоосоо хэллээ. Залуудай тэр бяцхан чулуун овоонд тавьсан зүйлийг ажиглан үзвэл шавраар тун аятайхан хийсэн хирис, арслан заан, баавгайн жижигхэн баримал нэг газар тавьсан байв.
- Саяхан хийсэн бололтой. Хур борооны усанд ч муудайгв юм байна гэж тэр бяцхан шавар дүрсийг ажиглахад нь Бух,
- Энэ л өрхнүүдийн хвн амьд байхдаа боснож л дээ. Бөө нь нас барсан байх. Тэгээд энэ хавьд чандры нь тавиад , өл тавьц босгосон хэрэг. Тэр л хэцүү нэрт өвчний хувийн нь хвртсэн байж болзошгвй гэхэд нь Залуудай :
- Тэртээ зүүнтэй юу вэ? гэж хэдэн мод зоож, дээр нь индэр шиг юм засаад нэг урт юм тавьж шилмүүс нь шарласан зулзган мод хатгасан юмыг заан сууваас Бух түүнийг гараа саравчлан хараад, бөөгийн чандар тавьсан аранга гэдэг юм байна. Энэ л сөнөсөн айл өрхнүүдийн бөө нь бусдаасаа түрүүн нөгчиж үлдсэн хвн нь бөөгөө тавиад энэ тавьц босгоод сүүлээр нь өөрсдөө тэсэхийн аргагвй бэрх өвчинд автагдан өрх гэр дотроо бие барж л дээ. Манй нутагт ч мөн ийм явдал гардаг даа. Хвн амьтан тийм газар нь хавьтан ойртдоггвй юм. Шөнө бол бүр чтэр хавиар нь айж ойртохгвй. Санамсаргвй дайралдвалтэрнээсээ болоод айж ичиж өвдөх үхэх явдал ч гардаг гэж хэлэхэд нь Шонхолой,
- Айснаасаа л болохгвй юв дээ. Би ер тийм юмнаас айдаггвй. Манай аав чайдаггвй хвн байсан. Айлтгвй чгэж нэр авсан хвн байсан юм. Нэрэндээ зохисон зоригт эр байсан даа. Их анч хвн байсан юм. Тэгээд ан араатанд яагаад бөө байдаггвй юм бэ? гэж Шарнууд бөөнөртэй маргадаг асан. Гомдож үхсэн амьтан буг болдог бол, миний алсан ан цөм буг болж намайг хорлрх асан. Надад өшөөтэй бөө нар намайг яагаад идэх гээд чаддаггвй юм бэ? гэж Шарнууд бөө нарт айлтгвй хэлдэг асан. Бугад мөргүүлж нас барахдаа намайг оршуулахдаа чулуун хврээ бүү хийгээрэй. Би агнадгаа агнаж, иддэгээ идээд , амьсгалын минь тоо гүйцэх цаг нь ирлээ. Үхсэн хойноо сүнс минь шөнө булшнаас гарч та нарыг вймүүлнэ гэж бүү зов. Надаас чадалтай хирис, бар, арслан заан давуу чадалтай юманд автагдаад үхэхдээясаа чулуун хврээгээр хашуулдаггвй боловч буг бослоо гэж би л үзээгвй. Намайг бас бүү хаш. Би үхээд хвн амьтан вймүүлэхгвй. Амьддаа вймүүлдэгээ вймүүлсэн гэж захисан ёсоор нь тавьсан юм шүү. Айвал догшин араатан , хар санаат дайснаас л айгаарай. Амьгвй юмнаас бүү ай гэж надад захисан үгий нь харь газар хэдэн жил тэнэхдээ би үргэлж боддог байлаа. Хвнийг хвндэтгээрэй , газрын ёсыг дагаарай гэж захисан захиагий нь би санаж явдаг гэхэд нь Бух,
- Чиний ав үнэхээр Айлтгвй гэдэг нэрдээ зохицсон хвн байж л дээ. Би урьдын юмыг ул, хуучны юмыг худал болгож чадахгвй, олны жишгээс зөрүүд болж чадахгвй хвн юм даа. Айхад аминд тустай гэж, танихгвй, зангий нь мэдэхгвй юм болгоноос айж явагч хвн бий гэж хэлээд за бидний зам хол, ус урт, газраа дөхүүлж үзье дээ гээд давааны ар уруу буухад нь Залуудай,
- Манай өрх айлыг хирис дайрахад осолдсон хвнийг оршуулахдаа Оодой өвөө эд нь эзнээ дага гэж арьсан гутал чархий нь хутгаар шарх оруулж байсан. Эд нв бүтэн бол, сүнс нь гардаггвй юм гэж надад хэлж байсан. Танай нутагт бас тийм ёс бий юв? Гэхэд Бух
- Тийм байлгвй яах вэ? гэлээ.
- Тэгвэл тэр арьс нь нэг л ангийн арьс байгаад хэдэн хвний чархи гутал хийхэд , гутал

тоолон сүнстэй болчихдог нь ямар учир билээ? гэж асуулаа.

- Тэр нарийн учрыг би мэдэхгүй ээ, хvv минь. Чи Оодой өвгөнөөсөө л асуудаг юмсанж. Над мэтийн хvн, далд нууцын учрыг яаж мэдэх вэ? гэлээ.

- Чингээд нэг хэсэг чимээгүй явснаа Бух өвгөн, Шонхолой, Залуудай хоёрын зvг

- Далай их дайд дэлхийд дая олны мэдэхгүй юм аль олон байгааг тоочиж яаа барахав? Урд гарсан чихнээс хойно гарсан эвэр гэж хожим хойнын хvн учры нь олж, хужры нь тунгаах цаг ирэх юм биздээ. Хоёр хөлт амьтан дотор алмас гэж огт гал мэдэхгүй vг хэлгүй амьтан байхад гал мэдэх боловч цахиур хавирч асааж чаддаггүй, манаж залгадаг Шар махчин байна. Цахиур хавирч дуртай цагтаа гал асаадаг манай Чонос, Шарнууд, Ихэрэс гэх мэт омогтон байна. Бодвол анх алмас шиг л амьтан байж, хожим Шар махчин шиг гал манадаг цаашилсаар яваад цахиур хавирч гал асаах ухаан олсон байх ёстой. Тэгэхээс анхнаасаа Шарнууд, Чонос, Ихэрэс мэт л цахиураар гал хэзээний асаадаг байгаагүй байх гэж би бодож явдаг. Манай Шарнууд Чонос, Ихэрэс омогтон огт мэдээгүй, нум хор годоль бид одоо Хорчин омгоос олж аваад сурч мэдээд, эзэн нь болоод, явна шvv дээ. Нутагтаа би мэнд хvрвэл, харь газар, хол нутаг vзэж, нvд тайлсандаа , Ихэрэс омгийн хvний vзээгүй сонин , аж төрөн амь хаацайлахад нь тустай сонин зvйл нилээдийг олж мэдээд, омгийнхоо ах дvv нэртээ сурган таниулах гэж явна шvv дээ. Манай Ихэрэсийн vлгэр онтохонд тэнгэрээр халин нисдэг гvн далайн ёроолд ордог чадалтай их эрс гардаг. Би тийм хvнийг vзээгүй. Vлгэрт байсан юм гэж итгэдэг. Хожим хойно, хэт холын цагт над шиг эгэл өвгөд чбас тийм чадалтай болж, агаар тэнгэрээр халин нисээд гvн их далайн усан дотор том загас шиг явах чадалтай болох цаг байж магадгүй юм гэж боддог. Хvн гэдэг хорхой –гайтай ухаантай хорхой шvv. Бяр хvчээр эвэртэн, сvvлтэн, араатан, соёотон амьтныг гvйцэхгүй боловч, ухаанаар , хамтын санаа , хvчээр даваад байгаа юм шvv. Хирисийн хvв төрөхөөсөө эвэр ургах бондгортой төрдөг бол хvний хvв төрөхдөө хутга сvх атгаад төрөхийг би vзээгүй. Амиа хаацйлж мод чулуу барьж сурснаасаа хойш аргалсаар байгаад хутгатай, сvхтэй, нумтай, годольтой болжээ. Хожим юутай болохы нь миний ухаан гvйцэхгүй, санаа хvрэхгүй боловч, олон veийн олон аавын хvв , одооныхоос сонин сайхан юмтай болох байх гэж бодож явдаг даа. Ийм байна даа хvв минь. Авынхаа байгаад нvн таньж, газрын холыг vзэж явах нь сайхан шvv. Тэгээд чамайг аавыгаа дагаж, намайг vдэлцэнэ гэхэд би дотроо их л тоож баярласан. Араатан дайсан байгаа цагт хар санаа аминд тустай боловч дотор сайтай , хvн сайтай, байх нь тун чухал юм шvv хvв минь, гэж хэлээд одоо төр дор голын хөвөөнд нэг vдэлнэ байгаа. Газар хол, аян урт. Амарч явах хэрэгтэй гэлээ. Бух өвгөний тэр vгий нь сонсоод Залуудай хvв сайхан дотортой тэр өвгөнд улам ч сэтгэлтэй болж хэлсэн vгэнд нь тун ч сонин сэтгэгдэл төрж явлаа.

Голын эрэг дээр бууж, урд шөнийн бодонгийн шарсан гуянаас идээд, иддэг vндэс төмс ухаж, галын нурманд булж идээд, уснаас ундлан сууж байтал тэр голоос ус уух гэж тахь орж ирлээ. Хvнээс нилээд холхон байсан боловч vнэрий нь аваад, хамраа дуугаргаж, vргэн цочиж, доошоо нилээд зайлан уруудаад, сая ус уув. Хөлнийхөө хурданаар л хар амиа хаацйлж явдаг тул, өчvvхэн чимээ гарвал сэрэмжилж, аягvйхэн vнэр гарвал, ямар аюул учруулах нь энэ билээ ? гэж насан турхар болгоомжилж явдаг тэр зэрлэг адууг хараад, Залуудай их л өрөвдөж байв. Модны хаяанаас нэгэн их сvрэг зэрлэг vхэр гарч ирээд яаралгүй голын зvг билчсээр дөтлөв.

Тугал бяруу нь голдоо , хойно урд нь том том бух явах байдал нь зохион байгуулалттай бөгөөд дайснаас хамгаалан явж байгаа шинжтэйг айван тайван харж суухад Залуудайд сонин санагдаж байв. Тахийн аймхай цочимтгойг бодвол үхэр гөрөөс чадал хвчээ мэдсэн, олноороо сүрэглэж явбал, хирийн дайсан халдаахгүй зохион байгуулалттай нь аятайхан санагдаж байлаа.

- Чингэж байтал , модны захын нэг хадан хушуу тойроод хврэн шар олон юм усны зүг чиглэн гарч ирсэн нь гурван аянчны анхаарал татав. Хэдэн зуун арслан заан ус уухаар ирж, голын хөвөөнд эгнэн ороод, ус ууцгаан яв явсаар усанд орж хушуугаараа ус сорж, бие дээрээ тургин асгаж эм арслан заан нь тугалаа дагуулан усанд шумбахад , үхэр гөрөөс хэдийн зам тавьж зайлаад, тхь хатиран уруудаад өгчээ. Арслан заан, ерөөс хвн амьтанд хамаагүй халддаггүй тул, гурван аянчин холоос тэр сүрэг зааныг харж суув. Сүргийн удирдагч хэдэн хөгшин арслан зааны бие нь сүртэй том, соёо нь хоёр вэвүр нь гадагшаа мушгиран , урт хушуу нь том могой мушгилдаж байгаа юм шиг . Усанд ороод сэлвүцсэндээ баярлан , зарим заан урамдан, хөндий дүвүрэн хвнгэнүвлж хаданд цуурай татав. Голыг зүг хврч ирсэн замд нь бут сөөг няц гишгүвлж, усанд ороход нь тэр хавийн амьтан бүхэн зайлж, ус хүртэл олон зааныг ороход савнаасаа халин давалж байхыг харахал ямар ч араатнаас айхгүй үлэмж их хвчтэн амьтны бүрэн шинж төгс сонин сүртэй вэзэгдсэнд, Залуудай тэдгээр цэцэн, сэргэлэн, айван тайван , үлэмж биетэнтэй шадардаж сайн болбол, манай Чонос өрхийнхөнд юутай сайхан болох асан бол ? гэж дахин дахин өчигдрийн сэтгэгдэл төрж, нутаг усандаа буцаж ирээд, арслан заантай танилцах арга сүвэгчилнэ дээ гэж бодож суув.

- Усанд орсон арсоан заан мөдд уснаас гарахгүй байх. Бид газраа хороож вээх үү дээ? Гэж Бухын хэлэхэд Шонхолой, залуудай хоёр босож, зааны ар хойгуур нь ойрон гарахаар зүглэж алхан явсаар% тэр сүрэг ирсэн замыг огтлон гарвал, хөлд нь хуга, няц гишгүвлсэн мод сөөг дунд нилээд хэдэн том могой няцарсан байв. Заан сүргийн замаар нилээд явж, хөндий уруудсаар тахь, үхэр гөрөөс , ороонго, зээр билчиж яваа талд ороод, тэр өвс иддэг амьтан айван тайван билчиж байгаа нь лав айлгах аюултай араатан үгүйн шинж гэж санаа амар явсаар, нар баруунаа хэлбийж буй тул, шөнийн араатнаас амь хаацайлах аятайхан газар эртхэн бууж вээх юмсан гэж хоногийн газар ажиглан явав.

- Талд хоноход араатан аюултай. Хад мод бараадах юм сан гэж Бух өвгөн уул өөд өгсөү взые гэлээ.

- Тэр зөв, гээд Шонхолой, баруун талын модны хаяа барьсхийсгээд явъя гэж гурвуулойн зах чиглэн одов. Замд нь алд өндөр өвсөн дунд хэдэн тоодог дайралдсанд , Залуудай нэг том тоодог харваж, унагаагаад гэдэс дотры нь гаргаж хаяад оройн хоол хийнэ гэж үүрэв. Чингээд модны зах дагасаар явтал нь хэдэн мич модны ёроолоор ургаж байгаа жимс идэж байснаа, хвн хараад, эр мич нь дохио өгч дуугармагц, хэдхэн зулзагатай эм мич, яаран модон өөд авиран гарч, хоёр гурван эр мич, модны ёроолд зогсоод үл таних хоёр хөлтний зүг ve ve муухай урхирах дуу гарч , хэнхдэгээ шаан зогсов.

- Бид та нарт хор хийхгүй э –э – эй, та нараас ч айхгүй э –э – эй , гэж Залуудайн хашгирахад, тэр эр мичин, мод түшин зогсоод, чих тавин , хвний үг сонирхон чагнаж байв. Чингээд үл таних хоёр хөлт амьтан тэдэнд халдах санаа үгүйг мэдээд, сүр бадруулж, урхиран хэнхдэгээ шаах нь зогсоод, холдож яваа аянчны хойноос модон

дээр гараад нилээд удтал харж байснаа , гишvv дамжсаар модон дотор орлоо. Гурван аянчин явсаар нэгэн хадан хясааны ёроолд босоо хvнээс өндөр том дэвхгэр чулууны дэргэд хvрч очоод, энэ чулуун дээр гарч хоновол, муу хонгилоос дутуугvй. Арслан заан биднийг лав дайрахгvй. Хирис дайраад энэ том чулууг хөдөлгөхгvй. Дээрн ь гарч чадахгvй. Бодон ч хадран халдахгvй. Барагтай араатан ч энэ чулуун дээр гарахгvй, санаа амар унтаж болох газар байна гэж Шонхолой тэр том чулууг нэг тойрч vзээд гурвуулаа дээр нь авиран гарч vзвэл гурав байтугай тав зургаан хvн зэрэгцэн хэвтээд байж болох өндөр давхар ургаа чулуу байв. Тэр чулуун дээр хонохоор шийдэж, эртлэн тvлш бэлтгэж хуурай гишvv тvvж, тоодгийнхоо маханд нэмэр болгох vндэс, төмс, мангир зэргийг тvvх завсар Шонхолой хус модны vйс хуулж, дөрвөлжин сав хийгээд, чулуу тvvж, тоодгийн махыг vйсэн саванд хийгээд, галд улайсгасан чулуугаар болгож шөoьэй хоол хийхийг зэхлээ. Хонох давхар чулуун дээрээ өвсөөр хэвтэш зассаар байтал нар ч жаргаж, чулууныхаа өвөрт авирах чулуу тавиад гал тvлж, улайсгасан чулуугаар тоодгоо хорхоглож, хоолоо хийж идээд, галдаа тvлээ нэмээд, vдшийн сэрvvнд тvvдгийн илчинд тун аятайхан сууж, орчин тойрны vнэр чимээнд хамар чихээ талбин суутал, хvн шиг амьтны vнэр ханхлах шиг болж, садан дйасан алин нь болох бол? Гэж байтал хажуугаар нь бас нэг махчин амьтны vнэр гарлаа.

- Бартай л адилхан vнэр гаоаад ирлээ. Ойд яваа хvний хойноос мөрдөж яваа юм билvv? Гэж Шонхолойн нам дуугаар хэлтэл, нэг муухай дуу хангиналаа. Амь алдаж байгаа хvний ёолон бархирсан дуу шиг бөгөөд гаслан хангинах тэр дуунаар Залуудайн бие зарсхийж, гурван аянчин зэмсгээ шvvрэн, хаанаас аюул ирэх нь вэ? гэж тэр дуу гарсан зvг ширтвээс, ой дотроос хvн шиг хоёр амьтан сандран гvйж гараад галын зvг сандан мэндэн гvйв. Байдлы нь харваас, шовтон мөртэй, бөгцгөр нуруутай туранхай биетэй, зантгар толгойтой ажээ. Гартаа нэг бороохой шиг юм бариад, маш айж хэлмэгдсэн шинжтэй. Нvд нь бvлтийж, амьсгал давхцан, галын дэргэд гvйж ирээд, , гурван аянчны дэргэд хошоод том алхмын хиртэй ойртоод, бvх бие нь чичрэн зогслоо. Модон дотроос том араатны ялан бахархсан урхирах дуу гарч, олон цөөврийн улин хуцалдах чимээ сонсоглоо. Тэр чимээ сонсмогц , ойгоос гарч ирсэн хоёр балтгар хvний царайл тэсгэлгvй эмээх байдал тодорч, аман дотроо нэг юм шулганасанд Шонхолой ,

- Бvв ай. Бидний энд айлтгvй гэж дуугарахад нь тайван талбиун дуугий нь сонсоод , тэр хоёр алцгар хөөрхий амьтны дотор нь баахан уужирсан шиг. Амь авар гэсэн юм шиг , гурван аянчны өөдөөс харан зогсоход, галын наад талд , том давхар чулууны энгэр талд орж ир гэж Шонхолойн дохиход, дохиогий нь мэдэж, айж зовсон байдалтай орж ирээд, ойн зvг нэн сvрдсэн байдалтай харж, бvх бтие нь чичрэн дагжиж зогсов.

- Суу, гэж дэргэдээ газар алгадан заагаад Шонхолой галдаа , дэргэдээ бэлтгэсэн тvлээнээс хийж, тэр хоёр хөөрхий амьтны зvг найрсгаар инээмсэглэн харваас, ядруухан бороохойгоо атгасаар, тэр хоёр амьтан дэргэд нь суугаад, дvржигнэн асаж байгаа галыг баярлан харж, Шонхолойн зvг нэг юм шулганан, шvдээ ярайлган, нэг том соёоны дvрэм хуруугаараа vзvvлэн, дvvлэн харайж юм барьсан байдал vзvvлэн дуугарахад нь, хутган соёот айхтар махчин барт нэгийгээ бариулж сандарсан юм байна гэж гурван аянчин урхаарлаа.

- Тэгээд, Шонхолой, аман тушаагаа хоёр долоовор хуруугаа урт соёо шиг унжулан,

нэг хуруугаа гозойлгож, хэдэн араатан бэ? гэж дохиогоор асууваас тэр хоёр хөөрхий амьтан, хvний аймаг болох тул дохиог ухаарч, хочр хуруугаа гозойлгон хутган соёот хоёр барт дайрууллаа гэж дохиогоор мэдэгдээд, гурван аянчны өөдөөс юм шулганан амь авар гэсэн байдалтай харахад, Бух өвгөн эрхий хуруугаа даран биеэ зааж, долоовроо даран Шонхолойг зааж, дунд хуруугаа даран Залуудайг заагаад, нэргvй хуруугаа заан, тэр хоёр ойн хvний нэгийг заагаад, чигчий хуруугаа даран нөгөө нөхрий нь зааж, таван хуруугаа зангидан, ойн зvг заасанд, тэр хоёр амьтан дохионы утгы нь ухаарч, хөөрхий царайд нь баяоласан шинж тодров. Тэгээд муу бороохойгоо дэргэдээ тавин тvндгийн халуун нөлөөнд их л жаргасан байдалтай, гал өөд харж, хааяа ойн зvг хулгай нvдээр харж суухы нь хараад Залуудай тун ч хөөрхийлөн өрөвджээ. Тэгээд халуун чулуун дээр мөөг тавин хайрч, тоодгийн махнаас өглөө иднэ гэж vлдээснээсээ хоноц хоёр алцгар хvндээ халуун чулуун дээр халааж өгсөнд, тэр хоёр баярлан инээж, маш амтархан, том томоор ам уруугаа чихэж, болсон мөөг, сонгино, цагаан төмстэй мах агшин зуур залгилан идээд, дотор нь уужирч, санаа нь амарч сав нь дvврсэн байдалтай, гурьан аянчны зvг тэсгэлгvй сайхнаар харан инээв. Гурван аянчин ч тав болсондоо бvл нэмэгдсэн шиг санагдаж хэлээ нэвтрэлцэхгvй боловч дохиогоор ойр зуурын юм нэвтрэлцэж болох байдалтайд баярлацгаав. Чингээд тэр ойн зvгээс хааяа хутган соёотын урхиралдах дуун сонсдох тул эртхэн чулуун дээрээ гарч авбал дээр юм уу даа? Гэж Бух өвгөн, чулуун дээрээ гараад,

- Үгvй, энэ чулууныхаа гол дунд нь юмуу, ойн зvг хандсан нэг буланд гал тvлбэл болох юм байна шvвдээ гэхэд нь Шонхолой

- Тэр зvйтэй, гээд босов. Өнөөх ойн хоёр хvн, хаягдлаа гэж бодоод, царайд нь нэн айн сандарсан байдал мэдэгдсэнд Шонхолой тэднийг тайтгаруулан тvлээгээ нэг заагаад, чулуу өөдөө нэг заасанд нь тэр хоёр амьтан санаа нь уужирсан бололтой. Чингээд Шонхолой, Залуудай хоёрыг тvлшээ чулуун дээрхи Бух өвгөнд авч өгөхөд туслалцан, ганц бие алцгар намхан тул дээшээ сарвайж гар хvрэхгvй тул Бух өвгөн, тэднийг дуудаж, наашаа гараад ир гэж дохин, гараа сарвайсанд, Шонхолой, Залуудай хоёроор дэмжvвлэн, тавхар чулуун дээр гараад, нөгөө хоёр анчны дороос өгч байгаа моды нь Бух өвгөнийг дууриан дээш ататж авцгаав. Чингээд дорх галдаа мод нэмээд шонхолой, Залуудай хоёр гартаа цучил барьж, өндөр давхар чулуун дээрээ гараад, мод тийш харсан буланд нь гал асаалаа. Өнөө хоёр ойн хvн гал асааж байгаа аянчныг хараад, их баярлан жаргасан байдалтай, аяарханаар инээж, гал дvржигнэн асахыг хvлээж суув. Галын гэрэлд Залуудай, тэр хоёр амьтны бороохойг vзвэл, гар барьсан газар нь мөлийсөн, нилээд хатуу модоор хийсэн бороохой байв. Юм цохисон шинжтэй зарим газраа амьтны цус болж харласан тэр бороохойн бариул тал нь нарийн шиг, нөгөө цохих vзvвр тал нь арай бvдvвн бөгөөд иртэй чулуугаар цохиж зассан мэт байдалтай. Ойн тэр хоёр хөөрхий хvний бие нь хирдээ шөрмөслөг боловч, манай гурван аянчны ханхгар жээжтэй, өндөр нуруутай чийрэг биеийн дэргэд сvр муутай, нуруу нь хэтэрхий урт, хөл нь даанч богино бөгөөд хавирга мэт матигар. Бяр тэнхээгээр яасан чгурван аянчныг гvйцэхгvй.

- Залуудай, Ихэрэс бух өвгөн, Шонхолой эцэг хоёроос нуруугаар нэг толгойн дайтай дутуу боловч, ойн тэр хоёр хvний дэргэд баатар хvн шиг vзэгдэн, тэр хоёр ойн хvн Залуудайн суганд зулайгаараа арай, чарай хvрэх балтгар алцгар амьтан байжээ. Эрт балар уагт, гуравдагч галавын ve дэх ой модонд мичнээс хvн болсон ойн хvний

дээдэс нь чулуу хага цохиж, ирмэгтэй нэгээр нь зэмсэг хийж, мод бороохой хэрэглэж сураад, цөөн хэдэн үгтэй болоод, ой дотор идэх жимс ногоо, жижиг ан амьтан олдох нь хялбар тул, элбэг хоолтойдоо дашуураад асар хөгжиж чадсангуй. Тэр учраас цаг байдал өөрчлөгдөхөд, тэр байдалд нь зохицон боловсрох ухаан чадал нь хүрэхгүй хоцрогдмол байдалтай хэвээрээ, гар хөл чдүй муутай, үг хэл нь ядуухан, бие бялдар нь ч үзэмж муутай, болхи, ядуу хэвээр хоцорч, тал газар араатан аюул бүр ч илүү учир, талын байдалд оршиж чадахгүй, чийгтэй модон дотор оршсоор, талын хүн ойд орж ирэхдээ, Шар махчин шиг зарим нэг нь ойн хүнийг идшиндээ нийлүүлж, бусад арай илүү боловсролтой отог омгийн хүн гал мэдэхгүй, муу сайн бороохойтой, ирмэгтэй гонзгой чулууны зүйлээр хатгах, цохих зэвсэг болгосон, хөөрхий тэр ойн хүнийг амьтан чгэж боддоггүй байсан тул, махчин нэгэн аймаг омогтонд идүүлж баларснаас болж, талын зүг зүглэдэггүй, ойд орогнодог ядуу аймгийн эдгээр хоёр хүнтэй манай аянчин дайралдаад, эртний тэдгээрийн түүх гарлыг яаж мэдэх ажээ. Тэр хоёр хөөрхий амьтан ч эртнийхээ түүхийг яахан мэдэх ажээ. Мэддэгээс, ойд хэрэн аж төрж, юм болгоноос айж, гагцхүү өөртэйгөө л омог нэгтэй ойн хүнээс айдаггүй амьтан байжээ. Тэр үдэш, ойн захад сөөг дотор ойртоод, модон дээр хонох газраа олж амжаагүй явж байтлаа эцгийгээ хутган соёотод бариулж, ухаан амиггүй зугатааж, гал хараад гүйж ирэн уул талын гөрөөчин хүнтэй анх тулгаран учрахдаа, нэгий нь барьсан хутган соёотоос арай ээлтэй, өөрсөдтэй нь төстэй амьтан гэж ядуу ухаанд нь орсон ажээ. Чингээд гурван аянчны галд болгосон хоолы нь идэж, хорхой мэт өчүүхэн амиа тэдэнд даатгаж, галын нь дэргэд дулаацаж, гэдэс цадаад, гурван аянчинд их л итгэж тэсгэлгүй элэгсэглэжээ. Чингээд ойын бэрх амьдралд үхэх зовох нь жирийн хэрэг тул, нэгийгээ араатанд бариулж амь гараад, сайхан билчээрт билчихдээ, нэгийгээ лдсанаа төдий л их гашуудан зовдоггүй ан адгуусан адил, саяхан наран жаргах үес гурван амьтан явж байснаа хоёр болсондоо нэг их шантрах байдалгүй, харин ч гурван чийрэг дайчинтай нийлсэндээ дотор нь уужирсан мэт байдалтай. Өндөр тавхар чулуун дээр авиран гараад, галын дэргэд дулаацан сууж байхдаа харанхуй ойд модон дээр хонодгоос нь зүйрлэшгүй жаргалтай байгаа шинж мэдэгдэн, гурван аянчны өөдөөс тэсгэлгүй талархсан байдалтай харж суув. Чингэж сууж байтал, ойн зүгээс том араатны сүрхий үнэр ханхалсанд галын өмнө сууж байсан таван хүн цөм зовнин, ойн зүг ширтвэл, хоёр хутган соёот эр, эм бар гарч ирэв. Ойн нэг алцгар хүнийг барьж идээд, гэдэс нь цадаагүй бололтой. Тэгээд галын үнэр, хүний үнэр аваад хүний үнэр нь саяхан барьж идсэн амьтантай нь адил тул бас барьж идэх санаатай, ойртон айсаж яваа бололтой. Хоёул тавхар чулууны өвөрт түлээ нь барагдаж, гэрэл гэгээ нь буурч байгаа түүдгийн ойр хүрч ирээд, өндөр чулуун дээр галын захад сууж байгаа хүний өөдөөс харан, эм бар нь амаа ангайн, нган, гэж эвшээгээд, галын дулаан илчийг таашаан сунгажээ. Эр бар нь чулуун дээрхи хүний хөдлөхөд ууртайгаар урхиран, сүүлээрээ гуяа ширвэжээ. Ойн хоёр хүн, тэр хоёр барыг хараад, нэгийгээ бариулсан сэтгэгдэл төрж, царай зүс нь үнсэн хөх болж, нэн социн хэлмэгдсэн байдал мэдэгдсэнд Шонхолой өндөр дуугаар барыг

- Ва, аминдаа хайртай бол, зайл, гэж хашгирахад нь эрэгчин бар нь муухайгаар урхирав. Гурван аянчин нэгэн зэрэг хавчаахай нумаа шүүрэн, өргөн хэнхдэг рүү нь харватал, бар дүүлэн сум ч элгэнд нь шигдэн, бар чурд хоёр хөлөөрөө өндөр ширээ чулууны ирмэгнээс савардан, амнаасаа цус сахруулан ход хоёр хөлөөрөө чулуу

маажилж, өөдөө толгойгоо өндийлгөтөл, Шонхолой чулуун сүхээ хоёр нүдэн хооронд нь тас хийтэл буулгав. Бух өвгөн барын суга уруу жадлаад, суга татах завдалгвй байтал, ард нь байсан ойн хоёр хүн сандран бархирч, өлөгчин барын толгой давхар чулууны дороос овгос гээд гарч ирэхэд, Залуудай хаш тэнигэр сүхээрээ хоншоор дээр нь тэнхээ мэдэн буулгаад орхив. Хоёр бар агшин зуур дөлд орж гэнэт барын доошоо ойчиход Бух өвгөн жадаа алдаж, өөрөө заяатай ойчсонгвй. Шонхолой шүүрэн татаж Бухыг тогтоож авчээ. Хоёр догшин араатан дайран довтолж, түүнийг няцаасан энэ явдал, хэдхэн хором дотор болсон хэрэг бөгөөд, гурван дайчин яаран нум сумаа шүүрэн доошоо өнгийн харваас, гэнэт бар нь ойчоод, босож ядан тарчилж байв. Өлөгчин бар эмзэг хоншоороо хага цохиулж, шархнаас нь олгойдох цусанд хоёр нүд нь юм харахгүй болоод, сүүл нь түвдэгт ороод халсандаа ухасхийж, тавхар чулууны ёроол толгойгоороо түс хийтэд мөргөөд, ргүв өвчин туссан юм шиг сүүлээ даган эргэж эхлэв. Гурван аянчин, өндөр чулуун дээрээсээ дорх түвдгийн гэрэлд хоёр барыг харваж, хэдэн сум тавимагц өлөгчин барын хойд хоёр хөл нь хойшоо жийн шөрмөс нь таталдаж, цусаар бөөлжиж, урхирсаар хөдлөх нь удаан болж% баахан муужирсан байдалтай боллоо. Нөгөө гэнэт бар нь олон шархандаа б ас л муужирчхэдий бөх толгой боловч, хөл дээрээ тогтож чадахгвй, босон унан тарчилж байв. Том араатныг бараа болгон дагалдаж, чадвал юм олж идэх, явдал олзноос нь цус нөжийг нь ч долоож идэхийг горьдожявдаг цөөвөр чононцор мэт араатан тэр хоёр хутган соёотын барьж идсэн хүний гэдэс дотроос нь олж идээд уоам ч хорхой нь хүрч өлөн шүлсээ гоожуулж байснаа өндөр тавхар чулууны ёроолд түвдгийн гэрэлд хоёр хутган соёотыг чулуун дээрх амьтан өөд цоройж үсрэн халдахы нь хараад, чулууны өвөр талд эргэж тарчилж байхы нь ойртон ирж, гайхан харцгааж оцойн сууж байгаагий нь чулуун дээрээсээ гурван аянчин галын гэрэлд ажиглан харж Шонхолой

- Харвахад сум хайран юм уу даа? Ингээд л голоо тасартал тарчилж байтал бусад амьтан ч бидэнд халдахгвй. Халдвал энэ хоёрт л халдана гэлээ. Ихэрэс Бух өвгөн доошоо өнгийж хараад,

- Ээ дээ тэр зөв байх, миний хайран жад, барын хаанд шигдээстэй, иш нь хугарч дахин ишлэх л хэрэг гарав уу даа? Бидний хэдэн годоль ч гэсэн ингэж өнхөрч тарчилж байхад нь хугарч гүйцэх нь дээ. Манагаар жад годлио сэлбэхгвй бол алсын аяны хүнд горьгвй шүү гээд, тавхар чулуун дээрээ асаасан түлээ нэмэн, толгойгоо гадагш нь, хөлөө галын зүг жийж гурван аянчны хэвтэхэд, нөгөө ойн хоёр хүн, бас дуурайж хөлөө дотогш, толгойгоо гадагш харуулан хэвтээд, цөм ойн мод, шөнийн салхинд орой нь шуугинас хийх анир, тавхар чулууны ёроолд хоёр хутган соёотын гол нь тасраагвй, үхэж ядан тарчлах чимээ, цөөвөр, шарнуудын улих гийнах дуу гарч байгааг чагнасаар төдхөн унтаад, хааяа хааяа босож, галдаа түлээ нэмж байв. Шөнө дундаас хойш чулууны ёроолын түвдэг ч унтраад тарчилж байсан хоёр хутган соёотын тэнд юм ноцолдож архирах юм зулгааж зажлах, яс шажигнах чимээ гарах болсныг Залуудай нойр дундаа сонсож өнөөх хоёр догшин араатан, чоно нохойд идүүлж байгаа юм байна гэж бодож хэвтлээ. Бух Шонхолой хоёрыг шөнө босож галдаа түлээ хийх бүр, ойн хоёр хүн нойрмоглон инээмсэглэж маш талархсан сэтгэлээ мэдэгдэн хэвтэж, аугаа хүчит хань нөхөдтэй болсондоо их л баяртай байжээ. Үүр цайх үес гурван аянчин босоод, чулууны ёроолд өнгийн харваас, шөнийн олон цөөвөр шарнууд чбайхгвй, хоёр хутган соёотоос гагцхүү том соёт ясан

толгой, хэдэн яс үмхий гэдэсний төдийхөн үлдээд, хэдэн хугархай сум, , соёо шүдний ором орсон Бухын жад хөсөр хэвтэн авай. Чулуун дээрээс гурван аянчны нум сумаа агсаж, сүхээ барин буухад , ойн хоёр хүн бас дагалдан бууж, хоёр догшин махчин бараас үлдсэн сэг ясыг гайхан харж, аянчныг сумныхаа чулуун зөв, хирисийн ээрээр хийсэн зэв өвс шороон дунд эрэхэд нь учрыг мэдэж эрэлцэн туслав. Зэвээ олоод, Бух Шонхолой хоёр дутуу сумаа нөхөж хийхээр тогтож, годольд хэрэглэх мод тайрахаар одов. Залуудай өглөөний хоолонд идэх үм олох гэж, ёвхээ бүснээсээ агсаад, нум сумтайгаа ойн зах чиглэхэд нь ойн хоёр хүн бас дагалцах гэсэнд Бух өвгөн

- Наадуул чинь хэл ам мэдэхгүй харь омгийн хүн. Чамайг ганцаараа явахад чинь басаж, нум сумы чинь булаана гэж оролдож магадгүй. Танихгүй газар , хэл мэдэхгүй хүнтэй болгоомжлох хэрэгтэй. Наад хоёр чинь биднийг дагаж, идэх жимс, төмс түүг гээд дохиогоор тэр хоёр ойн хүнийг хамт явъя гэж зангахад нь тэр хоёр алцгар хүн инээмсэглэн, Бух , Шонхолой хоёрыг дагав. Балар цагийн ой шугуй , тал хөндий ан амьтнаар маш элбэг тул Залуудай ойн захад бөр гөрөөс үзээд, салхин дороос нь сэмхэн гэтэж годоль харвам газар ойртоод хоёр гөрөөсний нэгий нь ганц сумаар унагаж, гол нь тасраагүй байсныг сүхдээд гэдэс дотры нь гаргаж, гөрөөсөө үүрч, урд шөнө хоносон давхар чулууныхаа тэнд хүрч ирвээс , түүдгийн нурман дунд ганц нэг цог байсан тул үлээж, гал асаагаад, элэг шорлон шарж гөрөөсний хоёр гуяыг бас шарж эхлэв. Чингэж байтал, модон дотроос өнөөх ойн хоёр хүн хиншүүний үнэрээр хүрч ирэхдээ, өвсөнд хэлхсэн мөөг, бондгор бондгор газрын идээ авч ирсэнд , Залуудай түүний нь авч галд халаасан чулуунд хавчин болголцов. Асар удалгүй Бух , Шонхолой хоёр нэг баглаа годоль хийх яргай шиг шулуун мод авчраад, цахиур чулуун хутгаараа хальсалж, шүүрхий шарсан махнаас ойн хоёр хүнтэй хуваадцан , бүгдээрээ өглөөнийхөө хоол идэв. Чингээд гурван аянчин, гөрөөснийхөө цээж махыг тэр ойн хоёр хүнд өгөөд, явахыг завдтал, өнөөх хоёр хүн салан хагацах дургүй, аман дотроо юм шулганасанд Бух өвгөн инээж,

- Энэ хоёр маань манаас салах дургүй, хамт Бай кул хүрэх гэж байна уу даа ? гэж тэр хоёрыг модондоо ор гэж дохиод, өөрсдийгөө хойшоо явна гэж дохиод өнөө хоёр харин биеэ заагаад, бас хойшоо явалцана гэж дохиогоор заасанд ,

- Эднээ дагуулаад явах уу? гэж хоёр нөхрөөсөө асуув.

- Дагавал дагаг л даа. Хаа хүртэл бидэнтэй явахы нь үзье гэж Шонхолой , тэднийг хамт явъя гэж дохиод, тэр хоёр алцгар маш их баярлав. Чингээд хамт хэдэн хоног явахад, тэр хүн, хамар нь гурван аянчнаас бүр ч илүү. Араатан өвс модонд байгааг ер андахгүй, их холоос үнэрий нь мэддэг байв. Бас ой модон дотор идэх жимс ногоо, газрын идээ төмс мөөг олж танихдаа сүрхий чадамгай бөгөөд булаг шанд ус модон дотор олохдоо тун ч сурамгай байв. Бас эмт өвс цэцэг навч үндсн танихуяа хэцүү тийм амьтан байв. Тэр учраас гурван аянчин бас тустай хань хамсаа болж ижилсэн дасалцав. Хижээлхэн нэгий нь Үхүү, залуугийн нь Гекү гэж нэртэй юм байна гэж мэдэж авав. Чингээд Үхүү гэсэн нь шар шувуу гэсэн нэр юм байна. Гекү гэдэг нь Хөхөө гэсэн нэр юм байна гэж мэдэж авав. Юм дуурайхдаа сүрхий авъяастай залуу нь Үхүү Үхүү гэж дуугараад шар шувууны дуугарах, хөдлөх маягийг үзүүлэн Гекү, Гекү гээд хөхөө донгодох нисэх байдлын дүрэм үзүүлсэнд гурван аянчин тэр хоёр ойн хүнийг шувууны нэртэй хүн юм байна гэж мэдэж авсан билээ. Бух, Шонхолой хоёр тэр хоёр хүнд аятайхан бороохой хийж өгөөд нэг нэг цахиур сүхэнд модон иш

гөрөөсний шөрмөс шандсаар тогтоон бэхэлж хийж өгсөнд тэр хоёр баярлаагвйгээр баярлаж хуучин муу бороохойгоо хаяв.

Нэгэн өдөр таван аянчин баруугаараа их модтой , зvvн талаараа их асга , хад чулуутай хөндий уруудаж яваад тоо томшгвй олон хорхойд шилмvvсээ идvvлсэн хар модны захад хврэв.Хврэн хар өнгөтэй нvцгэн болсон нvдэнд тун жигтэй аягвй vзэгдэж,хэрэм буга гур зvр ойн олон ан огт дайралдахгвй гагцхvv биедээ vстэй вй тvmэн муухай хорхой хар модны оройн шилмvvс идэн барж завсар цэггвй бааж байх нь модон дорх газар цөм тэр хорхойн хивдэс баасаар хучаастай, хөндийн өвс ногоо хөхрөн харагдаж байхад нvцгэн модны шилмvvсгвй гишvv мөчир нь тоо мултарсан олон хорхойн шилмvvс хивэх найлзуур мөчир өөд уруу арваганан явах, баах гарилах чимээ нь намираа бороо орж байсан чимээтэй адил дуугарч чийг хөгцийн аягвй внэр ханхалж байсанд таван аянчин бушуухан тэр газраас холдох гэж ширvvлэн алхалж байтал том дархийн хажуугаас араатны внэр гарав.

-Ирвэсийн внэр гарч байна гэж хэлээд Шонхолой жадаа барин ,тэр дархийн ойр нь салхины доод талаас ойртов.Бух ,Залуудай , хоёр хавчаахай нумаа саадгаас сугалаад нэг нэг сум онилон хойноос нь дагав. Тэгтэл Шонхолой одоо айлтнши гэж гараараа дохиод тэр дархийн ёроол тушаа хврч очоод явган сууж доошоо шагайгаад ,ирвэсийн нэг зулзага шилэн хvзvvнээс нь атган нарнаж vзvvлэв.

Эцэг эх хоёх нь энэ хэдэн зулзагандаа баригдаад нvvн зайлж чадаагвй байх нь нэг их холдохгвй гөрөө хийж байгаа байх.Одоо болгоомжтойхон явъя гээд тэр зулзагыг хэвтэшинд нь тавьжээ.Үхvv Гекv хоёр хврч ирээд ирвэсийн зулзага харангуут,сэтгэлд нь урд ирвэст хорлуулж, отог омгийн хvн осолдож байсан нь санаанд орсон юм билvv, Гэнэт царай нь муухай болж хөмсгөө зангидан, нvдний нь харц ширvvн болоод, бороохойгоороо цохилон алав. Гурван аянчин , тэр хоёр ойн хvнээс, учры нь асууя хэл нэвтрэлцэхгвй, дохиогоор утга нэвтрэлцэхгвй тул арга буюу ирвэстэй тун их өшөөтэй л байж дээ гэж хий таамаглаад, юм хамаагвй алдагвй, албал хамаагвй хаядагвй заншилтай тул, тэр хоёрын маш хорсон алаад хаясан гурван зулзагыг авч гурвуулаа цахиур хутгаар туламлан өвчөөд, бvснээсээ агсах, сав хийнэ гэж төдхөн өвчиж авав. Чингээд нэг хадан хушуу тойртол, нэгэн сvрэг vхэр гөрөөс бэлчиж байх нь харагдав. Зарим нь хэвтэж, сэвсээ хивж, зарим нь бэлчиж, хэдэн том бух, хааяа хааяа сvvлээ ширвэн зогсож, арваад тугал тоглон давхилдаж, нэг хөгшин бух хааяа тэр тугалын зvг харж, ve ve огцомхон ууг, ууг, гэж дуугарч байгаа нь болгоомжилж бай гэж сануулж байгаа юм шиг. Ил цухуйн vзэгдвэл vхэр гөрөөс, тугалаа харамнан дайруузай гэж, дээгvvp нь уулан тал дагаж, өнгөрдөг юм билvv гэж харж байтал, тоглож байгаа тугалын дэргэд өвс ногоон дунд бараг мэдэхгвй хоёр цоохор юм хөдөлсхийх шиг болсныг Залуудай ажиглаад, Тэр тугалын барантай нэг хоёр цоохор юм хөдлөөд байгаа нь саяын дархин дор байдаг ирвэс vv дээ ? гэхэд нь Бух өвгөн, өлсөж улангассан энэ хоёр ирвэс лав олон vхэрт алуулна даа, та нар vзээрэй, аягвйдвэл, тэр ирвэсээс болж бид ч vхэр гөрөөсөнд хөөгдөж мэднэ. Мод бараадъя гэж модны захад сэмхэн хврч, өнөөх тугалд мярааж байгаа ирвэсийг ажиглавал, өвсөн дунд мөлхсөөр, захын нэгэн тугалд ойртмогц дvvлэн vсэрч дээр нь буугаад, агшин зуур хоолойгий нь тас татжээ. Тугал хагас дутуу нэг мөөрөөд ойчлоо. Бусад тугал сvvлээ сөхөж, сvргийн зvг мөөрөн, дутаатал, олон vхэр тэр унасан тугалын зvг дайран орлоо. Ирвэс өнөөх унагасан тугалаа шvvрэн толгойгоо нэг хөдөлгөмөгц, тугалын ар шилэн дээр тоохоод том том дvvлэн зугатаав. Нөгөө ирвэс нь ар

хударгын нь хамгаалсаар влдээд, тугалын захад ойр байсан нэг внээ бусдаасаа түрүүлэн ойртоод ирэхэд, өөдөөс нь урхиран дүүлж, нуруун дээр нь асаад, дөрвөн хөлийнхөө савар хумсаар маажлан, гүрээгий нь тасдах гэж ноцов. Амьд махаа уруулж өвдөхдөө тэр внээ муухай дуугаар мөөрөн, цовхчиж, нуруу зоон дээр нь мордсон ирвэсийг унагаах гэж оролдовч хвч хүрсэнгвй. Хачиг шиг наалдсан ирвэс хумс соёогоороо урсаар, внээний гүрээ тасдаж, цус олгойдон бие нь шарваж эхлээд, төдхөн ойчоод өглөө. Ирвэс тэр внээг ойчиход всрэн зайлаад, олон вхрийн дунд орж сандарчээ. Хойгуур, урдуур, зvvгээр, баруугаар нь давхиж явсан вхэр цөм тэр ирвэсийг бvслэн тойроод, хаашаа ч всрэн зайлах аргагвй олон эвэр тойрон хашжээ. Чингээд нэг урхиран дvлтэл, том бух толгойгоо сэгсрэн урт эвэрийнхээ взvvрээр ирвэсийг өлгөж аваад, сэжмэгц дvвлсэн ирвэсийн эрч, мундаг хвчтэй бухын сэжих хоёр таарч трвэсийн гэдэс хутгаар хага татсан юм шиг эвэрийн нь взvvрт ангасхийтэл өвчvvнээс сvвлээ хvртэл хага ярагдан, ирвэсийн толгой түрvv нь унжирсхийн газар ойчлоо. Олон вхэр, тугал вvрээд дутааж яваа ирвэсийг мартаад, гэдсээ хvv татуулан ойчсон ирвэс дээр овооролдож, мөргөн гишиглэж гарваа. Хvн бас энэ вхэр шиг байдаг шvv гэж Бух өвгөн тэр ирвэс дээр овооролдсон вхрийг хараад хэллээ. Дарж авбал цохих юмыг гаргахгвй, унаад хаашаа ч зайлахгвй, юман дээр овооролдон муугий нь вээж, муухайгий нь дуудсаар, нөгөө юманд чадуулж орхидог шvv гэж хэлээд,

- Нөхдөө, тэр тугал вvрсэн ирвэс бидний зvг айсаж явна. Зулзагы нь алснаас хойш, энэ араатныг ч вгвй хийнэ байгаа? Гээд нумаа шvvрэн бvгхэд, ойн хоёр хvн учрыг мэдэж, бас далд газар хоргодон тосов. Тугал вvрсэн ирвэс огт юм вvрээгвй мэт маш хөнгөн хөдөлж, всрэн дvвлэн давхисаар, салхины дээд талаас огт ажиггвй Бух өвгөн дээр орж иртэл, хавчаахай нумын хөвч тас хийгээд хирисийн эвэр, зэвт сум, тэр араатны омруу нь тус шав хийгээд шигдлээ. Хажуунаас нь бас Шонхолой, Залуудай хоёрын сум хавирга бөөрөөр нь орж, тугал вvрэн дvвлсэн ирвэс амандаа хоншоороос нь зуурсан тугалаа алдаж, өөрөө ч газар ойчоод өндөсхийхийн завдалгвй бас гурван суманд тусагдаж тийчилтэл, ойн хоёр хvн ухасхийж бороохойдож алав. Чингэтэл түрvvчийн ирвэс дээр овооролдсон вхэр сvвлчийн ирвэсийг анчинтай дайралдан тулахыг хараад, довтлон ирсэнд таван аянчин, тэр вхрээс зайлаар модны зvг гvйхэд Бух, Шонхолой хоёр ирвэсийн барьсан тугалыг шvvрэн гvйж, захын саглагар нэгэн модонд хүрэнгvvt яаран тэр модон дээр тугалаа аван гарлаа. Нөгөө гурван аянчин хойноос нь хөөсөн вхэр гөрөөснөөс дутаан бас ойр хавийн модон дээр гарав. Цус улайн внэр авсан вхэр догширч, таван аянчны авирч гарсан мод тойрон мөөрч, шөргөөгөөд, ер зайлах санаагвй, модон дээр хvнийг өчvvхэн хөдөлмөгц мөөрөлдөн, том том бух нь тойрон мөөрөлдөж, газар ухаад салахгвй сахин эргэв. Цаг алдаад яахав? Гэж модон дээр тугалаа авч гарсан Бух, Шонхолой хоёр тvvнийгээ цахиур хутгаараа өвчиж, нэг бух модон дороос нь салж өгөхгвйд, тугалын сэвстэй гэдэс гvзээг тэр бухны толгой эвэрт өлгvвлэн хаяв. Чингээд тугалынхаа мах өрөөлдөж, модны гишvvнээс ойчихгвйгээр өлгөөд бvдvvн гишvvн дээр аятайхан сууж аваад, сум ч цахиур хутгаа гаргаж, баглаатай годолийн мод засаж, хирисийн эвэр цахиур чулуугаар хийсэн зэв ээ годольд тааруулж шөрмөсөөр бэхлэн, тогтоож суух зуур хааяа хааяа доошоо харж байв. Хэдэн бух сахиад хэвтчихсэн зайлах шинжгвй тул Шонхолой, Бух хоёр хэдэн сум хийж, гvйцээд тугалынхаа нэг өрөөлийг модны доод гишvvнд бууж, зэргэлдээ модны ойн хоёр хvний

звг шидэхэд, тэр ойн хvн модонд асах авирахдаа шаламгай тул дор нь шvvрч авсанд ид гэж дохиогоор нэвтрvvлээд, сvхээрээ гишvv мөчир тайрцгаан , модон дээрээ гишvv дамнан , хэвтэх хэвтэр засаж авав. Тэгээд тугалынхаа өрөөлийг нэг гишvvнд аятайхнаар өлгөөд модны хаг тvvгээд нэг хэдэн хуурай гишvv тэр модон дээрээсээ цавчиж аваад, цахиур хавиран, уул хаг хоёр хавсран vлээж, хоёр гурван гишvvний vзvvрт гал асаагаад, тэр цучлаараа өлгөөстэй өрөөл махаа шарж борлуулаад, асаж байгаа модыг шатсаар богино болоход ондоо нэг хуурай гишvvг vзvvрээс нь асаан барьж, богинодсон цучлаа vхрийн звг хаяж, vргээсхийх заваар, Залуудай модноосоо буугаад нэг ухасхийж, Бух Шонхолой хоёрын сууж байсан модон дээр гарч ирэв. Бух гөрөөс хойноос нь хөөх гэж давхийгээд шаламгай залууг гvйцэж амжсангvй модон дээр гаргажээ. Гурван аянчин тэр бvдvvн модон дээр тугалынхаа өрөөлийг гурван гишvv нэгэн зэрэг барин шарсаар, тун аятайхан болгож, саглагар гишvvн дээр хэвтэр зассан газраа тохитойхон сууж, аятайхан хооллоод, нөгөө модон дээрхи ойн хоёр хvн ч тугалынхаа өрөөлийг ерөөс тvvхий мах идэж явдаг, гал мэдэхгvй амьтан болхоороо манай гурван аянчны шарсан махнаас дутаагvй амтархан идэж байгаа нь хутга огт хэрэглэхгvй болоод байжээ. Цахиур чулуун хутна хэрэглэж сурсан хоёр Чонос нэг Ихэрэс цөм цахиур, цөм хутга гаргаад, шарсан махаа аятайхан огтолж, vхэр гөрөөсөнд хөөгдөн ээрvvлсэн хvн гэмээргvй тохитой хооллож, модон дээрхи хэвтэр дээрээ хажуулаад, дор нь зэрэн ёахиж байгаа хэдэн тэнэг vхэр гөрөөсийг огт мартжээ. Чингээд нилээд удтал хэвтэж амраад, доошоо харвал өнөөх vхэр гөрөөс огт явах санаагvй сэвсээ хивж, хэвтэхэд Залуудай,

- Ам баахан цангаж байна. Ус уувал юутай билээ гэж горхины звг харан санаа алдав.

- Үхэр холдоогvй цагт ус санах хэрэг биш. Бух өвгөн инээмсэглэв. Аягvй бол энэ vхэр нар шингэхээс нааш зайлахгvй, шөнө араатан гvйдэлтэй явж болохгvй. Энэ модон дээр л хонох болно байх гэхэд,

- Тэгвэл энэ одон дээр л хонохоос доо гэж бvргэдийн vvр шиг хэвтэр дээрээ сунаад, хэвтэж алсын бараа харж байтлаа зvvн звг хадан хясааны тэнд нэг хэдэн бараан юм хөдлөх шиг болсонд ажиглан хартал, нэг vзэгдэн , нэг далд орж, наашилж байгаа байдалтай ажээ.

- Тэр зvvн хойно нэг юм хөдлөөд байх шиг гэж авдаа хэлэхэд нь Шонхолой ширтэн хараад,

- Эр эм хоёр арслан байна. Манийг ээрсэн vхрийг хөөх юм ирж яваа юм билvv? Гээд гурвуул чимээгvй ажиглан хэвттэл, тэр араатан нь ойртож модон дээрээс харахад эр арслан нь бараан зогдортой, сvрхий том амьтан, дэргэд нь урт шар эм арслан зэрэгцэн явж байгаа нь хөдлөх байдал тун гавшгай.модон дор хэвтсэн vхэр гөрөөс тэр айсуй буй араатныг хараахан мэдээгvй тул санаа амар, сэвсээ хивж хэвтнэм бөгөөд vнээ тугал бэлчих нь бэлчиж, хэвтэх нь хэвтэж байв. Дээрээс нь харахад хоёр арслан зарим газар хотгор дагаж маш хурдан давхиад vхэрт vзэгдэм газар мярааж гэтсээр улам ойртож, захын нэг залуу vхэрийн нуруун дээр дvvлэн гарч, нуга даран унагаалаа. Тэр vхрийн амь тасран, муухай дуугарч газар пидхийтэл ойчих чимээгээр vхэр тугал, тvр хийтэл vргэж зугтаагаад, модны ёроолд хэвтэж байсан хэдэн бух ухасхийн бостол, эм арслан дvvлж нэг тарган гунж тоглож байгаа юм шиг унагаж авлаа. Хэдэн том бух зугтааж, байгаа vхрийнхээ арыг халхлан хамгаалж, арсланы звг урт эвэрт толгойгоо бөхийлгөн урд хоёр хөлөөрөө газар ухаж, сөөнгө бvдvvн дуугаар мөөрөв. Эр арслан гавар унагасан vхрийн хvзvvн дээр нэг хөлөө тавиад сvртэй том

дуугаар урхирсанд эм арслан бас сүр нэмэн урхирав. Тэр хэдэн бух үхэр сүргээ бар ирвэсээс зоригтой хамгаалдаг боловч арсланаас баахан эмээн сүрдсэн байдалтай хялайн хялайн ухарсхийсээр үхэр сүргийнхээ хойноос тэмүүлээ.

- Хоёр арслан нэг үхрээ идэж бараад, эр арслан нөгөө үхрийг үүрээд, хадан хонгил уруугаа аваад явав. Аянчин ээрүүлж байсан үхрээсээ хоёр арсланы ачаар салаад, тэр хоёр араатны холдохыг сэм хүлээж байтал арслан ч далд орлоо. Нар ч баруунаа хэлбийлээ.

- Энэ газар лав энэ хоёр арсланы ан хийдэг нутаг байна. Ондоо том араатан энд байхгүй байх ёстой, хоёр арслан ч өнөөдрийнхөө хоол олж идээд, маргааш өглөө ч идэх юмтай болсон хойно өнөө шөнө дөө хэвтэшнээсээ гадагш гарахгүй байх. Эндээ хоновол бид шөнө ямар араатан хаанаас халдахав? Гэж айлтгуй. Шарнууд, цөөвөр иинэ бидэнд халдаж зүрхлэхгүй нь лавтай. Тэгэхлээр бид одоо яавал дээр вэ? Бух авгай эндээ хонох уу? газраа хороож нэг хэсэг явах уу? гэхэд нь Бух өвгөн

- Энэ хорхойд идүүлчирсэн модон дунд хоносноос нэг баахан яваад үзнэ байх аа. Энүүнээс арай сэргэлэн гавар хүрч хоноё гэхэд нь Шонхолой, Залуудай хоёр зэр зэвсгээ аваад доошоо буув. Ойн хоёр хүн гурван аянчныг модноосоо бууж, алсын зам хөөх санаатайг мэдээд, бас яаран бууж сүхээ аянчныг дуурайн бүснээсээ агсаад, бороохойгоо атгаж, найрсгаар инээмсэглэн дэргэд нь хүрч ирэв. Чингээд зүг барин алхсаар таван аянчин горхи дагаж амныхаа цангааг гаргаж, уснаас уугаад, хэдэн цүрх нугас харваж, усны шувуу маш олон тул бас баахан явах зуур хэдэн галуу харваж, оройн хоолны юмтай болж авлаа. Цаашлан алхмаар хулан, тахь, зээр, тэмээн гөрөөс бэлчсэн талаар явж, тэр олон амьтан айван тайван байгааг үзвэл лав аюулт араатан үзэгдсэн шинжгүй байна гэж баруунаа хэлбийсэн нарны ташуу гэрэл сацрагт хариуран харагдах талын толгод зүүн талд сүүдэртэй болж байгааг ажиглан харж, хонох газар сонгох санаатай явтал Залуудай хойд зүгт нэг сонин хэлбэртэй онцгой уул байхыг дэргэд нь очиж үзмээр санагдаж, Бух өвгөн ч бас сонирхож цөмөөрөө тэр уулын зүг чиглэв. Ойртох тусам нь газар тун сонин хар бараан, хүрэн чулуу дайралдаж, хөөс шиг нүхтсэн байдалтай бөгөөд чанар маш хөнгөн. Уулын орой нь хутгаар огтолж авсан юм шиг тэгшхэн бөгөөд байдал нь овоолон босгосон юм шиг тэгш хэлбэртэй. Уулын хормойгоо бор гөрөөс, зээр бэлчин явнам бөгөөд хүн ойртоход цочих, үргэх шинжгүй харин ч сонирхон харах тул Шонхолой тэр байдлын ажиг,

- Энэ хавьд л лав хоёр хөлт хүн яваагүй газар байна. Танихгүй хүн, дайсагнах омогтон байх вий гэж зоволтгүй, бас аюултай араатан ч гайгүй байж магад газр байна. Саяын хоёр арсланий эзэлсэн газар нутаг юм болов уу даа? Гэлээ

- Энэ сонин уулын орой дээр гарч хоновол яана? Гэж Залуудай санал гаргаваас, өвгөн Бух

- Тэгвэл тэгж үзсүгэй. Модон дээр хонож болдог юм, уулын орой дээр хоноод үзэхэд яадаг юм бэ? гэж инээлээ. Тавуулаа тэр сонин хэлбэрт уул уруу мацан авирч орой дээр нь гартал тэр уулын орой нь нэг их том тогоо шиг бөгөөд гол дундаа төгрөг нууртай, тэр нуур тойрон мод ургажээ. Гаднаас харахад тэр нуур тойрон ургасан мод огт харагдахгүй. Нуур хүртэд доошоо нэлээд уруудан буух тийм өндөр хүрээн дотор байгаа юм шиг хашаастай нуур байжээ. Залуудай тэр сонин уулын орой дээр нь буюу чухамлан хэлбэл, дотогшоо хонхорын гаднах зах дээр нь гараад, тэр гол дундах нууры нь хармагц,

- Юутай сайхан уран тогоо шиг бvтсэн уул бэ? гэж гайхан өгvвлэхэд нь Бух өвгөн
- Нээрээ уран хvний хийсэн уран тогоо шиг уул даа. Хожим хойно энэ сайхан нутгийн эзэн болох хvн энэ сонин сайхан ууланд манай Залуудай шиг бас л уран тогоо гэж нэр өгөх болтугай гээд тэр уулын оройн тогоо шиг том гэгчийн хонхорын голд нь байгаа нуурын зvг уруудан буулаа. Бусад дөрвөн аянчин Бух өвгөний хойноос дагалцан буугаад, нуурын захад очиж vзвээс, болор мэт тунгалаг сайхан устай, тэр нуур доош нь өнгийн харахад хөлгvй гvнзгий, бусад нуурын ус нь эргээсээ холдож байж сая гvнзгий болдог аваас тэр уулын оройн голд нь байгаа нуур, яг доошоо өрөмдсөн юм шиг эргийн аль ч талаас очоод vзэхэд доошоо эгц чиглэсэн хөлгvй гvнзгий устай байгаа нь Ихэрэс Бух өвгөн, Чонос омгийн Шонхолой, Залуудай эцэг хvв хоёрт их л жигтэй санагдавч учир утгы нь олж чадсангvй дэмий л гайхаж, ийм сонин газар байдаг ажээ гэлцээд нуурын захад модны ёроолд хонохоор болж, гишvв мөчир тvвж, цахиур хавиран гал асаах боллоо. Ижилсэн дагасан хоёр ойн хvн, цахиур хавирах бvр маш сонирхон гайхдаг тул, бас л Бух өвгөнийг цахиур хавирч, уул дээр оч унаад, утаа гарч уул шатан хуурай хөвдөнд гал авалцан асахийг анх сая vзсэнтэйгээ нэгэн адил тэсгэлгvй сонирхон харж суув. Чингээд удалгvй гал дvржигнэн асаж, галуу нугасны өд ноолууры нь зулгааж, гэдэс дотры нь цахиур хутгаар хагалж гаргаад, модонд шорлон, галын захад хатгаад илч нөлөөнд шарж болгох вес нар чхэдийн ороод, салхигvй намуун сайхан бөгөөд өөдөө харахад хар хөх огторгуйд од нь тvгээмэл баахан доошоо харвал, хар хөх огторгуйгаас илvв бараан хар юм эргэн тойрон харлаж, гол дунд нь их дор нуурын захад тvвний хавьд модны ёроолд хvн сууж байгаа нь ямар сонин юм бэ? гэж Залуудай дотроо бахдан, Бух өвгөнийг нутагт нь хvргэж өгөх гэж авыгаа дагаж, холын сонин аян хийж, урьд vзээгvй юмаа vзэж, их юм сурч яваа даа баярлан бахдав. Ойн хоёр хvн ч бас ийм сонин газар хоног тааралдсандаа баяртай байгаа мэт галын хажууд жарган сууж, нам дуугаар юм шулганалдан, шувууны мах болохыг хvлээж байв. Удалгvй шарсан шувуу мах ч болж бvгдээрээ амтархан идэцгээгээд, Бух, Шонхолой хоёр галын хажууд хэвтцгээв. Залуудай тэр ойн хоёр хvний дэргэд суугаад тэдэнд хэл зааж, цаад хоёр нь хичээнгvйлэн суралцаж, хэлж өгсөн шинэ vгий нь шивнэн давтав. Чингээд бvгдээрээ эрт сөнөсөн тэр галт уулын амсар дотор өрхөнд нь тогтсон хөлгvй нуурын захад унтацгаав.

Таван аянчин өнжин хонон явсаар хойшоо урссан нэг том голын хөвөөнд хvрч vдлэх вес, Бух өвгөн усны шувуу янз бvрийн загас нэн илбэг тэр голын ус харж баахан бодлого болоод, дагаж явсан хэдэн нөхөртөө

-Энэ том гол лав нэг хоёр гол мөрөн дамжаад манай нутгийн Бай кул гэдэг их далайн нуурт хvрэх ус шинжтэй байна. Загасны нь байдалыг ажвал манай тэр Далай буурал аавын усанд байдаг загас байх шиг байна. Тvвгээр бодоход лав энэ голын ус, Бай кул нуурт ордог нь зайлшгvй болно. Нөхөд бид энд хонож өнжиж байгаад нэг сал хийгээд уруудвал, биенд амар аминд аюул багатай болов уу? би сал хийж чадна. Бvгдээрээ мод огтолж аваад сайн сал хийж дээр нь саравч босгоод нар бороонд зоволтгvй, саравчин доор унтах газар засаад галаа ч гэсэн сал дээр тvлээд явж болно гэхэд нь

-Сал дээр яаж гал тvлдэг юм бэ? гэж Залуудай сонирхон асуужээ.

-Манай Ихэрэс омгийн улс усанд хэзээний чадамгай, сал дээр чулуу шороо зузаалан, дэвсээд дээр нь гал тvлж болдог юмаа гэж инээмсэглэв. Чингээд Бух

өвгөний сонгон заасан мод огтолж унагаад, голыг зүг өнхрүүлэн аваачиж, бургас мушгин холбож сал хийв. Бух өвгөн салаа залах залуур хийж, салхи борооноос хамгаалах саравч дархлаад, Үхvv , Гекvv хоёроор туслалцуулан гал түлэх газраа хавтгай чулуун өр хийж, шороо зөөлгөн чулуугаар хашуулж бэлтгүүлээд, саравчин дотроо таван хүний хэвтэрэнд хөвд цагаалж, өвс зэргийг дэвсүүлж , дээр нь ангийн арьс тавиулаад, түлшинд хэрэглэх , хуурай гишvv вйс, хөвд түвлгэн сал дээрээ ачуулав. Залуудай тэр завсар сал хийж, байгаа дөрвөн хүний хоолны зүйл дааж, загас гөөгдөх, сэрээдэх, гэрдэх зэргээр загас барин, усны галуу , нугас харваж, Бух өвгөний заавраар зарим том загас давсалж, зарим нэгий нь утаж хүнсний нөөц хийв. Галуу нугаснаас бас нэг хэсгий нь модонд өлгөж, дор нь гал түлэн, утаа шингээж, ялаа батгана сууж, үнэр танар орохгүй болгов. Загас, нугас, галуу жигтэйхэн элбэг тул , хүнс базаахын зэрэгцээгээр бас өглөө, өдөр, оройн хоол тасалдуулахгүй хийж , тэр загас шувууны махан хоолон дээр нь Үхvv, Гекvv хоёр янз бүрийн үндэс төмс түвж, элдвээр найруулан буйлуулсаар, сал хийж хэд хонох ves , таван аянчин хоол нэн элбэг, хийх ажил ч нилээд их. Тэнгэр ч маш цэлмэг, газар ус ч тун тайван, ер аюулт араатан огт үзэгдэхгүй, хэл ам, учир зүг нь мэдэгдэхгүй, айлгаж сандраах, байлдаж ядраах, харь омгийн хүн амьтан ч огт үзэгдэхгүй сайхан байлаа. Чингээд хамаг юмаа цэгцэлж сал дээрээ ачаад, салаа аргамжих сайн аргамж хийн гэж үхэр гөрөөсний сүрэг бэлчин буй зүг Шонхолой, Залуудай, Гекvv гурав очихоор болж, хоёр Чонос нум сум, жад, сүх авч Гекvv бороохой, сүх хоёроо аваад явах гэтэл, голын тэртээ бургасан дотор үхрийн чимээ гарч, олон үхэр усанд оров. Огт хүн үзээгүй бололтой, ер хүнээс айх сочих янзгүй, санаа амар ус уув. Бух өвгөн Шонхолой, Залуудай хоёрыг даллаж, сал дээрээсээ дуудаад, голын тэртээ ус ууж байгаа, үхрээс нэгийг харвая гэж дохисонд хоёр Чонос сал дээр аяархан гарч харваас голын цаад талд ус ууж байгаа үхэр элбэг, хавчаахай нумын сум тусам газар тул, гурвуул нэг үхэр харвахаар болж, зэрэг гурван сум тавихад, тэр үхэр, сандарч эргэтэл, бас гурван сум бөөрөнд нь тусаж, тэсгэлгүй өвдөхөд, мөөрөөд голын захад гарах гэж зүтгэтэл, цаана нь байсан үхэр зам тавьж өгөхгүй тэр самбаанд бас гурван сум тусаж, үхрийн тэнхэл муудав. Бусад үхэр нь учир мэдэхгүй, урьд өмнө нь алс холоос хүнд харвуулж үзээгүй тул, голын тэртээх хоёр хөлт хэдэн амьтнаас болж нэг үхрээ хүнд шарх олсныг огт мэдсэнгүй, дэмий л цусны үнэр аваад мөөрөлдөв. Шарх олсон үхэр эргийн тушаа баахан элс шавартай газар тохиолдсон учир шаварт шигдэн, муухай дуугарч ам хамраар нь ус орж, цацаж эхлэхэд, бусад үхэр айн цочиж эрэг дээр гараад өгөв. Холхон байсан үхэр харин ажиггүй ус ууж, гагцхvv шархтай үхрийн дор ус ууж байсан үхэр, цусны үнэр авч, баахан сандран ухарсхийв. Өнөөх шаварт шигдсэн үхэр, хэдэн суманд тамир нь тасарч, гарах гэж оролдох тэнхээ нь тасарч, улам шигдээд, цацаж хахаж хэд муухай дуу гараад, усанд хэвтээд өгчээ. Бусад үхэр нь хорлох дайсан үзээгүй тул хамраа баахан шуухинуулсхийгээд , уснаас гарч, удалгүй цөм бургасанд далд ороод, ганц шаварт шигдээд үхсэн үхэр л эргийн усанд үлдлээ. Бух өвгөн залуураа барин салаа хөдөлгөж, голын тэртээх бургасны захад үхрээд, үхрийн тушаа салаа ус өөд татаж зогсоогоод, толгойгий нь сүхээрээ салгаж, гэдэс дотры нь гаргаж хаяад, салдаа үхрээ чирэн ойртуулж гаргаад, ус урсгал даган уруудлаа. Бух өвгөн залуураа барин, Шонхолой үхрээ сал дээрээ өвчиж, Залуудай , Үхvv, Гекvv гурав махы нь эвдэхэд туслалцав. Ийм бэлэн юм олдох гэж юутай сайхан хэмээн Бух өвгөн баярлаж, салаа аргамжих ч юмтай боллоо. Хүнсний хойноос ч

зоволтгвй боллоо гэж их л урамтай явав. Үхvv, Гекvv хоёр бас их баярлацгааж, салаар явж vзээгvй, ойн тэр хоёр хvн , нар салхинаас халхлах саравчтай, зөөлөн гэгчийн хэвтэртэй, сал дээр суугаад явахдаа , vзээгvйгээ vзэж, тун ч хөхvvн явжээ. Бух өвгөн Шонхолой, Залуудай хоёрыг салын залуур барихыг заан сургаж, ээлжээр залах боллоо. Үхvv, Гекvv хоёр , Залуудайтай тун сайн болж, салын залуур барих ээлж тохиолдоход дэргэд нь суулцан, ямар газар хаашаа залдагий нь сvрхий ажиглаж, бас Чонос vг заалган тогтоохыг их хичээж, Гекvv нь Үхvvгээсээ илvv авъяастай тул ойр зуурын юм ярьдаг болж эхэллээ. Нэгэн өдөр таван аянчны уруудаж яваа гол нь өөр нэг том голд цутган ороод, зvг нь мөн л хойшоо урсах тул Бух өвгөн ,

- Одоо санаа зоволтгвй. Ус бvхэн хойшоо цутгавал манай зорьсон их Бай кул нуурт цутган орно гэсэн vг. Харин сал явж болохгvй боргио дайралдвал осолтой шvv. Усны чимээ их болж, урсгал ширvvсээд ирвэл намайг унтаж байсан ч мэдэгдэнэ шvv гэж Залуудайд захъжээ. Салаар явахад тун таатай, биеэнд зvдэргээнгvй тул Бух , Шонхолой хоёр хавчаахай нумандаа хэрэглэх сумны млд сайхан хатааж засаад, хирисийн эвэрээр олон зэв хийж авлаа. Гекvv тун авъяастай тул сумны мод засалцах, хирисийн эврээр зэв хийхэд туслалцсаар нилээд дvйтэй болсоо тул Шонхолой нэгэн өдөр монос огтолж, хавчаахай нум хийж өгсөнд, Гекvv баярлаагvйгээ баярлаж, сум онилох татах зэрэг барил заалган, салыг эргийн бургаснаас уяж, vдлэх вес Залуудайгаар заалган харваж vзээд, зэвгvй булцуут годлиор бай харваж сургууль хийх боллоо. Үхvvд Шонхолой Дvvгvvрээр чулуу чулуудахыг зааж өгсөнд ойн тэр хvн бас сонирхон баярлаж, сал дээрээсээ чулуу дvvгvvрдэж, явдаг болоод нэг мэдэхнээ сvрхий дvvгvvрчин болж орхилоо. Нэг орой Бух өвгөн залуураа бариад, өргөн голын хоёр эргийн бургасны навч намаа, зөөлөн салхинд шуугинахыг сонсон явах вес Залуудай дэргэдээ суусан Үхvv, Гекvv хоёроос - Та хоёр тэр нэгэн vдэш, махчин барт нэгийгээ бариулаад, манай гал дээр гvйж ирэхдээ, хаанаас хаачиж явсан билээ? ямар омгийн улс болох байна та нар чинь ? гэж асуусанд Гекvv

- Чоносын vгээр хэлбэл, бид ойн хvн гэдэг. Ойн хvн дотроо бид Хумка гэдэг омогтон. Хумка гэж нэг шувууны нэр. Үхvv гэдэг шувуу бас Хумка гэдэг шувууны нэг зvйл. Манай хумка омгийн хvн олон байсан. Манай нэг хvн ойд хадын хvний өмсдөг юм олоод биедээ өмсөөд, тэр хvний бvх бие нvvр гарт муухай юм гарч, толгой бие , наранд халсан чулуу шиг халуун болоод vхсэн. Хумка хvн цөм vхсэн. vлдсэн хvнийг урт гартай, шар vстэй хvн идсэн гэхэд Залуудай

- Шар махчин гэв.

- Манай Хумка хvн , тэр урт гартай талын хvнийг хvн иддэг хvн гэдэг байсан. Их айдаг байсан. Тал газар манай Хумка хvн явдагvй. Хvн иддэг шар vстэй хvн ойд орж манай Хумка хvн харвал барьж иднэ. Хжмка хvн талын шар vстэй хvнээс их айна. Үнэрээр мэднэ. Үнэр их муухай. Үхvv, Гекvv Хелаки хvн иддэг хvнд баригдсангvй амьд гарсан. Тэгээд Хелакиг тэр шөнө ийм урт соёот юм барьж идсэн. Үхvv, Гекvv их айсан. Танай гал харсан. Танай галд гvйж ирсэн. Хvн иддэг хvний галд ирсэн гэж их айсан. Танай vнэр , хvн иддэг хvнээс ондоо байсан. Үхvv, Гекvv амь гарсан. Одоо Хумка хvн Үхvv, Гекvv байна. Бусад Хумка хvн муу өвчгөөр vхсэн. Би нvvр гар ийм болсон гэж цэцэг өвчний хомхруу , хогжруу дvрслэн vзvvлсэнд Бух Шонхолой Залуудай гурав тэр ойн хvний Хумка омогтон бодоо өвчин халдаж, хиар vхсэнийг мэдэв. Гекvv бас сэтгэл

нь ихэд хөдлөн, сайн сураагвй Чонос вг нь цөөдөх газар гар, толгойгоороо дохин звс царайгаа ярвайлгах, зэргээр вгийн дутууг дохио, хөдөлгөөнөөр нөхөж, цааш нь вргэлжлэн ярьсан нь

- Үлдсэн Хумка хвнийг талын урт гарт шар встэй хвн идээд, Хелакийг урт соёот идээд, одоо Үхvv, Гекvv амьд влдсэн. Гекvv Залуудайн явсан газар явна, суусан газар сууна, унтсан газар унтана. Үхvv бас Гекvvгийн явсан газар явна, суусан газар сууна, унтсан газар унтана. Үхvv бас Залуудайд дуртай, Залуудайн авд дуртай. Бух авд дуртай. Гекvv бас залуудайн авд дуртай, Бух авд дуртай гэхэд нь гурван аянчин , тэр ойн хвний Хумка омогтны гашуун тvvх сонсон сэтгэл уяран хөдлөв. Чонос, Ихэрэс омогтон Ойн хвн Хумка нараас илvv чадалтай, илvv олон хвнтэй, илvv боловсролтой омогтон гэж санахад сэтгэлд нь сайхан бөгөөд Хумка омгийн хамгийн сvvлчийн хоёр хвн влдээд, Чонос , Ихэрэсийг дагаж яваг гэж бодоход сонин санагдав.

Таван аянчин салаар уруудсаар олон хоног саадгвй сайхан явж, илэх хоол элбэг, бие чилээгвй, санаа амар аялж, Үхvv, Гекvv хоёр мэдэгдэхвйц тэвээрч махаллаа. Гекvv инээж, Залуудайд Хумка хэлээрээ нэг юм хэлсэнээ чонос вг болгон өгvvлрvvн

- Хумка хвн Чонос вг мэдвэл, Хумкагаар бодоод Чоносоор хэлж болно. Чонос вг олон. Хумка вг олон вгвй. чонос вг Хумка вгэнд вгвй. Жад гэж Хумка вгэнд вгвй. Нум гэж хумка вгэнд вгвй. сvx гэж хумка вгэнд вгвй, сал гэж хумка вгэнд вгвй. Чөрхи гэж хумка вгэнд вгвй, хутга гэж хумка вгэнд вгвй, олон вг вгвй. Чонос хвн чоносоор бодоод хумкаар хэлбэл, олон чонос вг Хумка вгэнд байхгвй. Гекvv , Үхvv вхнэ гэж уйтгарлан хэлэхэд, Залуудай сэтгэлий нь засах гэж,

- Гекvv - ийм тарган, махтай болсон. Үхvv бас ийм тарган болсон. Ойд ойн хвн олон бий . Хумка хвн олон болно. Гекvv бие сайн, Үхvv бие бас сайн гээд Гекvv чи тврvvн юу гээд инээсэн бэ? гэхэд нь Гекvv

- Талын урт гартай, шар встэй хвн, Хумка хвнийг барина, эндээс барина. Энд сайн байвал иднэ гээд Залуудайн ирvvнээс барьж взvvлсэнд, Залуудай инээж,

- Гекvvгийн эрvv их зузаан болжээ гэхэд нь Шонхолой, Бух хоёр

- Гекvv нээрээ хэлж байна шvv. Шар махчин хвн барьж идэхдээ эрvvгий нь тэмтрэн вээд, эрvvний өөх зузааныг урдаар иддэг гэж внэн шvv гэлээ. Чингэж явтал, өргөн голын эргийн хоёр талд хадан хясаа вээгдэх болж, урсгал баахан ширvvдлээ. Бух өвгөн салын урд взvvрт очиж зогсоод, урлах замаа ажиглан харж,

- Одоо боргиотой газар ойртлоо. Би залуур барья. Та нар хатгуур мод бариад, миний залуурт тусалж, хатга гэсэн газар зэрэг хатгаарай гэж , хөөсрөн буй усны урсгалыг ажиглан, голын урсгал нь, усан дунд энд тэнд цухуйж байгаа том ургаа чулуунд мөргөж хөөсрөн буйг сврхий ажин чулууны завсраар салаа гаргах гэж байдаг чадлаа гарган оролдов. Чингээд нэгэн хэсэг ургаа чулууны завсраар салаа гаргатал голын өндөр эрэг дээр бороохой, жад, чулуу барьсан нилээд олон хвн салчныг бургасны завсраар даган гарч ирсэн бололтой.

- Ээкvvр кvvр бисийс?

- Ийдvv комоннеэ ?

- Эргийн улс хашгиралдан, эрэг рvv зал гэж Бух өвгөнд дохин дохин хашгиралдаад , вгий нь эс дагасанд чулуугаар чулуудаж гарав. Зарим нэг нь ахар жад шидэцгээн, Үхvv чулуунд цохиулж, ус уруу ойчтол, Шонхолой шvvрэн барьж, саравчин дотроо оруулж авав. Залуудай, Гекvv хоёр хатгуур модоороо Бух өвгөнд тусалж, Гекvv нь

чулуунд хацраа хага цохиулан цус гоожуулж байтал, Бух өвгөн бас нэг ахар жадаар хөлөө шархдуулж, Шонхолойг дуудтал, Шонхолой хавчаахай нумаа авч, харваж нэг хвнийг унагаад, нэг хвний ахар жадаа шидэх гэтэл нь эгэмий нь онож ус руу бууж байсан нэг хвний гуя уруу харван унагаасанд эргийн улс гайхан сандрал. Тэр самбаанд Гекvv бас хавчаахай нумаа авч, нэг хвнийг оносондоо баярлаж,

- Хумка хумка гэж хашгирав. Саравчин дотроо Үхvv босож ирээд, бас дvvгvvрээ барьж, чулуу хvнгэнvvлэн дvvгvvрдэж, хоёр гурван хвнийг шаравтал ойчтол чулуудаж,

- Хумка хумка гэж Гекvvгийн уриаг хашгиран дvvгvvрдэв. Шонхолой Гекvv хоёр харвалдаж, Үхvv дvvгvvрдэн, Бух өвгөн залуурдан, Залуудай хатгуураа хатгаж, салаа боргионы чулуун дундуур тээглvvлэхгvй гаргах гэж байдаг чадлаа гаргацгаав. Чингээд эргийнхэн салчны сум, дvvгvvрийн чулуунд хэдэн хvнээ шархдуулаад, тvрvvнийх шиг хамаагvй ойртохоо байж, дvvгvvрийн чулуу хvргэхгvй газар зайлбаас, Шонхолой Гекvvгийн сум туссаар тул, арга буюу холдон зайлаад, өөрсдөө чулуудаж vзвэл чулуу нь хvрэхгvй, ахар жадаа шийдээд vзэхэд жад нь хvрэхгvй болсонд ихэд тэсэж, ядан хорсоцгоож, муухайгаар хашгиралдан зарим нь чоно шиг улин тун их шуугилдан, сал дагаж эргээр гvйлдэв. Чингэтэл Бух Залуудай хоёр салаа боргион дундаас гаргаж, тайван намуухан урсгалтай газар ороод, дайснаас баахан хөндийрөх гэж нөгөө талын эргийг дагасхийж салаа залав. Сал дагасан дайсан салалгvй хашгиралдан дагах тул Бух өвгөн нөгөө эргийн зvг салаа залаад, энд бууж саравчаа бургас модоор зузаалья. Би ч хөлийнхөө шарх боосуу, та нар ч шарх олсон цохиулснаа аргалж vз гэв. Эрэг дээр гарч салаа аргамжаад, бургас огтлон, саравчаа дайсны ахар жад, чулуунаас хамгаалах гэж свлжиж, Залуудайгаар манаа тавиад, нөгөө эргийн дайсныг ажиглан сэрэмжил гэж захиад, Шонхолой, Бух, Гекvv, Үхvv бургас огтолцгоогоод Бух өвгөн тэр бургасы нь свлжин дайсны талаас шидэх чулуу жадаас хамгаалах халхавч босгох гэж салын гулд модны дагуу гадас хатган тогтоож, хооронд нь бургас свлжин, босоо хvний суганд хvрэх, хашилт хийж свлжсэн бургас, давхар бариж зузаалав. Залуудай эрэг дээрээсээ дайсныг ажиглан, харваас аянчныг салаа бэхэлж байгаад хорсон чулуудахыг оролдовч Залуудайн сумаа онилон харвах гэтэл нь Шидэхээ байж гэдэргээ ухардаг байв. Таван аянчин салаа дайсны жад чулуунаас хамгаалах гэж оролдсоор байтал нар ч баруунаа нилээд хэлбийв. Нөгөө эргийн хvн ч бас нилээд нэмэгдэв. Шуугилдах нь их болов. Чингэсээр нэг хэсэг нь эрэг дагуу доошоо гvйлдэв. Нэг хэсэг нь мод шатаан ухаж, хийсэн суман онгоц дамжлан авчрав. Бух өвгөн дайсны тэр бэлтгэлийг хараад,

- Одоо л горигvй болж эхэллээ. Доошоо гvйдэг нэг хэсэг нь лав, суман онгоцоор голын нөгөө талд гарч, биднийг жадан чулуудах гэж байгаа байх. Эд нь суман онгоцоор биднийг дайрах санаатай. Олондоо бардаж байгаа хэрэг. Бид нум дvvгvvртэй төлөөдөө л нэг хэсэг тулна. Дvvгvvрийн чулууг базааж авах хэрэгтэй байна. Годоль нилээд олныг Шонхолой бид хоёр хийж авсан маань одоо л хэрг болох нь дээ. Хамаагvй харваж болохгvй шvv. Годоль гарздвал аминд хортой болно шvv. Нэг годоль нэг дайсан, нэг дvvгvvрдэхэд нэг ёйлох таарч байвал ухаантай юм асан. Шонхолой бид хоёр ээлжлжн сал зална. Залуудай Үхvv Гекvv та нар харвах нь харваж, дvvгvvрдэх нь дvvгvvрдэхдээ чулуу годлио хамаагvй бvv зар. Дайсан гуя онгоцоор халдаж, сал дээр гарах гэвэл Шонхолой бид хоёрын нэг маань тулуур модоор дайсны онгоц тvlхэн зайлуулна. Тэгэхэд та нар чулуу годлиор биднийг

хамгаална шvv гээд салынхаа аргамжааг тайлж, дайсангvй талын эрэг бараадсхийн уруулав. Эргээс салыг довтлогсод салын хойноос нэг суман онгоц усанд тавин, хоёр хvн хатгаж, гурван хvн ахар жад хэд хэдийг тэврэн суув. Тэгээд онгоц нэгд салаас хурдан, хоёрт хатгах хvн хоёр тул салын хойноос хөөж, эрэг дээр байсан хvmvvc онгоцоор салын хойноос хурдлан явахад нь баярлан хашгиралдаж, өөрдийнхөө хvнийг зоригжуулан эрэг дагуу гvйлдэв. Бух өвгөн дэргэдээ жадаа тавиад, бар цоохор саадаг хоромсгоо агсаад суман онгоц санамсаргvй ойртоод ирсэнд Шонхолой, Залуудай, Гекvv гурвын харвахыг завдмагц ,

- Хоёр хатгуурчныг унага гэж хашгиран Бух өвгөн яаран нумаа суга татаж, годлио онилоод хармагц, дайсны онгоцны нэг залуурчин суманд харвуулан усанд палхийтэл ойчоод, нөгөө залуурчин нь хатгуур модоо усанд алдаад, онгоц руу гаа унав. Ахар жад барьсан нэг хvн шарх олж, онгоцондоо хөндлөн тавьсан жадаа усанд алдаж vлдсэн хоёр хvн ахар жадаа шидэх гэтэл нэг нь Үхvvгийн дvvгvvрийн чулуунд цохигдож, гэдэргээ алдлан унав. Ганц жадчин vлдсэн нь сандрахдаа ус руу всрэн ортол онгоцны хошууны салд ойртон тулсанд Бух өвгөн онгоцы нь татаж аваад vзvvрт нь басан аргамжий нь суга татаж, суман онгоцыг олзлов. Эрэг дээр сал дагаж гvйлдэгсэд нэг суман онгоцоо автагдсанд хорсон бархиралдаж, Үхvv тэр ус руу всэрч орсон жадчныг хэд дvvгvvрдэн, чулуу нь толгойги нь оносонд , усанд далд ороод, дахин vзэгдсэнгvй . Суман онгоцон дотор ойчоод хэвтсэн гурван хvн онгоцоо баригдсан гэж мэдмэгц, vxэлдэн тулах санаа шулуудаж, суман онгоцоо салын залуур шөргөөх чимээгээр ухасхийн босоод, залуураас барин нэг жадчин сал дээр всрэн гарлаа. Гэнэт хvн всрэн гар чирэхэд сал дайвалзан , залуур байрьсан Бух өвгөнөөс бусад нь хөл дээрээ тогтож ядан унацгаатал, бас нэг жадчин сал дээр жадаа тулан гарч ирэв. Эргийн олон хvн баярлацгааж,

- Дьавакал , дьавакал ва акал гэж хашгиралдан цовхчиж, салын зvг чулуу жад шидэцгээв.

- Жафамби, ваамби гэж Хумка vгээрээ хашгираад Үхvv бороохойгоороо нэг жадчины толгой дээр тасхийтэл буулган цохитол, нөгөө жадчин Үхvvгийн элэг рvv жадлахыг завдсанд Залуудай жадан дээр нь сvхдэж, хvчий нь бууруулсанд , Үхvvгийн гэдсий нь шалба зуран vзvvрээрээ сал шаасанд тэр жадчин хальтарч, ойн босохтой нь хамт Гекvv бороохойгоороо цохиж унагав. Шонхолой урт жадаа барин Онгоцонд тvрvvн Үхvvгийн чулуунд хуйхаа хага уохиулсан дайсны зvг жадлан дайрч, ус руу чичин унагав. Чингэтэл тулалдах вес залуур эзэнгvй болсон учир сал усны урсгалд цохигдон дайсны эргийн зvг ойртож, эргийн зарим хvн сал дээр гарсан хvн дээр туслах гэж усанд орцгоож, салд нилээд ойртож ирсэн тул, Бух өвгөн яаран залуураа шvvрэн нөгөө эрэг тийш салаа залав. Салын модноос барилцан хоёр гурван хvн өөдөө авиран гарахыг завдсанд Гекvv нэгий нь бороохойдож, Үхvv сvхээрээ нэгий нь цавчин, эгэмий нь тас цохитол хажууны нь хvн Үхvvгийн гараас шvvрэн хоёулаа усанд далд оржээ. Эргийн олон шуугилдан, сал дээрхи дөрвөн аянчин, нэгийгээ усанд алдсанд гашуудан хашгиралдаж, тэсгэлгvй хорссон доо хавчаахай нумаа шvvрэн усан дунд айсуу буй хэдэн дайсныг харваж гарав. Чингэж байтал Үхvv салын урд vзvvрийн тэнд цухуйн гарч, өөдөө авиран гарах гэж оролдтол, Залуудай гvйн очиж, Үхvvг татан гаргав. Усаар сал хөөсөн зарим нь суманд тусагрдан живээд, бусад нь сандан мэндэн эргийн зvг дутаав. Дайсны ширvvн довтолснийг няцаагаад, таван аянчны дотор баахан онгойж, Бух өвгөн салаа дайсны эргээс холдуулсанд ,

завшаанаа гол өргөн болж, эргийн дайсан хор хийж чадахгүй боллоо. Үхvv усан дотор тжлалдсандаа халаад, бvх бие нь чичрэн жаданд зуруулсан гэдэснээсээ цус гоожихыг vл анзааран, дөрвөн нөхөртөө тэр дайсныг усан дотор багалзуурдсанаа дvрслэн vзvvлж,

- Хумка хумка хэмээн хашгиран, эргийн дайсны зvг гараа зангидан занав. Чингээд усан дотор сvхээ алдсандаа гашуудан

- Миний сvх, миний сvх гэж ус руу зааж хашгирахад нь Бух өвгөн өрөвдөж, Шонхолойгоор залуураа бариулаад, саравчин дотроосоо тvрvv ишилсэн нэг цахиур сvх гаргаж,

- Гэртээ аваачих гэсэн сvхээ би урьд шөнө та нарыг унтаж байхад, энэ тулаан болохыг мэдсэн юм шиг ишилсэн билээ. Миний бие мэнд хvрвэл, цахиур хаа мундахав. Энvvнээс дутуугүй сvх би хийж чадна. Үхvv май, энэ сvх ав,

Араатан дайснаас

Амий чинь хамгаалж

Урдах хvний

Улан дороос

Хойдох хvний

Хормой дороос

Олзын ихийг

Олгон баярлуулж

Уруулы чинь тостож

Урамы чинь оруулж

Гэдсий чинь цатгаж

Гэр өрхий чинь гийгvvлэг

гэж ерөөж өгөхөд нь , Үхvv vгий нь сайн ухаараагүй боловч, урт иштэй сайхан цахиур сvх өгч байгаад нь ухаангүй баярлаж, сөгдөн аваад эргийн дайсны зvг шинэ сvхээ далайн, Хумка хумка гэж гурав дахин омгийнхоо уриа хашгиран уриалав. Тэр сvх нь сvх хийж vзээгүй ойн хvний Хумка омогтонд байтугай, Чонос омгийн дайчин эрцvvлд ч бараг байхгүй гэмээр сайхан сvх тул, Хумка Үхvvгийн баярлах нь ч аргагүй. Гekvv нөхрөө тийм сайхан сvхтэй болсонд бас их баярлаж, нөхрийнхөө уриаг тосож аван бас Хумкаа гэж ялгуун хашгирахад, Шонхолой Залуудай хоёр бас Чоносынхоо уриаг ваа гэж хашгиран , Бух өвгөн ч Ихэрэс омгийнхоо уриа шоо гэж хашгирлаа. Өргөн мөрний ус , жаргаж байгаа нарны гэрэлд тvмэн толбо мяралзуулж, тулаанд сvрдсэн усны шувууд гунганан нисэлдэж, хараацай салын өмнvvр усан дээгvvр ялаа шумуул шvvрэн жирэлзэж vдшийн сэрvv татлаа. Бух өвгөн дайсангүй эргийг бараадасхийн салаа залж алсыг ширтэн хараад,

- Тэр дор бургаснаас бас нэг суман онгоц цухуйж, биднийг тосож байгаа бололтой . Манай олзны онгоцон дотор нэг тулуур, нэг сэлvvр хэвтэж байна. Залуудай, Гekvv бид гурав онгоцонд сууж, дайсны зам болж, Шонхолой Үхvv та хоёр салаа залан гарч vз гэхэд нь Шонхолой онгоцоо салд ойртуулан, Бух Гekvv хоёр нум сумаа авч онгоцонд суугаад, Бух өвгөн бас жадаа авч, нэг багц сум задлан, хоромсгондоо хийгээд, гурвуул онгоцноо сууж, Шонхолой тулуур мод барин, Бух өвгөн сэлvvрээр хvч нэмэлцэж, салаас тvрvvлэн дайсны онгоц бургасан дундаас цухуйн буй газар

ойртон очив. Эргээр дагаж явсан хvн шуугилдаж, өөрийн онгоцны зvг гvйцгээж, дайсны суман онгоцны тэндээс бас хоёр мод бургасаар холбож, хэдэн жадтай хvн дээр нь унаад, нэг нь урт модоо хатгаж, аянчны зам хөндөлсөх санаатай дөхөв. Нvврээ улаан шар цусаар алаглан сvр оруулж, будаад, вс нь сагсайсан догшин зэрлэг царайтай, дайсны хvмvвс бvдvн хийцтэй цахиур чулуун гилбэртэй жад барьцгаан, эрэгчин эмэгчнээ vзэлцэн тулахаар санаа шулуудаж, тvрvнчийн довтолсон нь дарагдсан боловч хvн олон хvч давуудаа эрдэж, муухай бvдvн хоолойгоор байлдааны дуу бархиран дуулж, салыг дайран махаараа дарна гэж аянчны зам тосон ирэхэд онгоцоо сум тусахаар ойртмогц , Бух өвгөн - Би юуны өмнө сэлvврчин залуурчны нь харваад байна. Шонхолой Гекvв та хоёр дайсны аль аюултайгий нь харваад байгаарай гээд Шонхолой хатгуур модоо онгоцондоо хийж, Бух өвгөн сэлvврээ хураагаад холбоо мод унасан дайсны залуурчныг ганц сумаар унагаахад, тэр хvн ойчингуутаа холбоо модны бөгсийг шарвуулан, толгойгоороо нөгөө суман онгоцны хатгуурчны мод цохин унасанд, хатгуурчин нь Шонхолойн суманд харвуулж, шарван ойчиход нь суман онгоц нь хөмөрчихлөө. Мод унасан хvний нэг нь Бухын суманд шарх олж, жадаа усанд унагаад, сал дээрхи Үхvнгийн дvнгvнрийн шунгинах чулуунд бас нэг нь толгойгоо цохиулан ойчиход vлдсэн нэг нь ахар жадаа шидээд арай холдсон тул жад нь салын наана усанд ойчоод, гилбэргvй vзvвр нь дээшээ гозгонон хөвлөө. Хөмөрсөн онгоцны хэдэн хvн , Бухын онгоцонд ойртсон тул Шонхолой жадалж, Бух өвгөн онгоцны бөөрнөөс шvврсэн нэг гарыг сvхээрээ тас цавчин, Ихэрэсийнхээ дайчин уриаг Шоо гэж хашгиран, сумаа онилж, усан дунд харлан буй нэг толгойг урт ишт сvхээрээ буулган, бас нэг дайсныг дарлаа. Чингэтэл салын хажуунаас гэнэтхэн хоёр сагсгар толгой уснаас цухуйж, жад атгасан хоёр хvн сал дээр гартал, Үхvв шинэ сvхээрээ нэгий нь далан дундуур нь татаад унагаж, нөгөө хvнийг цавчих гэж сvхээ далайтал, тэр нь дайран орж, Үхvвг даран уналаа. Залуудай сандарч, залуураа хаяад Үхvвг тэнхрvллэх гэж всрэн гvйж очоод, дээр дороо гаралцан ноцолдож байгаа тэр хоёр хvний дэргэд дэмий л цовхчин, Үхvвгээ цавчуузай хэмээн болгоомжилж хийгий нь тааруулах гэж байтал, дайсны эр Үхvнгийн дээр гараад ирмэгц , Залуудай сvхээ ууцан дээрн ь буулгаад авлаа. Дайсны бие нь шал хийгээд суларсанд Үхvв дороос нь сугарч сvхээрээ аман хvзvн дээр нь ясы нь шархийтэл буулгаад, Хумкаа гэж дайчин уриагаа уриалав. Онгоцон дээрх Бух өвгөний дотор онгойж, Шоо гэж Ихэрэсийн уриагаа цуурайтуулан, усанд сэлж яваа нэг дайсныг харван далд оруулсанд Шонхолой Чоносынхоо уриа Ваа ваа гэж ялгуун хашгирч, дайсны хөмөрсөн онгоц татаж авав. Чингээд усанд бариул талын vзvвр нь гозос гозос хөвж, явсан дайсны хэдэн ахар жады нь тvвж авахад, эргийн хvмvвс, өөрийн талын эрцvвл дарагдсанд шуугилдан хашгиралдаж, онох онохгvй, хvрэх хvрэхгvй нь хамаагvй ахар жад , чулуугаар дэмий л тэчъядан чулуудав. Таван аянчин , хоёр удаагийн дайран довтолснийг, нум сум , дvнгvвр, урт ишт сайн чулуун сvхийн давуутай чадлаар няцааж, дайснаа дарж, хvнгvй эргийг барин уруудахад дарагдсан тэр vл таних омгийн хvмvвс дээлдээ багтаж ядатлаа уурлан өширхөж, хараан зvхэж, нэг хэсэг дагалцаж явтал, нар чшингэж, харанхуй ч болж эхлэв. Шонхолой тэдний зvг хараад, - Энэ омгийн улс, цахиур хавирч гал асааж чадахгvй улс байна шvв. Ваар саванд галаа аваад явж байна. Тэр цогтой галы нь унтраавал лав дахин гал олж автлаа гал алдаж сандрах юм байна. Энэ харанхуйн далимаар олзныхоо онгоцонд сэмхэн сууж,

зам дээр нь тосоод галтай савы нт бороохойгоор няц цохиж орхивол бидний хойноос хөөдөг зориг нь мохох ёстой. Эс тэгвэл энэ хэрмэл улс биднээс саядаа салахгвй , шөнө гэнэдүүлэн дайрах гэж зовооно гэхэд нь Бух өвгөн

- Тэр зөв. Хоёр хvн явахгвй бол горьгвй. нэгэнд нь би явсуу. Манай хоёр Хумкаа арай л мулгуудах болов уу? Залуудай бид хоёр явбал яана? Шонхолойтой явбал энэ сал дээр Залуудай залуудан ганцаардаж, бид хоёр хэрэв осолдоход хvрвэл, хоёр хумкаатайгаа баларна гэсэн vг. Шонхолой энэ хоёртойгоо vлдвэл хал vзэж хашир таниснаараа наад хоёртойгоо хvч нийлэн хэрийн юманд санаа зоволгвй аргалах байх гэж бодож байна гэхэд Шонхолой хvвгээ хараад,

- Могойг нарийн дайсны буурай гэж голж болдоггвй юм шvв дээ хvв минь. Эрийн цаана эр байдаг гэж бодож болгоомжтой яваарай, Бух авгайнхаа vг сонсож, сургаалы нь дагау яваарай хvв минь, харийн газар хартны дунд орохдоо, Бух авгайгаа л сvвдэр шиг дагаж, сугы нь тvшиж явдаг юм шvв гэж хvвгээ явуулан хэлсэнд Бух Залуудай хоёр олзны онгоцны нэгэнд нь суугаад, чимээ гаргахгвй гэж сэмхэн хатгасаар, харанхуйд vл vзэгдэн одов. Шонхолой цахиураа хавирч гал асааж, дайсны анхаарлыг салдаа татах арга хэрэглэсэнд Цахиур хавирах чимээ , цахиурын оч гялалзах нь нөгөө эргийн хvнд андашгвй, гялс гялс хийж харагдаад, удалгвй сал дээр бургасан хашаасны завсраар гал харагдахад, эргээр явагсад шулганалдан, юм дуугарцгаах чимээ нь дуулдаж, галт ваар барьсан хvн нь бусдын сvвлд явах шинжтэй. Цогийн гэрэл хааяа хааяа сvмэлзэсхийх нь харагдав. Шонхолой Үхvвгээр залуураа бариулаад, сал дээрээ дайсны талаас хамгаалан босгосон бургасан сvлжмэл хашааны цаанаас харанхуй эргийн зvг дайсны талд юу болохыг харж суутал, гэнэт нэг юм пидхийтэл цохих чимээ дуулдаж, оч бутарган нэг юм усанд шархийж ойчих чимээ гарч, ус руу чулуу мод жад буух, бургасанд тээглэх чимээ гарч, хvн хашгиралдах шуугиодах дуу харанхуйд дуулдлаа. Манайхны дуу гарах нь уу? гэж чих тавин нэгэн хэсэг суутад хойноос нь суман онгоцны хошуу галын гэрэлд харанхуйгаас гарч ирээд, Бух өвгөн Залуудай хоёр онгоцноос сал дээр гарч ирлээ. Сал дээр байсан гурван хvн баярлаж, олзныхоо хоёр онгоцыг салын хоёр бөөрнөөс аргамжаад, Бух өвгөн сал дээр тvлсэн галаа унтрааж, харанхуйгаар салаа дайсангвй эргийг бараадасхийн залах зуур дайсны галыг хэрхэн сөнөөснөө ярьсан нь

- Залуудай бид хоёр дайсны эргийн зvг ойртохдоо араас нь орох гэж сvвлдэж дагаад, бургасны нэг чөлөөнд онгоцоо олоход амар газар Залуудайгаа онгоцон дээр нь vлдээгээд, дайсны хойноос нь дагалаа. Завшаан дайрч сархи хойноосоо миний зvг дайсны vнэр надад мэдэгдээд, миний vнэр тэдэнд мэдэгдсэнгвй. Галтай сав барьж явсан хvн, хамгийн сvвлд явсан тул тvвнийг цохиж унагаад, галтай савы нь шvврэн авч, усанд хаяад хажуу тийшээ зайлахад минь урд явсан улс, галаа сөнөөлгөснөө гайхан дэмий л ус бургас уруу мод чулуу шидэлцэн жадалж, намайг хөдөө талд нь хоргодсоныг мэдсэнгвй, шуугилдан сандрах хооронд нь аяархан араар нь гарч , онгоцоо хvлээлгэсэн газар мэдэгдэлгвй хvрч, та нарын гал дагаж , хойноос тань хvрээд ирлээ. Сал дээрээ гал асаасан тань бидэнд их тус болсон . Одоо галаа унтраагаад, харанхуйгаар эндээс холдсон нь дээр. Бидэнд халдсан улс, өөр галт сав vгвй бол галаа алдаад нэг хэсэг их сандарч, биднийг хөөх байтугай, өөрсдөө гал vгвй яаж амь зууна гэж тэвдэх бий. Чимээ л гаргалгвй явж vзье. Манай сал дээр гал бий гэж бодоод, учир мэдэхгвй улс, галын төлөө улайран дайрч болох юм шvв. энэ шөнө унталгвй явж, дайсны нутгаас холдож vзье гэхэд нь бvгдээрээ дайснаас холдох гэж

Шонхолой салынхаа толгой талд гарч, Бух өвгөн залуур барин, Залуудай ээлтэй эргийн талд хатгуур барин, Гекvv, Үхvv хоёр салын бөгсөнд урт модоор тулж, салын хурд нэмvvлж, аль молхоор чимээгvй явахыг оролдоход хойгуур урдуур нь хааяа том загас энд тэнд цvлхийх чимээ гарч, мөрөн голын хоёр захын шугуй бургасны навч нь салхинд шуугинан , дайсны эргээс харьтан хvний vнэр нь мэдэгдэмгvй шахам болсоор нэгэн хэсэг явахад , усны чийг замгийн vнэр ханхлахаас биш , эргийн хvний vнэр огт мэдэгдэхгvй боллоо. Чингэхэд , таван аянчин сая ядарч , аман ч цангаж, гэдэс ч өлссөнөө мэдэж, шарх олсон нэг нь шарх өвдөх хорсохыг сая мэдэвч, дайснаас бvрмөсөн холдож, аюулгvй айван тайван хvрэх юмсан гэж залуураа барьсан өвгөн Бух тулуур модоо голын ёроол хатгаж, салаа хурдлуулж яваа Гекvv, Үхvv хоёр эргийн талд тэмтрэн хатгаж яваа Залуудай, салын толгойд хатгуураар хатгаж, эрэг мөргvvлэхгvйг хичээж яваа Шонхолой цөм их аюулаас мултарсандаа хатуужиж, биеийн чилэхийг юмнаа тоохгvй явлаа. Дараа энэ таван хvнд, ямар явдал урт замд нь тохиолдохыг хойд хэсэгт vзнэ vv

Шөнө дундаас хойш Бух Шонхолой хоёр дайсны эргийн зvгээс огт чимээгvй тул нөгөө гурвыгаа амарч унт гэж хэвтvvлээд, өмнөд нангиа аймгийн нутгийн захаас эхлэн одоо хvртэл зовлон жаргалангаа хамтатгасан хоёр найз, vvр цайтал ээлжлэн залуурдаж явлаа. Залуудайн нойр нэн сэргэг. Үе ve хоёр өвгөдийн дvнгэр ярилцах нь чихэнд тусавч өдрийн тулаанд ядраад, “ зөөлөн бөхөд “ дийлдэж нэг хэсэг ухаан мэдээгvй унтаад бас нэг сэрэхдээ Бух ав хоёрын юм ярилцах нь дуулдавч тэр хоёр хvн юв гэж ярилцаж, юугаа дурсан vvрийн шөнийн бvрэнхvйд хэлэлцэж байгаа нь нойрын эрхээр хvнгийн ухаан санаанд орохгvй байлаа. Үvр цайх вес Залуудай сэрээд харваас, Бух өвгөн унтаж ав нь залуур барин суув. Дэргэд нь Гекvv салын хажууд суун хавчаахай нумын годлийн мод цахиур хутгаар засаж, өчигдрийн байлдаанд алдсан сумын тоог гvйцээх гэж оролдож байгаа бололтой, зорж зассан модоо Шонхолойд шалгуулан vзvvлж, зэв суулгахад бэлэн болсон нилээд мод хажуудаа тавьжээ. Залуудай өндийж босоод, авынхаа дэргэд очиж халаагийн нь авч залууры нь барин голын хоёр захыг хөвөөлөн ургасан бургас шугуйд vvрийн салхи шуугинан , урсгал ус велзэн, хөлгvй гvнзгий газар мэлтийн харлаж дороос нь ус ундрах адил цалгилах байдлыг харж, богширго бялзуухайн жиргэх чимээ сонсон явтал vvрийн туяа татаж, тэнгэр маш цэлмэг, таатай сайханд усны шувуу сvрэг сvргээр дайралдан салаас нэг их айхгvй зөвхөн замаас нь холдосхийн зайлах ажээ. Чингэж явтал нэг хадан хошуу vзэгдэж, хэдэн гуя онгоц шиг юм холоос харагдсанд эмээж, бас дайсагнах омогтон тосуузай хэмээн, унтагсадыг сэрээтэл, хадан хушууны ёроолоос хvний бараа харагдлаа. Сал хараад, зарим нь гуя онгоцны зvг, зарим нь отог уруугаа гvйх нь vзэгдэхэд, таван аянчин баахан эмээсхийж, дахин тулалдах хэргэ гарав уу? гэж салаа нөгөө эргийн зvг залсхийтэл, хадан хушуу ч ойртлоо. Эрэг дээр эрэгтэй, эмэгтэй хvн, хvvхэд шуухад цуглаж даллаж эхэллээ. Холоос харахад гартаа зэр зэмсэггvй, халдах довтлох санаагvй мэт тул аянчны санаа амсхийж, найхсаг байдалтай даллахад нь аргагvй салаа эргийн зvг залав. Загасны элдсэн арьсаар хувцас хунар хийсэн хvрэн улаан царайтай, эрэгтэй эмэгтэй хvн vl мэдэгдэх vгээр юм хэлж, хэдэн чийрэг эрс, гуя онгоцноос том том хилим барин авчирч дайлах санаатай тун элэгсэг байхад Бух өвгөн,
- Хvн гэдэг ийм л байх ёстой юм даа. Хэл мэдэхгvй өөр омгийн хvн гэсэн ч хvн

хүндээ нөхөрсөг найртай байх ёстой юм шүү дээ. Бууя гэж салаа эргийн зүг зориглон зааад аргамжаа эргийн зүг хаямагц хэдэн хүн ухасхийн тосож аваад эргийн захын улиаснаас аргамжив. Хэл нэвтрэлцэхгүй боловч дохиогоор санаагаа нэвтрүүлэн найртай сэтгэлээ илэрхийлэлцэж, тавуулан тэр эргийн хүний отог дээр нь хүрч очиход, эмэгтэйчүүд хэдийн галд загас шарж зарим нь тарган загасны түүхий мах зурвас зурвасаар зүсээд, давсанд дарсан сонгино мангиртай тавьж зочилжээ. Таван аянчин, гэдэс нилээд өлссөн тулманд хайлах тарган махтай хилимийн түүхий мах, дарсан ногоотой маш амтархан идээд шарсан загаснаас нь бас цадталаа идлээ. Зочныг дайлаачин, Бух өвгөн, Үхүү хоёрын шархтайш үзээд юм асууваа. Хэл нэвтрэлцэхгүй тул, дохиогоор Бух өвгөн, голын боргионы байдлыг чулуу заан дүрсэлж, эргийн зүгээс хүн дайран чулуу, ахар жад шидэн халдсаныг гар хөл, царай биеийн хөдөлгөөнөөр маш чадамгай харуулж, тэр отгийн улс,

- Кара Намиаттар, Кара Намиаттар, гэж шуугилдан, тэр дайчин Хар Намиад омгийнхонд гол загасчилж яваад дайруулж, хэдэн хүн алдсанаа дохиогоор үзүүлж, хоёр хуруугаа гозойлгон явган сууж, сэлэх байдал дүрэм гаргаж, тулалдаад, хоёр онгоцноос хүн усанд унаж, онгоцоо Хар Намиадын хүнд алдсанаа дохин дүрсэлж үзүүлэв. Шонхолой тэр дохио байдлыг ажиглаж байгаад, манай олзолсон хоёр онгоц эдний онгоц биш байгаа гэтэл, нэг хижээлхэн загасчин, эргийн зүгээс хүрч ирээд сал зааж, юм хэлэхэд загасчингууд шуугилдаж, Бух Шонхолой хоёроос нэг юм асуух мэт тул, Шонхолой босоод, салын зүг одоос загасчин хойноос нь очоодсалаас аргамжаастай хоёр суман онгоц заан, хушуунд нь загасны толгой дүрсэлснийг заан юм хэлэхэд Шонхолой дохиогоор тэр хоёр онгоцыг Хар Намиадаас олзолсноо таниулав. Чингээд энэ хоёр онгоцоо та нар ав гэж дохиод тэр загасчингууд учиргүй баярлав. Тийм онгоц хийхдээ галтай цог тавьж, шатсан газар нь чулуун сүхээр хусаад, дахиад цог тавьж шатсаны нь цахиур хусуур сүхээр хичнээн олон хоног ухсаар сая нэг онгоц хийдэг түмэн төвөгтэй ажлыг Шонхолой андахгүй тул, тэр загасчны баярлах нь аргагүй гэж тэдний хамт баясалцаж хүнээ алдаад, онгоцоо олзлуулсан улс, санамсаргүй дахин онгоцоо олж авсанд нь ийм сонин тохиол бас байдаг юмаа гэж бодсоноотог дээр очиж Бух өвгөнд хэлбээс :

- Чи тэр Хар Намиадыг галаа сжнөөлгөж хоёр онгоцоо алдсанд нь өрөвдөж, онгоцы нь урьд шөнө тэдний эргийн бургаснаас аргамжих гэж байсан шүү дээ. Тэр тонуулчинд онгоц олдоно. Бидэнд илүүдэхгүй авч явъя. Бусад хүнд өгсөн ч авах хүн олдоно гэж миний хэлсэн одоо зөв боллоо. Энэ найрсаг загасчин онгоцоо бидний хүчээр эргүүлж авах түүхтэй байж л дээ гэж хоёр найз баярлалдав. Чингээд дайлуулж, дайлуулж, аян замаа хөөх гэж найрсаг загасчинтай салах ёс хийхэд нь тэр отгийн нэг эмгэн, Бух, Үхүү хоёрын шаоханд навч үндсээр найруулсан эм талбин боож өгөөд, загасчингууд хэдэн том тул, хилим загас бэлэг болгож өглөө. Нэг чийрэг загасчин, ясаар хийсэн сайхан сэрээ өгч, Шонхолойг загас сэрээдэж байгаарай гэж дохисонд, сайхан сэтгэлт Шонхолой сал дээрх юмнаасаа хирисийн эврээр замдаа зорж хийсэн жадын гилбэр хариу бэлэглэж, хоёр этгээд маш элэгсэг найртайгаар салах ёс хийхэд сэрээ бэлэглэсэн чийрэг загасчин биеэ, нөхдөө заагаад

- Биз Балакчинар бар гээд балак балак гэж загас заасанд Шонхолой тэр дохиогоор нь бид Загасчин улс гэсэн юм байна гэж ухаараад,

- Би Чонос, хүүгээ зааж, Чонос гээд, Бух өвгөнийг заан Ихэрэс, Үхүү, Гекүү хоёрыг заагаад Хумкаа гэсэнд Балакчинар учрыг мэдэж, толгой дохин маш элэгсэг байдал

взвүлэв. Чингээд таван аянчныг салдаа суугаад өргөн мөрөн уруудахад хойноос нь талархах үг хэлж гараар дохин эрэг дээр удтал зогсов. Чингээд хадан хушууг тойртол дахиад хүн үгвй зэлүүд их тал газар сүрэг сүргээр билчиж яваа хулан зээр үзэгдэж цаана нь хөхрөн харагдах өндөр уулс сүндэрлэн, сүрлэг жавхлант байгалийн байдал тун үзэсгэлэнтэй тул өргөн мөрнийг уруудан яваа таван аянчин чив чимээгвй сууж, баян хангай дэлхийг харж, амьдын жаргалыг эдэлж явлаа. Хэдэн хоног нартай сйахан, өдөр амгалан, шөнө жаргалантай явтал, нэгэн орой салхи хөдөлж тэнгэр муухай боллоо.

-Өдөр даанч бvгчим халуун байсан юм. Хөх түрүү хэдгэн ч сүрхий ширүүн байсан, бороо орохыг л зөгнөж дээ. Салынхаа боолт бөхөлж саравчаа зузаалах хэрэгтэй боллоо. Их бороо орвол бид нэг газар бууж өнгөрүүлдэг юм билүү? Гэж Бёух өвгөн, салаа эргийн зvг залж бургаснаас аргамжаад, тавуулан эрэг дээр гарч, баахан бургас огтолж салын боолт суларсныг сэлбэж засаад, унтдаг саравчаа дээрээс дусаал орохгвй болгож засав. Үхүү Гекүү хоёр хэдийн галын ач тусыг мэддэг болсон тул, хуурай мод түвж, сал дээрээ хураагаад, сүлжсэн бургасаар даруулж, мушгисан бургасаар торгож салхинд хөдөлгөхгвй болгов.

Чингээд цаашлан хөдлөхөд нь салхи баахан ширүүсэж эхлэв. Борооны бараан хар, маш сүртэй үүл. Уул даван гарч ирэхэд, Бух өвгөн,
- Борооны өмнө салхи, боохойн өмнө хэрээ гэж энэ дээ. Үхүү, Гекүү та хоёр салхи, бороонд ус уруу ойчив, болгоомжтой бай, Залуудай чи ч бас мэдэж яваарай. Их салхи хөдлөхөөс өмнө нэг аятайхан нөмөр газар хүрч, бороо өнгөрүүлэхийг бодье гэтэл салхины чимээ улам их болж, мөрний хоёр захын бургас шугуйн шуугинах дуу сүрдмээр ширүүн боллоо. Тэнгэрийн хормойгоор гялаан цахилгаан гялалзаж, жаргаж байгаа нар, зузаан үүлэнд халхлагдан, харанхуй болоод, салхины хүч чимээ нэн их болж, мөрний ус буцлах адил, оргилж сал ч салхин өөд явахгвй, болоход таван аянчин арга буюу аятай газар сонгох нөхцөлгвй болж, улиас бургасны нөмөрт салаа зогсоож, ширүүн бороо, догшин салхийг өнгөрүүлэх гэж салаа модноос аргамжин, шуугинах салхины айхтар их чимээнд тэнгэрийн дуу, цахилгаан ойртож байгааг эмээн чагнаж суув. Цахилгаан завсар үгвй гялалзан цахилж, нүд анивч, ногоон гэрэл аньсга нэвт харагдаж, тэнгэрийн дуу чих дүжрэм, газар доргим сүртэй болж ирсэнд Үхүү Гекүү хоёр нэн эмээж чичрэн дагжин Бух Шонхолой хоёрт шахалдан наалдав. Чингэсээр аадар бороо айсуй чимээ дуулдаж, улам ойртох тусам жихүүн амьсгал сэнгэнэж, тэнгэрийн дуу, вер борооны чимээ нийлэн, алсаас нижигнэн шуугих чимээ ойртсоор, мөндөр бууж, шугуй, модны навч тас цохиход хөдөө шугуйн амьтан, араатан жигүүртний сандран дуу тавих анир чимээ гарав. Цахилгаан цахиоахад уулнаас уруу гялалзан мушгирч буух нь харагдан тахь унгалдах, үхэр гөрөөс сандран мөөрөлдөх, арслан зааны урамдах дуу, салхи бороо, мөндөр, аяндын чимээнд нэмэрлэн оролцож хоёр Хумка нэн айв. Уулнаас ширүүлэн буух уруйн усанд нэг хирис, голын усанд унасан цох хорхой шиг эргэн хөрвөн урсаж явахыг Залуудай цахилгааны нүд гялбам гэрэлд хараад тийм сүрхий амьтан ийм болчих гэж ямар хэцүү юм бэ? хэмээн сүрдэн харж байтал, тэнгэр нурах, газар цөмрөх адил их дуу гарч, нэг өндөр саглагар модонд аянга туссанд дэргэд нь бйасан хэдэн мод бас хяргуулсан юм шиг ойчиж, нэг шхэр гөрөөс хугаран унасан модонд цохиулж ойчихыг хараад, эцгийн гараас сандран атгатал, бас нэг урт эрээн амьтан тэр үхрийн хавиас үсрэх шиг болов. Энэ юу вэ? гэж хартал, нэг бар дэргэд нь шахуу аянга

буусанд ухаан алдаж зөв буруугүй, ийшээ тийшээ дүүлсээр, яг салын зүг верийн усан дундуур давхиж ирэв. Таван аянчин сандарч сүхээ шүүрэх нь сүхээ шүүрч, жадаа шүүрэх нь жадаа шүүрч, тэр давхин ирж яваа араатнаас амь биеэ хамгаалах гэж тулалдахаар босов. Усан дунд үсрэн цовхчиж явсан бар, сал хараад, саравчин дор нь хоргодон суусан хвнийг анзааралгүй, хэд үсрээд сал дээр гарч ирэнгүүт, мөндөр борооноос зайлах гэж саравчин дор орох гэж ухас хийхэд тэнгэрийн дуу, цахилгаан дундуур Бух Шонхолой хоёр, тэр барын хоёр талаас жадаараа омруу өөд нь ёворч, Залуудай өргөн духан дунд нь сүхээрээ нэг буулгангуут барсын толгойд мөргүүлэн хажуу тийш хомоол шиг үсрэн ойчихдоо, нэг юм тас хийж хугарах чимээ гараад, Бух өвгөн барын хойноос чирэгдээд саравчин дороос гарчих шиг боллоо. Саравчны хоймроор бургасан хаалт цөм цохиод гарсан догшин араатан, дайрсан эрчиндээ Бух өвгөний жад хуга үсрээд өвгөний жад нь тэр хвчинд барын зүрхэнхд шигдэн орсон тул, саравч шовтлон дайраад унасан байв. Бух өвгөн жадаа хуга дайруулахдаа дэргэдүүр нь сүр хийгээд гарсан тэр араатны сүүлээс атган, чирэгдэж гараад баруун гартаа сагалдрагалаастай сүхээ шүүрэн самбаачилж зоон дээр нь буулгасанд барын тамир тасарч, гагцхүү амаа ангалзуулан урхирч урд хоёр хөлөөрөө дэмий л салын мод цохин маажилж байв. Бух өвгөн ухасхийн босож, сүхээрээ нуруун дээр нь цавчин, Үхvv тэр самбаанд саравчин дотроос сугаран гарч, сүхээрээ нүүр нүдгүй дэлдэн тэнгэрийн дуу цахилгаанд цоохор мэдээтэй болсон тул хэдийн гол нь тасарсан араатныг ха ха ха гэж цавчин нүдсээр байхад нь Бух өвгөн араас нь татаж зогсоолоо. Залуудай барт ширvvлж ойчихдоо хоёр нэгэн газар шалбаравч өөр гэмтэлгүй гарчээ. Үхvv, Бухын жад хуга татуулахад, ишинд нь мөрөө хага зуруулаад, Бухын хөл дор унасан байжээ. Барын саравчин дор дайран орох, саравчин дор хоргодсон хвний эсэргүүцэн тулах нь хэдхэн хормын хэрэг боловч, тэнгэрийн дуу цахилгаан ухаан алдсан араатантай адил сочин хэлмэгдсэн аянчин, бараг сандрааггүйгээ сандарч саравчин дорх бага зайд том араатантай халз тулгаран, тvvний үмхий амьсгалын шурхирах чимээг сонсож, чийрэг биенд нь дайруулан шөргөөх тэрvvхэн хооронд хэцvvхэн сангдсанаа ярилцахын ч завгүй догшин саохи, шiovvvн бороо, мөндөр дундуур уулын уруу түрхрэн буух чимээ, гялбааны нүд эрээлжлэм хурц мяралзалд нэг бэрх юмнаас амь бүтэн гарлаа гэж яаран сандран, саравчин дороо шурган орцгоогоод, газар тэнгэр хоёр нийлж, гал дөл болж байгаа юм шиг тэр дуутай тэнгэр, төндөртэй хурын сүрхийд мөрний ус дээшээ хөөсрөн ойж хоёр эргээс уруйн усанд абургас мод урсан орж ирэх болсонд сал аргамжсан мод ч уруйн усанд үндэс шороо нь идэгдэн, унах шахсан байдлыг тавуулан эмээн ажиглав. Чингээд нүд ирмэх завсар тэр улиас мод унаж, орой нь залуур байгаа газрыг нөмөрч салын бөгсөн тал нь ус уруу доошоо орж, цээжин тал нь өөдөө цухуйсхийн урсаад өгсөнд Үхvv Гекvv ойн хvн бөгөөд модон дээгүүр авиран мөлхөж явахдаа уулаас чадамгай тул, сагалдрагатай сүхээ унжигнуулан, тэр сал даран унасан модон дээр аймшиггүй гарч, гишvv мөчрий нь тас тас цавчилж, залуураа шулуутгаж авав. Бух Шонхолой, Залуудай гурав Гекvvд туслалцан тэр сал дарсан модны оройг цавчилцтал, Үхvv аргамжааны уяаг тайлж авах гэж тэр сал даран унасан модны нэг бүдvvн гишvvнээс уясан аргамжийг усанд дэвтэж, салхинд татуулж, тайлахад хэцvv болсныг, гишvvгий нь сүхээрээ тас цавчих гэж оролдов. Нойтон модыг ширvvн бороон дундуур харанхуйд, ганц гялбааны гялалзах гэрэлд чулуун сүхээр байтугай ган сүхээр ч оволзож байгаа сал дээрээс ганц нэг цохиод тас

цавчихад амаргвй тул Үхvvгийн байдаг хvчээ гаргаж, аргамжны доод талаар цахиур сvхээрээ цавчиж байхад нь сал мод хоёр хөдлөөд , сvх бас нойтон гилгэр мод дааж өгөхгвй, ир нь халтираад байв. Бас гишvv мөчир дотор шургалан орсон Үхvvгийн далайж цавчих гэхэд гишvv навч саад хийгээд далайц ихтэйгээр цавчиж болохгвй байв. Чингэтэл бух, Шонхолой, Гекvv гурав салыг доош нь дарж байгаа гишvvг огтолж, модны оройн хэсгийг тас цавчиж, салаа хөнгөлсөнд сал аргамжсан гишvv , Үхvvгийн цавчилж байгаа газраар хугарч хоёр нэг цохиход нь салаад өглөө. Том улиас ч салаас хөндийрөн хөвж Үхvv ч аргамжаа гишvvнээс нь мулт татаж аваад, Гекvvтэй хvч хавсран, тэр том гэгчийн гишvvг ус уруу твлхэн унагаалаа. Тэнгэрийн дуу аянга ч баахан холдож, бороо ч баахан намдах шинжтэй болж, аянчны дотор ч баахан уужирч ирлээ. Эргийн модноос салаа уях гэхэд их борооны вер ус уруу зvг зvгээс бууж, эрэг дээр гарахад чхэцvv, бас харанхуйд тохитой газар сонгон, олох нь хэцvv болсон тул, хоёр эргийн чимээгээр мөрний гол дундуурыг баримжаалан салаа залж явахаас өөр аргагвй болжээ. Гялбааны гэрэлд харвал, veo уруйн ус, мөрөн рvv орж ирэх нь улам ихдэж байн байн эрэг нурах ажээ. Салын өмнө нэг том мод хөвж явах нь харагдтал Залуудай, цахилгааны гэрэлд нэг хирис уруйд золтос шиг урван хөрвөн усаж мөрөн v рvv ороод, өмнөх тэр том модонд нөмрvvлж орхихы нь vзэн сандарч, тэр аюулт том амьтан сал дээр гарах гэж оролдвол яадаг билээ гэж бодтол завшаанаа тэр модон дороос гарч ирсэнгвй. Чингэж айн эмээж явтал мөрөн дунд нэг том арал тохиолдсон тул, Бух өвгөн, салаа тэр арлын нэг нөмөр эргийн зvг залж, таван аянчин арлын бургасны нөмөрт хонохоор шийдэж, салаа аргамжаад, бороо чзогсож, сал дээрээ галаа твлж, даарснаа дулаацан, загасчин Балакчиларын өгсөн загаснаас идэж хонолоо.

Таван аянчны олон хоногийн урт аян шувтрах тийшээ хандаж нэгэн өглөөний өөд улаан нарнаар тэдний нvдний өмнө мэлтэлзсэн далай их ус харагдав.

- Одоо л Бай кул гэдэг далай их ээжийнхээ бараа харлаа, гэж Бух өвгөн уяран баярлаж идээнээсээ авч аман дотроо

Унасан их дайд газартаа

Угаасан их далай усандаа

Амтат идээнийхээ дээжийг

Арван хуруугаараа өргөнөм

Өргөн их мөрөнд сал тавьж

Өндөр өвгөдийнхөө нутагт

Алс холын аян замаас

Амь мэнд буцаж ирсэндээ

Баярын магнай тагнайлж

Барьц идээгээ өргөнөм

гэж усанд цацав. Бай кул гэж Бух өвгөний бахдан ярьдаг их ус ийм юм байжээ гэж Залуудай, хөхрөн харагдах тэр жавхлант их нуурыг тун бахдан сонирхож, эргээрээ тэнгэр өөд сvндэрлэсэн сvртэй сайхан уултай, ууландаа их модтой, тодондоо их антай, андаа тураг их гөрөөстэй нь юутай таатай вэ? гэж бодож тэр далай их усны загас ихтэйгий нь гайхан харж явлаа. Чингээд мөрөн их усны цутгалан хавьд нэг аятайхан газар сонгон , манай таван аянчин , салаа далай нуурын эрэг дээр зогсоож, том чулуунаас аргамжин бууж, хоол ундаа идэж уугаад, зэр зэмсгээ агсаж, явган аялах боллоо. Бух өвгөн өдийд эрэг дагуу яваад байвал, лав манай омгийн хvн

дайралдах ёстой гэж нөхдөө дагуулан явсаар атал нэгэн хадан хушууны хавьд утаа гарахыг хараад, тэр зүг чиглэн алхацгаав. Ойртон очтол, хэдэн өвсөн өмбөл усны захад үзэгдэж, хэдэн суман онгоц эрэг дээр гаргаастай, өмбөлийн өмнө гал твлээстэй, хэдэн хвн, хvvхэд шуухад үзэгдэв. Хэдэн нохой аянчныг хараад хуцаж галын дэргэдэх хвнээс хэдэн эрцvвл, жад бороохой барин босоод, аянчны урдаас угтан ирэв. Ойртмогц нэг өвгөжөөл анчин,

-Үгвй энэ чинь Бух авгай, та мөн vv? Гэж баярлан асуув.

Мөн байлгвй яахав? Чи Тогоруу ач минь мөн бол би Бух авга чинь мөн байлгвй хайчих вэ? гэж инээн золгож, нутгийнхаа хвнтэй баярлан уулзлаа. Отгийн тэндээс давхиж ирсэн нохойгоо хорьцгоож таван аянчныг аятай сайхнаар угтаж галынхаа дэргэд суулган, тэр хэсэг загасчныг тэргvвлж яваа Тогоруу холоос ирсэн айлчны нэр усы нь асууж танилцав. Бух өвгөнийг нутгийн зах хвргэх гэж газрын хол, усны уртаас явж ирснийг сонсоод эмэгтэйчvвд дайлан зочлох гэж хоол унд хийж гарлаа. Нимгэн бяслаг шиг шахсан врэл жимсийг шавар тавагт тавьж бас зэрлэг арвайн болсон гурилтай нухаж ааруул шиг хатаасан идээ, мэхээртэй найруулж ыуйлуулсан цагаан төмс сараана, зэдгэнэ, бөөрөлзгөнө, аль байдаг тансаг идээгээ тавилцан, сая давсалсан загасны мах, утсан загас тавьж шинш гэдэг хар модны холтос чанасан хврэн унд, модны ураар хийсэн аяганд аягалж тавилаа. Халуун чулуун дээр тосонд хайраад сайхан внэр ханхалсан зэрлэг арвай вйсэн саванд хийж, холын гийчнийг дайлсанд Чонос, Хумка омгийн хвний идэж үзээгвй газрын сонин идээгээр дайлахад нь маш сонирхон амтархаж, цадатлаа идэх завсар Залуудай ийм сонин идээ хийдэг аргы нь асуун сурч, нутагтаа буцаад Булжуухай эмээдээ зааж өгөх юм байна гэж бодож суув. Ихэрэсийн тэр нэгэн отгийн хвн, цөм Бух өвгөнийг таних бөгөөд тэр жил ан аянд яваад, сураггвй болсонд нь араатан дайсанд осолдсон гэж бодож байсан нь амьд мэнд буцаж ирсэнд нт их баярлалдаж, нэг залуу эр Бух өвгөний ар гэрийнхэнд буцаж ирсний баярын мэдээ хвргэх гэж нэг сжман онгоцоор яаран яваад өгчээ. Отгийн хвн бvгд, бух өвгөн сэлтийн нум сум тун сонирхож, ийм чадалтай сонин сайхан зэвсэг бас байдаг ажээ гэж ихэд гайхан одоо манай ихэрэс хвн ийм хурдан зэвсэгтэй болж, ангийн олз ихтэй, уруул тостой болно. Дайсан халдвал, хавьдуулахгвй урт гартай, чадал ихтэй боллоо гэж бахдацгаав. Чингээд Бух өвгөний звлгэмэл чулуун сvхийг үзээд гайхан сонирхож Бух дархан маань улам их уран болж ирлээ гэж тэр схий нь хвн бvр дамжуулан үзэж шагшин гайхав. Загасчны ан элбэг, ууланд жимс элбэг тул өвлийн хатаамал загас жимс бэлтгэж байсан тэр отгийнхон Бух авгын буцаж ирсэнд рой галын наадам хийнэ гэж бэлтгэцгээв. Бух өвгөн ч наадмынханд гөрөөсний мах идvвлнэ гэж нум сумаа агсан, ууланд гарахыг завдахад Шонхолой Залуудай цөм явалцахаар болж Гекvv бас хавчаахай нумаа агсан нутгийн хэдэн хвн, харвалы нь сонирхох гэж дагалдсан, ууланд гарч, модон дунд ортол ан гөрөөс элбэг тул төдхөн хвн бvр нэг нэг бор гөрөөс хартаж ойгийн хвн олзы нь vврч, бvгдээрээ гал дээр хрч ирвээс дөрвөн гөрөөс ийм тvргэн агнаад ирэх ямар сонин юм бэ? гэж отгийн хөгшин залуу vгвй цөм гайхалцав. Залуудай Гекvv хоёр уснб эргээр явна гэж, нум сумаа агсаад нэгэн хэсэг газар эрэг дагуу явтал, элстэй налуу эрэг дээр нэг хэдэн сонин амьтан хэвтэж, уснаас бас нэг хэдэн амьтан гарч ирээд, тэр хэвтэж байгаа амьтны дэргэд гарч ирэхийг үзвэл, усанд сvрхий мөртлөө, газар дээр явах нь тун болхи дөрвөн хөл нь богино, вс тачирхан бөгөөд гялгар, бие нvсэр бvдvvн тийм сонин амьтан байхыг маш гайхаж салхин дороос нь сэм гэтэж очоод,

сум харвам газраас ажиглаваас байдал гөрөөс атал , усанд бас орших нь юутай сонин жигтэй амьтан бэ? Махлаг тарган биетэйг үзвэл идэж болох байх гэж зөвлөөд хоёр залуус тэр урьд өмнө үзээгвй амьтны ус уруу орох замы нь хөндөлсөн хааж ойртоход нь нэг их ёочиж сандрахгвй гагцхvv ганц нэг урхирах мэт дуу гараад, нэг том нь элсэн дээр хэвтэж байснаа ус уруу орох гэж цээжин биеэ өндийн хоёр залуусийн өөдөөс шvдээ ярзайн бөгсөн биеэ чирсхийн ус уруу гулгав. Хоёул тэр амьтны өөдөөс зэрэг харваж, дахиад нэг нэг сумонилон харвахыг завдтал усны эргийн захад хvрээд тэнхэл тасран, амнаас нь цус олгойдон тарчилж байхад дахин нэг нэг харваж алаад, өргөж үзвээс нилээд хvнд. Тэр завсар бусад амьтан нь ус уруу гулгасаар усан дотор шумбан далд оржээ. Харваж унагасан тэр амьтнаа урд хоёр хөлөөс нь чирсээр , отгийн ойр хvрч ирэхэд улс тосон ирээд, vврэн аваачиж хоёр залуу анчны зэвсгийн чадлыг гайхав. Чингээд Залуудайн тэр ямар нэртэй амьтан бэ? гэж сонирхон асуухад хав загас гэж нэртэй амьтан. Усанд байдаг юм. Уснаас гарч эрэг дээр нарлаж хэвтэх дуртай. Мах тарган. Арьс ер ус тавьдагвй тийм амьтан гэж отгийн хvмvvc ярьж өглөө. Чингээд тэр хав загас гэдэг усны амьтныг өвчиж махы нь оройн наадмын олонд идvвллнэ гэж эмэгтэйчvвд ажиллаж гарваа.

Тэр загасчин отгийн эмэгтэйчvвд орой нар жаргатал vдшийн найр наадмын хоол хийх гэж тун зав чөлөө муутай байлаа. Тэгээд vдшийн бvрэнхvйгээр хоёр том тvвдэг асааж, нэгий нь тойрон отгийн эрэгтэйчvвд сууцгааж, нөгөөгий нь эмэгтэйчvвд тойрон сууж, залуу эрэгтэй эмэгтэй нь хоср тvвдэг тойрон суусан ахмад эгчмэд хvндээ бэлтгэсэн хоол барив. Өвгөдийн тvвдгийн гол хойморт нь Бух өвгөн, тэргvвтэй таван аянчин, хvндэт зочин боллон сууцгааж, эхлээд модон торхонд тvвж дарсан жимс, жимсний шvвснээс амсацгаан, дараагаар нь загас, ангийн мах идэцгээн эмэгтэйчvвдийн галын тэнд бас хоол унд идэж ууж гvйцээд наадам хийхээр болж, өвгөд настангууд нь урдаар жишиг үзvвлдэг заншилтай тжл их тvвдэг тойрон гар гараас барилцан нар зөв галаа тойрон хатирах наадамын дуу дуулалдан, цөм маш цэнгэлтэй хөгжилтэй байв. Чоносын хоёр хvн, хоёр Хумка төдхөн тэр гал тойрон хатирах хөдөлгөөнийг сурцгааж, Ихэрэсийн олны адил наадалцаж байтал, хэдэн гуя онгоцоор өдрийн элч дагалцан Бух өвгөний төрөгсөд ирэлцэж, улам их баяр хөөр боллоо. Бух өвгөний охин гэж Залуудайн насны нэг хөрслөг бор царайтай, хөөрхөн торомгор хар нvдтэй, сvрхий сэргэлэн янзын бvсгvй жаал, эх, ах хоёртойгоо ирж Бух өвгөн бага охиноо баруун хацры нь таалан vнэсээд,
- Чоносын Шонхолой, Ихэрэсийн Бух гэдэг бид хоёр энэ хэдэн жил vхэхээс л бусдыг үзэж, зовлон жаргалангаа хамтатган, дайсантай мөр зэрэгцэн тулж өнөөдөр хvртэл явж ирлээ.

Далай ээжий нутагтай Ихэрэс бид
Дая олонд охидоор алдартай билээ
Бай кул нутагтай Ихэрэс бид
Бацгад царайлаг гэж нэртэй билээ
Өнгөтэй айхан охидоо өгч
Өнөр олон зээнэртэй болдог
Хад сайтай нутагтай
Хадам сайтай Ихэрэсийн
Бух дайчин гэдэг би өнөөдөр

Буянт Чоносын Шонхолойтой
Газрын холоос наашаа
Гал нэгтэй яван аялж
Аюулт дайсан араатны дунд
Амь нэгтэй звтгэн туулж
Ууган нутагтаа ирээд
Ураг элгэн болцгоож
Тансаг идээгээ амсалцаж
Тангараг үгээ хэлэлцэж
Эрийн сүлд болсон бvсээ
Эрхэм элгэн төрөл болохын
Бат тэмдэг олны өмнө болгож
Баярлан солилцсуу бид хоёр
Баргудай баатар нагацтай
Баргужин гоо охин минь
Чон чулуун зоригтой
Чонос Шонхолой минь
Заан Залуудайн
Заяат хань нь болог
Нvдэндээ галтай
Нvвртээ цогтой
Зээ нар, ач нараа vзэж
Зэрэгцэн найрлах болтугай
Зээнэр маань
Зээрнээс олон
Ач нар маань
Аргалаас олон
Шонхолой бид хоёрын улс
Шороо мэт олон болтугай
Шоо, шоо шоо
гээд бvсээ тайлан Шонхолойд барихад, харь газар харьтны гарт хvний газар, хvний
эрхэнд хамт явж, өлсөх, ядрахыг хамт эдлэн өнөр олон төрөлтэйгөө улаан нvврээ
vзэлцэн золгосон Шонхолой, Ихэрэсийн Шударга Бух өвгөнд тун хайртай болсон тул
өвгөний Баргужин гоо охин сэргэлэн цэврийг бахдан vзэж, Баярлан бахадсандаа
яаран бvсээ тайлж Бух өвгөнтэй солилцон бvслэлцээд
Хvний газар
Хvчитний дунд
Үнэн сэтгэлээр
Үерхэн нийлсэн
Ихэрэс Бух дайчинтай
Ижилсэн нийлсэн Шонхолой
Заан гэж сая цоллуулсан
Залуудай гэдэг хvндээ
Баргужин гоо ханьтай болгох
Баярт үг сонсоод бахаднам

Усны холоос ихэрэс, Чонос
Уулзалдан танилцаж,
Ураг элгэн болоод веийн вед эвтэй
Үрийн үрд жаргалтай
Эрчимтэй гараараа хэзээд
Эдийн сайныг бүтээж
Саруул тунгалаг ухаанаараа
Сайхан бүгдийг зохиох болтугай
Ваа, ваа, ваа

гэж Чоносынхоо уриаг уриалан, үнэн голынхоо үг хэлж дуусахад нь Залуудай
Баргужин гоо хоёр ичингвйрэн улайж наадмын олон баярлан, нэг залуу эр урагш
давшин ахмад өвгөдийн өмнө ыөхийн ёслоод, хангинам сайхан хоолойгоор :

Бүрэнхүй шөнийн наадамд
Бүгдээр цуглаад ирлээ бид
Харанхуй шөнийн наадамд
Хамгаар цуглаад ирлээ бид
Хун галуу мэт дуугаа нийлүүлж
Хулан тахь мэт зүсээ нийлүүлж
Настан ахмад дээдэс та нар маань
Наадмаа үүсгэн эхлэх ч болоосой
Тогоруу мэт тохилзон бүжиж
Тоодог мэт дайвалзан алхаж
Буянтай буурал эгчмэд дээдэс маань
Бултын наадмыг захлах ч болоосой
гэж уриал айлтган дуулахад нь Бух өвгөн нүд нь гялалзан гуяа алгадаад,
Бүрэнхүй шөнийн наадамд
Бүжих дур минь хөдлөв л
Харанхуй шөнийн наадамд
Хатирах дур минт хүрэв л
Харь л газраас ирээд үү
Халуун та нартайгаа золгоод уу
Хамаг л олны наадамд уу
Бүжил үгвй яахав би

гээд , алсын аян туулж ирсэн дөрвөө нөрдөө дагуулан, отог олны наадамд ахас
ихэстэй нь хамт гар гараасаа барилцан, гал түүдэг тойрон хатирахад чонос
Шонхолой Залуудай хоёр, хумка Үхүү, Гекүү хоёр олны бүжин хатирах хөдөлгөөнийг
төдхөн сураад, их л таашаан наадав. Үхүү Гекүү хоёр тэр гал тойрон хатирах наадам
анх үзсэн авчтун таашааж их л баяр хөгжилтэй хатирч төдхөн наадмын дууны аяыг
тогтоон сураад, өндөр дуугаар дуулалцан бүжив. Балар эртний хүмүүс, галын наадам
хийхэд орон дэлхий баясаж анч хүн, анд олзтой, эр хүн олз омогтой, явдал урагштай
болдог гэж итгэдэг байсан учир өвгөд өтгөс, галын наадам хийж хатиран бүжиж
байгаа залуучуудыг урамшуулж дунд нь оролцон наадалцаад өвгөдийнхөө галын
дэргэд суун амарч, наадамчдыг урамшуулан хөхүүлж байв.

Ихэрэс Бух худ, төрөл төрөгсөд олонтой их омгийн хvн байжээ. Өдий төдий жил сураг чимээгvй болж одсон хvн, санамсаргvй эсэн мэнд маш хол газраас буцаж ирээд, буцаж ирэхдээ бас омог олондоо харвах нум, хэрэглэх арга, хатан чулуугаар маш сайхан зvлгэмэл зэвсэг хийх нарийн дархны зvйл сурч ирсэнд нь омог олноороо их л баярлаж, өвгөнийг алс хол газраас олон аюул дундуур хамгаалан хvргэж ирсэн Шонхолой, Залуудай сэлтийг тэсгэлгvй элэгсэглэж, өрх бvр дайлах гэж салахгvй хэсvвлсээр нэг мэдэхнээ хус модны навч шарлах шинж оров. Чингээд маш зочломтгой Ихэрэсvнд арга буюу нутаг ус холтой зочноо өвлийн хvйтэн болохоос урд буцаж vзье гэхэд нь саатуулах ёс яаж байж болохов? өвөлжөөд буц гэж vлдээх гэхэд Чонос Шонхолой, Ихэрэс Бух өвгөнтэй хамт өмнөд хол газраас нутаг усандаа дөнгөж хvрч ирмэгц Бух өвгөнийг нутаг усанд нь хvргэх гэж төрөл элгэнийхээ хvнийг уулзан золгонгууд орхиод ирсний нь санахдаа бас өвөлжvвлэн vлдээх гэж оролдоход яаж болохов? Гэж шударга сэтгэлт Ихэрэсvнд худ ураг болсон Чонос Шонхолойгоо vднэ гэж ус чийг тавихгvй хав загасны арьсан годос гэдэг гутал, өмд -өөдөө амсартай юм гэж бvгдэнд нь хийж өгсөнд, хөлдөө годос байтугай чархи чуглаж vзээгvй Үхvв, Гекvв хоёр нэн баярлав.

Заан Залуудай хvнгээ хvргэж ирсэн хvргэн болгож vлдээнэ vв, худ минь гэж Бух өвгөн Шонхолой Залуудай эцэг хvв хоёрыг хагацуулан салгахыг сэтгэл vл тvвдэн, энх эсэн л явбал хvргэн хvвтэйгээ уулзах цаг бий гэж эцэгтэй нь буцаахаар боллоо. Чингээд, Шонхолойгоо тэр хар Намиадын нутаг усыг яаж өнгөрvвлэх вэ? Хичнээн дайчин эрс дагуулан явах вэ? гэхэд Шонхолой, Үхvв, Гекvвтэйгээ дөрвvвлээ явна. Ихэрэс ургийн намрын анд хvн бvлий нь ан аваас нь холдуулаад яахав гэж цааргалсанд Ихэрэсvнд худ Шонхолойгоо ядахдаа гурав хоногийн газар vднэ гэж тогтов. Омог олноороо Шонхолой худыг дайлж нэгэн сайхан цэлмэш өглөө Бух өвгөн тэргvвтэй хэдэн яийрэг Ихэрэс аянчин Шонхолой худ, хvргэн Залуудайг гурван хоногийг газар vдэхээр аялахад, Баргужин гоо, Залуудайд

- миний ээжийн надад өгсөн чимэг юм. Зvвж явахад өлзийтэй сайн эд гэдэг юм.

Аралжаа хийж, хойд хол зvгийн омогтон улсаас халиу булгаар авсан юм гэнэ билээ. Учрахын бэлэг болгоё гэж Залуудайд тунгалаг сайхан хуваар сийлж хийсэн арслан заан чимэг өгөөд ичингvйрсхийн тэргvвнийг дарсанд анх vзсэн цагаас нvдэнд нь дулаахан, сэтгэлд нь сайхан санагдсан тэр цэвэр охины хvрэн бор царайг харахдаа, дахин энэ сайхан царайгий нь харах болтол их удна гэж зvрх шимшрэх мэт сонин сэтгэгдэл төрж, тэр хув чимгий нь хvзvннээсээ зvнгээд охины хvрэн өөр бяцхан бөгөөд хөөрхөн гары нь өөрийн эрхгvй аяархан илэв. Шовхоног, Залуудайн баруун хацрыг vнсэн таалаад,

Алс холын замд автайгаа

Амгалан сайн яваарай хvв минь

Наран залаат хөх тэнгэр ивээж

Гачин залаат хөрст дэлхий тэтгэж

Усны уртыг сааталгvй туулж

Уулын өндрийг саадгvй давж

Алс холын их замд автайгаа

Азтай заяатай яваарай хvв минь

гэж ерөөгөөд загасны арьсаар хийсэн хөнгөн цув бэлэглэв. Бух өвгөн нэг айхан арслан зааны соёогоор хийсэн бариулд нь хулан тахь сийлсэн найман талтай, тал

бүрдээ хвчтэн араатан сийлсэн бороохой бэлэглэж,
Ур сайт хуланцгийн минь урласан
Эр айт элэнцийн минь эдэлж явсан
Чанга гартай ёадал сайтай эрийн
Чамбай зэвсэг чамдаа бэлэглэн барьсуу
Хатуу заяат Заан Залуудайгийн минь
Хартны нь хага цохин дарж
Бортны нь булга цохин сөнөөж
Амий нь сахиж, атаатны нь дарж
Агаа хвчий нь нэмүүлж, алдры нь мандуулж
Бух хвзвүтнийг булга цохин дарж
Булиа хвчитнийг бут ниргэн сөнөөж
Эр зоригт хвргэн заан Залуудайд минь
Ээлтэй сайхан зэвсэг болж яваг
гэж ерөөн барьсанд Залуудай тэр гоё сайхан бороохойг хоёр гараараа хвндэтгэн
хвлээн авч,
Бат зоригт баатар эрсийн
Барьж явсан энэ зэмсгийг
Бэлэгтэй ерөөлий тэнв сонсон
Бэлэгшээж баярлан хвртлээ би
Агаа их хвчитний барьж явсан
Арслан зааны соёо бороохойн хариуд
Атаатны тань товрог тоос болгож
Араатан дайсны тань аргал хоргол
Хортон дайсны тань хоргол аргал
Хол ойроос халдах өшөөтний тэнь
Хог саг болгох эр болсуу би
Хол боловч ойр мэт бодож явсуу би
Баярын царайгаар дахин учрахын
Бат ерөөлөө дэвшүүлэн тавьсуу би
гэж эртэс дээдсийн заншлаар өлзийт ерөөл үгээ хэлэлцэн салахын ёс хийж, Чонос
омогтны нутгийн зүг аялах урт замдаа ороод гурван хоног үдэх Ихэрэс эрсийн
хамтаар дөрвөн аянчин өглөөний өөд улаан нарнаар бэрх холын аянд зорин одов.

Өөдөө салаар явах аргагвй тул Ихэрэс эрцүүл Шонхолойн буцах зам гудас хустай
газраас вйс хуулж, хоёр хвн суугаад, явж болох , явж боломгвй газар өргөөд явах
вйсэн завь хийж өгнө гэж хэлэлцсэн байлаа. Ихэрэс омогтон , тийм завь хийхийг
нутаг зэргэлдээд бий болсон вйсэн завьтан нэгэн аймгаас хийж сурсан бөгөөд
хөнгөн хурдан сайхан онгоц гэж нэг хвн, хоёр хвн суух вйсэн завь зарим загасчин
хийж хэрэглэдэг болсон байжээ. Бух өвгөн Шонхолой худыг үлэн гаргаж өгөхдөө
вйсэн завь хийдэг урцуулыг олж, урт ванд хэрэглэх тийм завь замд нь хийлгэж
өгөхдөө Шонхолойг нутагтаа бас вйсэн завь хийж хэрэглэх аргы нь үзэж сураг гэж
бодсон байв. Өдөрчийн газар, их мөрөн дагуу хус мод үлэмж буй газар маш бүдүүн
хустай тул, вйс нь завь хийхэд таатай юм гэж нэг Ихэрэс анчин газарчилж явсаар
нээрээ ч жигтэйхэн их том хус модтой газар хврч ирээд, тэр анчин , бүдүүн хусны

үйсийг хуулан авдаг аргы нь Шонхолойн нөхөд сэлтэд нь үзүүлж, одоо цаг нь арай оройтсон, гэвч аргалан хуулж болно. Ёстой зохист цаг нь дол орсон цаг байдаг юм гэж Чонос анчинд хусны өргөн үйс хуулж, завь хийх арга зааж, хоёр хоёр хvн суугаад явах хоёр онгоц хийж залах сэлбvvp гэж хоёр талдаа халбага шиг хавтгай сэлvvp хийлцээд, тэр үйсэн завийн хитvгэн талд нь юмаа хийгээд, явах шургуулагатай, урагшаа хөлөө жийгээд, жад зэмсгээ шургуулах затай тун хөнгөн завь хийгээд, бургасны долоор vдээр хийж, цоорхой гарвал үйсэн нөхөөс тавиад ус оруулахгvй гэж vдээрийн нvх сvвийг давирхай жилийгээр шавах арга байдгийг зааж өгөхийн хамт, усанд завиа аваачиж залах сэлэхийг үзүүлэхээр боллоо. Үйсэн завь хийж Их мөрний эргэд vврэн аваачиж, Үхvv, Гекvv хоёрыг хоёр хvнт завийн урд талд сууж сэлэх, залахыг сургатал хоёр хонож, тэр завсар Үхvv Шонхолойн урд, Гекvv Залуудайн өмнө сууж сэлэх, бас ардах хvнийхээ сэлэх залахад хvч нийлvвлэхийг сурцгааж Ихэрэс анчин тэр ойн хоёр хvнийг ээлжлэн сургаж Бух өвгөний vгээр бол нилээд “ элдэн боловсруулжээ “. Чингээд Гурав хонохын өглөө нь Бух өвгөн

Алгана зэвгийн мах

Араанд шалай болов

Ан гөрөөсний мах

Амттай санагдах болов

Гэж ууланд агнахаар болж, отог дээрээ хэдэн хvн vлдээгээд, Шонхолойг нөхөдтэй нь дагуулан ууланд гарлаа. Хусан ойт уулыг даваад нэг бор нуруун дээр гарч доошоо тонгойтол будан татсан оройтой нэг сайхан уул цаана нь байв. Модон захаар нь ан тураг үзэгдэхэд тэр уулыг чиглэн явтал, арван хоёр салаат эвэртэй буга, ширэнгэ дотроос гарч ирснийг амин газар нь онож, Шонхолой ганц сумаар унагасанд Ихэрэс гөрөөчин урд өмнө тийм юм үзээгvй тул ихэд гайхаж, нум годоль гэж ийм хvчтэй зэвсэг юм байж, хэмээн Бух өвгөнийг харвал зааж өгөөрэй гэж гуйцгаахад нь, намрын ав болохоос өмнө налгай сайхан нжмтай болгож, харвал заана гэж амлав. Чингээд ууланд гартал, хаданд явсан нэг хvдрийг өвгөн Бух харван унагаж, Булжуухай худгуйд өгөөрэй гэж заары нь Шонхолойд өгөөд, хоёр соёогий нь мулталж аваад анчиндаа буга өвчиж байсан нөхөд дээрээ хvдрээ vврэн аваачиж, отог дээр буга хvдрийн махаар хоол хийж байгтун гээд бцсад анчнаа дагуулан Шонхолойн нөхөдтэй уулаад гарваас энгэр талд нь Нэг хадны хөмөгт агуй шиг юм харагдав.

- Тэр юун агжуй вэ? гэж Залуудайн сонирхоход Бух өвгөн

- Бvв мэд. Би энvвгээр урд яваагvй гээд анчнаасаа асууваас, нэг хvн өгvвлрvн :

- Энэ газар даруй Булагад хvний нутаг Будант гэдэг уул. Энэ ууланд Булагад омогтон тахидаг Будан эвийн агуй бий гэж дуулсан. Тэр байлгvй дээ. Булагад хvн ан хийх, аянд явахдаа Будан эвийн агуйд замд нь тааралдах нь бэлэгтэй сайхан байна. Хатавчинд нь ирээд харалгvй, босгонд нь хvрээд буулгvй буцаж болохгvй. Будан эвийн агуйд будаг зосоор зураг өргөн, харь газраас хар толгой мэнд буцвал хөрөг дvрий нь шинэтгэнэ гэж амлаж явсан юм. Амласандаа эзэн босуу, Будан эвийн агуйд орсуу, гээд Бух өвгөн хадан хөмгийн зvг мацав. Бусад нь хойноос нь дагалцан агуйн амсарт хvрвээс гаднаас амсар нь бага мэт харагдах авч дотроо өндөр уужим. Голд нь чулуугаар овоо босгож Бай кул далай, нуурын усны хясаа, далайн хөвөөн янгир, хирис, бух гөрөөс, угалз, хандгай бугын эвэр, хутган соёот бар, хздрийн соёо тавиастай, хатаамал борц, жимс, төмс тавиастай байгааг үзээд Бух өвгөн саяхан агнасан хvдрийнхээ соёог тавив. Чингээд бор цайвар чулуун агуйн амсар доторх

хадан хоёр хананд нь хvн хvн ангийн дvрс улаан зосоор зураастайн зарим нь балархай шиг болсныг vзээд, бvснээсээ агссан эвэр халзын таглаа сугалаад

- Нангиа газраас авч ирсэн нарийн зос. Одоо л надаа хэрэг болох нь өвгөн дархан Пек Тсиег агуйн өтгийн тосоор найруулж өгсөн юм гээд, агуйн балархай зургийг сэлбэж, хулан тахь, тэх, бух гөрөөс, арслан зааны дvрс тэр тун хурц өнгөт зосоороо сvрхий дvйтэй, дадамгай зураачийн намбатайгаар зурж эхэлсэнд нь Залуудай хажуунаас нь сонирхон харж ганц нэг чадамгай зураасаар ан амьтны төрх байдлы нь айхтар онон гаргаж байгаад нь vнэхээр бахдаж байв. Чингэж байтал хvн алхах хөлийн чимээ гарч, агуйн амсарт чийрэг сайхан биетэй нэг эр гараад ирэв. Тэр хvний хvрэн бор царай шударга эрс хvний шинжтэй бөгөөд нvд нь төв амирлангуй, харсан хvн бvхний сэтгэл татмаар тийм нэгэн эр ажээ. Агуйн амсар дотор сууж байгаа хvн, хананд зураг зурж байгаа Бух өвгөн сэлтийг хараад, гаднаас ирсэн тэр хvн

- Амар мэнд байна уу? Та нар аль омгийн юун хvн бэ? Хэт нутаг хаа бэ? Хэрэг зориг юунд бэ? гэж ханхар хөндий цээжнээс нь гарч байгаа цээл сайхан хоолойгоор асуусанд бvгд тvvний зvг хандаж Бух өвгөн

- Бидний олонх Ихэрэс омогтон. Миний нэр Ихэрэс Бух гэдэг. Өмнөд Нангиа газар явахдаа Булагад олны Будан эвийн агуйд хөрөг зургий нь шинэтгэж өгнө гэж амласан билээ. Чингээд, Нангиа газраас надтай хамт явсан Чонос омгийн Шонхолой нөхөртэйгөө худ ураг болоод, vдэн гаргаж явтлаа санамсаргvй Будан эвийн агуйн хавьд хvрч ирээд, урд амласан юмаа гvйцээх цаг тvvх нь боллоо гэж агуйд нь бараа бол, зосоор зурсан зураг хөрөг шинэтгэж байна гэхэд нь, тэр шинэ ирсэн хvн

- Анд яваад сураггvй болсон хvн, урд зvгээс газрын хол, усны уртаас аялан хvрч ирлээ гэж би дуулсаан. Энэ хоёр хvн яасан, манай Булагад нутгийн сав газар ойд байдаг Хумка хvнхтэй зvс байдал төстэй хvн бэ? гэж Үхvv, Гекvv хоёрын зvг заан асуусанд, Гекvv тэр Хумка гэдэг омгийнхоо нэр сонсоод ихэд гайхан, зvрх нь цохилж сэтгэл нь хөдлөн,

- Энэ газар Хжмка хvн байдаг юм уу? гэхэд нь

- Шивэр их ойд Хумка хvн байдаг юмаа. Тогтмол суурьшсан газар vгvй, ойд хэрэн хэсэж явдаг улс. Өвөл хавар манай Булагад өрхийн хавиар vзэгдэж, тарчиг ховор цагаар өл зөлгөх юм гуйж явдаг юм. Гал гэж мэдэхгvй, гутал чархи гэж мэдэхгvй, ядруухан омогтон доо. Хэл бас Булагадтай сайн нэвтрэлцэхгvй, дохио зангаагаар л нэг юм мэдэлцдэг улс даа. Хамар сайтай. Муу мэх байхгvй, тийм л аймаг омогтон доо. Би энэ хавар хvртэл ойд дайралдаж байсан гэхэд нь Гекvv

- Эндэхийн Хумка нар, өөр газар Хумка хvн бий гэдэг vv? Гэхэд

- Би хэлий нь мэдэхгvй, дохиогий нь л мэднэ. Манай хэл муухан мэддэг нэг өвгөн Хумка Үхvv гэдэг өвгөн урд зvгт явалцахаа байсан гэж өвгөдөөс сонссон vг бий гэж Булагад хvнд ярьсны нь би дам дуулсан. Тэгээд энэ хоёр хvн, манай Хумка хvний төстэй тул, би сонирхож асуусан юмаа гэхэд нь

- Би Хумка Үхvv гэдэг хvн байна. Манай урд зvгийн Хумка хvн, хойшоо их модоор аялбал, шинэ сар ургахыг гурав дөрөв vзэхэд, Хумка хvний царай vзэж, vгий нь сонсож болно гэж эцгээсээ би урд дуулсан. Тэгээд урд зvгийн Хумка хvн, учрахын тэмдэг болгож, унтахдаа толгойгоо заавал хойш нь харуулж унтдаг, хойд зvгийн Хумка хvн урагшаа харж унтдаг. Чи хойшоо харж унт гэж намайг сургадаг асан гэж хэлээд, одоо урд газар толгойгоо хойш нь харуулан хэвтэх Хумкагаас энэ бид хоёр л vлдсэн дээ гэж гуниг хэлэхэд нь тэр хvн

- А, Яаж мэдэхэв? Их ой дотор хэрэн хэсэж явдаг омогтон, бөөнөөрөө нэг дор байдаггүй юм хойно, нэг хэсэг нь аюулд учравч, нэг хэсэг нь хэрэн хэрсээр байлгвй яахав.? Миний бодолд орохдоо, урд газрын шивэр их модонд Хумка хвн бас байна гэж зоригтой хэлэхэд нь Гекvv ихэд баярлаж,
- Таны нэр хэн бэ ? гэхэд нь
- Урд зvгийн Хумка хвн гэхэд , манай хэл сvрхий сурчээ. Манай Хумка хвн ийм цэвэрхэн хэлж чадахгвй шvv гээд, Бух өвгөний зvг хандаж
- Би Булагадын Арслан минаач гэдэг. Миний нэр та дуулсан ч байж магадгвй гэхэд нь
- Дуулалгвй яахав? Нэр сонсоод , зvс vзээгвй болхоос
Гурван орон хэсvлтэй
Гухамсан сухай минаатай
Өргөн их цээжтэй
Өндөр их сугатай
Хамаг олондоо хайртай
Булагад олондоо элэгтэй
Ах зах Арслан минаач
- Гэж хэлцэхийг дуулсан даа. Өнөөдөр Будан эвийн агуйд , Булагадын сайн Арслантай уулзсандаа их баятай байнам би. Хол нутагтай Чонос Шонхолой худы минь орон нутагтаа саадгвй сайн явж хврэхий нь Арслан минаач та , санаандаа саналцаж, бодолдоо бодолцож өргөн их цээжиндээ дурдаж, өндөр их сугандаа тvшvvлж, гэгээн өдөр ухаандаа, харанхуй шөнө зvдэндээ орхилгвй яваа та гэхэд нь Тэр чилгэр сайхан эр мишээж
- Эзэн хичээвэл аз хичээнэ гэдэг мэргэн vvg бий. Худы тань харвал сэлбэлгвй сэцэн хвн байна л. Хvvгий нь харвал нvдэндээ галтай, нvvрдээ цогтой, сэргэлэн хурц залуу мэт харагдаж байна. Магтуулсандаа маасганаж, сайн хэлvvлсэндээ сагсууралгвй, гутахгвй хатуу зоригтой, гунихгвй хатан сэтгэлтэй, хvнд сайн, хvний vнэртэй, зорьсондоо хврч, хэлсэндээ эзэнэ болж яваарай хvv минь , Аавтайгаа , нөхөдтэйгөө аяндаа аштай, замдаа заяатай, хоногтоо хоолтой, араатан халдашгвй хvчтэй ханьтай, алхац арвитай, явдал дорвитой сайн явж, санасан газраа саадгвй хvртvгэй гэхэд нь бvгдээрээ
- Тэр сайхан ерөөл бат оршиг, гэж баярлалдав. Арслан минаач Бух өвгөний сайхан найруулсан зосыг бахдаад тvр хэрэглvvлэхийг гуйж
- Өвлийн идэш базаах гэж, манай Булагад, намрын сvллчээр ав хийх гэж , Будант уулын агуйд буурал ээжээс хулангийн хутаг, тахийн хишиг гуйгаач гэсэнд нь ангийн дvрсийг сэлбэн зурах гэж ирсэн билээ би . Гэтэл та ирээд, надаас сайхан зурж байгаа тул , би таны энэ сайхан зосоор хэдэн юм зарим зураг дээр нэмсvv гээд зарим ангийн зураг дээр жад шаасан зураас нэмэв. Залуудай, Арслан минаачаас зос аваад, бас хэдэн годоль сум шигдэж амнаасаа цус цувруулж байсан хутган соёотыг самнаа зургийн байдлаар зурсанд, тэр хвн
- Энэ яасан богино жад вэ? Чи хэмжээгий нь алдаж зурсан бишvv ? гэхэд нь амсарт нэг буланд хураасан жад, , саадагтай нум, хоромсготой сумаа зааж
- Манай хоёр аав урд газраас ийм зэмсэг хийдэг болоод ирсэн гэж, Арслан минаачид хавчаахай нум, годоль сумаа vзvvлэн, доошоо буухпаа харваж vзvvлнэ гэхэд нь Гекvv
- Би энэ өндөр хушийн орой дээрх тэр гурван боргоцойг харваад өгсvv гээд, ганц

сумаар гурван боргоцой унагасанд, Арслан минаач Бух өвгөнд

- Та нумчинтайгаа энэ агуйн дээд салбарт оролцож, нэг юм харваж өгнө үү? Гэхэд нь Бух, Шонхолой, Залуудай, Гекүү дөрвүүлээ агуйн амнаас салбарласан нэг нарийн нүхээр бамбар барин, шургаж ороод үзвэл, дотроо маш уудам өндөр бөгөөд нэг хананд шар улаан зосоор тахь, үхэр гөрөөс, угалз янгир, гурын дүрс зурсан нь цөм олон анчин жадлан хөөж, унагаж байгаа зураг ажээ.

- Агуйн дунд шавраар, хэвтэж байгаа нэг тахь хийж, тахийн арьсаар нөмөргөсөн байв. Тэр баримал тахийг тойрон олон хүний хөлийн мөр бамбарын гэрэлд харагдсанд Шонхолой,

- Энэ шавраар барьсан тахийг нар зөв тойрсон олон хүний мөр ямар учиртай юм бэ? гэж асуувал Арслан минаач

- Намрын их ав хийж өвлийн идэж бэлтгэхийн өмнө Булагад омогтон энд хүрч ирээд, бамбар барин энэ тахь тойрон бүжиж, сайн сайн анчин жадалдаг юм. Ан олз ихтэй болдог гэж эртнээс нааш заншсан ёс доо. Жад чулуу хүрэхгүй газраас тусгадаг танай энэ шинэ зэмсгээр нөхөд, энэ шавар тахийг нэг нэг онож, манай энэ намрын ан авыг урагштай болголцож өгөөч гэхэд нь эрт балрын хүн, ажил явдлаа урагштай сайхан болгоно гэж итгэн боддог байсан тулд Бух, Шонхолой, залуудай огт гайхсангүй, гуйсан ёсоор нэг нэг сум харван тэр барималд шигдээстэй үлдээжээ. Гекүү нөхдөө дууриан бас нэг сум тавиад Хумка гар нум сум байтугай, олигтой чулуун зэвсэг засаж чаддаггүй бөгөөд байгаль ертөнцийн тухай мэдлэг нь энэн ч балар байсан тул,

- Одоо бид сумаа сугалж авах уу? гэж асууваас, Арслан минаач

- Одоо сумаа сугалж болохгүй ингээд л үлдэх ёстой гэсэнд

- Ээ тэгвэл би хайран сайн годлио харваж энэ шавар тахид идүүлээ. Годоль шаалгах дуртай юм гэж надад урдаар хэлж өгсөн бол би арай ондоо годоль энэ тахид шааж өгөх юмсан гэхэд нь Гекүүгийн годлио харамсан, бамбарын гэрэлд байн байн харж байхад нь Залуудайн инээд хүрч би чамд нэг сайн годолв өгнө гэхэд нь - Гекүү тоо сайн сураагүй нэг, хоёр, олон гэж гуравхан тооны үг мэддэг тул хоромсгондоо байгаа сум зааж надад олон годоль байгаа дээр нь энэ шавар тахийг харавсан нэг годоль, Залуудайн өгнө гэсэн нэг годоль, нэмбэл, нэг годоль, хоёр годоль, бас нэг годоль, хоёр годоль, бас олон годольтой байх юмсан гээд санаа алдсанд, Шонхолой инээд нь хүрэвч царайг төв болгон:

- Би чамд бас нэг годоль өгөмц. Энд тийм үг хэлж болохгүй гэв. Гекүүгийн годлио харамсах үгий нь сонсоод Арслан минаач зэвүүнээр инээмсэглээд, нүд нь тун сонин харцтай болж, бамбар барьсан гараараа тэр шавар тахийн зүг заамагц дөрвөн харваачин, өөрийн эрхгүй түүний заасан дагуу харваас, өнөөх тахийн арьс нөмрөөстэй шавар тахь хөдлөх шиг боллоо. Энэ яаж байгаа нь тэр билээ гээд, хэдэн бамбарын сүүмэлзэх гэрэлд сонин сүүдэр хөдлөн үзэгдэж байгаа харанхуйагүй дотор шавар тахийн зүг бүгдээрээ харваас, шавар тахь хэдийн байхгүй, дөрвөн сум шигдсэн нэг их сүртэй том тахийн азрага хэвтэж байснаа босох гэж, догшин сүртэй нүднээс нь цахилгаан цахилах мэт, Гекүүгийн өөдөөс муухай харан, чонон хоёр чихээ хжлмалзуулан ам юугаан ангайж, шүд юугаан ярзайлгаж, цустай хөөс сахруулан цээжээ өндөлзүүлэн босох гэж овс овс хийгээд, агуй дотор цуурайттал догшин сүртэйгээр унгалдан, Гекүүгийн годоль шүдээрээ шүүрэн биенээсээ суга татаж аваад, толгойгоороо нэг ширэвмэгц годоль шур хийгээд, Гекүүгийн гуя хөндлөн цохиод хуга буужээ. Гекүү царай нь үнсэн хөх болоод ёо хэмээн, гартаа барьж

байсан бамбараа газар алдан, царайд нь тэсгэлгүй эмээсэн байдал тодров. Догшин тахь урд хоёр хөлөөрөө газар цавчмагц зүг зүг оч цацран ногоон туяа гэрэл татуулахад агуйн туурганд зураастай байсан олон амьтан хөдлөх шиг харагдав. Чингээд нүд ирмэх зуур тэр тахь өөдөө цоройн Гекvvгийн зүг эргэж толгой дээр нь урд хөлөөрөө цавчих гэхэд Залуудай шаламгайлан нэг харавмагц тэр тахь агуй дотор хvнгэнэтэл газар ойчив. Цөм тэсгэлгүй хэлмэгдэн цочиж тэр газар ойчоод тарчилж байгаа тахийг харваас дахин шавар тахь болж тахийн арьсаар нөмөргөөстэй урьд хэвээр байнам. Гагцхvv омруу тушаа нь Залуудайн бас нэг сум шигдээд, Гекvvгийн сум нь гуяы нь хцга цохиод дэргэд нь газар хэвтэж байв. Гекvv тэр тахийн азарганд цавчууллаа гэж сандран , хоёр гараараа толгойгоо хамгаалан , нүдээ аниад зогсож байхыг бvгд эмээн харж, Арслан минаачийн зүг харваас аажуухан зогсож, баруун гартаа гурмасан сухай ташуур минаа бариад, зvvн гартаа бамбар барин , Гекvvг минаа барьсан гараар дохимогц,

- Ёох, гэж дуу алдаад толгойгоо гараараа илэн хага цавчуулав уу vгvй юв? Гэсэн юм шиг барьж vзээд годольд савуулж говгор болон хавдсан гуяа ярвайн барьж царай нь хачин болоод, доошоо бөхийж, хугархай годлио аваад Залуудайн гараас шvvрэн,

- Явья, явья, айдас минь хvрч байна. Гадаа наранд гаръя гээд чичрэн дагжив. Эртний грек vгээр хипноз буюу нойр зvvд, эртний монгол vгээр ховс буюу ховусун хэмээх бөгөөд хогоосон, хоосон гэж мэргэн нэр өгсөн нэгэн зvйлийн хvний сэтгэлийн чадлыг тэр эрм балрын жирийн хvн учры нь олж мэддэгvй байсан тул, Арслан минаачийг дагаж , Будан эвийн агуйд орсон дөрвөн аянчин их л сvрдэж, нэгэн хэсэг vг дуугvй зогсон, тэр их айж цочисноо харахад, айван тайван зогсож тэднийг мишээн харж байгаа Арслан минаач явья гэж дахин агуйгаас гарах нvхэн зүг улирдан одов.

Чингээд тэр их хөндий агуйгаас нарийн нvхээр нь доошоо бууж, агуйн амсрын том хөндийд хvрч ирвээс харанхуй газраас гэрэл гэгээ тусдаг газар гарч ирэхэд сайхан ч юм шиг, эртний хvmvvсийн босгосон чулуун овоо , ханын зураг нь ёvртэй сонин ч юм шиг . Бас Бух өвгөний хурц улаан өнгөт зосоор шинэтгэсэн зураг нь бvр ч сvр vзэмж vлэмжхэн орсон юм шиг сонин жигтэй харагдав.

- Биднээс өмнөх олон veийн хvний зурсан юм энд хэвээрээ л байгаа гэж Булагад Арслан минаач хэлээд Ихэрэс Бух өвгөнийг

- Та энэ нум годоль хэрэглэх сонин аргаа манай Булагад хvнд сургаж, амаа тостож, ахас өвгөсийгөө гэдэс цатгалан суулгахад нь тус болж vзээ та. Урд хол газарт энэ нум хэн бий болгосныг та эс мэдэрч амандаа идэх юм нийлvvлж, амиа хаацайлахдаа нумын ачаар чадал нэмэгдсэн шиг , таны сурч ирсний ачаар манай энэ газрын хvн омогтон, танаас амь зуухдаа тустай юм олж явбал сайхан шvv гэхэд нь,

- Тэр зөв өө, ах дvv омогтон тэгэлгvй яахав гэж Бух өвгөн хариуллаа.

Залуудай ахас хvний тэдгээр vг сонсож байгаад, Бух өвгөний Баргужин гоо охины төв харцтай торомгор хар нүд нь, хvрэн бор цэвэр царай нь гэнэт харагдах шиг болж, Булагадын энэ агуйд ойр залгаа Баргужин гоогийнхоо нутагт дахин би нэг ирэх болоосой гэж бодоод барын соёогоор хийсэн дун цагаан зэвээ агуйн амсрын чулуу босгосон овоонд тавиад,

- Урьдын хvний юм нь

Хожмынхоо хvнд дурсгал болог

Учрахыг хvссэн хvсэл

Хожим санасан ёсоор бvтэг

Гээд Арслан минаачийн цэцэн бөгөөд хvний дотор юу бодож байгааг хараад мэдчихмээр гэж бодогдом сvрхий нvд өөд нь хараад, баахан ичингvврэн зовнисхийтэл, тэр хvн нээрээ чсанаагий нь мэдсэн юм шиг мишээсхийгээд,

Уужим дотортой хvнд
Уулын өндөр саадгvй
Усны урт хориггvй
Учран баярлах цаг бий

Гээд мөрий нь алгадахад чин зоригт талбиу доторт тэр Булагад хvний самбаатай уужим сэтгэлийн нэг хэсэг нь шингэсэн шиг, нарт сайхан байгаль ертөнц улам гэрэлтэй сайхан болсон мэт харагдаж, давхар давхар сvндэрлэсэн уулс, хөхрөн харагадгч мод уоам ч вээмжтэй мэт санагдав.

Их мөрний эргэд хоёр вйсэн завь хэдийн бэлтгээстэй байсанд, Будант уулнаас бууж ирэнгvвт Ихэрэс анчны барьсан загаснаас идээд, дөрвөн аянчин хоёр хоёроор завьдаа сууж, мөрний эрэг дээрх Ихэрэсvнд , Баруун гартаа жад бороохойгоо өргөцгөөн ёсолж vдэв. Шонхолой , Үхvv роёр тvрvвлэн, Залуудай Гекvv хоёр хойноос нь дагаж, хоёр залуу, хөнгөн вйсэн онгоцонд суугаад зөөлөн урсгал усны өөд сэлvврийн ая даган хөдлөх онгоц нь нvсэр хvнд салтай тун адилгvй тул ихэд бахдан сэлж явталаа урдах онгоцоо vзтэл Шонхолой , Үхvv хоёр ээлжлэн сэлж биедээ vздэргээ багатай явах байдлы нь ажиглаад, бас тэр аргы нь хэрэглэж ээлжлэн сэлэв. Урьд өмнө сэлж вээгvй хоёр залуу, гар баруунаа таших вес нилээд ядарч дал мөр хөших мэт боллоо. Чингэтэл урдах онгоц, мөрний нэг аралд бургасны завсар зогсож, Шонхолой Үхvv хоёр буугаад онгоцоо эрэг дээр гаргаж, Шонхолой - арал дээр хоновол, араатны аюул бага байх ёстой. Эртхэн бууж, хоол ундаа хийж амарцгаая. Сэлж вээгvй тул, баахан ядарч бйана, аажимдаа дасаад, гар бие чангарна гэж, Гекvvгээс :

- Ядрав уу? гэхэд нь

- Гар их чиллээ гэж том амаа ангайн инээв. Ихэрэс нөхдийн өгсөн идээ мах авч явсан тул, цахиур хавирч гал тvлээд, хоолоо халааж идсэн хойно, Үхvv Гекvv хоёр хэвтэж засаж Шонхолой хуурай мод тvвж, загас орой гэрдэхэд бэлтгэв. Чингэж байтал, Гекvv Шонхолойн дэргэд гvйн ирж,

- Би дэвсгэр засах мөчир , зөөллөх өвс тvвж байгаад, энvвхэнд нэг том хөлийн яс оллоо. Надаас том юм. Энд ямар том амьтан байдаг юм бэ? Энд хонох юм бол тэр том амьтныг идсэн тэр аюултай том юманд идvвлнэ байх гэхэд нь Шонхолой гайхаж бvгдээрээ очиж vзвэл, эргээс нэг том, дунд чөмөг нурсан байжээ. Нээрээ чГекvvгээс бvпvнн бөгөөд том яс ажгуу. өргөөд vзэх гэхэд хоёр хvн даамгvй хvнд байдлыг ажиглавал, саяхны яс яасан чбиш, чулуу болсон шинжтэй тул, урьд өмнө тийм том яс вээгvй Шонхолой ч гэсэн гайхаж,

- Махны внэр ч байхгvй, чийгтэй чулууны л внэр гарч байна гэж шиншиж вээд, мөлжvвр нь салсаар лав удсан юм байна. Ийм чулуун ястай амьтан энэ газар байж л дээ. Саявтар идvвлсэн амьтан гэхэд ийм том амьтныг идсэн араатан гэж лав энvннээс багагvй биетэй том байх ёстой. Тэглээ гэхэд мөр нь энэ элс шороо, шаварт сvртэй юм бйах ёстой. Ийм том биетэй хоёр амьтан ноцолдож, нэг нь идсэн, нэг нь идvвлсэн гэхэд ноцолсон мөр нь бас мод булга хуга гишгэж, дов газрыг хотгор,

хотгор газрыг дов болгосон байх ёстой. Ийм том чөмөгтэй амьтны толгойн яс бас байх ёстой гэж дөрвүүлээ тэр хавийн газар тэр чулуун яст үлэмж биетэй амьтны ул мөр бусад ясы нь нь эрээд огт юм олсонгуй.

- Бид энэ аралд хонох уу, их мөрний нөгөө эрэг дээр гарч хонох уу? гэж Гекүүгийн эмээн асуухад, Шонхолой санагий нь тайтгаруулж,

- Эндээ хоновол дээр бий. Тийм том амьтан энэ аралд олон байж болохгүй. Байвал чулуун ястангууд энэ их мөрний хоёр эргээр л байж магадгүй. Мөрний эргээс энэ арал, яасан чаюул багатай. Эндээ хононо гээд, отог дээрээ очиж, загас гэрдэх ясан соёот сэрээгээ хирисийн сураар оосорлоод гэрэл барих хуурай бургас нэг завьдаа аваачин бэлтгэхэд нь загас гэрдэхийг үзээгүй ойн хоёр хүн маш сонирхож, эрэг дээрээс харна гэж очилцов. Чингээд онгоцон дээрээ гэр барих бургасаа аятайхан тавиад сэрээгээ оосорлосон сурын нэг үзүүрийг үйсэн завийн урд үзүүр талаас торгон тодноос уяж зэхээд, цахиураа хавирч, бургасандаа гал асаан, онгоцноо аятайхан сууж, Шонхолой сэрээгээ барин, Залуудай ард нь сууж, аяархан сэлсээр нэг мэлтгэнэн гэр бургасны галд харлаж харагдах хөвчийн зүг чиглэн очтол, арлын эрэг дээр үлдсэн хоёр Хумка эрэг дагуу чиеэ аниргүй алхан дагаж, вагас гэрдэхийг харах гэж явлаа. Залуудай эцгийнхээ дохиогоор сэлэхийг зогсоод, гэр бургасаа барин ус гэрэлтүүлж, Шонхолой ясан соёот сэрээгээ бариад, харлан харагдах ус ширтэн, галын гэрэлд усны гүнээс гарч, онгоцон тушаа ирэх загас хүлээн харж байтал, удалгүй хэдэн загас үзэгдлээ. Чингэж байтал усан дотор нэг их том хар юм ойртон ирэх шиг болсонд, Залуудайн харахд тул шиг байдалтай боловч хоёр алд гаруй юм уу гэмээр бүдүүн гэгчийн загас, час час хийн шатах бургасны гэрэлд усанд харагдаж том гэгчийн толгой нь сүрхий махчин загасны сүртэй байдалтай яаралгүй өөдөө хөвөн гарч ирэхэд нь Шонхолой сэрээгээ хүчлэн хаясанд шав хийгээд ус уруу орж, тэр том загасны шилэн хүзүүнд чадамгай загасчны чийрэг гараар чиглүүлсэн сэрээ шаах шиг боллоо. Чингэтэл ус буцлах мэт, өөдөө оргилон, нэг том сүүл цухас хийгээд, далд ормогц, үйсэн завийг ямархан нэгэн юм маш хүчтэйгээр угз татсан шиг болж, Шонхолой зогсож байснаа ус уруу ойчин алдаж, гагцхүү хөл сайтай төлөөдөө тогтон, завьдаа гэдэргээ суун ойчив. Залуудай хүү, завь ухасхийхэд сандрахдаа, яаран нэг гараараа сэлүүрээ шүүрч, ву болсныг огт мэдсэнгүй, дэмий л нөгөө гартаа галтай гэр бургасаа атган, нүүрий нь нэг юм шавхдаад байх шиг болсонд сая ухаарч, завь маш хурдлан давхиж, арлын эргийн бургасны мөчир, нүүр ширвэж байна гэж ухаанд нь оров. Чингээд эцэг нь хэдийн жадаа шүүрэн бариад, завийн өмнө ус уруу нэг юм хараад яваа юм шиг ширтэн суух байдлы нь ажаад лав нэг маш том загас сэрээдүүлж, манай завь чирээд давхиж явна гэж бодож олов. Чингэтэд эцэг нь - Галаа л унтраалгүй байж үзээрй, хүү минь. Сэлүүрээ алдаж болохгүй шүү гээд, өмнөх усан дотор нэг юм жадлаад орхих шиг болсонд, завийн явах нь улам ч ширүүн болсон мэт. Байсгээд ус уруу нэг чичиж явтал арал чөнгөрөх шиг болж завь онгоцны явах нь арай зөөлөн болж ирээд, хааяа хааяа ухас ухасхийн заримдаа ч зогсох шиг боллоо. Чингэхэд нь Шонхолой, хирисийн ширээр хийсэн аргамжаа аяархан татсаар, уснаас харанхуйд гэр бургасны галын гэрэл туссан газар сэрээ жадны аргамжаастай үзүүр нь татагдан гарч ирлээ. Залуудайн харж байтал, харанхуй уснаас нэг бүдүүн мод шиг юм харлан ойртож, хавтайсан том толгоймахчин загасны муухай гэгчийн харцтай хүйтэн нүд, гэр бургасны гэрэлд үзэгдэн, заламгайг халхалсан хоёр хацар нь оволзон усны гадаргад тэр айдас хүрэм аягүй том толгой

ойртон татагдаад ирмэгц, Шонхолой хвчлэн жадалж, тэр хавтгай том толгойд цахиур гилбэрийг далд ортол шааж авав. Урт гуалин шиг харлан харагдах тэр аварга тулын бие нь чичгэнэсхийх шиг болж, гэр бургасны гэрэлд тэр амь талбин буй лут тулын шархнаас гарсан цусанд татагдан , хэдэн том том нүдтэй цурхай вэзэгдсэнийг үл анхааран, Шонхолой тэр аварга тулын толгойд шаасан жадаа суга татаж аваад хүүдээ сэрээнээс уяастай аргамжийн вэвүрийг завийн хушуунаас тайлж Залуудайд өгөөд, , сэлвүрий нь авч арлын зүг аяархан сэлэв. Аварга тул, анх усны өөд авч давхисан тул , одоо уруудан буцахад арай дөхөмтэй боловч, чухам аль хавиар түрүүн буусан газар сайн мэдэгдэж өгөхгүй байтал, бургасан дундаас галын гэрэл гялалзсанд , Үхүү, Гекүү хоёр дохио тэмлэг өгч, галаа асаасан юм байна гэж тэр зүг завиа залан хүрч очлоо. Эргийн бургасанд , нөгөө завийн тушаа зогсоод, сэрээдсэн загасаа эрэг дээр татан гаргах гэж вэтэл их том тул загас байжээ. Үхүү, Гекүү хоёр усан орж , сүүлээс нь өргөөд эрэг дээр гаргатал Шонхолой тэр тулын толгойг өргөж, уснаас өндийлгөн эрэг дээр гаргах гэж байтал гэнэт тэр хоёр алд шахам том загас годосхийгээд, сүүлээрээ ширэвмэгц Үхүү Гекүү хоёрыг ус уруу хаяж орхилоо. Ойн хоёр хүн ерөөс усанд муу тул, ихэд мэгдэж, арваганан сарваганан жавшаанаа ус гүйхэн учир эрэг дээр гарч иртэл, Шонхолой тэр том тулын толгой биеийг эрэг дээр гаргаж Залуудай , нуруун дундаас нь өргөн гаргах гэж оролдож байтал, усанд хаяулсан хоёр Хумка элбэлцэж арайхийн эрэг дээр гаргаж авлаа. Чингээд модоор цээжин биеий нь дамжлан отог дээрээ дөрвүүлээ дамжлан аваачиж, усанд норсон хувцасаа галд ээхийн завсар, цахиур чулуун хутгаараа Шонхолой тэр том тулын гэдсийг хагалж цэвэрлэж эхэлтэл, гэдсэн дотроос нь хагас айлж урсаж очсон нилээд хэдэн том загас , нэг зангидсан хүрэн бор гар гарчээ. Тэр гарыг гаргаж, гайхан вэвэл буглагаараа тас цавчуулсан байдалтай бөгөөд, зангидсан хуруугий нь нь цахиур хутгаар салган дэлгэхэд , нэг хүний баруун чих тас атгасан байжээ. Гар нь бас ямархан нэгэн араатны шүд соёоны ор мөртэй бөгөөд гэдсий нь цааш вэвэл, бас нэг тунтгар юм залгисан халиу гарч ирлээ. Гекүү тэр халиуг вээд, тулын гэдэснээс гарсан тэр гарт байгаа шүдний ор сорви нь халиуны шүдтэй таармаар мэт санагдаж, халиуны ам ангайлган тааруулж вэвэл , яг нийлэх тул, Шонхолой ,

- Энэ халиу гар зуугаад тулд баригдан залгиулж, гартайгаа гэдсэнд нь оржээ. Гар нь нэг хүний чих атгаад, атгаалаараа тас цавчуулсаныг бодвол эндээс асар холгүй их мөрний хөвөөнд нэг тулаан болж, энэ гарын эзэн нэг хүний чих тас татаад гараа тас цавчуулсныг халиу хожим шүүрээд өөрөө тул загасанд шүүрүүлж үхсэн бололтой. Бидний ирсэн зам дагуугийн эрэг хавиар тийм тулаан болсоо ор мөр ер вэзэгдсэнгүй билээ. Залуудай Гекүү та хоёр замдаа юм ажиглав уу? гэж асуухад нь тэр хоёр ер бидний нүдэнд тийм юм торсонгүй гэлээ. Чингээд тэр том тулаа , цахиур , хутга, сүхээр эвдэж хэдэн хэсэг болгоод арьсы нь өвчиж аваад гэдэс дотры нь усанд хаяхад, тулын гэдэснээс гарсан халиуны арьсыг бас өвчиж, усанд угаагаад авлаа. Дөрвүүлээ, аварга тулын махнаас галд шорлон шарж идээд, Үхүү Гекүү хоёрын бургасаар нөмөр босгосон хэвтшинд хэвтэн, өдрийн аянд баахан ядарсан тул , төдхөн унтацгаажээ. Шөнө амгалан хонож, өглөө эрт вүрээр галаа түлцгээн , чийгтэй будантай тул галд дулаацан, хувцсаа ээгээд, хоолоо идэж аваад, дахин үйсэн завьдаа сууж, манан татсан их мөрнийг өгсөн сэлэхдээ хоёр эргийг ажин явав. Орчин тойронд араатны дуу чимээ гарахгүй нам гүм тул, аянчин их усны тэр нэгэн хэсэг газар лав догшин араатан үгүй юм байжээ гэж өглөөний сэрүүнд эрчтэйхэн сэлж,

нилээд хурдлан явж байтал, нар чгарч, манан будан ч дээшээ дэгдэн арилав. Чингэж явтал, огторгуйд том тас их мөрний эргийн зүг нисэн буух шиг болсонд Шонхолой

- Энд лав нэг удай гарчээ. Өчигдрийн гарын учир энэ хавиас мэдэгдэх ч магад. Та нар ажиглаж яваарай гэтэд нэгэн хадан байц харагдав. Түүнээ элээ бүргэд маш цадсан шинжтэй сууж, ялзарсан мах ясны нилиг үнэр ханхалсхийв. Тэр байц тушаа ойртоод, завиа эргийн дэргэд зогсоон харваас, тулаан болсон газар бололтой. Арваад хүний тамтатг болсон хүүр яс үзэгдэж, орчин тойронд нь амаараа гартал идэж цадсан махчин шувуу энд тэнд чулуун дээр лаглайн суух ажээ. Түүрүүн агаарт халин нисэж явсан том тас нэг хүүрийн дэргэд хэдийн бууснаа, эргийн захад үйсэн завь хүрч ирэн, хүн гарч ирэхийг үзээд, дуртай дургүй зайлсхийгээд, хялайн харж, өглөөний хоол идэх гэж байхад нь хүрч ирээд үймүүлсэн энэ хоёр хөлт амьтан яах гэж байгаан бол? гэсэн шиг харж суув. Шувуу, жижиг араатанд сэглүүлсэн тэр арваад хүүр, цөм цавчуулж цохиулсан, бяцар, няцар буусан ясны байдлаар үзвэл, тулаан болсон байдал илэрхий бөгөөд иш нь хугарсан жад, бас зарим хүүрийн хажууд бүгдүүн хийцтэй бороохой, чулуун сүх үзэгдэж байгаа нь ямархан нэгэн дайсагнах хоёр омгийн хүн тулалдсан бололтой. Саарь сармай хувцасны тамтаг тасархай, махчин шувуу цөөвөрт уруулаан энд тэнд хэвтнэм бөгөөд, нэг хүүрийн хэмхдэс яс үзвээс баруун гарын бугалаг яс нь та савчуулсан байдалтай тул, урд шөнийн аварга тулын гэдсэн дотроос гарсан гарын эзэн нь энэ боллоо гэж дөрвөн аянчин тэр шувуу цөөвөрт химлүүлсэн ягаан хавиргатай хэнхдэг ясны үлдэгдлийг ажиг харж нэг хэсэг зошгсоод Шонхолой,

- Энд усны захад тулаан боллоо гэхэд, дийлсэн нэг нь эргэж өөрийнхөө дайчны яс авдаггүй, яваад өгдөг учир нь юу билээ? гэж гайхав. Чингэж байтал, тэр хадан байцын ёроолд нэг эрэн юм хөдөлсхийх шиг болсонд, тэр зүг ажиг харвал, хадны хөмөгт нэг маш том аварга могой, дунд бие нь нэг том урт юм залгисан мэт бондойгоод хэвтэж байснаа тэр хэдэн хүүрийн дунд хүн явахад хөдөлсөн бололтой. Чулуун дундаас хавтгай муухай толгой нь өндөсхийн цухуйсанд Шонхолой эмээж, - Эндээс бушуухан зайлсуу. Энэ газрыг эзэлсэн аварга могой бидэнд халдвал аюултай хэмээн, яаран завьдаа сууцгааж, тэр үл мэдэгдэх омогтны, гэнэт аварга могойноос сүрдэн сандарч тулалдаанаа зогсоон дутаасан газраас манай дөрвөн аянчин бас бушуухан зайлав. Дараа юу болж нутаг усандаа хүрэх эсэхийг нь хойтох хэсгээс үзнэ үү.

Хирис гэдэг амьтан маш дээр эрт цагт Монгол газар байсан нь, одоо хүртэл энд тэндгүй яс нь олддог. Улаанбаатарын хавьд Сонгины булангаас эртний хирисийн яс олдсон удаа бий. Улирад сэрүүн учир бие нь үстэй байжээ. Хамар дээрээ нэг том эвэртэй, түүний ард нь арай бага шиг нэг эвэртэй, маш дошгин амьтан бүлгээ. Хирисийн вед монгол газар бас арслан заан гэдэг бүх биедээ урт үстэй, заан байсан нь, одоо хүртэл шүд, соёо зэрэг яс нь олддог байсныг хуучин толь бичигт мөсч хулгана хэмээн нэрлэж, үсээр нв юм сүлжин нэгдэг хэмээжээ. Хуучин толь бичигт мөсч хулгана гэдгийг газар доогуур яваад, гэнэтхэн дээшээ гарч ирвэл, салхинд цохиулж үхдэг гэж дурдсан нь, хөлдүү, цэвдэг газрын эрэг урин дулааны цагт эвдрэн, ус бороонд нурахад маш эрт цагт үхсэн арслан зааны хүүр гарч ирэхийг үзэгсэд арван найм- есдүгээр зууны толь бичигт тусган мөсч хулгана мөсч хулгана гэдэг

влэмж биет амьтан, нар салхи вээдвхчихдэг юм байна гэж хэлэлцдэг байсан нь Монгол хуучин тайлбар тольд тэмдэглэгджээ. Хөсрөөс олдсон тэр арслан зааны ясаар манай урчууд саьх, хэт хутгын тээг, элдэв чимэг сийлэхэд хэрэглэдэг байжээ. Сибирьт хөлдvvгээ бараг бүтэн шахуу хөлдvv арслан зааны хvvр олдсоныг орчин вейн хуучин аргаар магадалбал, орчин веес нэгэн тvm хоёр мянган жилийн өмнө вхсэн арслан зааны хvvр байж хэмээн магадласан байдаг учир балар эртний энэ романд өгvvлэн буй явдал, даруй тvm орчим жилийн өмнөх байдал болно. Өрх гэж одоо бид өдөр гурвалжин, , шөнө дөрвөлжин гэж оньсгонд хэлэлцдэг бөгөөд эсгий гэрийн тооно бөглөх дөрвөлжин эсгийг нэрлэдэг нь хожим хойнын утга, айл өрх , ам өрх гэдэг хоршоо вгэнд харин хуучин утгын санаа бий бөгөөд газрын өрх гэж хэлэлцдэгт мөн эртний утга нь бий. Монгол уйгуржин вгээр өрх гэдгийг эрвкэ гэж бичдэг бөгөөд одоо бид чингэж бичсэнийг эрвкэ гэж бичсэн вг хэмээн одооны аялгуугаар монгол всгийн бичилгийг дууддаг болсон нь , аман аялгуунд өрх (өрхө) хэмээмvv. Уг гарлы нь шинжилбэл , эрв - гэсэн язгуур вг нь малт – гэсэн утгатай бөгөөд - кэ (хэ) гэдэг дагавар нь юи гэсэн утгатай тул, эрх гэж , уул нь малтмал юм, малтсан нvх, гэсэн утгатай, вг байж эрт балар цагийн хvн, оршин суух сууцаа анх газар нvх малтаж суудаг байсны нь заажээ. Ингэхдээ нvх малтаад, багана дээр тооно шиг юм босгож, сургааг унь тавиад, дээрээс нь модны долон холтос, вйсээр хучиж, тvvний дээрээс шороо ширэг двсэж, тооноор нь доошоо хvн орох гишгvvр цавчдас гаргасан мод налуулан тавиад, дор нь голд нь тvlсэн налын утаа нь хvн орж гардаг нvхээр гардаг тийм малтмал орон сууц басныг малтмал юм гэж өрх хэмээн нэрлэдэг байжээ. Чингээд нэг тийм өрх гэр дотор суугсдыг нэг өрх гэж нэрлэн хожим айлын тоог ч өрхийн тоо гэж нэрлэдэг болж ирээд, хожим, ангаар амьдрах байдлаас мал аж ахуйтай болох веес манай дээдэс нvхэн өрхөөс гарч гэртэй болжээ. Гэртэй болохдоо вvд хаалгатай болжээ. Чингэхэд өрх гэдэг малтмал орон сууц нь газар дээр босгох орон сууц болж ирсэн учир, утаа гарах нvх, хvн гарах нvх аяндаа тусгаар болсон авч, вvд өрх гэдэг хоршоо вгэнд эрт цагт орон гэрийн орох гарах вvд нь малтмал нvх байсны дурсгал хоцорчээ. Үвнд монгол хэлтнээс хэрэглэсэн тэр вг хамниган хэлтэнд одоо хvртэл вvд хаалга өрх гэж нэрлэдэг нь монголчуудаас маш дээр цагт тэр вг хэрэглэн авсныг гжрчилж байгаа хэрэг.

Чулуун зэвсгийн вейнг дотор нь эртний чулуун зэвсэг, дундад чулуун , шинэ чулуун гэж хуваан шинжилжээ. Орос хэлнээ эртний чулууны вейг грек вгээр палеолит гэдэг нь даруй палео гэж эртний , лит – гэж чулуун гэсэн вг. Дундад чулууны вейг орос номд мезолит гэдэг нь мөн грекээр мезо – гэж дундад лит гэж чулуун гэсэн вг. Шинэ чулууны вейг оросоор неолит гэдэг нь грекээр нео – гэж шинэ лит гэж чулуун гэсэн вг болно. Иймд монголоор эртний , дундад, шинэ чулууны вe гэж грек вгийн утгыг монголоор орчуулж, утга нь нийтийн , вг нь монгол байвал ухахад дөхөмтэй болно. Эртний , дундад , Шинэ чулууны вe нь дэлхийн хэмжээгээр нэгэн эрин цагт байсан нь зарим газар эртний чулуун зэвсгийн аргаар зэвсгээ хийж байхад, өөр нэгэн газар дундад зууны буюу шинэ чулуун зэвсгийн шатад ороод байсан газар ч байжээ. Монгол газар, говь хангай аль ч нутгаар эл чулуун зэвсгийн влдэц нэн влэмж вээгдэх бөгөөд чулуун зэв мэтийн байдал нь цахиур чулуу, галт уулын шил чулуу зэргийг чулуун хасуураар цохин дарж, олон талтай шовгор юм босгосон зvйл Монгол газар маш элбэг тохиолддог.

Бөөгийн шүтлэг бол чулуун зэвсгийн үеэс үүссэн , маш эртний шүтлэг бөгөөд эртний судлалтан эрдэмтэн,балар уагийн хүний булш дотроос онгодын дүрс ыаримал зэргийг Европ, Ази зэрэг тивийн олон газар олсноос гадна, агуй, хадны хөмөг, элгэн хаданд балар эртний хүний зурсан шүтлэгийн холбогдолтой зураг хөрөг олсон нь бас үлэмж буй. Монгол газар ч мөн ийм зүйл арвин тохиолдох ажгуу. Орос хэлнээ Август Буриан гэдэг Чех эрдэмтний Эртний –хүний амьдрал – Жизнь деревного человека гэдэг зурагт айхан номд эдгээр байдлыг сайхан тодорхойлсныг олж үзвээс сонин бөгөөд, манай эртэс дээдэс хэрхэн амьдарч яаж аж төрдөг байсныг мэдэхэд тэж хэрэгтэй сонин ном болмой.

Балар эртний хүн үхэгсдийг оршуулахдаа, амьд ахуй үеэс хэрэглэж байсан орон сууцны үлгэрээр нүхэн нууц ухааж, идэх, уух, юм эдлэх сав сааль, зэр зэвсгий нь тавилцан оршуулдаг учир эртний хүний оршил газрын байдлаар амьдхар үеийн орон сууцыг гадарлан мэдэж болно. Балрын хүн юм бүхэн сүнстэй гэж боддог учир үхэгсдийг дагалдуулан тавих зүйлийг бас дор бүрнээ сүнс буй гэж үзэх учир, сав, зэмсэг, хувцас хунары нь хүртэл сэв шарх оруулж « алан» , сүнсий нь эзнээ дагаж үйлчлэг гэж үздэг байжээ. Тэр эртний үзлийн үлдэц нь олон улсын ёс заншилд одоо ч бий агаад гагцхүү учир утгы нь мартаж, ёс хэмээн баримтлах зүйл цөөнгүй. Жишээ нь бөөгийн шүтлэгт монголчууд хожим шарын шашинд орсон хойно, шарын шашны бурханы хөрөг дүрсийг он удаж элэгдэн тамтрахад хүрвэл, даруй уул хаданд зайлуулан тавьдаг байсан нь, тахиж байсан бурханыхаа хөргийг эвдэрч тамтрахад, үхэж одлоо. Бурхан биш буг болох нь гэж дээр цагт эртний бөөгийн үзлийн үүднээс үзэж байсан ёсоор , хөрөг нь сэвтсэн бурханаа уул хаданд аваачин « оршуулдаг » байжээ. Бас хүнд цай хийж өгөхдөө , хагархай аяганд хүртэл цай хоол хийж өгдөггүй нь одоо бол зочин гийчин зэрэг хүнийг хүндэтгэн үзэхийн зедэг найрсаг ёсон боловч, эрт балар цагт бол амьд хүнд цай, хоол хийж өгөхдөө эвдэрч, тамтарч , «шарх олж» үхсэн саванд цай хоол хийж өгөх нь аяггүй гэж үздэг ёсноос үндэслэн гасан ажам. Үхэгсдийг оршуулахдаа , орон сууц хийж өгдөг байсны ул мөр нь, олон улсын заншил, хэл үгэнд хүртэл, нарийн шинжлэлбэл бийг энд жишээлж цухас дурдвал, орос хэлнээ авсыг бас « домовина » буюу монголчилбол « ганц хүний байшин, хүний орших сууц » гэсэн утгатай үг бөгөөд, орон сууц гэсэн дом гэдэг үгнээс үүссэн үг болно.

Шар махчин балрын хүн аймгийн дотор махчин бас байсны гэрч баримт, эртний судлалтан (орос хэлнээ архелогия гэдэг ухааны нэр нь грек хэлний архео – буюу эртний логия гэж судлал гэсэн үгээр монгол, утга нь дэлхий нийтийн байдалтайгаар хэрэглэхэд эртний судлал болно) магадлан олсон билээ. Энэ тухай дээр дурдсан Эртний хүний амьдрал гэдэг номоос тодорхой үзэж болно.

Гал эртний хүн тэр бүр цахиур хавиран дуртай цагтаа асааж чаддаггүй , твймтрийн гал зэргээс гал үүсгэн манаж, аян анд явахдаа тусгай бяцхан ваар буюу чулуун хорго мэтэд авч явдаг байжээ. Чингээд тэр хорготой галаа алдвал маш их зүдэрдэг байсан байна. Энэ тухай Францын зохиолч Их рони гэдэг хүн Галын тэмцэл гэдэг уран зохиол бичсэн нь , орос хэлнээ Борьба за огонь гэдэг ном болгожорчуулсан хэвлэсэн зүйл бийг сонирхогсод сураглан олж үзвээс болно. Галыг эртний хүн , чадал

боловсрол нь нэмэгдэж ирэхэд хоёр мод хавирч гал гаргах болж, улмаар цахиур чулуу хавирч гал гаргах арга олсон билээ. Эртний хvний аж төрөхөд гал нь хоолы нь болгож, биеий нь дулаацуулж, өрх гэрий нь гийгvвлж, араатнаас амий нь хамгаалах зэргээр маш их ач тустай байсан учир , галыг нэн эрхэмлэдгийн уламжлал нь монголчуудын гал голомтоо тахидаг эртний бөөгийн vзлийн vүднээс галыг амьтаг гэж vзэж байсны ор vлдэц нь галыг « асаж байна , ноцож байна » гэж хэлдэг хэллэгэнд vлджээ. Чингэхэд бид одоо гал асаж байна, гал ноцож байна гэж хэлэхдээ эртний тэр утгаар нь бодохгvй болжээ. Орос хэлнээ гал асаж байгаа гэдгийг огонь горит гэж хэлэхдээ бидний одоо гал асаж, ноцож байна гэж хэлдгийн нэгэн адил эртний утгыг нь мөн бодохгvй ажим. Чингэтэл, горит гэдэг нь халаад байна, цоргиж tvлж байна гэсэн утгатай vг бөгөөд халуун , халхай , халцгай гэсэн язгуур vндэс гарсан горьчий , горячо гэдэгтэй гарал язгуур нэгтэй нь эртний оросын дээдэс галыг хайрдаг , халаадаг гэдэг шинжээр нь , манай дээдэс , мод tvлээ , шатах гал авалцах юманд гал « асаж, ноцон, ноолж » байгаа vзэгдсэн шинжээр нь асаж байна, ноцож байна хэмээн нэрлэсэн байнам.

Гутгаар бөлөг

Достум гель мандаа гэж , tvрэг хэлтний нэгэн аялгуугаар - нөхөр минь, наашаа хvрээд ир гэсэн vг. Монгол нутагт эрт цагт tvрэг, монгол, хамниган гурван vндэстэн байсан нь газар орны нэр, булш , эдийн vлдэгдэл, зэрэг зvйлээс нэн тодорхой. Бус бас овог vндэсний аймаг байсан авч, хэлний талаар эл монгол , tvрэг , хамниган аймаг харилцан ойр байсан ажээ.

Дөтгөөр бөлөг

Хавчаахай нум сумтай болсон явдал бол, эртний хvний аж амьдралд нэн их ач холбогдолтой байсан бөгөөд монгол аймгийн хvн, нумыг эврээр элэг, шөрмөсөөр ары нь хийж, зvймэл бөгөөд маш уян хатан нум хийдэг болсон нь нумыг туйлд нь хvртэл боловсруулжээ. Yвнд : Хор гэж сум, харвал гэсэн утгатай vг авсан учир , одооны монгол омогтон дотор Хорчин гэж нэртэй аймаг бий нь Харвалчин гэсэн утгатай нэр ажээ.

Тавдугаар бөлөг

Чархи гэж tvрэг, монгол нийтийн vг. Оросоор кожаны лапоть гэж орчуулдаг. Нэгэн зурвас нойтон шир , хөлийн улын хэмжээнд тааруулж аваад, нарийн сураар хумин , хөлдөө шаахай шиг болгон тааруулж , сурын хоёр vзvvрийг борви булчин өөдөө зөрvvлэн ороож уядаг юм. Гөрөөчин улсын өмсдөг гутал байжээ. Америкийн индианы өмсдөг нэгэн зvйл гутлыг орос европ хэлнээ мокассин гэдэг нь даруй монголоор энэ чархи гэдэг нэртэй дvйнэ.

Зургадугаар бөлөг

Бай кул гэж Байгал нуурын нэр. Эртний tvрэг аймгийн хvн Баян нуур нэр өгсөн ажээ. Манай Хөвсгөл ч бас эртний tvрэг нэр бөгөөд Кексукул буюу монголчилбол , Хөр уст нуур гэсэн vг байжээ. Арваннаймдугаар зууны монгол албан бичигт Хөсугул гэж байдаг нь орос жуулчин тэр veийн монголчуудын аман аялгуунаас сонсож, Косогол гэж тэмдэглэсэн нь олон улсын газар зvйн зурагт орсон билээ. Хожим Хөсvгvл гэдэг нэр сунжирч , албан бичигт Хөвсгөл болж ирсэн билээ.

Долдугаар бөлөг

Ойн хvн гэж балар цагт хөвч их ойд амьдардаг нэгэн хэсэг аймаг байжээ. Ойн аймгийн хожим бугын зvйлээс ца гэж цагаан өнгөтэйгөөр нь нэрлэсэн буга бас оро гэдэг нэгэн зvйл буга гаршуулж, унаа мал болгосон нь одоо цаатан, оротон гэдэг тvрэг , хамниган аймгийн хvн бий . Монголчууд, талын хvн асан учир , ой хөвч, хад уулын гөрөөчин хvнийг хадын хамниган , ойн ортон гэж нэрлэдэг байжээ. Эртний хvний нийгэмлэгийн байдлаас энд товч тойм төдийгөөр , манай Азийн зэргэлдээ эртний улсын тvvxнээс дурдвал, Нангиадвал, Нангиад (Хятад) газар балрын хvний яс олдсныг эртний судлалтан, хvн судлалтан (орос хэлнээ грек нэрээр антрополог гэдэг нь антропо –гэж хvн, лог гэж судлалтан гэсэн утгайтай vг болох тул , нийтийн утгатай бөгөөд эх хэлнйихээ vгээр нэрлэвэл ,орон судлалтан гэвэл эвтэй юм) шинжиж vзээд, Бээжингийн хавьд олдсоноор нь латинаар Синантропус пекинен зис гэж нэр өгсөн нь , син гэж нангиад , антропус гэж хvн гэсэн грек vг пекинензис гэж латинаар Бээжингийн гэсэн vг. Нийлээд, Бээжингийн нангиад хvн гэсэн нэр болжээ. Эрдэмтэн шинжлээд тэр Бээжингийн нангиад хvн гэдэг балар эртний нэгэн зvйл хvн, таван буман жилийн тэртээ байсан хvн юм байна гэж шинжилж, таван тvм орчим жилийн өмнө нангиад газар эхийн засагт ёс дэлгэрэн хөгжиж, тариалангаар гол аж амьдралгаа хийх болсон байна гэж шинжилжээ. Эцгийн засагт омог таваад мянган жилийн өмнө тэртээ хөгжиж, омог отгийн байгуулал, омгийн холбоо аймаг улс бий болсон гэж нангиадын тvvx судлагч эрдэмтэн vзжээ. Боолын нийгэмлэг Нангиад газар дөрвөн мянган жилийн өмнө буй болж, Сиа улс гэдэг нь даруй боолын нийгэмлэгт улс байжээ.

Шан улс гэж хуучин монгол бичиг зохиолд гардаг нангиадын нэгэн улсын вед хvрэл зэвсэг vүсэн гарсан гэж магадлан мэджээ. Тэр эртний Шан улс болбол манай он тооллоос өмнөх 17 –гоос наашлан 11 дvгээр зууны вес хvртэл байсан улс ажээ. Монгол бичигт байлдааны улс гэж нэрлэдэг нангиад улсын вед төмөр зэвсэг vүсэн гарч , боолын нийгэмлэгт улс аажмаар феодалын нийгэмлэгт улс болж эхэлсэн байнам. Байлдааны улс гэдэг нь манай эринээс өмнөх 475 оноос наашлан 221 он хvртэл байсан улс болно. 221 онд Цин улс хvчирхэг болж, тэр Цин улсын хуанди хаан, умар зvгийн , нvүдэл аймгаас хамгаалан зах хил дээрээ нангиадын тvмэн газрын урт цагаан хэрэм босгосон билээ. Тэр Цин улсын нэр нь алдаршиж , Энэтхэш улс, Нангиад Хятадыг их Цин улс гэж нэрлэснийг монгол бичиг судрын хилэнд Махазина, Махазинын орон гэж нэрлэдэг болсон яруу найргийн нэр болж ирсэн нь Английг Орос зэрэг Европ улс яруу найргийн хэлнээ Будант Албион гэж , Грекийг Эллада гэдэгтэй адил болжээ. Англиар Нангиадыг Чайна, Германаар Хина, Францаар шинэ гэдэг нь Цин улс гэдгийн Цин гэдгийг латинаар бичсэн ц vсгийг ч, х, ш зэргээр дууддаг уламжлалын vүднээс нэгэн нэр олон дуудлагатай болж ирсэн байна.

Гэнд бар гэж эр барыг нэрлэдэг.

Хутган соёот бар гэж балар эртний нэгэн зvйл одоо сөнөсөн бар

Орос хэлнээ Махайрод бас ёаблезубый , тигр гэдэг

Наймдугаар бөлөг

Үхэр гөрөөс гэж эртний зэрлэг шхэр монгол бичгийн сонгодог хэлнээ гөрөөс гэж аливаа зэрлэг ан амьтныг нэрлэдэг учир , зэрлэг хvнийг хvн гөрөөс, зэрлэг vхрийг vхэр гөрөөс, зэрлэг тэмээг тэмээн гөрөөс гэх зэргээр нэрлэдэг бөгөөд , энэ хvv зэрлэг гэсэн утгаар барыг ч бас гөрөөс хэмээмой.

Есдvгээр бөлөг

Муу өвчин - балар эртний хvн, элдэв өвчнийг чадахгvй бөгөөд vvсдэг учры нь vl мэдэх тул , халдварт зарим тахал, өвчнийг тусгай эзэнтэй юм гэж боддог байсны vлдэгдэл улс бvхний аман зохиолд гардаг бөгөөд бөөгийн шvтлэгэнд тэдгээр өвчний эздийг аргадах засал хэрэглэдэг байсны олон улсын цгсаатны зvйч эрдэмтэн тэмдэглэжээ.

Арван зургадугаар бөлөг

Минаа гэж нэгэн зvйл ташуурын нэр. Бас малиач гэдэг. Монгол сонгодог бичгийн зvйлд минага гэж хуучин сударт бичигдсэн vзэгддэг.

Маниач гэж ташуурч гэсэн бөгөөд эрт дээр цагт хэц хэнгэрэггvй бөөг маниач гэдэг байжээ.

Ховос гэж монгол бичгийн сонгодог хэлнээ хобусун гэж судар бичигт гардаг vг . хогусун гэдэг vг энэ хобусун гэдгийн б нь г болж , хогусун гэдэг нь хожим хоосон гэдэг vг болж, хоосон сан, хөндий хоосон, гэх мэтэд хэрэглэдэг болсон аваас, хобусун гэдэг нь аман хэлэнд ховос болоод, , уг утга нь хоосон гэсэн тул , vнэндээ байдаггvй , хий хоосон санааны юм, бодьгvй, биегvй, хоосон юм гэсэн утгаар хvний оюун сэтгэлийн нэгэн зvйл чадлыг нэрлэх нэр болжээ. Тэр чадлыг Европ нар грек хэдээр хипнос, гипнос гэж нэрлэдэг нь уг грекээр даруй нойр гэсэн vг. Монголоор ховос гэж нэрлэсэн нь зvvд , нойр биш боловч хоосон юм гэж утга учры нт сvрхий гаргасан , туг ч гvн учиртай нэр тул, хvний сэтгэлийн тэр чадлыг монголчууд эрт дээр цагаас танин мэдэж, гадаадаас нэр зээлдэж , бусад аймгаас сурч авсан зvйл биш гэдгийг шинэ ховос гэдэг нэр vзvvлж байгаа нь , монголын соёлын tvvx судлах хvнд сонин юм байгаа юм.

Арван долдугаар бөлөг

ШАВАРЧИН ОТОГ

Өргөн мөрний эргэнд хvртэл тулсан хадан хошууны өвөр талд жалгатай бөгөөд тэр урт жалгын хоёр талаар нь шар наанги шорооны судалтай. Жалгын адагт хэдэн том хавтгай ургаа чулууг өндөр иштэй өвс эмжин ургажээ.Хөх цөцгий нэг чулуун дээр нь суугаад , хошуугаа цэвэрлэж байтлаа, гэнэт зогсоод ямархан нэг юмны чимээ дуулсан мэт чагнасхийтлээ цөгцгөнөн хэд vсрээд нисэж, амьтан айсуйн дохио чимээ өгч доошоо дээшээ дэгдэн нисэв. Чингэтэл, хvний дvнгэр дvнгэр хэлэлцэх анир дуулдаж, зарим нь модон малтуур, зарим нь бор гөрөөсний арьс туламлан өвчиж борвитой юм барьцгаан, саарь сармай өмдтэй, хөгшин залуу хэдэн эмэгтэй тэр хэдэн

чулуу звглэн гарч ирлээ.

- За , малтууртай нэг нь наашаа эгчмэд эмгэн нь хэдэн залуу эмэгтэйг дагуулан, шар наанги шорооны судал тийш дагуулан аваачаад , эндээс шороо ав гэж заагаад, нэг том хавтгай чулууны дэргэд очиж, дээр нь гарч суув. Ухсан шар наанги шороог дээлтэй нэг нь дээлийнхээ хормойгоор , дээлгвй нэг нь адсагаар дамжилж, тэр эгчмэд эмгэний сууж байгаа хавтгай чулуун дээр захаар нь цувуулан асгаж эхлэв. Тэгээд дараагаар нь голд нь асгасныг эмгэн сайхан тэгшлээд , дахин захаар нь цувуулан асгуулаад , борвитой эмэгтэйчvvдийг усанд явуулж, тэр наанги шар шороог сайтар чийгтvvлж, нилээд хэдэн борви ус хийлгэв. Тэгээд нэг уутнаас шөрмөсөн чулуу гаргаж, хэдэн охидоор сайхан нvдvvлж, мяндас шиг урт ширхгий нь шороо чулуунаас ялгуулаад, тэр дэвтээлгэж байгаа шавартаа хийж, хэдэн эмсийг одоо шавраа зуур гэхэд нь сармай өмднийхөө шуумгийг дээш нь шуугаад хөлөөрөө гишгэн зуурч эхэллээ. Тэр зууран нухаж байгаа шаврын хажуу дахь нэг давхар хар чулуун дээр өнөө эмгэн, дороо нэг адасга дэвсэн суугаад, энд нь ус нэм, тэнд нь шорооноос нэм гэж зааварлан удирдаж, хашир нvдээр тэр хэдэн эмсийн ажиллаж байгааг хааяа хааяа харж, шавар гишгэн зуурч ядарсан нэгий нь усанд явуулж, ээлжлvvлэн ажиллуулж байв.

- Одоо цагаан элснээс тэгшхэн холь гэхэд нь хоёр эмэгтэй нэг нэг борви бvдvvн цагаан ширхэгтэй элс жигдхэн асгаж, гишгин зуурагч эмэгтэйчvvд, шөрмөсөн чулууны мяндас шиг ширхэгтэй наанги шороог элстэй сайтар нухлан гишгилж, хvрэн бор царай биед нь хөлс цувран орж, нилээд ядарсан шинжтэй боллоо. Өнөө нухаж байгаа шар наанги шороо ч, чийрэг эмэгтэйчvvдийн хөлд нухуулсаар, наранд гялалзсан бор шар сайхан зуурмаг боллоо.

- Одоо барьж эхэлнээ гэж хэлээд, сууж байсан чулуун дээрээсээ эмгэнийг бууж ирэхэд, шавар гишгиж байсан эмэгтэйчvvд, хөхөн сордог шавраас хөлөө сугалан, мөрний усанд очиж хөл гараа угаан сэрvvцээд, шавар сав барих ажлаа эхэллээ. Нухаж зуурсан шавраас хvн бvр нэг нэг бөөн шавар хоёр гараараа татаж аваад, урдаа тавьж, нарийн ширхэгт торгон элснээс хvн хvн овоолж, хоёр хvн дундаа нэг шавар аяга ус тавилаа. Чингээд, эгчмэд эмгэний эхлэхийг хvlээн сууваас , амирлангуй тайван царайтай, цэцэн сайхан харцтай тэр эмгэн, нэгэн хэсэг чив чимээгvй сууснаа, хоолойгоо засаад :

Сээ – эг сэ – э - э –г сээг
Наран сая мандужуу,
Навчис сая дэлгэрчvv,
Саран сая мандужуу,
САйхан цэцэг дэлгэрчvv,
Усны хvv мэлтийжvv,
Уулын хvv шовойжуу
Газрын хvv шарлажуу,
Галын хvv улайжуу,
Хvний хvv хvрэн царайлажуу,
Хvдэр идэр болохын
Илир балар цагаасуу
Идээн ундааны савыг

Нартай өдөр сонгожуу
Наанги шороо зуурчуу,
Эртэс дээдсийн ёсоор
Эмс охид нийлжvv
Арван хуруугаар барих уу
Амсартыг бүтээдэг билээ
Орон дэлхийн эзэд
Олон буурал аав ээж
Тамир сайт охидынхоо
Тааруулан зуурагсан
Чадал сайт үрсийнхээ
Чамбайлан элдэгсэн
Өөхөн мэт гялалзагсан
Өнгөтэй шар шавраар
Цав үл гарах
Цахиур мэт бат
Галд шатаахад
Гав гарахгvй
Эзэндээ ээлтэй
Эдлэгээ бөхтэй
Айлд хэрэгтэй
Амсарт нэртэй
Сав гэдэг
Сайхан хэрэглэл
Хийх гэж зорьж
Хичээж байгаа
Үрэс биднээн өршөө
Үйлсийн маань урагштай
Баригсаны маань
Бат бэх болгоо

Гэж тамалан дуудаад , өөх махны зvйлийг дээш доош нь , дөрвөн зvг цацаад, зуусан шавраас нэг атга авч, савын ёроолд хийгээд, бас нэг хэсэг шавар хоёр алган хоорондоо өнхрvvлэн, урт нарийн гэдэс шиг юм болгоод, тvvнээ шавар ёроолд наалдуулан илж, бас нэг хэсэг шавар урд адил алган хооронд өнхрvvлэн, тvрvvчийн шавар шавар цагираглан наалдуулсан дээрээ залгаад, хуруугаа устай саванд дvрж, тэр цагриглан наалдуулсан шавраа гадна дотноос нь илэн засав. Бусад эмэгтэйчvvд бас тэр эмгэний нэгэн адил шавар барьж, урьд тийм сав барьж vзээгvй ганц нэг залуу охид, чаддаг нэгнийхээ дэргэд ажиглан харж зуурсан шавраас дөхvvлж байв. Эгчмэд эмгэн маш чадамгай тул , шавар цагираглан нааж, гадна дотноос нь усанд дvрсэн нойтон хуруугаараа илэн барин зассаар төдхөн нэг хөөрхөн шавар ваар хийгээд, дэргэдэх хавтгай чулуун дээр хатаах гэж тавиад, бусад эмэгтэйн хийж байгаа том жижиг аяга ваарын хэлбэрийг ингэж зас, тэгж шавраа цагираглан наалдуул, дотор талаас нь ингэж хэлбэж, vзэмжтэй болго гэж зааварлан, огт сав барьж vзээгvй охидыг бас шавар бариулан урамшуулж, аятайхан зааж хэлж өгөхөд нь тэд нь их л

баяртай, хичээнгвйлэн барьж эхлэв. Чингээд, том жижиг хэд хэдэн ваар шавж гвйцсэнийг шалгаж үзээд, тэр эгчмэд эмгэн, нэг үзвүр нь хавтгай иртэй, нэг үзвүр нь бөөрөнхий ясан савх бариад, савын амсрыг тэгшлэн засангуут, тэр ясан савхаараа нойтон шавар ваар саванд ясан савхын хавтгай бөөрөнхий хоёр үзвүрээр нь хээ дарж чимэхдээ :

- Энэ хээний утга учрыг та нар тогтоо. Энэ бол эзэнд нь блзийтэй хээ юм. Аяга саванд хийдэг ёстой юм гэж урьдын улс заадаг асан. Аяга сав хийж сурахдаа, эзэнд нь ээлтэй хээгий нь яаж хийдгийг ажин сурцгаа.

Энэ бол мангина, сонгино дарах саванд хийдэг хээ. Хонох өнжих хоолны савын амсар бөөрөнд нь ийм хээ хийдэг юм. Ховдог хомхой муу сайн өлөн ада анахай, бузар хэлээрэй шөнө хоол долоож бузарлахгвй гэж өтгөс дээдэс, ийм хээ гаргаж бай гэж захидаг асан. Бузраас хамгаалдаг хээ энд ингэж гаргадаг юм. Та нар сайн тогтоо. Урьдын улсын журам, эртний эмгэдийн ёс. Нас бага, нар эрт та нар шавар нухаж, сав хийх цаг олон тохиолдох бий. Эзэндээ ээлтэй, отог олондоо өлзийтэй сайхан сав хийж сурагтун гэж заахад нь, залуу эмэгтэйчвүл маш хичээнгвйлэн сонсоцгоож, эмгэний заан үзвүлж байгаа ээлтэй өлзийтэй хээг хийсэн савандаа ясан савхаар шахан дарж үзэв. Ээлтэй хээ, өлзийтэй хээ, савын сахиусан хээ гэж ийм гурван звйлийн хээ байдан. Зарим саванд гурвуулы нь хийдэг ёс бий. Тэгэхдээ амсар хавьд нь ойр сахиусан хээ хийж, бузар хэлтэй юм сав өөд асан авирах, өнгийн долоохыг хавитуулахгвй болгодог юм. Бас савын амсрыг ингэж чимхэж, шүдэн хээ гаргавал, муу юмны хэлий нь тас хэдэрдэг юм гэж эгчмэд эмгэн эртний ёс зааж, сав ваарын звйлд хийдэг хээ угалз нь, цөм дор бүрдээ учир утгатай байгааг шаварчин залуу эмс охидод тайлбарлан хэлж, цагриглан барих шаврын бүдвүн нарийны хэмжээ ямар байвал тохиромжтой болохыг залхуугвй зааварласаар, том жижиг ваар, их бага аяга сав хийж гвйцээд, нар салхинд тэгшхэн эврээв. Тэр завсар хэдэн эмэгтэйчвүд, түрвүн базааж түвсэн хуурай бургас, тэвэр тэврээр авчраад, эгчмэд эмгэний заавраар тэгшхэн өрж, ваар саваа түлэх гал асаахад бэлдлээ. Чингээд эгчмэдийн заавраар өнөөх ваар аяга саваа шалгаж үзээд, наранд халсан хавтгай чулуун дээр шатаахын өмнө өрөөд, гал асаах боллоо. Эгчмэд эмгэн, цахиур хавирч, цагаан түрүв цэцгээр хийсэн уулд оч тусмагц, уулыг цагаан хялганаар ороон дэвж, гал асаагаад, нэг хэсэг бүдвүн шиг түлээ хийлгэж, ваар сав тавих цог гарахыг хвлээн суув. Тэр завсар эмэгтэйчвүд, хуучин ваао гал дээр тавьж, гурын хааг чулуун хутгаар чадамгай эвдэж, нуурын бор давс, уулын сонгино хийгээд, хатаамал мөөг нунтаглан нухаж, цулхирын үр хийж, тун аятайхан үнэр ханхалсан шөл чанаж, махаа шүрхий шиг байгаа тун сайхан амтан дээр нь гаргаж, тэвшинд хийгээд, эгчмэд эмгэний өмнө тавив. Эмгэн дээжий нь галд өргөөд, дөрвөн зүг цацаад, бас нэгэн чимх өөх мах хойш тавиад, бусды нь нөгөөдвүлдээ аятайхан хувааж, бүгдээрээ амтархан идлээ. Эгчмэд эмгэн, наранд нилээд эвэрсэн ваар савыг нэг нэгээр нь шалгаж үзээд тэгшлэн зассан цог дээр тавьж, тал талаас нь бургас тэгшхэн өрүлээд, болсон идээнийхээ дээжийг галд өргөн тамалж дуудсан нь :

Сэ – э –эг, сэ – э –эг, сээг

Цахиур чулуун эцэгтэй

Цагаан хялгана эхтэй

Өөхөн тосон идээтэй

Өрвөлзөгсөн дөлөн үстэй
Өнгөт улаан нөлөөн царайтай
Очит гялалзагсан мэлмийтэй
Од галын эзэн сүрт эх ээ.
Цолмон их цолоор чинь цоллож
Цомцойн сууж, айлтган дууднам
Нэрлэм их нэрээр чинь нэрлэж
Нэвсийн сууж, тамлан дууднам
Нартай сайхан энэн өдөрнү
Наанги шороо нухан элдэжнү
Арван хуруугаараан арчижуу
Аяга сав барин бүтээжнү
Ээлтэй хээн өлзийтэйн угалзуу
Эзэнд нь ивээл болтугай гэжнү
Уридас дээдсийн журам ёсооруу
Урлан хийжнү, тамлан дуудажуу
Цэлмэг тэнгэрийн наран салхиндуу
Цэгцлэн өрөжнү, цэвэрлэн тавьжуу
Чангыг сул болгогч сүржинтэй
Сулыг чанга болгогч чадалтай
Хатууг зөөлөн болгогч идтэй
Зөөлнийг хатуу болгогч эрдэмтэй
Од галын эзэн сүрт эхийн
Оволзогсон улаан хормойдуу
Дэс дэсээр нь өрөн түшүүлэгсэн
Дэлгэр олон энэ ваар савыг
Хагарашгвй хатан бат болгожуу
Эвдэршгвйн эрхэм бөх болгожуу
Аман хишиг зузаатын аяга
Сайхан санаатын сав таваг
Хоол элбэгтийн хайви тогоо
Идээ сайтын дүүрэн аяга
Санаа сайтын дүүрэн тогоо
Сайхан нөхөртийн сав болгон
Галын эзэн сүрт эхийн ээлээр
Гав гарахгвй бамт савын хишиг
Уугаад байхад ёроол цухуйхгвй
Ундармал аягын хишиг гуйнам
Утгаад байхад ёроол цухуйхгвй
Уудам тогооны хишиг гуйнам
Уудлаад байхад ёроол цухуйхгвй
Улам дүүрэх ваарын хишиг
Улирлан гуйжуу, дахин суунам
Гуйсны минь гуйвалтгвй бат
Айлтгасны минь айлтгвй бат

Бодсоноос булиу,
Санаснаас илvv болгож хайраал
Өршөөж хайраал
Сэ -э -эг , сэ – э – эг сээг
Цахиур чулуун эцэгтэй
Цагаан хялгана эхтэй
Өөхөн тосон идээтэй
Өрвөлзөгсөн дөлөн vстэй
Өнгөт улаан нөлөөн царайтай
Очит гялалзагсан мэлмийтэй
Од галын эзэн сvрт эх ээ
Цоллом их цолоор чинь цоллож
Цомцойн сууж айлтган дууднам
Нэрлэм их нэрээр чинь нэрлэж
Нэвсийн сууж , тамлан дууднам.

гээд налд өөх тос цацаж мөргөөд, хуурай бургас галд нэмvвлэн, ваар савыг тал талаас нь тэгшхэн шатаагаад хөрхий нь хvлээн сууцгааж байтал, нэг эмэгтэй усны зvгээс гvйн ирж :

- Мөрөн өгсөөд хоёр vйсэн завь айсуу. Таван хvн сууж яваа бололтой гэхэд нь ,
- Vйсэн завьтай гэвэл , их ус дагуу нутагтайулс байна. Байкул их далай ээжийн хvн байж болох магад.Тэгвэл манай махан төрөл Ихэрэсийн хvн ч байж болзошгvй. Юу ч болсон ойртохы эт харзанаж vз дээ , хvvxээ. Гээд эгчмэд эмгэн , улайссан ваарын гал, нойтон бургасаар засаж, амарлингуй царай нь маш төв, айван тайван тул, анх баахан цочисхийсэн эмэгтэйчvвдийн дотор нь онгойгоод, айсаж буй vйсэн завьтныг ажих гэж бvгдээрээ одоцгоосонд - айх аминд тустай. Ил битгий цухалзаарай гэж захиад , ганцаараа vлдмэгц, царайд нь баахан зовуурын шинж мэдэгдэвч юу болохыг хvлээн, галаа засан тааруулж суув.Ваар саваа мөрөн голын захад хэзээнээс шар наанги гардаг газраа шөрмөсөн чулуутай нухаж элдээд ваар саваа хийж байсан эдгээр эмэгтэйчvвд , Дархас ясны Шаварчин отгийнхон бөгөөд, эрэгтэйчvвд нь гөрөөнд гарч, эмс нь тэр өдөр сав хийж шатаан бэхжvвлж байсан байжээ. Эгчмэд эмгэнийг галаа засаж, сураг чимээ хvлээн суутал, усны захаас нэгэн эмэгтэй хvрч ирэн, эмгэний зvг өгvвлрvн :

- Танихгvй нэг чийрэг эр, нэг залуу хvв, бас хоёр танихгvй хvн, нэг хойшоо хараад суусан хvнтэй хоёр vйсэн завь тун ойртлоов шvв. яахав? гэтэл, хойноос нь бас нэг эмэгтэй хvрч ирэн,

- Манай Цахиурчийн отгийн Погдоон ах, хоёр танихгvй хvнээр дамжуулан, завиас буулаа. Бас хоёр танихгvй хvн завиа бургаснаас уяж байна гэхэд нь эгчмэд эмгэн хочр эмэгтэйг дагуулан мөрний зvг яаран одлоо. Усны захад, бургас улиасанд биеэ далдласхийн очиж харваас ваарчин эмэгтэйчvвд, завиар ирэгсдийг хэдийн тойрч, айх эмээх байдалгvй, харин ч тэр ирэгсдийн нэгийг газар суулган тэнхрvвлж байгаа бололтой. Эгчмэд эмгэн яаран урагш давшиж, ирэгсдийг ажин харваас, хоёр нь ойн хvний шинжтэй, онигор нvдтэй догшин харцтай улс. Нөгөө хоёрын нэг нь хижээлхэн боловч сvрхий чийрэг байдалтай. Нvдний харц нь цэцэн талбиун дэргэд нь нvдэндээ галтай, нvврэндээ цогтой чамбай залуу хvв. Газар сууж байгаа нь Дархас ясны

цахиурчин отгийн Погдоон өвгөн ажээ.

- Холоос яваа бололтой алсын аяны та нар замдаа сайн явж ирэв үү ? Аль усны ямар ясны хэн гэдэг вэ, та нар ? Хэт зориг хэнд вэ ? Хэрэг зориг юунд вэ ? гэж амар мэндий нь мэдэхэд , тэр ирсэн хvний ахмад нь найрсгаар инээмсэглэн өгvвлрvн :

- Аян замдаа азтай мэнд явж байна. Унасан газар угаасан ус урд зvгт тун холоо. Миний бие Чонос ястай Шонхолой гэдэг. Энэ миний хvв Залуудай гэдэг. Манай хоёр нөхөр ойн улс, Хумка омогтойн. Энэ нь Үхvв, тэр нь Гекvв гэдэг нэртэй. Залуудай бид хоёрыг Ихэрэсийн Бух өвгөнийг Байкул нутагт хvргэх замд нийлсэн хоёр нөхөр маань гэхэд, эгчмэд эмгэн :

- Тэли, тэли, Ихэрэсийн сурагvй болсон Бух өвгөнийг нутаг усанд нь хvргээд буцаж яваа улс юм бий та нар . гэхэд нь Шонхолой, найз Бух өвгөний нь таньдаг хvн дайралдахад гайхан баярлаж,

- Ихэрэс ястан Бух өвгөнийг таньдаг хvнтэй санамсаргvй дайралдахад сонин сайхан байна. Гэхэд нь эгчмэд эмгэн :

- Урт хөлтэй гөрөөчин маань Ихэрэсийнхэнтэй хамт агнадаг цаг ч бий . Манайхантай махан төрөл , ураг барилдсан ястан юм даа. Та Ихэрэс хvний идээ ундаагий нь амсахдаа, манай дархас ястны Шаварчин отгийн бидний хийсэн бөх голтой ваар саваас идээ унды нь амссан ч байлгvй. Загасны нуруун хээтэй ваар сав дайралдав уу ? манайхны саванд тийм тэмдэг байдаг юм гэхэд нь Шонхолой :

- Дайралдсаан. Танайхны урлан бvтээсэн урт наст сав юм бий гэхэд нь эгчмэд эмгэний царайд тэр vг сонсоод бахархан баярласан шинж мэдэгдэж, гараараа газар тулан сууж байгаа хvний дэргэд очиж,

- Погдоон дvв яачих нь энэ вэ ? гэхэд нь чихээ тас татуулсан шарх нь өвс навч наалттай, ам нь муруйн, хацар хавдсан Погдоон vг хэлэхэд тун зовлонтой тул, талт мөлт өгvвлрvн:

- Цахиуртын аманд Дvлхижегт алуулан алдлаа, эгч минь. Аз дайрч эдэнтэй тааралдаад амь гарлаа гэж Шонхолой нарын зvг толгойгоо дохисхийв.Эгчмэд эмгэн, Погдооны шархыг байцаан vзээд, Шонхолойн зvг хандаж өгvвлрvн :

- Манай их отог гэдэг Цахиурчны огдоон дvвг тун сайхан аргалжээ. Шархын халуун болдгийн даваан дээр та нартай дайралдаж, амь гарсан хvн байна. Ота өвс таньдаг сvрхий оточ хvн та нарын дунд яваа юм байна. Бодвол та байлгvй дээ ? гэж Шонхолойгоос асууваас би эмт өвс бага зэргээр танина гэж хариулав.

- Холын аяны та нар манай отогт хэд хонож, гарынхаа чилээ хөлийнхөө хөшөө гаргагтуй. Урин дулааны цаг, унд хоол элбэгтэй вээр тааралдсан тань таатай сайхан байна. Зvсээ танилцаж сайхан vгээ ярилцъя. Аялгуу ондоо боловч хэлээ мэдэлцэх улс байна та. Хvвхээд, Погдоон ахыгаа хятай сайхнаар тvшин дамжилж, отог дээрээ аваачигтун. Энэ холын аяны хvний завийг нь аятайхан нууцгай газар алдуулахгvй бөхөөр торгож тогтоогоод, буулгах юмыг нь буулгалцан отог дээрээ хvргэж өгөгтvй, хvвхээд. Марал, Мэгж та хоёр энэ ваараа хашраараа сахин vлдэж аргалаарай. Би отог дээрээ очиж, Погдоонд тэнхэл өвсний ундаа хийж аргалсуу гээд, Шонхолой, Погдоон сэлтийн хамт отгийн зvг алхав.

Отгийн буудалд хvрэх вес наран бараг жаргаж, мөрний зvн талын сvрлэг сайхан уулсын оройд улбар туяа нь тусавч, мөрний баруун талын өндөр уулын ширэнгэ модны захад хэдийн бvрэнхий болж, vдшийн бvрийн сэрвvн амьсгал татав.

Эмэгтэйчүүд галаа түлцгээж, эргийн дагуу тавьсан ходоод гэдэг өөшнөөс хэдэн том хилим, загас дамжилан авчирцгааж, ногоо давс найруулан, тун аятайхан хоол хийж байна нь дөрвөн аянчны шүлс гоожмоор таатайхан үнэр ханхлав. Отгийн эмэгтэйчүүд, холынхоо зочинд хоног засаж, хоёр хэсэг газар шөнийн чийг шүүдрээс хамгаалах налуу тал саравч хийж шилмүүст мөчир, долон холтсоор хучаад, дор нь шилмүүст мөчир дээр тургийн арьс дэвсэж өгсөн билээ. Погдоонд бас хэвтэн амрах газар засаад, аятайхан түшиж хэвтүүлээд, отгийн эгчмэд, босоо вааранд амны цангаа гаргаж, тэнхээ оруулах өвс цэцэг найруулж ундаа хандлаад, шавар аяганд аягалуулж, гийчиндээ бариулаад, Погдоогд бас тусгай нэг ханд хийж уулгасан билээ. Дөрвөн аянчин, тэр урьд амсаж үзээгүй хүрэн өнгөтэй, сонин сэвүүн ундаанаас нэжээд, хошоод аяга уунгууд, бие сайхан талбиун хөнгөн болж барьснаа балба, хүрснээ хvv татмаар бянтай болсон, хөл - үсрэн дэгдвэл ургаа модноос дээхнүүр, нүүгээ үүлнээс доохнуур, дэгдэн дүүлмээр санагдсанд ямар сонин ундаа вэ ? гэж их л гайхаж, Погдооныг харваас ангаа гаогаж, амь залгуулдаг ундаанаас нэг аяга уугаад цуцаж алжаасан нь нэг мөсөн үгвй болж өөдөө өндийн суугаад, нүд нь галтай болж, царайд нь өнгө ороод шарханд нь цэцэг үндэс хандалсан эм түрхэж өгсөнд, өвдөх хавдах нь нэг мөсөн дарагдав.

- Эгчмэдийнхээ эмийн ачаар дотор минь онгойж, зангирсан гол минь тавигдлаа. Ачтай болдоо эгчмэд эмгэн минь гэж Погдоон, тэр шаварчин отгийн эгчмэд эмгэнийг нэрий нь үл нэрлэн хүндэтгэж тал өгөөд – омог нэгтэй бага отгийнхоо та нартай энэ дөрвөн айлчны аёаар уулзлаа даа. Цахиуртын аманд зэмсгийн цахиур авах гэж Онгоодой бид хоёр дагалдан суралцах хоёр залуутай, бас цахиур таньдаг хоёр сайн дархантай хүрч очоод амын эзнээс цахиурын сайныг гуйж, цацан өргөдөг юмаа өргөөд чулуу түвж байтал, олон Дүлхижег гэнэт биднийг дайран халдаж, хоёр сайн залууг маань тэнд нэг нэг Дүлхижег дэрлэн уналаа. Хоёр цахиурчин маань ч тэнд хоцорлоо гэж үхэгсдийн нэрийг нэрлэхээс цээрлэн, бас үхсэний нь “хоцорлоо” гэж нас эцэлснийг заан хэлжээ.

- Юутай ёсон бус вэ ? Цахиуртын аманд Дархас Дүлхижег хоёр ястан, хэзээнээс нааш цахиур авч, хэн хэндээ саад хориг хийдэггүй тангарагтай шvv дээ. Юутай ёсон бус вэ гэж Бага отгийнхон, Погдооныг тойрон сууж, сонсож сууснаа, Дүлхижегийн гэнэт дайран халдсаны нь сонсоод тэсгэлгүй хорсон жигшив. Погдоон “хоцорсон” нөхдөө Дүлхижегтэй тулалдсаны нь нүүр гарын хөдөлгөөнөөр дүрслэн, сэтгэл маш хөдөлсөн байдалтайгаар ярьж, Бага отгийн олон үгий нь сонсон “хvvш, чаа бас” гэж дуу алдацгаан, өөрсдөө тэр гэнэт, дайрсан Дүлхижегтэй дайралдсан юм шиг харцгаав. Погдоон гэнэт аврага их могой дайран орж, Дүлхижегийг гэлмэгдүүлсэнд, машинд эмээж, сандан мэндэн тархан тутаасанд, чихнээсээ цус гоожуулан гүйсээр усны захад мэдээ алдан унаад, юу ч болсныг мэдсэнгүй, хичнээ ч болтол чингэж үхэх сэхэхийн хооронд тарчилснаа мэдсэнгүй. нэг ухаан ороход, хэдэн танихгүй хүн тэнхрүүлж байсан нь манай энэ зочин байлаа гэж ярьж байтал модон дотроос арваад том нохой гүйн гарч ирсэн нь босоо зарим нь дөрвөн нүдтэй шар халтар сүрхий өргөн хэнхдэгтэй, гялалзсан цагаан соёотой бөгөөд, сургууль сайтай бололтой. Гарч ирээд хамаагүй давхихгүй, хүний хөлд орооцолдохгүй, маш журамтайгаар явж, отгийн эмс охид, өвгөд өтгөс, балчир хvvхдийг хүртэл сүүлээ варван үнэрлэсээр, дөрвөн аянчны дэргэд нь хүрч очоод хар хоншоороо хөдөлгөн шиншээд хүний хөлөөс зайс газар нэг хоёроороо хэвтэв.

- Манайхан гөрөөнөөс айсуу гэж, отгийнхон, тэр нохойн давхиж ирсэн зүг байн байн харваас модон дунд хүний дүнгэр дүнгэр хэлэлцэх чимээ сонсдож, арваад чийрэг эр, хоёр хүнийг хүзүүнээс нь сураар холбоод нэг нэг бор гөрөөс бөгтрүүлэн гарч ирэв. Ирэгсдийн нэг нь Погдооныг харангууд дэргэд нь гүйн очиж, сөгдөөд, гары нь илэн,
- Ахынхаа улаан царайг дахин олж үзэх юутай сайхан, юутай сайхан гэхэд нь Погдоон ч бас баярлан ,
- Дүү минь амь мэнд гарч, дүү минь амь мэнд гарч , гэж толгойгий нь илэв. Чингээд тэр залуу босоод, отгийн эгчмэдийн зүг хандаж, маш хүндэтгэсэн байдлаар
- Эгчмэдийн эсэн мэндийг асууя, гээд олны зүг отог олны мэндийг асууя гэхэд эсэн эсэн гэж хариулцгааж, отгийн эгчмэд :
- Онгоодой чи хаанаас манайхантай нийлэв ? гэхэд, тэр залуу өчрүүн :
- Гурван Дүлхижегт баригдаад, туугдаж явсаар Тавьцийн өндрийн тэнд нийллээ. Нохойтой төлөөдөө, намайг салгаж, энэ хоёрыг барьж авсан шүү гэж тэр хоёр олзын Дүлхижег заалаа.
- Отгийн өтгөс, тэр Дүлхижегийг өмнөө зогсоон, отгоосоо анх хэн тэргүүлж хэн хэнтэй гарсныг асуув. Насан арай ахмад Дүлхижег нь бага отгийнхны өтгөс залуус олны царайг хялав хялав харан өчиж, Крагөс бөөтэй явсан гэхэд нь нэг өвгөн Крагөс гээд урдаа нэг чулуу тавилаа. Тэгээд, бас хэнтэй явсан бэ ? гэж асуун , явсан хүний тоогоор нэг чулуу өрж, Дүлхижегийг одоо гүйцлээ гэхэд нь өрсөн чулуугаа заан хэн хэн явсан бэ ? гэж дахин лавлан бүртгэвээс анх хэлсэн дэс дараагаа огт алдалгүй , чулууг хуруугаараа заан , тэр тэр гэж түрүүн хэлсэнтэйгээ ширхгийн зөрөөгвйгээр тоочихдоо энэ аврага могойд амь алдсан энэ үхсэн, энэ үхсэн, энэ би, энэ миний нөхөр гэж дэргэдэх нөхрөө толгой дохин зааж гүйцэв. Отгийн өтгөс, үхсэн Дүлхижегийн тоогоор нэжээд чулуу хассаар эцэс сүүлд хоёрхон чулуу үлдсэнд , нэр тоо дүйлээ. Анх гарсан хүнээс энэ хоёр л үлдээд байгаа юм байна. Хэл хүргэж завдаагвй болох тул эднээ яасныг Дүлхижегүүд мэдээгвй байгаа юм байна. Манай Дархасын дөрвөн хүн эдэнд амь алдсан гэж үхсэн Дүлхижегийн тоогоор овоолсон чулуунаас дөрвийг хасаад, цаана нь үлдсэн чулуу харж, - хохирсон хүнээр Дүлхижег илүү боловч ёсон бусаар халдсан тул, бид – дөрвөн хүнийхээ амь нэхэх ёстой биздээ ? гэж олны зүг хандан асуув.
- Дүлхижезгийн дураар хүнээ хядуулж яаж болохов ?
- Амь нэхнээ. Хэл авалцаагвй дээр нь хэмх дайръяа. Галы нь сөнөөж голы нь самнавал таарах муухай улс байна шүү . Өнгөрүүлээд л байвал , номхон бор гөрөөс ноцож сурсан шилүүс шиг , шилэн хүзүүн дээр маань гарах нь шүү . гэж отгийн анчид шуугилдав. Чулуугаар тоо бодож байсан өвгөн, гараа өргөж олны шуугиан намдаагаад, хоёр Дүлхижегээс
- Та нар отгоосоо гарахдаа манайхны Цахиурчин отгийнхныг дайрна гэж зорин гарсан уу ? гэж асуув.
- Үгвй , Манай Карагөс бөө, өмсгөлөө шинэтгэнэ гэж биднийг дагуулан гөрөөнд гарсан билээ. Тэгээд нэгэн өдөр манай замыг буруу талаас хөндлөн огтлон гарсан хэдэн хүний мөр дайралдсанд , үдшийн бор хоногоор бөөлөөд,

Харь омгийн хар санаатан
Харгуйгий маань хөндөлсөж

Бузар юм буглан дагалдаж
Буруу талаас дайран орлоо
Хвйтэн мөртөнгүүдийг хөөж
Хвйсий нь тэмтрэн дарагтуй
Усан мөртөнгүүдийг мөшгөж
Уушиг зүрхий нь зүлдлэгтүй
Уулынхаа өвгөдийг тахигтуй
Ул мөр зохистой болготуй

гэж заавар зааж, сургаал сургаад, биднийг дагуулан , тэр хэдэн хvний мөрөөр явж, Цахиуртын аманд хврээд цочмог дайран ортол гэнэт аврага могой гарч ирээд Карагес танайхны нэгэнд гараа цавчуулаад, амны эзэн аварга могойд нугасаа тас ширвүүлж Сарыгес дvв нь бидэнтэй хамт зугтаахдаа , энэ залууг самбаачлан бариад, олзны хvнтэй отгоо чиглэж явтлаа, танай анчидтай тааралдаж Сарыгес амь алдаад, бид нохойд ээрүүлэн олзлуулсан билээ гээд дуугвй боллоо.

- За мэдлээ. Бvх Дvлхижег ястан ч биш, ганц Карагесөөс болсон хэрэг байжээ. Карагес, Сарыгес хоёр ч муу санаа нь мухар толгойд нь хврч, хар санаа нь хар толгойд нь туссан юм байна даа. За одоо оройн хоол ч боллоо. Бид хоолны сvвлээр зөвшилдөн тогтсу. Энэ хоёр Дvлхижег, санаа муут Карагесийн гайгаар зовж яваа багацуул байна. Одоо хоол унд өгөгтвй, хvvxээд. Хvний vр хойно хвлгэнд ороод , өлсөж цангаж зvдэрч ядарч яваа байлгвй яахав. Уяа хвлээсий нь суллагтуй, хvvxээд. Та хоёр зугтана барина гэж болохгвй шvв. Сарыгесийг гвйцсэн нохой, та хоёрыг гвйцэхгвй гэж байлгвй шvв. гэхэд нь хоёр Дvлхижег, тэр өвгөний энэрэнгвй vг сонсоод , баярлан биширч, ахмад нэг нь мөхvйн ёсолж,

- Буурал аавын суу гэсэн газар сууж, бос гэсэн газар боссу гэлээ. Эмэгтэйчvвд тэр орой маш хичээж хийсэн хоолынхлл аль амттай, нэртэй сайн махнаас холын гийчинд бариад, өвгөд өтгөстөө аягалан таваглаж, анчин идэрцvвлд тэвшинд хийгээд, хvvxэд багацуул бvгдэнд хувий нь тvгээж, бvгдээрээ гал тvвдгийн гэрэлд хоолоо идэцгээж, мөлжсөн ясаа нохойд хаяцгаан, чулуугаар чөмөг хуга таших нь ташиж, бор гөрөөсний шvврхий шарсан мах, хилим загасны мах шөл ханатлаа идэж уугаад, хөгшид хvvxэдтэй эмс унтдаг газраа очиж хэвтэцгээн залуу охид тэвш, аяга саваа хурааж хоёр Дvлхижегийг сахин хонох галын дэргэд хуурай тvлээ овоолж өглөө. Погдооны амь аварсан хvн гэж, Шаварчин отгийн өтгөс , Шонхолойг тун хvндэтгэн бас олон уул давж олон ус гаталсан, хал vзэж, хашир таньсан гийчин гэж машид элэгсэг байж Дvлхижегийн хэдэн хvн , хоёр ястны эвдрэн байлдахад зайлшгвй хvргэх хэрэг өдvвлснийг Шонхолойтой нийлэн зөвлөө гэж дэргэд нь хврч ирэхэд, хvvgээ хоёр Хумкаа дээр явуулаад , өвгөдийн vг санал сонсон, гvнээ бодлого боллоо. Их отгийнхондоо маргааш өглөө хvн явуулж, хэрэг учир танилцуулахаар болсон бага отгийн өтгөс, Дархас ястны отгийн өтгөсийн зөвлөлдөхөд өшөө нэхэх санал барих уу, эвлэрэх санал барих уу? Өшөө нэхэхэд хvрвэл , бас л Дархасын нэгэн хэсэг идэрцvвлийн амь vрэгдэхэд хvрнэ. Өнгөрvвлэх аргагвй хэрэг гарсан тул , эвлэрэхдээ яаж эвлэрэхэв? Гэдгийг зовнин бодож мэргэн санал, эвтэй арга юу байна гэж чонос Шонхолойгоос асуусу гэж бодсоноо хэлэхэд , Шонхолойн сэтгэлд тvмэн юм бодогдож, хоёр ястан эвдрэлдэхэд , идэр анчин vрэгдэж, догшин араатнаас отгийн өтгөс, эмс хvvxдийг хамгаалах зоригтон эрс дутагдаж яс сөнөж, отог мөхөх аюул

тохиолддог зовлонг санахад үнэхээр бэрх. Түүдэг галын гэрэлд өөдөөс нь харж суугаа өтгөсийн зовнисон царай харахад, нүд халтирмаар санагдаж, баахан бодлого болж байснаа :

- Танай Дархас ястанд өөр яс омгийн хүнийг өөрийн омогт багтаадаг ёс бий юу ? гэж асуухад нь отгийн ахмад өвгөн, тэр үг сонсмогц , царайд нь баярын тэмдэг тодорч, Та нөхөдтэйгээ манай элкен болох гэж байна уу? гээд

Үгвй гэхэд нь өвгөний царай тун урамгвй болсноо, тэгвэл таны тэр асуудаг ямар учир вэ ? гэлээ.

- Бух өвгөнтэй урд газар хүний нутагт бариа тавианд орж явахдаа би нэг сайн хүнтэй танилцаж анд бололцоод тэр сайн анд минь надад итгэмжилж амьтанд туслах чухал хэрэг тохиолдвол хэрэглээрэй. Хар амиа бодон хэрэглэж болохгвй гэж сурган заасан нэг арга бий. Түүнийг хэрэглэж , хоёр ястан эвдрэлдэхийг эвлэрүүлэхэд хэрэглэж үзвэл чадах болов уу? үгвй болов уу? гэж бодож байна даа. Гэхэд нь отгийн өтгөс маш баярлалдав.

- Хоёр Дүлхижегээр тэдний омог олны сэтгэлийг танай талд болгож, Цахиурчин отгийн амь хохирсон хүний орыг гаргуулж өгсв. Танайханд өөр омгийн хүнийг өөрийн болгож авдаг ёс бий юв? Гэж асуусан учир минь тэр. Бас танай Цахиурчин отгийнхонд зүлгэмэл цахиур зэмсэг хийх арга зааж өгсв. Гараар хүрэхгвй, чулуудаад дийлэхгвй, газар жадлах арга зааж, ан гөрөө хийхэд тэнь тус болж өгсв. Ингэвэл ямар байна ? гэхэд Бага отгийн өвгөд, хүүхэд мэт баярлалдаж, тал өгөөд, хоёр ястныг эвлэлдүүлэн гүйцэтлээ манай отогт саатаж хайрлагтуй гэж гуйлаа. Отгийн өтгөст санаа сэтгэлий нь тайтгаруулах үг хэлж, олзны хоёр Дүлхижегийн гал дээр очин, сахиулд нь дохио өгч зайлуулаад , түүдгийн гал нүүртээ тусах газар сонгон сууж хоёр Дүлхижегийг ширтэн ширтэн харахад нь тэр хоёр залуу анчин, түүдэг галын жирэлзэн хөдлөх дөлөнд бараг сүүдэр сүүмэлзэн тун сонин харагдах Шонхолойн айван тайван хүрэн бор царай галтай хар нүдний тогтуун амарлингуй мөртөө хүний сэтгэлийг өөрийн эрхгвй татан дагуулах харцыг анх гайхан харж байснаа, төдхөн биеэ сул тавьж царай нь тайван болж ирлээ.

- Одоо хэвт, унт унт гэж эцэг хүн, энхэр үр хүүхдээ хэлж байгаа юм шиг нам талбиун дуугаар өгүүлэхэд нь хоёр Дүлхижег дуулгавартайгаар хажуулан хэвтээд, төдхөн унтаад өглөө. Шонхолой байрнаасаа хөдлөлөгвйгээр тэднийг ширтэн харж, баахан юм хэлэх шиг болоод, хоёр сахиулыг дохин ирүүлж, нам дуугаар тэдэнд хэдэн үг хэлээд, унтах газраа чиглэн одов. Их модны захад буусан Дархас ястны Шаварчин отгийн буудалд, гагцхүү олзын хоёр Дүлхижегийг манан хонох сахиулын гал хэвээрээ асаж, бусад түүдгийн гал цогшин унтарч, хөл чимээгвй боллоо. Шөнийн харанхуй огторгуйд түүг түмэн одон жирэв, жарав хийж ойн вахын модны орой , зөөлөн салхинаа найгасхийн, юухан нэгэн юм шивнэх мэт шуугисхийнэм бөгөөд отог олноороо нэгэн дор цугларсан хоёр хөлтний бие болон хувцас хунарын тос, хөлс, утаа элдэв тэргүүтэн шингэсэн хачин үнэр, гал түүдэг, үнс утааны үнэр тойрон хэвтэж байгаа нохойны үнэр, янз бүрийн идээ ундааны амт нөнжиг шингэсэн ваар сав, аяга тэвшийн үнэр нийлэн зүг зүг ханхалж, ойн дөрвөн хөлт амьтныг сүрдүүлэн, холоос айлган зайлуулж, сахиулын галын гэрэл улайн харагдах нь араатныг бас давхар цочоон зайлуулах ажээ.

Хоёр Дүлхижег залуу, Дархас ястны Шаварчин отгийн олны хамт хойт өглөө нь чонос Шонхолой, Залуудай хоёрын харвалыг гайхан үзэж, чулуудаад хүрэхгүй газар дэлэм хиртэй бяцхан жадаар онох гэсэн юмаа санааны зоргоор онодог айхтар чадалтай зэмсгийн эзэн улс юм байна гэж гайхсан билээ. Хоёр Хумка ч бас харвах чадлаа үзүүлж, өөр омгийн хүн ч гэсэн, тэр сонин гайхамшигт зэвсгийн эзэн болж чадах гэгчийг үзүүлж билээ. Чингээд хоёр ястан эвлэн найрамдах аваас, тэр гайхамшигт зэвсгийг зааж өгч хэрэглүүлнэ. Хэрэв хэрэг өдүүлсэн Дүлхиуег эс найрамдаваас, давшгүй чадалтай тэр хурдан зэвсгийг Дархаст бариулж өшөө нэхэн удирдана. Тэр цагт Цахиуртын эзний нэхэн зарц болсон Карыгес ч ёс алдсан Дүлхижегийг далдуур сөнөөн тусална гэж шонхолойн хэлсэнд хоёр Дүлхижег хирдхийн цочиж, урд шөнө нь үүдэндээ Цахиуртын амны эзэн аварга могойд голоо тас ширвүүлсэн Карыгес бөө гашуудан гэмшиж, Дүлхижегээ Дархастай эс эвлэрвэл бүгдээрээ баларна гэж захин үзэгдсэний нь гайхан санаад, болзон тогтсон газар Дүлхижегийн өтгөс хүрч ирэн зөвлөх бий гэж омог ясандаа буцсан билээ. Цахиурчин отгийн өтгөс, хэдэн идэр анчнаар хамгаалуулан сувилуулж, Бага отог дээрээ Шонхолойг сонирхон, Дүлхижегийг хэрхэхийг хууви нийлэн зөвшилдөх гэж бага отгийн элч хүрмэгц дагалдан иржээ. Санал нийлэн хэлэлцэж тогтоод байтал, Дүлхижегийн хэдэн өтгөс өнөө хоёр залуугийн хамт хүрэлцэн ирсэн нь урд өмнө үзээгүй сонин гайхамшигт зэмсэгтэй хүнийг үзэн танилцаж, зэмсгий нь ольж үзэх санаатай байж, бас Дархастай эс эвлэрвэл яс омгоороо баларна гэж хоёр залуугийн үүдэнд шөнө бүр Карагес үүхдэг болсонд нь хирдхийн эмээж, эвсэн найрамдах санаатай, олон үеийн тэртээ Дүлхижегийн нэгэн сайн анчин, Дархасын нэг сайн ангуучинтай дайралдаад, анд болж зэмсэг солилцсон, жадын цахиур гилбэрийг өвгөдийн шүтээн гэж хадгалж байснаа хүдрийн арьсан хавтагатай нь залан авчирсан байжээ. Дархасын Бага отогт үе улиран бас эртний Дархас ангуучны Дүлхижег анчнаас хариу бэлэг болгон авсан хирсийн эвэр гилбэр хадгалаастай байдаг нь эртний тэр “ангуучин аав” гэж нэрлэдэг дээдэс нь Бага отгийн хүн байсан тул зэмсгий нь өлзийтэй эд гэж тахидаг байжээ. Намрын их гөрөөгөөр хоёр отгоороо нийлэн цуглаж “ангуучин аавыг тахина” гэж найрладаг, үүнд, Дүлхижег ч мөн “анчин аавыгаа” мөн ойролцуухан үес тахиж, гилбэрт нь намрын их ангийн дээж өргөн мялаадаг заншилтай байжээ. Эртний домогт Дархасын “ангуучин аавын” бэлэглэж, Дүлхижегийн “Анчин аавд” өгсөн гэж хэлцдэг тэр яс омгийнхоо шүтээн гилбэрийг Дүлхижег өвгөд залж ирээд, эв хэлэлцэхэд тус болох болов уу? гэж горилжээ. Бага отгийнхон, тэр эртний их “ангууч аавын” урлан бүтээсэн нандин зөв залж ирснийг сонсоод, отог олноороо идээнийхээ дээж өргөж, агь ганга уугиулсанд Дүлхижег өвгөд баярлалдан, манай их “Анчин аавын” эрт дээр цагт “Ангуучин аавд” бэлэглэн өгсөн эвэр гилбэр Дархас омогт бий гэдэг нь үнэн үү? гэж лавлан асууваас бага отгийн өтгөс, бий гэж хариулаад, хилим загасны арьсан хуучин гэгчийн хавтагтай тэр шүтээнээ хавтагтай хэвээр нь авцарч Дүлхижегийн шүтээний дэргэд эзэн зочны суудлаар залан, Дүлхижег өтгөс түүнд отог нутгаасаа авч ирсэн идээ, өөхнөөсөө өргөж хавтагт нь мялаалаа. Хоёр ястанд нь эрхэм болсон эртний эв найрмын тэмдэг шүтээн, өчнөөн төчнөөн үе болж сая сая нэгэн дор эзэн зочны сууринд зэрэгцэн тавиулсан нь Дархас, Дүлхижегийн эвлэн найрсаг болох хэлэлцэлд их тус дөхөм болж өглөө. Бас Шонхолойн нум сум гайхан үзэж, Дүлхижег өтгөс, хоёр залуугийнхаа үгийг мадаггүй үнэн юм байна гэж биширсэн нь Дархас

ястан ийм бүрхий зэмсэгтэй Чонос гэдэг сүрхий омогтой найртай харилцаатай болсон тул, эвлэрэхийг хичээвэл зүйтэй болох нь гэж бодоцгоож, үг найрсаг зан маш эелдэг боллоо. Чингээд, Дархас Дүлхижег хоёр ясны өтгөс, найрамдуу сайхнаар зөвшилдөж, Цахиуртын аманд амь алдсан Дархас, Дүлхижегийн ясыг тэр нь Дархас, энэ нь Дүлхижег гэж ялгахын тэмдэггүй болсон тул, гурван намар өнгөрөх үес, мөлжүүр салсан ясы нь хам нэгэн дор өндөрлөн тавьж нийлэн ёслохоор хэлэлцэн тогтлоо. Дүлхижег өтгөс, Дархас Их отгийн дөрвөн хүний маь хохирч, эмс үрс өнчирсөнд үе нас ойролцуу дөрвөн сайн анчнаа ёслон өгч, хоёр ястны дөрвөн өрх харилцан төрөл элгэн болохоор хэлэлцэн тохирч, эвдрэн муудалцахын муу шалтгаан тасарлаа. Цахиурчин отгийнхон Дүлхижегт анчин бүхнээ цахиур зэмсэг өгч, эвлэрэн найрамдсаны бэлэг болгон өгөхөөр болж, хариу Дүлхижегүүд Цахиурчин отгийнхонд өөдөө амсартай өлзийтэй юм гэж анчин бүхэнд өмд, сөөхий бойви бэлэглэнэ гэж хэлэлцлээ. Шаварчин отгийнхон, Дүлхижегт өөдөө амсарт ваар сав өрхийн тоогоор өгч, Дүлхижегүүд, ой хөвчөөр хэрэн явахад таатай хомбогон сав өгөхөөр болж, хоёр отгийн өтгөс, тэмдэг модонд хэдэн хүнд цахиур зэмсэг, ваар сав өгөхийг, мөн хэдэн хүнд өмд, сөөхий бойви, хомбогон уут сав өгөхийг тус тус хэрчлээ гарган тэмдэглэж аваад олон үеийн тэртээ “ Анчин аав “, “ Ангуучин аавын “ уулзаж бэлэг солилцсон бор толгойн тэнд хоёр ястан нийлэн цуглаж, хоёр их аавын шүтээн зэмсэгт идээнийхээ дээжийг өргөн мялааж, найрлан хуримлахаар хэлэлцэн тогтож хоёр отгийн эвдрэн өшиж, дайралдсан газраа тулалдах аюулаас хагацан эвлэрсэндээ баярлалдан, бас урьд өмнө үзээгүй сонин сайхан зэмсэг Чоносын их анчнаас заалган хийж, ойр хавийн ястанд байдаггүй сайхан нум сум гэгчтэй болцгооно гэж бодохдоо улам ч их баярлаад болзсон өдрөө хоёр яс омгоороо нийлэн цуглах газар хождолгүй цуглах гэж Дүлхижегийн өтгөс яаран буцлаа. Цахиурчин отгийн өтгөс ч мөн бэлтгэн зэхэх юмаа янзлан амжих гэж шамдан хөдлөхдөө, өвгөдийн Болзоотын бор толгойд баяртай учирсу гэж Шонхолой нартай маш элэгсэг дотноор салах ёс хийгээд явцгаалаа. Чингээд тогтсон өдөр болзсон газраа цуглах гэж шаварчин отгийнхон, эрэгтэй эмэгтэй хүн юмаа үүрцгээж Шонхолой Залуудай хоёр, хоёр хумкаатайгаа бас тэдэнтэй нийлэн, Болзоотын бор толгой чиглэжээ. Найрын бэлэг, идэх хүнс төхөөрөх гэж отгийнхон ихэд чармайж, Шонхолой, бас анчид нь нэмэрлэх гэж анд явалцаад, нум сумтай тул анчин их олзтой, омогтой баяр хөөр болцгоон, найрын газар дааж ядам олзтой дөхөж, алсаас харваас, наран мандах зүгтээ өргөн мөрөнтэй, төрний захын бургас шугуй нь өтнө зүгт хөхрөн харагдагч уулсын хормойтой нийлж халиуран харагдагч их талын зүүн захад, мөрөн их усны ойр уран хүний өөлөн хийсэн юм шиг хөөрхөн бор толгойн өвөрт отгоороо буусан олон хүн харлан үзэгдэв. Ойртон очвол, Дүлхижегүүд хэдийн хүрэлцэн ирж буугаад, Их отгийн түрүүч нь хойморлон бууж, Бага отгийн хэдэн гавшгай залуу анчин болзсон өдрийн үүрийн шөнөөр хүрч отгийнхоо буух байрыг шавга босгон тэмдэглэж, бэлтгэн зэхэх ажлаа жин тан болгосон тул, Их отгийн идэрчүүдийг дагуулан отгийнхоо хүний өөдөөс угтан очиж үүссэн юмнаас нь хөнгөлөн үүрэлцэж буух газар нь удирдан аваачив. Бага отгийн өтгөс хилмийн арьсан хавтагтай ангуучин аавынхаа зэмсгийг булган сүүл унжуулсан тас, шар шувууны өдөөр хийсэн шүхрийн ишинд зүүгээд, нэгэн чийрэг анчнаар залуулан, хоёр талд нь отгийн ахмад эгчмэд хоёр өндөр настан явалцаж, хойноос нь Шонхолой, отгийн сайцуултай тэдний хойноос Залуудай, Хумкаа нар Шаварчин отгийнхонд

туслалцаж, юмнаас нь үүрэлцэн айстал Их отгийнхон Дүлхижегийн өтгөстэй шүхрийн өмнө хврч ирээд өвдөг нугалан , баруун гараа өргөн ёслоод, Шонхолойн хоёр талд очиж жагсан явсаар Болзоотын бор толгойн өвөрт хврч шүхрээ зоолоо. Дүлхижег ястны Анчин аавын зэмсэг шүтээн нь шүхэр чимээгвй зулзган хар модноос өлгөөстэй байгаа нь сүр үзэмжээр Дархасын булган сүүл цацагтай тас, шар шувууны өдөн шүхэртэй ангуучин аавын зэмсгээс арай дутуу үзэгдэх тул, дархас ястан баярлалдаж, шүхэр шүтээний эзэн суудалд нь заалаад, Дүлхижег өтгөсийг анчин аавынхаа цахиур гилбэрийг шүхэр дор хамт залан хоёр ястны их найрамдуугийн хуримд хамтатгаягэхэд Дүлхижег өтгөс баярлалдан хүдрийн арьсан хавтагатай цахиур чулуун гилбэрээрээ, зулзган хар модноос салгаж шүхэр дор бага отгийн Ангуучин аавын гилбэрийн дэргэд залжээ. Чингээд Дархас Дүлхижег хоёр ястан отог омогтны бэлтгэж ирсэн ирсэн идээ ундааны дээжээс шүхрийн өмнө хавтгай чулуугаар хийсэн ширээн дээр өргөж, бага отгийн эгчмэд, өчиг найруулахдаа бэлэн үгтэй тул архас ястны өмнөөс түрүүлэн босож, Ангуучин аав, анчин аавын өмнө өчиг дуудах болоод алаглан оёж, хар цагаан ангийн үсээр чимэглэсэн хувцсаа засаж булган малгайгаа буурал толгой дээрээ янзтайхнаар өмсөөд, хэдийн тэнхээ оруулах ундаанаасаа уусан тул, цагриглан хөхөрсөн нүд нь залуугийн адил гялалзан , ваар аягаар дүүрэн хийсэн мэлтгэнэн хүрэн өнгөт ундаагаа хоёр гараараа бариад уянгатай сахйан хоолойгоор эгшиглэн дуудаж :

Сэ – э – эг, сэ – э –эг, сэ –э –эг
Сэнгэнэм сайхан салхитай
Сэтгэл сэргэм цагаан талын
Үзэсгэлэнгийн манлай бологсон
Үетэй чулуугаар эрээлэн бүтэгсэн
Өнгөт цэцгээр мяраалан чимэглэсэн
Өтгөс дээдсийн маань уулзалдагсан
Буянтай сайхан энэ толгойн өвөрт
Булган цацагт шүхрийн дор
Дархасын ангуучин аавын
Дүлхижегийн Анчин аавын
Өлзийтэй цахиур чулуун гилбэр
Өгөөжтэй хирисийн эвэр гилбэр
Үе олныг дамжин хадгалагдсан
Үй олныг ивгээн тэтгэсэн
Харьшгвй иртэй хатан зэвсэг
Мохошгвй иртэй мөнх зэвсэг
Эн чацуу зэргэцүүлэн залжуу
Энд хуран чигуулугсан бидэн
Хун галуу мэт дуугаа нийлүүлжүү
Хулан тахь мэт зүсээ нийлүүлжүү
Чамбайн анчны гөрөөлөн ологсон
Нямбай эмсийн найруулан хийсэн
Тансаг идээн ундааныхаа дээжээс
Таваг тэвш дүүргэн талбижуу

Амттын амсаагвй амтат ундааг
Аяганы амсар бялхам дүүргэжүү
Ач үр олондоо хишиг гуйжуу
Арван хуруугаараа өргөн барьж уу
Ангуучин Дархас аавдаан өргөнөм
Анчин Дүлхижег аавдаан баринам
Халиурагсан сайхан өвс ганхагсан
Хадан сайхан толгойн энгэртүү
Эрт дээр илэр балар нэгэн цагтуу
Эрсийн цог жавхлан бадруулжуу
Анд хэрэглэдэг зэвсгээ солилцжуу
Анд нөхөр бололцон тангараглажуу
Дотнон үгээ итгэн хэлэлцжүү
Дотоод хормойгоо барилцжуу
Эн чацуухан зэрэгцэн суусан
Энэ сайхан буянтай газарт тань
Ангуучин аавын ач үр бид бүхэн
Анчин аавын ач үртэй цуглажуу
Дуугарвал дуу нэгтэй болсуу
Дугтарвал хүч нэгтэй болсуу
Булган цацагтай шүхрийн дор
Буянтай хоёр аавын гилбэр нь
Эн чацуу зэрэгцсэнтэй адил
Энд цугласан хоёр омгийн бид
Буурал хоёр аавын үр сад нь
Бутаршгвй бат эв нэгтэй
Салшгвй бат элэг нэгтэй
Анд хоёр ястан болсуу гэж
Ам тангарагаан өргөж байнам
Анд хоёр буурал аав маань
Ач үр бологсон биднээн
Өршөөлөөрөөн өргөн тэтгэгтвй
Хайраараа харан дэмжигтвй
Хар санаагаар хардан хагаруулсан
Муухай санаагаар муулуулан эвдрүүлсэн
Урьдын хамаг гомдол
Урагшгвй муулар мартагдаж
Үеийн вед эв нэгтэй
Жилийн жилд хүч нэгтэй
Анд ястан болохын хутаг гуйж
Аав болслн та нартаан
Хоёр омгийн хотол олон
Хоолой нэгтэй тангараглам
Өргөсөн тангарагий маань
Өвгөн буурал аав нар тогтоо

Өргөсөн ундаагий маань
Өчсэн ёсоор тогтоон хайраал
Сэ –э – эг , сэ - э – эг , сэ –э – эг

гэж хангинам сайн хоолойгоор хадан толгойд цуурайттал дуудаад ваар аяга дvvрэн ундаагаа дээш нь тэнгэрт, доош нь газарт, хойш нь булган сувл цацагтай шvхэр дор залаастай Ангуучин Дархас буурал Ав, Анчин Дvлхижег Буурал авын гилбэрийн зvг өргөөд, Дархас отгийнхны зогссон газар эргэж одов. Дvлхижег талаас Анчин авын удамтай гэдэг нэгэн өтгөс гарч ирээд, бас нэг ваар савтай ундаа мэлтэлзvvлэн барьж, хоолойгоо баахан чичирхийлэн :

Саалуу, саалуу, са- а-а-лу-у-у
Сарьсан нимгэн чих минь хатуу
Саарь нимгэн гуя минь салга
Цагираг хар нvд минь бvрэг
Царгиа нарийн хоолой минь чичрээ
Өтөлсөн толгой минь буурал
Өвгөрсөн царай минь атриа
Ангалзах ам минь шvдгvй
Аталзах хэл минь цулцаги
Хэлэх vг минь бvгэдхэн
Хэрсvвлэх ухаан минь зөнөгхөн
Айлтгах vг минь тоотой
Амлах юм минь ганцхаан
Дvлхижег ясныхаа өмнөөс
Дvлж байгаад хашгирах минь
Анчин Дvлхижег ав дуулаач ээ
Ангуучин Дархас ав сонсооч ээ
Алд бие минь атигархан боловч
Анчин буурал авын удам шvв би
Өцгөр бие минь буурайхан боловч
Өндөр буурал авын угтай шvв би
Анчин, Ангуучин анд хоёр авдаан
Аль ч талаас халууны хvн шvв би
Баригсан унды минь амсагтуй
Бархирсан vгий минь сонсогтуй
Хоёр ястан маань осол гайгаар
Хоорондоо өшөөтөн болохын даваанд
Хурц ухаант хашир өвгөд маань
Хуувь нийлэн зөвшилдөөд
Дархас ястны дөрвөн эрийг
Дайран хороосон буруугаан
Дvлхижег ястан хvлээгээд
Дvнхийн сөгдөж, ичин зовж
Анд болсон хоёр буурарл аавдаан

Андуугаа хвлээн өчиж байнаа л
Эндүүрсэн Дүлхижегээ зэмлэн
Эндсэн Дархаын орыг босгож
Чийрэг дөрвөн эр сайнаан
Чин сэтгэлээр дархас хvv болгож
Хоёр ястнаан холбон барилдуулж
Хоёр авын хутаг гуйж байнаа л
Нэг биеийн хоёр хөл шингэ
Нэг биеийн хоёр гар шингэ
Хөдөлбөл хөл нэгтэй
Гарвал гар нэгтэй
Халдсан дайсныг хага дарж
Балмад дайсныг балба дарж
Харьтан дайсан халдвал
Хар санаатан вймүүлбэл
Цээл усыг ширгэтэл
Цэгээн чулуу хамхартал
Хамтын хвчээр дайран дарж
Хамаг олноороо санаа нэгтэй
Эв их найрамтай
Энх их жаргалтай
Хувь их заяатай
Хутаг их буянтай
Хөвүүд хвчтэн
Охид царайтан
Унтаршгвй гал их голомттой
Бууршгвй их буянтай болохын
Хишиг хутаг авч авч үрдээн гуйж
Хилмийн арьсан хавтагатай
Хирисийн эвэр гилбэрийн эзэн
Ангуучин буурал ав танаасаан
Хүдрийн арьсан хавтагтай
Хүрэн цахиур гилбэрийн эзэн
Анчин буурал ав танаасаан
Ах дvv болсон хоёр ястны өмнөөс
Аяга дvvрэн ундаагаан өргөн цацаж
Ам мэдэн бархирчуу
Амгар өвгөн Дүлхижег
Айлтган гуйсны минь
Сонор их чихээрээн сонсоод
Сод их ухаанаараан толилоод
Хүслий маань хангаж
Хүн олны маань баясгаж
Өргөмжөөрөөн өгөгтвй
Тэтэмжээрээ тэтгэгтвй

Дүлхижегийн төлөө
Дүлин дүлин дуудаж
Дархасыг төлөө
Дарвиан тавин даллаж
өвгөн буурал аь нартаа
Өчин айлтгасны минь тогтоо
Саалуу, саалуу, саа – а- а –луу –у у

гээд савтай ундаагаа цацан өргөөд Дүлхижегийн сууудлын дээд талд очин суув. Чингээд зvvн баруун хоёр талаас дархас, дүлхижег хоёр эмгэн босож, шүхрийн идээний чулуун ширээний өмнө чулуу дөрвөлжлөн өрж зассан газар очоод, өөд өөдөөсөө сөхөрч, тэр дөрвөлжлөн өрсөн чулууны зvvн баруун талд суулаа. Хоёр талаас хоёр залуу бэрээд жигд нарийн хагалсан давирхайтай хуурай түлээ атга атгаар барин тэр дөрвөлжин чулуун хврээн дотор өрөөд хоёр эмгэдийн доод талд нь цомцойн суужээ. Дархас эмгэн цахиур хавирч Дүлхижег эмгэн галаа тод эрчлэхийг хоёр талынхан ширтэн харж, дархасын эмгэний уулнаас утаа урдаар уугихад цархас их бага отгийнхон ,

- Хааг , хааг, хааг гэж Хэрээ гарвалт ясныхаа уриаг гурвантаа сүртэйеэ хашгиралдан , өөрийнхөө галыг урдаар ассанд урагштай сайхны шинж тэмдэг гэж баярлалдав. Чингэтэл Дүлхижег эмгэний уулнаас ч утаа баагиж, внэгэн гарвалт Дүлхижегvvд,

- Шуа, шуа, шуа гэж яс омгийнхоо уриаг өндөр дуугаар гурвантаа хашгираад өөх тос барьсан дөрвөн эмгэн, дөрвөн хvvгээ дагуулан дархас ястан цахиур цахин Дүлхижег ястан нь галын мөд эрчлэн хавирч эргvvлэн нэгэн газар нь хоёр талаасаа тахилын галbn зvг очиж, гал асаасан хоёр эмгэний доод талд очиж сууцгаалаа. Хоёр талаас асаасан гал дүрэлзэн бадарсаар нэгэн гал болон асахад , хоёр талын хvн цөм баруун гараа тохой нугалан залбирч, галын хоёр талын эмгэн босоод , өөхнөөс барин дархасын эмгэн хоолойгоо засан дуудруун :

Сээг, сэ – эг, сээ –э – эг
Ангуучин буурал авын цахигсан
Ангуучин буурал ээжийн үлээгсэн

гээд түр завсарлахад нь Дүлхижег талын эмгэн босоод өөхнөөсбарин жингэнэм хоолойгоор татаж эгшиглэрvvн :

Саалуу, саалуу, саа – аа –луу –уу
Анчин буурал авын үрэгсэн
Анчин буурал ээжийн үлээгсэн
Гэхэд нь залгаж хангинатал дуудруун :
Цахиур хврэн чулуун эцэгтэй
Цагаалжин хялгана өвсөн эхтэй

гэхэд нь Дүлхижег эмгэн залган дуудруун :

Харгай модон эцэгтэй
Хуш модон эхтэй
гээд, хоёр эмгэн дуугаа нийлүүлэн эгшиглэж

Өөхөн тосон идээтэй
Өрвөлзөгсөн дөлөн үстэй
Өнгөт улаан нөлөөн царайтай
Очит гялалзсан мэлмийтэй
Од галын эзэн сүрт эх ээ

гээд, хоёулаа өөх тосноос галдаа өргөөд, цомцойн сууж, уртаар татан галынхаа магтаал хөгжөөн дуудруун :

Цолмон их цолоор чинь цоллож
Цомцойн сууж айлтган дууднам
Нэрлэм их нэрээр чинь нэрлэж

Нэвсийн сууж дууднам гээд галдаа дахин өөх тос өргөхөд, хоёр талын залуу бэрээд галдаа давирхайтай мод хийхэд дүржигнэн асаж, өөх тосноос дөл нь дөрөлзөж, давирхайхнаас мушгиралдсан хар утаа өөдөө суунаглан өрвөлзөхөд Дүлхижег эмгэн, тос өөх өргөн залбирсаар тамлан дуудруун :

Хоёр буурал авын асаасан гал
Хоёр буурал ээжийн үлээсэн гал

гээд өөх тос өргөхөд нь хоёр омгийн эрс, эмсүрэн дуудаж,

Ангуучин буурал аавын асаасан гал
Ангуучин буурал ээжийн үлээсэн гал
Анчин буурал аавын асаасан гал
Анчин буурал ээжийн үлээсэн гал

гээд зогстол, Дархас эмгэн үргэлжилж,

Ач л олон үрсийнхээ голомтонд
Асан бадарсаар өдгөөд хүрэгсэн
Өдгөөгөөс эхлээд Дархас, Дүлхижег
Өвгөн буурал аавын од галын эзэн
Өлзийт эх чамайгаан нийлэн тахиж
Буурал аавынхаа анд барилдагсан
Буянтай энэ толгойн энгэрт нь
Он бүрийн дэлгэрсэн намар цаг

Олноороо нийлэн дундын бологсон
Од галынхаа эх юугаан тахису

гээд налд өөх тос өргөхөд, бээрээд түлээ тос нэмэн Дүлхижег эмгэн :

Дүлхижег Дархас дундын эх бологсон
Дүрвэлзэгсэн Од галынхаа эхэд
Өөхөн тосон иезн өргөн тахижуу
Өвгөн буурал ав нарынхаан
Өлзий хишиг хураагсан гилбэрт нь
Дэлхийн шим идээний дээжээс
Дэвшүүлэн өргөж хутаг гуйнам
Анчин буурал авын ач үрээс
Анчин буурал ээжийн үр хүүхдээс
Ангуучин буурал авын омогт нь
Ангуужин буурал эжийн үрэст нь
Шилдэг дөрвөн анчнаа сонгож
Шилжүүлэн өргүүлж өгч байнаа
Анд бологсон хоёр ав маань
Ашдын хишиг бидэндээ хайрлаа
Ясан төрөл барилдагсан бидэндээ
Ялгуулсан Од далай эзэн эх маань
Ээл өршөөлөө хайрлан соёрхож
Эгнэгт биднээ тэтгэн хар аа

гээд галдаа өөх тос өргөн дохиход дор нь сууж байсан дөрвөн Дүлхижег анчин ,
Дархас эмгэний талд гарч, галын өмнө сөгдөн , өөх тос хийлээ. Дүлхижег эмгэний
талд сууж байсан дөрвөн эмгэн Дархас ястанд шилжиж байгаа дөрвөн хүүгийнхээ
ард нь сөхрөн сууж, Дархасын гурван эмгэн, нэг өвгөн тэдэнтэй зэрэгцэн сөхрөөд гар
тахигч Дархас эмгэн дуудруун ,

Шил сайт хөвүүдээн мандаа
Шилжүүлэн төрөл барилдагсан
Анчин буурал аавынхантай
Ашдийнхаа бэлгийг зохиож
Өвгөдийнхөө сүлдэнд мөргөж
Од гаоынхаа эхийг тахинам
Анд хоёр яс аймаг бидэн
Амь нэгтэй явахын хутгийг
Айлтган гуйж мөргөнөм
Анд аавын сүлд мэдээ
Од галын эзэн эх мэдээ
сээг сээг сээ – э –эг

гээд галдаа мөргөхөд нь Дүлхижег эмгэн өндөр дуугаар

Саалуу саалуу саа – аа – луу

Гээд галдаа өөх тос өргөн мөргөхөд нь Дархас Дүлхижегийн дөрвөн өрхийн найман өтгөс, агь ганга, өөх тос галд хийж, дөрвөн хvв нь сөгдөн мөргөж галд өөх хаяад, шvхрийн өмнө очиж, хоёр хавтагыг тосоор мялаалаа. Тэгж байтал дээгvүр нь хон хэрээ гааг, гааг, гааг гэж гурвант гааглан нисэж өнгөрсөнд Дархас бvгдээрээ баярлан :

Гааг, гааг , гааг гэж хашгиралдан, өвгөд эмгэд, хон гэрээ гарваль маань хишгээн хайрлаа, хишгээн хайрлаа. Хурай, хурай ,хурай гэж дээшээ идээнийхээ дээжээс цацав. Чингээд ёслол гvйцэж, сахь галын хоёр талаар , настангууд нь дээд талд, залуучууд нь доод талаар сууж, хоёр захынхан нь нийлэн, том тал хvрээ мэт жигдрэн суусанд, хоёр анд ястны шаламгай эмэгтэйчvүд , ясан төрөл барилдах хуримын идээ зуушийг базаан бэлтгэсэн тул загасны чанасан, шарсан, утсан, давсалсан мах, ан гөрөөний болон тураг шувууны чанасан, хорхоглосон, утсан, татсан, янз бvрийн махан хоол, шөл, цангаа хариулах ундаа барьцгаан, хоёр vүрд найрамдуу ястны хvмvүс , хутга тавилгvй мах идэж, хундага тавилгvй тэнхрэл ундаа ууцгааж, өвгөд өтгөс, цөмөөрөө Дархас Бага отгийн эгчмэдийн удирдлагаар хоёр отгийн эмсийн найруулсан тэр сайхан цэнгvүлэгч ундаанд сэтгэл сэргэж, бие чангарсандаа баярлацгаалаа. Чингээд Дархас Их отгийн өтгөс зөвлөлдөөд, ясанд нь хамжсан дөрвөн Дүлхижегийг олонд зарлаж, Дархас яст Цахиурчин Их отгийн Дүлхижег омогтон боллоо. Гээд, дор бvрд нь цахиур чулуун гилбэртэй жад гардуулж, гvйцмэгц, Шонхолой босоод, насаар ахмад нэгэнд

Хорч мэргэн болж
Хотол олондоо өмөг
Харваач мэргэн болж
Хамаг олондоо тvшиг бол
Өмнө зvгийн Чоносоос
Өгч байгаа бэлэг минь
Анд хоёр ястан та бvхэнд
Ашдын тустай юм болог

Гээд нэг нум, хэдэн суттай өгөхөд нь тэр Цахиурчин отгийн Дүлхижег омогт болсон анчин нум сумы нь аваад, чухам яадаг юм болохыг мэдэхгvй, дэмий л эргvүлэн харж, жад гэхэд богинохон бөгөөд нарийхан энэ юу юм бол доо, бороохой гэхэд энэ матигар мод яасан чиг хөнгөн юм бэ ? гэж одоо эцэг нь болсон Цахиурчин өтгөсөөс сэм асуувал тэр өтгөс Шонхолойн харвалыг vзсэн тул, инээмсэрч өгvүлрvүн :

- Энэ гайхамшигч зэмсэг чамд бэлэглэсэн нь манай отог хамгийн тvрvүнд ийм чадалтай зэмсгийн эзэн боллоо. Яаж хэрэглэдгий нь чи мөдхөн vзнэ гэж хэлэхэд нь чийрэг анчин эр, нум сумаа элгэндээ тэврэн, царайд нь баярласан шинж мэдэгдэж

өнгөний дор цомцойн суув. Хурим түр завсарлаж, Дархасын ахмад өвгөн олны зүг хандаж, өндөр дуугаар зарларуун :

- Ах дүү олон бүгд сонс оо . Манай хоёр ястныг эв нийлэн ясан төрөл барилдуулах мэргэн арга зааж өгөөд манай хоёр ястанд урд өмнө дуулдаггүй сонин гайхамшиг нум сум гэдэг сайн эрийн мэхийтэл татаж, санаандгүй хол газар араатан дайсан алин алиныг чиг даран чадах бид бүгдийн зүүд зөнд ороогүй зэмсэг хайрлан гийгүүлсэн Чоносын Шонхолой мэргэн , нөхөд сэлтээр бидэнд нум сумаар харвадаг чадлаа үзүүлэн баясгана. Өлзийт сайхан энэн хуримандаа бид харвал үзээд , сүүлээр нь манай Дархас, Дүлхижег хоёр анд ястны шөрмөстэй бөхцүүл, гарынхаа бөхийг гайхуулан үзүүлж, олныг баясган, эрхэм гийчнээ цэнгүүлнээ , гэхэд нь хоёр Хумка тавин нумны газар гөрөөсний нойтон арьс урт сур аргамжинд тэлэн татаж хоёр талд зогслоо. Шонхолой, гурван сум бүсэндээ хавчуулан, урагш давшиж гурвантаа харавмагц сум тоолон гурын арьсыг шовт харвалаа. Дүлхижег олон, тийм юм огт үзээгүй тул, маш их гайхаж, сум онтуудах бүр хөгшин залуугүй дуу алдан шуугилдаж, Дархас Их отгийнхны олонх нь бас Шонхолойн харвалыг хэдэн өтгөсөөс дуулахаас биш , үзээгүй тул, тэсгэлгүй баярлалдан сонирхов. Шонхолойгоос нумаар шагнуулсан Дүлхижег, тэр харвал үзээд , дэвхцэн баярлаж, яаж харвадагийг заалгасу гэхэд нь Хумка Үхүү би зааж өгнө гэж олны хөл үймээнээс холхон газар аваачив. Харвалы нь сурах гэсэн Дархас, Дүлхижег залуус хойноос нь бөөгнөрөн дагалдтал, бөх барилдана гэж зарласанд, барилдах оноотой хэдэн залуус, арга буюу бөхийн цуглах газар, гэдэргээ эргэн эргэн одлоо. Дархас, Дүлхижег хоёр ястан , гурван өдөр хуримлаж, Үхүү, Гекүү, Залуудай гурван хэдэн хавчаахай нум хийж, Цахиурчин, Шаварчин, Дүлхижег анчинд яаж нум сум хийж харвадагийг заан хуримын сүүлийн өдөр, хоёр ясны эмэгтэйчүүд, хоол хийхдээ Залуудай, Үхүү, Гекүү гурвын гөрөөлж, талын цагаан зээр, тахь, хулан харван гөрөөлснийг дагалцан явсан анчин, өвчин эвдэж, үүрэн зөөж, нум сумны чадлыг гайхан биширчээ. Тэр гөрөөнд бас хэдэн дархас, Дүлхижег анчин ерөөс хээрийн ан гөрөө маш элбэг бөгөөд , сум тусах хэмжээний газар ер ангаас айхгүй харваач хүний гөрөө хийхэд тун ц таатайхан тул, харвал сурч байгаа Дархас, Дүлхижег маш хөгжилджээ. Хуримын сүүлийн өдөр хоёр ясны өвгөд , хэрчлээ модоо барьцгаан Дархас Их Бага хоёр отгоос Дүлхижег ястанд барих бэлгийг нэр дуудан түгээж, мөн Дүлхижегээс Дархаст найрсаг сэтгэлийн бэлэг болгон баоиулах зүйлийг хүн хүнд гаодуулан өгч, бөөн их баяр хөөр боллоо. Гурван хоног найрлан хуримлаж, идээ умдааныхаа сайнаар харилцан дайласан тул, Дархас, Дүлхижегийн бараг хүн бүр тэр гурван хоногийн найр хуриманд зүс нь өнгө орж, хацар нь булцайж таргалцгаан, ирэх жилийн яг энэ үед энэ л Болзоотын бор толгойд баярын царайгаар бүгдээрээ золгож, яс дундын найр хийнэ гэж тогтжээ. Дархас, Дүлхижег хоёр ястан харилцан анд бололцсон тэр Болзоотын бор толгойн энгэрдэх элгэн чулуунд бороо усны дусаалаас нөмөр нэг хөмөгт нь цахиурчин отгийн нэгэн уран өтгөс, улаан зос, өвгөдийн гилбэрт өргөсөн өөх тостой нухан зуураад , далавчаа дэлгэсэн нэг шувуу, нэг араатан зураад, нум сум барьсан гурван хүн бас адуу гөрөөс тэргүүтнийг зуржээ. Нэг дөрвөлжин хүрээн дотор тоо томшгүй олон цэг шиг юм зурж, хоёр хажуу талд нь жад барьсан хоёр том хүн дүрслээд цугласан олон тэр зосон зургийг үзээд , шувуугий нь дархасын хон хэрээ гарваль нөгөө нэг том сүүлт араатныг Дүлхижегийн Үнэгэн гарваль нум сум барьсан

гурван хvний дvрсийг дор нь шавар ваар цахиур гилбэр зурснаар нь Дархасын шаварчин отог Цахиурчин отог гэж таниад дээрээ жижигхэн vнэг шиг амьтны зурагтай хvний дvрсийг Дvлхижег гэж vзvvт танин, Дархасын Шаварчин, Цахиурчин отог, Дvлхижег гурван анх удаа нум сумтай боллоо гэснийг хэлvvлэлтгvй ухаарч, ан амьтаны дvрсийг ангаар баян дөрвөлжин доторх олон улаан цэгийг эв нэгтэй хоёр ястан өнөржин, дөрвөн зvгт тvгэн дэлгэрсээр дэлхий дvврч, гал нь огторгуйн одон мэт олон болоын ерөөл болгож, хоёр хажууд нь хоёр жад барьсан том хvн бол , анд ястнаа тэтгэн хамгаалагч ангуучин буурал аав, Анчин буурал ав гэж зураад, Дархас Дvлхижег хоёрын гарвэлийн дунд нь босоо чихтэй дэлт нэгэн араатан зурсан нь гайхамшигт чадалт нум сум бий болгон гийгvvлсэн Чоносын дэлт чонон гарваль гэж, дор нь нум сум зурсанд , олон бvгдээр тэр зосон зургийг өөх тосоор мялааж гурван хоногийн өлзийт хурим найраа төгсгөн, гурван зvг тархан одлоо.

Их мөрний усанд тулсан хясааны өвөр талд дөрвөн хvнд сайхан таарсан нөмөр хөмөгт нь дэвсгэрээ засаад ёроолд нь галаа тvлж, Шонхолой, Залуудай хоёр нэг оронго хорхоглон боож суув. Гекvv, Үхvv хоёр тvлш базааж хуурай мөд татаж байв. Мөрний зvгээс vдшийн сэрvv татаж, өдөржин сэлж алжаасан аянчинд маш таатай тул, Гекvv, Үхvv хоёр хуурай тvлээ овоолон хураагаад , галын хажууд суун машид амсхийн жаргасан байдалтай, боож хорхоглосон оронгын мах иднэ гэж хамраа сарталзуулан болж байгаа идээний vнэр шиншлэн авай.

- Хvн гэдэг мөн хэцvv аргатай амьтан юм даа. Ийм хурдан амьтныг харван унагаж, ийм сайхан хоол хийх гэж мөн ч сайхан аа. гэж Гекvvгийн хэлэхэд Шонхолой инээмсрэн :

- Хvн яагаад ийм аргатай болсныг чи мэдэх vv ? гэхэд нь

- Үгvй гэлээ.

- Тэгвэл дуулж бай. Анх дээр цагт эвэртэй сvvлтэй, араатан соёотой, жигvvртэй, далавчтай олон амьтанд их тэнгэр арга өгнө. Хэнд нь өгөхийг чуулган чуулж, өөрсдөө мэд гэж гэнэ. Тэгтэл тарвага , арслан, заан, хирис, чадалтан тэнхээтэн мэдэх байлгvй дээ гээд чуулганд очсонгvй. Чуулган тараад нэг угалз ууландаа буцах замдаа, тарвагатай дайралдаж, тарвага

- За, чуулганы сонин юу байна. Арга хэнд өгөхөөр тогтов гэхэд угалз :

- Эвэр сvvлгvй ядуу нэгэндээ өгье гэж чуулганаараа хоёр хөлтөд л аргаа өгье гэж тогтлоо гэхэд тарвага амаа барьж

- Чаа бас даа. Очдог юмандаа би очсонгvй, эвэртэн соёотонд найдаад очсонгvй биш боллоо. Аварга их чадалтан маань бяр их тэнхээндээ найдаад, айхтар амьтанд арга алдчихаж дээ. Одоо даргар их эвэр чинь даваанд, дарвагар том эрvv чинь хоёр хөлтийн ард vврээстэй болно доо. Би бушуухан далд орохыг бодсуу гээд нvх ухаж эхэлсэн гэдэг.

- Тэгээд хоёр хөлтөн бид аргатай болж, арслан , заан, хирис, бух гөрөөс ч хvний арганд орж, уруулы маань өөхөөрөө тостдог боллоо. Хурдан хөлт зээр оронго чиг , хоёр хөлтийн идэш болсон гэж манай өвгөцvvл ярьдаг асан гэхэд нь Гекvv

- Тэр арганд орохгвй юм гэж байх уу ? энэ нартад ? гэж асуулаа.
- Орохгвй юм байхгвй гэж өтгөс дээдэс маань ярьдагсан. Урд гарсан чихнээс хойно гарсан эвэр гэж, уулын цаана уул байдаг шиг ухааны цаана ухаан, аргын цаана арга байх учиртай. Хожим хойнын ач үрсийн арга ухаан нь юутай х болохыг тийм гэж одооны бид таахын аргагвй бий гээд , юм их үзсэн амирлангуй цэцэн нүдээрээ Гекvv, Үхvv хоёрын гайхан сонирхсон гэнэ зальгвй царайг хараад, эцэг мэт энэрэн мишээв.
- Одоо хорхог болж байна. Гээд Гекvv хоёр яаран босож, Залуудайд туслалцан, цахиур хусуур, хутгаар оронгын всийг хусалцан зулгааж цэвэрлэлцэхэд ойн хоёр Хумкагийн дэргэд Залуудай, эцгийнхээ нүдэнд тун сайхан чилгэр биетэй аруухан цэвэрхэн бөгөөд хөдлөх нь уяхан таатайхан харагджээ. Ойн хоёр Хумкагийн бие нь чийрэг шөрвөслөг боловч, нарлаг талын анчин удамтны дэргэд арай л сүр муутай үзэгдэж, зэрлэгдvv шинжтэй ажээ. Тэднийг харж суутал, хоол ч болж сайхан болсон махны үнэр ханхлан , Залуудай, галдаа твлээ нэмээд,
- Аав аа, хоол боллоо шvv гэхэд нь дэргэд нь очиж,бүгдээрээ амтархан идэж эхэллээ. Чингээд, Дархасын Шаварчин омгийн эгчмэдийн зааж өгсөн өвс үндэс тvvж, хатаасан цэцэг жимсээр нь хандалсан умд, шавар ваарнаас аягалан ууцгааж, үлдсэн махаа өглөө иднэ гэж шөнө араатан амьтан хврэхгвй өндөр чулуун дээр тавиад галын дэргэд хврч ирэхдээ Залуудай:
- Энэ хавьд хvний үнэр гарч байна гэж эцэгтээ нам дуугаар хэлсэнд, Шонхолой зовнисхийж, хоёр Хумкагийн хамт галаас баахан холдосхийн, салхи үнэрлэвээс үнэхээр, шугуй бургасан дотроос хоёр хөлтний үнэр гарах ажим. Гекvv, Үхvv хоёр , салхин зvг үнэрлэсхийж байгаад, хоорондоо хэдэн vг шивгэлдэн, Шонхолойн дэргэд хврч ирээд,
- Дайсагнах хvний үнэр арай биш, хэдэн эм хvний үнэр сэнгэнэсхийж байна. Эр хvн байхгвй бололтой. Гэж хэлтэл, хуурай мөчир тас хийн хуга гишгэсэн мэт чимээ шугуй дотроос сонсдов.
- Хvн байвал, наашаа хврээд ир гэж Шонхолойн дуудахад, хариу чимээ огт гарсангвй. Гартаа барьсан нум сумаа газар тавиад, галын зvг найрсгаар дохин зааж, бас хэл нэвтрэлцэх хvн байвал, наашаа хврээд ир гэж дахин дуудваас , тэр үл таних хvний үнэр салхинд ханхалсхийн мэдэгдэх боловч, бас л хариугвй. Үхvv урагш давшиж, өөрийн нутгийн vгээр бас хэдэнv дуудваас, шугуй дотроос нэг жад барьсан навтгар хvн гарч ирэв. Үхvv, Гекvv хоёр бас дахин урин дуудваас , тэр навтгар эмэгтэй, гэдэргээ эргэж хэдэн vг дуугараад аяархан галын зvг дөтлөв. Хойноос нь жад бороохой барьсан арваад хvн, байдлы нь үзвээс цөм хижээл насны буюу нэг хэсэг нь бие бялдарыг үзвээс залуу бололтой эмс дагалдан гарч ирэв. Олонх нь уранхай сармай хувцастай, хөх царайтай хөгшин залуу бөгөөд хvvхэд шуухад дагуулсан үүрсн юм үзэгдэхгвй эмс. Оронгын махны үнэр хамраа сарналзуулан шиншлэн айсаж, байгаа байдлыг үзвэл маш их өлссөн бололтой бөгөөд үл таних хvнийг үзээд баахан эмээх байдалтай боловч, галын гэрэлд Шонхолойн айван тайван амирлангуй царай, найрсаг байдлыг үзээд эмээх найрсаглах сэтгэл хутгалдан буй ину хөх царайд нь тодорхой үзэгдэм. Наашаа ирж сууцгаа. Бид та нарт гэм болохгвй, аяны явуул улс гэж Шонхолойн хэлэхэд , хэлий нь мэдэхгвй боловч дууны өнгө байдлаар хорлох муу санаагвйги нь тэр ойн эмс танин мэдэж галын зvг дөтлөн

ирэв.

- Наашаа суу гэж Хумкагийн зааж , галын дэргэд суухад тэдгээр эмс эгчмэд эмийг дагаж галын дэргэд сууцгаав. Чингээд өлөн нүдээр ийш тийш харж саяхан цадтал мах идсэн хvнээс тос нөнжигтэй идээний vнэр гаоч буйн дээр гал удтал vзээгvй байдалтай галын нөлөөнд их л таашаан баярлаж элгээ ээж суухад нь Шонхолой өрөвдөж, Залуудайг

- Өнөөх vлдсэн махаа эдэнд өгч, санамсаргvй гийчинтэйгээ идээгээ хуваалцья гэхэд нь Залуудай төдхөн мах тавьсан чулуун дээр авиран гарч , Гекvвд доош нь буулгаж өгсөнд, мах хараад, тэдгээр ойн эмсийн нүд гялалзаж, маасганан инээмсэглэцгээлээ. Шонхолой хутгаа авч , эгчмэдээс нь эхлэн хvн бvрд хувь хvртээж өгсөнд , цөм тэсгэлгvй баярлацгаан маш өлссөн байдалтай, жигтэйхэн амтархаж идэцгээлээ. Дөрвөн аянчны идээд vлдээсэн оронгын махнаас vлдсэнийг нь идээд цадсангvй боловч өл залгаж, дотор нь онгойсон бололтой . Ингээд нэг хоёроороо усан дээр очиж ундлаад галын дэргэд хvрч ирэн сууцгааж, Шонхолойг ахмад хvн юм байна гэж тэдгээр ойн эмсийн эгчмэд нь таньж маш найрсаг байдалтай инээмсэглэн хэдэн vг хэлсэнд Гекvв ,

- Эдний vг нь манай Хумкагийн vгтэй нилээд ойролцоо. Ер тойм төлөвийг мэдэж болох юм байна. Галынхаа дэргэд хонуулах гэж хоолноосоо өгөлцсөнд баярлаж байна гэж хэлж байгаа болотой гэхэд нь Шонхолой,

- Эд чухам юун улс, яагаад дан эмс, эрэгтэй хvн нэг ч vзэгдэхгvй байгаа юм бэ ? Отог гал нь хол уу ? гэж асуулгасанд Гекvв, Үхvв хоёр даруй хэл залгаж, тэр эмэгтэйд Шонхолойн vгийг дохио хавсран нэвтрvвлэл эгчмэд нь гар дохин нvвр царайн хөдөлгөөн оролцуулан нэгэн хэсэг юм тоочиж, заримдаа босон харайж, ноцолдон тэмцэлдэж байгаа зэрэг байдал vзvвлэн ярив. Гекvв Үхvв хоёр заримдаа дахин дахин юм асуун , рхарилцан дохилцож, бусад эмэгтэйчvвд нь эгчмэдийнхээ хэлж байгаа vгэнд нэмэр оруулан, хажуунаас нь өлгөж аваад юм хэлэх дохих байдал нь хэл мэдэхгvй хvнд чтойм төлөв нь ямархан нэгэн дайснаас тутан дvрвэсэн бөгөөд гал алдаж зvдэрсэн байдалтай бололтой. Тэлгээр ойн эмсийн эгчмэд нь vг яриагаа төгсгөөд хөдөлж халсандаа хөлс цуварснаа арчаад, галын дэргэд суун, Шонхолойн өөдөөс маш дотно элэгсэг бөгөөд талархсан байдалтайгаар харав. Гекvв , Үхvв хоёр бие биендээ элбэж, тэр эмэгтэйн хэлсэн vгийг Шонхолой, Залуудай хоёрт дохио нэмэрлэн нэвтрvвлэхэд ойн эмсийн эгчмэд нь Гекvв, Үхvв хосрын ам царайг ажиглан харж, зарим газар толгой дохин , зарим газар гар бие хөдлөн юм дуугарч суув. Аялгуу баахан өөр тул vг бvрийг эс нэвтрэвч Үхvв, Гекvв хоёрын тоймлон ухаарсан нь урин дулааны цагт эочvвл нь тусдаа хэрэн хэсдэг, эмцvвл нь тусгайдаа бидэн аж төрдөг бөлөг улс ажээ. Чингээд дайсагнах нэгэн аймагт эмэгтэйчvвд нь дайруулж нэг хэсгийгээ олзлуулаад, вааран саванд авч явдаг галаа алдаад дахиж гал олж чадахгvй, сандан мэндэн дутаах вес хvвхэд шуухадаа хvртэл хаяцгааж, амь бултан гарсаар огторгуйд тэргэл сах гурван удаа гарахыг vзсэн. Тэр завсар их мөрөн дагуу тvвхий загас, дийлэх нэг амьтнаа агнаж, тvвхий махы нь идэн амьдарсаар иржээ. Эрэгтэйчvвлээ эрээд олсонгvй, гагц хэдэн хvвр vзсэн. Мөн өнөөх дайсан аймагт дарагдан сарниж зайлсан бололтой гэж ярьж байгаа болотой хэмээн Шонхолойд сонсон ухаарснаа нэвтрvвлэн хэлэхэд Шонхолой тэднийг тэсгэлгvй

өрөвдөж, уранхай ноорхой, тамтаг болсон хувцас хунар, ядруу муу бороохой, ур хийц муутай чулуун гилбэртэй богино жад шиг зэмсгий нь хараад сүүрс алдаж,

- Эр эмээрээ салангад явдаг аймаг байдаг гэж би дуулсан. Тэдний нэг нь эд байж л дээ. Тун ч хөөрхий улс байна даа. Цахиур чулуу хавирч гал гаргах арга бид зааж өгсү гэж хэл гэхэд нь Гекvv, vxvv хоёр vг дохио хавсран нэвтрvvлбээс, тэр ойн эмсийн эгчмэд нь машид гайхан, яаж чулуунаас гал гарч болдог юм бэ ? гэж асуув. Шонхолой, цахиураа авч, бяцхан хавтган дотроосоо уул гаргаж, цахиур хэд хавираад, уул нь уугиж , өвс хялгананд хавчуулан vlээж, гал асаасанд тэр эмс бvгдээр гайхан сочиж, нэг нь vнэхээр гал юм уу ? гэж хуруугаа галд хийж халаад дуу алдан яаран гараа татсанд бvгдээрээ инээлдэв. Чингээд ойн эмсийн эгчмэдэд хавтганаасаа бас цахиур гаргаж өгөөд цахихыг заахад анхандаа чадахгvй, тийм жижиг юм бараг барьж vзээгvй, тун мулгуу тулгуу байвч, сурахыг vнэхээр хичээж xvvhэд шиг сонирхон цахиж, оч гяласхийхэд баярлан, аман дотроо юм гvнгэнэж байв. Чингээд яаж уул хавчин барьж цахиур хавирахыг заалгаад, нэгэнт оч, уул дээр нь тусаж уугисанд, дэргэд нь овооролдон цугласан эмс бvгдээр баярлалдан дуу алдав. Чингээд цахиураар ноцолдсоор мөддөө салах шинжгvй байхад Шонхолой, маргааш уул яаж хийдгийг зааж өгнө гэж Yxvvгээр хэлvvлээд энэ орчим дайсагнах хvн , том араатан байхгvй биз гэж асуулгахад ойн эмс, ойр хавьд өөр хvнийг vзээгvй. Том араатан ч байхгvй гэж хариулаад, араатнаас чоно л бий гэж нэг эмэгтэй нь яг чоно шиг улин дvрслэв. Гараараа дохиж, арслан заан, хирисийг асууваас, арслан заан хааяа дайралддаг. Хирис байхгvй гэж хариулсанд , араатан дайснаас айлтгvй юм байна гэж Шонхолойн сэтгэл амрав. Унтахыг завдаж дэвсгэр зассан газлраа очиход нь ойн эмсийн эгчмэд нь нэгэн эмд юм хэлж , галын дэргэд мануулан суулгаад, бусад нь гал тойрон хэвтэцгээсэнд Шонхолой энэ шөнө манаатай боллоо гэж санаа амар унтав. Нойр нь сэргэг тул шөнө хэдэн удаа сэрээд харваас ойн эмс ээжлэлдэн гал сахиж, шөнөжин гал өрдөн байгаа нь харагдав. Өглөө босоход нь ойн эмс хэдэн том гэгчийн загас галд шарах нь шарж, булж болгох нь болгож, алдсан галаа отсондоо их л бахархаж, дөрвөн анчныг идээнийхээ дээжээр хvндлэв. Чингээд Шонхолой Yxvv хоёр нэгэн хэсэг бор гөрөөс ойн захад vзэгдсэнийг гөрөөлөх гэж очоод төдхөн нэгийг харван унагаж авцарсанд ойн эмс , харвал vзээгvй тул маш их гайхаж, Yxvv, Гекvv хоёроос яаж ингэж чулуудаад гэм хvргэхгvй хол газраас амьтан жадлан унагадаг юм бэ? гэж асуун сонирхож нум сумы нь ямархан энэгн догшин амвтан адил vзэж, эмээсхийн болгоомжлох боллоо. Тэдгээр ойн эмсийн эгчмэд нь сvрхий ухамсар хvн тул бусад эмсийн бор гөрөөсийг шарж болгох завсар Шонхолойгоор заалгаж цахиурын уул хийхэд хэрэглэдэг өвс мөөг танин мэдэх болж, Yxvvгээр хэлvvлэн , яаж уул хийдгийг заалгаж авав. Тэр завсар мах ч болж, цөмөөрөө идэцгээгээд, Шонхолойг тэр ойн эмстэй салах ёс хийгээд явах гэхэд Гекvv

- Эд биднийг дагаж явсуу гэж байна. Танихгvй газар бидэнд бас нэмэр болох юм биш байгаа гээд Шонхолойн өөдөөс харахад нь

- Манай завьд эд яаж багтахав гэхэд Гекvv , усны захаар явахдаа яасан чбиднээс гээгдэхгvй гээд, ойн эмсийн зvг хэдэн vг хэлэхэд , тэр бvгд Шонхолойн зvг хоёр гараа сунган гуйх байдалтай дор дороо юм шулганалдаж, эгчмэд нь жадаа барин , дайсан дайралдана гэсэн юм шиг хатган чичих дvр vзvvлэн юм хэлэв. Yxvv хэлмэрчилж,

- Бидэнд тусалсан та нарыг бид дагдан явж, дайсантай тулах цаг тохиовол ухралтгүй тулна. Бид хамт явья. Та нарт бид саад болохгүй. нэг хэсэг газар ч мэднэ. Галы тань сахиж хоолы тань хийж явсу гэж байна гэхэд нь Шонхолой өрөвдөн зөвшөөрч,

- Ганц хvн - хvн болдоггүй, ганц цучил гал болдоггүй гэдэг билээ. Бие биендээ тvшиг болж яваад vзсv гэж, завьдаа суутал Гекvв эргээр тэр ойн эмстэй явж, хөлийнхээ чилээ гаргана гэж, тэдгээрийн хамт нум сумаа барин явжээ.

Ойн эмс өлсөх цангах, ядах зvдэхийг энгvвн хэрэг гэж бодох, маш хатуужилтай бөгөөд загас барих, идэх, vндэс төмс тvвх, хирэндээ таарсан ан агнахдаа дадлагатай, аргагvйд хvрвэл араатан дайсантай чулахаас буцахгүй, хатуужил зоригтой тул, дөрвөн аянчинд нэлээд бvл хань болж, адаг наад зах нь шөнийн хоногт тvлээ тvвх, араатан тэргvвтнээс ээлжлэн манаж сэрэмжлэхэд тус нэмэртэй байлаа.

- Нөхрийн тус бvтвэл, өөрийн тжс бvтнэ гэж энэ дээ. Гал алдсан энэ хэдэд бид цахиур хэрэглэж гатай болох арга зааж өгсний хариуд эд бас бидэнд хvч нэмэр болж, танихгүй газар олон араатан амьтны дунд амиа бvгдээрээ нийлэн хаацайлахад бас тус болж байна шvв. Хvн хvндээ тус болохыг бодож явах ёстой юм шvв хvв минь. Гаднаа болгоомжилж хар санавч, дотроо цагаан санаатай, амьтанд туслахыг vргэлж бодож явах ёстой юм шvв гэж Шонхолой хvндээ сургаж, эцгийн амьдад газар таньж, хvнд тус болохыг ёс болгож явах хэрэгтэй шvв гэж vйсэн завьдаа хоёулан эргийн ойр гvехэн шиг газар ээлжлэн хатгаж явахдаа эргийн дагуу цуван явж байгаа ойн эмсийг харан хэлж, наран шингэх тийш хандсан тул, бор хоногийн газар шинжиж явав. Ойн эмс бас амь хоргодож шөнө элдэв араатнаас айлтгvй хонох газрыг шилж сонгохдоо сайн тул, тvрvвлэн явсан нэг эмэгтэй буцан ирж, хоноход тохиромжтой нэгэн газар олсноо мэдэгдэв. Чингээд тэр газрын тушаа завиа хатгасаар ойртвоос хэдэн залуу эмс, хэдийн хуурай мод тvлш базаан овоолж, явах зам дагуу тvвсэн мангир гогод, цагаан төмс, сараана зэргийн хоолны хачир бас vйсэн саваар жимс тvвснээ нэг газар овоолоод, арын завьд Үхvв, Гекvв хоёрын өдөр агнасан галуу нугас, Шонхолой, Залуудай хоёрын ясан дэгээгээр барьсан загас хvрч ирэхийг хvлээн тосож байв.

- Чингээд ойн эмсийн эгчмэд нь цахиур хавирч, гал асаахдаа тун чадамгай болсон тул, хоёр завийг эргийн зvг хvрч ирэхэд хэдийн гал асааж, хvлээн тосож хэдэн эмэгтэйчvвд, завиас загас шувуу буулгаж, өд сөд, гэдэс доторы нь арилгаад хоол хийх завсар Залуудай эргийн дагуу өгсөн явж байтлаа, элсэн дээр хэдэн хvний хөлийн мөр vзэж, гэдэргээ гал дээрээ буцаж эцэгтээ хэлсэнд ойн эмсээс тэр зvг явсан эсэхийг асууж, бvгдээр тэр мөрийг очиж vзвээс, хэдэн хөл нvцгэн хvний мөр эргийн дагуу чийгтэй шиг газар гишгэсэн зарим нэгэнд нь дороос нь ус нэвчин гарч ирсэн байдлыг ажваас, арай ч цоо шинэ мөр биш бололтой.

- Юу ч гэсэн өчигдрөөс хэтрээгүй мөр бололтой. Үвгээр хvн өнгөрөн гарсан нь осолгүй боллоо. өнөө шөнө тэргэл сартай. Бас нар арай шингээгүй байна. Газар нь гайгvй цагаан ширэнгэ модгvй, уул тал, төөрөх аюудгvй. Би мөрөөр нь баахан хөөгөөд vзсv гэхэд нь Залуудай эцэгтэйгээ явалцана гэж хоёулаа явах болсонд

Хумза ойн эмсээс нэгийг дагуулан явалцъя. Отог дээр Үхvv эр хvйстээс vлдэг гэж ойн эмсийн эгчмэдтэй явахаар боллоо. Үлдэгсэд нь тvvсэн тvлээ, унасан мод бургасаар хоногийнхоо газрыг хашин болгоомжлох ажил хийцгээж, мөрчин, өнөөх vл таних хvний мөрөөр чиглэн явсаар асар удалгvй нэг хадан хошуу даваад , нэг уулын цавд ажваас гал уугиж буй бололтой , утаа суунаглаж буйг vзээд, орчин тойронд хvн амьтан vл vзэгдэх цагаан газар тул , тэр утаа суунаглан буй газар зvглэн одов. Алсаас ажиглан харваас , галын хавьд хөдөлж байгаа хvн амьтан харагдахгvй сайн харахад , халын хажууд нэгэн хvн хэвтэж буй мэт vзэгдэнэ. Ажин ажин ойртвоос ганцхан хvн хэвтэж, орчин тойронд нь өөр хvн огт харагдахгvй. Бvр дөтөлж, дэргэд нь очвол отог дээр нь орхиод явсан нэг хvн . Хажууд нь хоёр мод зөрvvлээд, нэг салаанд нь бургас сvлжиж, суудал засан хийсэн нагшуурга . Тэр хэвтэж байгаа хvний дэргэд vйсэн савтай ус, нэг утсан загас тавьжээ. Тэр хvний байдал маш эцэнгэр. Дэргэд нь хvн ирэхэд толгой өндөсхийн хараад огт дуугарсангvй. vг асууваас тэр өвчтөн хvний хариу бvгдэд дуугарах vг нь огт мэдэгдэхгvй, хэл нэвтрэлцэхгvй хvн байжээ. Арай чvv гэж өндийх гэхэд нь Шонхолой тvшин суулгаваас, тэр өвчтөн хvн, хоёр гарын хуруугаар нар дvрслэн нар хэлбийж байх вес гэж тэнгэр заагаад уул даван явсан хэмээн дохиогоор заасанд , нар шингэхээс өмнөхөн отгийн хvmvvс зайлан одсон гэдгийг мэдэв. Чингээд тэднийг буцаж ирэхийг дохиогоор асууваас, толгой сэгсрэн, буцалтгvй явсан гэж дохисон тэр дохио, өвчтэй тэр хvний гунигт царайн байдлаар ориход явсан гэдэг байдал илт мэдэгдэн, тэр хvн дэргэд нь хэвтэж байгаа шагшуурга заагаад , тvvнийг гээн хаясан байдлыг дохин vзvvлж, бөгсөн бие огт мэдрэлгvй болсныг заан дохисонд, тvvний садан хvmvvс, хөлгvй болсон хvнээ нагшуургаар чирч явсаар , сэхэх төлөвгvйд отог дээрээ хоцоргон нар шингэхийн өмнөхөн урт мод давхарлан нэг гал тvлж өгөөд, устай сав, ганц загас дэргэд нь vлдээн өвчтөн хvнээ найдах горьгvй болсонд салан хагацсан байдал ил боллоо. Отог дээрээ хоцорсон тэр эрийн бие маш бие маш эцсэн боловч, уг нь их чийрэг хvн байсан шинжтэй бөгөөд дохиогоор бух гөрөөсөнхд мөргvvлж бэртсэн гэж том эвэрт юманд мөргvvлсэн хэмээн зааж, дэргэдээ хэвтэж буй нагшуургаар чирvvлж явснаа хуруу чичин заагаад биеэ заан, хуруугаар нар дохин шингэж буйг дохин vзvvлж, насны наран шингэх цаг ирснээ мэдэгдэн, Залуудайг заан , нар нь эрт байна гэж дохиод сулхан инээмсэглэж гар занган, шингэж буй нар дvрслээд, биеэ заан Залуудайн зvг нар дvрслэснээ өгөх шиг дохисонд , нас залуу нар эрт Залуудайд насалсан насаа нэмэн өглөө гэдэг утгатай дохиогий нь цөм ухаарч, Залуудай тун чөрөвдөн, нагшуургы нь зааж , суулган чирч аваачна гэж ирсэн зvг тийшээ дохиход нь инээмсэглэж толгой сэгсрэн биеэ заагаад , газар зааж нvдээ аньсанд энд л vхэх цагаа хvлээн хэвтэнэ гэсэн дохиогий нь ухаарч, отог халуунаасаа хагацан , эзгvй буйд газар vхэх гэж шийдсэн санаагий нь мэдээд, тун чөрөвдөж элэг эмтэрлээ. Цагаа хvлээсэн тэр эрийн дэргэд нь том бороохой, бvдvvн цахиур гилбэртэй жад, цахиур цохиж хийсэн урт иштэй сvх тавиастай байгаа нь , ишинд нь цөм ямархан нэгэн иртэй юмаар цохиж шарх оруулсан байдалтайг vзвэл, эзнээ дагаж vйлчлэг гэж зэмсэгт нь шарх оруулж, « vхvvлэн » Сvнсий нь эзнийхээ сvнсийг тосон vйлчлэхэд бэлэн болгосон байжээ. Ойн эмсийн эгчмэд, тэр хvний өмнө сөхрөөд, мөхийн дохиж, аман дотроо хэдэн vг хэлэхэд, Хумкаа, сvнсий нь бидэнд сахиус бол гэж мөргөж байна гэж Шонхолойд хэллээ.

- Газрын ёс. Бэртэж, хvн болохоосоо өнгөрсөн буюу өвдөж, отог садандаа тээр болоод ирэхэд нэг хvний төлөө цөмөөрөө баларч vхсэнээс, амьд vлдэх нь амьдын зам, ан гөрөөгөө хөөгөөд, vхэх нэг нь отог дээрээ хоцордог ёстой бид яахын ч аргагvй . Буцахаас өөр аргагvй гэж хэлээд, Шонхолой – ядахдаа энэ хөөрхийн галы нь засаж өгсv гээд, урт мод цувуулан , дээр дээрээс нь тавьж, ёзоор талаас нь асаасан галы нь сэргээж засахад , Залуудай эцэгтээ туслалцаад, vйсэн савтай усы нь ойртуулан тавьж өгснөө, бvснээсээ сураар өлгөн зvвсэн цахиур хутгаа авч тэр хvний дэргэд тавихад нь тэргэл сарны гэрэлд тэр хvн тал өгсөн байдалтай инээмсэглээд, эмтлээд орхи гэж гараараа дохив. Нөгчих гэж байгаа тэр хvний хvсэл ёсоор нь тэр цахиур хутганы бариул тушаа нь эмтэлсхийгээд дэргэд нь тавихад, тэр хvн, бэлхvвсэн тушаагаа тэмтрээд, арслан зааны соёогоор хийсэн жадны гилбэр гаргаж, өөрөө хийсэн юм гэж биеэ заан, Залуудайд сарвайн өгсөнд аргагvй, талийх гэж байгаа тэр хvний эцсийн бэлгий нь эр хvнд жр хvний өгдөг бэлгийн дээд гэж хоёр гараар тосон аваад, нvднээсээ нулимас бөмбөрvвлэхэд тэр хvн, дахин биеэ нэг заан, нvдээ анин газар заагаад, Залуудай нарыг буцагтун гэж дохиод аяархан гэдэргээ хэвтээд нvдээ анив. Чингэхэд нь арга буюу дэргэд нь баахан зогсосхийж байгаад, чимээгvйхэн эргэж буцан одоцгоолоо.

- Ан амтныг агнан алж, бас дайсагнах аймагтай тулалдан, vхэхийг олонт vзсэн Шонхолой Залуудай нар, отог дээрээ хоцроод, vхэх цагаа маш хатуужин хvлээж, насы минь залган аваарай гэж дохиогоор ерөөгөөд , амь хагацаагvйдээ биедээ бvтнээр нь хадгалж, төрлийнхөө хvнд vлдээх гэж хадгалж байсан ганц хайртай зэмсгээ урд зvс vзэж таниагvй Залуудайд эр хvний эцсийн бэлэг болгож өгсөнд нь сэтгэл догдлон хөдөлж, тэр галын дэргэд амьсгалынхаа тоо барагдахыг хvлээн хэвтэгч эрийн зvг толгой дохин ёслоод, бvгдээрээ хоног буудлынхаа зvг дуу чимээгvй буцан одлоо.

- Мэдсэн бол, тэнхрvвлэх ундаа найруулж өгдөг юмсанж. Өвдөх эвэршээхий нь тvр чгэсэн намдуулж, биеий нь амасхийхэд тус болох асан гэж Залуудайн хэлтэл тэр уулын цавын адгаас цөөвөр улилдах дуун дуулдахад, Шонхолой сvврс алдан
- Одоо удаан эвэршээж зовохгvй боллоо. Өглөөний ургах нар vзэхгvй болсны дохио нь гарч байна. Галын дөл намжисхийхэд , энэ олон цөөвөр нөмрөн хvрч ирээд эцэс болгоно доо гээд, дөрвvвл буудалдаа хvртэл чив чимээгvй, тэргэл сарны гэрэлд алхав.

- Одоо энд нэг vдэлдэг байгаа гэж Шонхолой завиа их мөрний нэгэн тохойн эргийн зvг залж, усны шувуу маш олон харагдаж байгааг гөрөөлөх гэж дөрвvвлээ завиасаа гарцгааж, эргээр яваа ойн эмсийн нэгэн хэсэг нь тvлш базаах гэж, нэг зарим нь хоолонд амт оруулах ногоо тvvx гэж тархтал гэнэт нэгэн эмэгтэй хvн муухай бархиран ёолох чимээ гарч, ширэлдэн ургасан боролж өвсөн дундаас ойн эмсийн нэгний царай vнсэн хөх, маш сандарсан байдалтай хvрч ирэн, гvйж ирсэн зvг тийшээ заан юм шулганахад Хумка хирдхийн сочиж , том эрээн араатан , энд нэг хvн барьжээ гэж тэр эмэгтэйн vгийг Шонхолойд уламжлав. Яаран сvх , нум сумаа шvврэн тэр эмэгтэйн заасан зvг шамдаж очтол , сөөг боролж дунд нэг том шар эрээн юм vзэгдэж, амандаа нэг амьд эмэгтэйг зуугаад хvнээс огт айхгvй явах нь vзэгдэв.

Барын аман дахь тэр эмийг үзвээс , ойн эмс биш, өөр танихгүй нэг эмэгтэй ажээ. Хүн хараад , юм хэлж хажиграх нь амь авар гэж байгаа хөөрхий бололтой. Шонхолой ухасхийн , тэр барын зүг яаран давшваас, хойноос нь Залуудай Гекүү хоёр гүйж, сум харвам газар ойртохтой зэрэг гурвуул харваж, хойноос нь бас Үхүү гүйцэж ирэн бас хашхиран харвасанд , дөрвөн сум цөм тэр барсын гэдэс зоонд шигдлээ. Барс амандаа зууж явсан тэр эмэгтэйг газар хаяад урхиран эргэж, дөрвөн анчны зүг дайран орох гэлээ. Ойн эмс, Шонхолой хойноос бороохой жад барьцгаан дагаж гүйдэн айстал хэд дүвлээд барс, түрүүлэн гүйсэн Залуудайд нилээд ойртон хүрч ирээд, сүүлээ шарван үсрэхийг завдал бас дөрвөн сум тусаж ыарс урхиран дүвлтэл, Гекүү завдан харавсан нь сум, санамсаргүй барсын ангайсан аманд шаав. Догшин араатан урхиран үсэрсэн нь дуу нь тасалдаж, дүвлэн үсэрсэн нь, олон сумын шарханд бас аманд нь шигдэн орсон сумнаас ч болж, Залуудай дээр буух гэсэн харайлтын эрч нь дутаад хажууд нь буутал, Шонхолой хүндээ аюул тусахыг зайлуулах гэж яаран ухасхийж, барсыг дахин босон өндийж дайрахаас урд сүх далайн толгой дээр нь буулгасанд, Залуудай бас жадалж, бар эргүй туссан юм шиг дороо эргэлдэв. Үхүү сүхээ далайн зоон дээр нь буулгах гэтэл , сүүлд нь нүдээ ширвүүлэн ойчоод , заяатай хөл дор нь орсонгүй. Завшаанаа өнөөх барт зуулгасан эмэгтэй угз татан мулталж зайлуултал, Шонхолой барын зоо руу нь сүхээ буулгаж, догшин эрээн араатны хоёр хойт хөл нь мэдээгүй болж бөгсөө чирэн хоёр нүд нь толгойноос гоожих цусанд юм харахгүй боллоо. Ойн эмсийн эгчмэд жадаа барин гүйж анчин дээр хүрч ирээд, барын өвчүүг жадалтал, жадын ишийг хуга алгадаж орхисонд эгчмэд түрүүлэн ойчиж, бар өрөөсөн хөлөөрөө нуруун дундуур нь дараад хөлий нь үнхэх гэтлээ амнаас нь цус олгойдон шилэн хүзүү нь татав. Тэр самбаанд Үхүү хойт хөлөөс нь угз –татан, санд мэнд дайрсан хүчиндээ барбг элгээр нь өөд харуулж, ойн эмсийн эгчмэд нь Залуудайд татуулан аюулт амьтны савраас мултрав. Бар тийчигнэн таталдаж, нэгэнт хүнд хор хүргэж чадахгүй болсонд , толгой руу нь Шонхолойн хэд сүхдэхэд чичив татав хийгээд хөдлөхөө байжээ. Араатан дайснаа дараад дөрвөн анчин, өөд өөдөөсөө харваас, цөм тэвдсэндээ хар хөлс асгажээ. Бэртэж гэмтсэн хүн бараг байхгүй, ойн эмсийн эгчмэд, барын хүнд саварт бага сага маажуулсхийвч, гэм болсонгүй нуруун дундуур шийдмээр татуулсан юм шиг хүнд хөлд нь алгадууллаа гэж нөгөө зуулгасан эмэгтэйг үзвээс бас онцын бэртсэн зүйлгүй. үг нь ойн эмсийн аялгуутай бараг нийлсхийх тул, жимс түвж явтал, араас нь нэг юм ёврон түлхэж унагасан шиг болоод, нүд харанхуйлж, дотор аягүй болоод, ухаан ороход , аюултай том эрээн амьтны аманд зуулгаастай , мануулд зуулгасан бозлог шиг , толгой хөл унжин ухаан саруул, ингээд л үхдэг цаг боллоо гэж дуу чимээ гарч бархирлаа гэж ярьжээ. Гекүү , барын сүүлд нүүрээ ороолгон ойчоод араараа газар цохиж ойчихдоо дотор харанхуйлсан гэж барын зүг гар зангидан занаж, сүх барин, дөрвөн хөлийн савар, амны нь дөрвөн соёог мулт цохиж аваад, Шонхолойгоос тэр савар соёог би авбал яана гэж гуйлаа. Чингээд барыг өвчтөл, баруун суганд нь идээлэн баалсан хуучин шархтай. Тэр шархнаас нь бүдүүн хийцтэй царуур чулуун гилбэрийн хугархай гарчээ. Бүгдээр тэр хугархай чулуун гилбэрийг сонирхон үзтэл, барт зуулгасан эмэгтэй , тэр гилбэрийн хугархайг хармагц цочин дуу алдаад, юм хэлсний нь Үхүү Шонхолойд уламжилж, эцэг нь хавар анд яваад үгүй болсон юм. Жадны нь гилбэр энэ мөн байна гэж таньж, эцгийгээ барт осолдсоныг мэдлээ гэж байна хэмээн хэлж өгвөл, чингээд манай отог дээр хүрч очно уу. Эндээс

холгвй. Нөхөр анд гарсан. Отог дээр эх, нэг жаал хvvхэдтэй бий. Бас хэдэн айл бий гэхэд нь өөрийнхөө буудлыг арай ойр байх гэж буусан газар тийшээ тэр барсад хэлмэгдсэн эмэгтнийг ойг эмсээр твшvвлэн аваачив. Хvнд шарх олж идээлж баалснаас болж, хурдан хөлт анг гvйцэхгvй тул, хvнд халдах болсон махчин бар байжээ , гэж Шонхолой тэр барын арьсыг эцгийн чинь өшөө авлаа. Одоо энэ барсны арьсыг эхэд чинь аваачиж өгье, дэвсгэр хийг гэж хэлvvлээд, загасчлаар одов. Их мөрөн загасаар элбэг тул, удалгvй дөрвөн анчин загас сэрээдэж, нум сум вээгvй галуу хvнээс бараг айхгvй тул , хэдэн галуу харвацгааж, өдрийн хоолны юмтай болоод , тврvvчий нь ойн эмс гэдэс дотры нь цэвэрлэж болготол бас хэдэн загас барьж, Үхvv, Гекvv хоёр хэдэн галуу нугас харваж, элбэг хоолтой болсон тул , тэр барст зуулгасан эмэгтэйд хэдэн загас бургасаар холбон өгч, бvгдээрээ хоол идэцгээн твр амсхийх завсар дөрвөн анчин ойн эмсийн эгчмэдтэй хамт тэр бараас амий нь аварсан эмэгтэйг отог дээр нь хvргэхээр одов. Зам зуур асууваас, тэдний отгийн хvmvvc өглөө буудаллаж, эр хvйст нь цөм анд яваад, хvvхэд шуухалтай эмс vлдэцгээн, тэр эмэгтэй, жимс ногоо тvvх гэж гарсан хvн байжээ. Чингээд отогт нь ойртон хvрч ирэхэд, гэнэт vл таних хvн хvрч ирсэнд отгийн эмс хvvхэд сандран ёочсон боловч, өөрийнхөө эмэгтэйг хамт айлтгvй явалцаж буйг вээд амсхийж, найрсаг байдлаар угтан тосоод, өнөөх эмэгтэйгээс барт зуугдаад, эдний ачаар амь гарсан гэхэд нь бvгд баярлацгаав. Тэр эмэгтэйн эх болох нэгэн настай бvсгvй, нөхрий нь идсэн барсын арьс гэдгийг сонсоод, всээ vгтээн уйлж, барсыг хараан зvхэж, арьсы нь хөлөөрөө дэвсэн дэвсэн аман дотроо юм vглэж хайлав. Отгийн эмс бvгдээр тэр барсын арьсыг дэвсэн цавчиж шуугилдав. Хvvхэд шуухад хvртэл барын арьсан дээр дэвхцэжтомцуулыг дууриан юм хашгиралдан шуугиж байтал, нэгэн хижээлхэн эмэгтэй , дөрвөн анчны зvг толгой дохин дохин юм хэлэхэд Үхvv хэлмэрчилж, өстөн дайсныг өрлөж өгсөнд тал өгч байна. Дайсныг нэгэнт дарж өгснөөс хойш дахиж маньд хор хvргэхгvй болгон дарж өгөөё гэж гуйж байна гэхэд нь Шонхолой тэр барын зvрхий нь авч ирсэн тул , тvvнийг өгч,

- Анчиндаа өгч, бvгдээрээ хуваалцан идэж барс шиг зvрхтэй бол. Зvрхээ идvvлсэн бар , зvрх нь vхэж, та нарт халдахгvй болно гэж хэлсний нь Үхvv нэвтрvvлж хэлбээс, бvгдээр баяр хөөр болцгоов. Чингээд анчныг зочлох гэхэд өөрсдийн нь анчин нэгэнт ан гөрөөнөөс бууж ирээгvй. Амсуулж барих юм байхгvй, гар хоосон шахуу тул, гагцхvv тvvсэн жимснээсээ вйсэн саванд хийж барихад , тvvнээс нь ам хvрээд буудалдаа буцах гэхэд нь тэр барт зуулгасан эмэгтэйн эх нь ач хvvдээ эхийн амь аварсан Шонхолойн нэрийг өгсv гэж гуйн нэр асууваас, Шонхолой гэхэд

- Сонколой, Сонколой гэж хэд давтаад, ач жаалаа тэврэн, Шонхолойн суганд толгойгий нь хvргэн юм хэлэхэд Үхvv,

- Сонколой ач хvvгээ ачит баатар аавын өндөр цээ, өргөн суганд нь твшvvллээ. Эр зориг, насны хишиг гуйж байна гэхэд нь Шонхолой , тэр жаалын духы нь таалаад,

Эр их зоригтой
Бяр их чадалтай
Уужим дотортой
Ухаан ихтэй
Урт настай
Цдаан жаргалтай

Сайн хvн болж
Садан олноо жаргуулаарай

гэж ерөөсөн vгий нь Үхvv хэлж өгөв. Отгийн эмс цөм мэхийн дохиж дор бvр юм дуугарсанд, Үхvv хэл залгаж, ерөөл бат орштугай гэж байна хэмээв. Шонхолой нэг чулуун зэв бvсэндээ агссан агсаанаасаа гаргаж тэр жаалхvvд өгсөнд, сайхан цохилж хийсэн тэр хөөрхөн тунгалаг чулуун зэвийг ер урьд өмнө огт vзээгvй тул , бvгдээрээ гайхан баярлалдаж, бие биедээ дамжуулан vзэцгээв. Чингээд бvгдээрээ өлзийт зочдоо нэгэн хэсэг vдэцгээн гаргаж өгөв.Завиа орхисон газар хvрч, цаашлан аялах гэтэл, ойн эмс хоорондоо баахан яриа болоод , эгчмэд нь Үхvvгээр Шонхолойд хэлvvлсэн нь манай нэгэн хэсэг эмс, энд хэл ойролцоо хvнтэй газар хvрсэн тул, эндээ vлдсv, гэнэм. Та нар юу гэж бодож байна гэтэл,

- Эднийг энд vлдвэл, би бас vлдэлцэх хvсэлтэй байна. өнөөдрийн барын савар соёог би эдний нэгэнд нь сvй тавьж өгөх санаатай байсан юм. Эднийг vлдвэл, миний бие явавч, санаа минь энд vлдэх зовлонтой боллоо гэж Гекvv Шонхолойд хэллээ.

- Чамд эм олдоно. Эр нөхөр олдох нь чухаг. Бид хоёрын амь аварсан ачтай хvнийг алс холын замд хань бvлгvй хаях гэж байх ямар өөдгvй амвтан бэ чи ? гэж хөндлөнөөс нь Үхvv загнаж эхлэв. Бид Шонхолой ахтай тэр нэгэн шөнө эс дайралдвал, би өнөөдөр ингэж явах уу? Би чамайг хvн гэж бодож явсан, хvн биш юм байна чи гэхэд нь Шонхолой

- Тэгж болохгvй, Үхvv минь. Эндээ vлдэх дуртай бол vлдэг. Бид анх гурвуул гарсан тул, Бух өвгөнийг нцтаг усанд нь хvргээд, хоёулаа л буцах байсан. Гекvv vлдвэл vлдэг. Чи ч бас өөрөө л мэд гэхэд нь Үхvv,

- Би та хоёртой л явна. Би Гекvv шиг хvн биш гээд, ойн эмсийн зvг юм хэлсэнд , эгчмэд нь Үхvvгийн vг сонсоод, гараа занган олон vг хэлэв. Ойн эмсийн зарим нь бусад нэгийгээ зэмлэх шиг шуугилдаад, эгчмэд нь Үхvvгээр Шонхолойд

- Миний буруу боллоо. Амий маань аварсан хvнийг алсын хол аянд нөхөр бvлгvй болгохыг би сэтгэл тvндэхгvй би хамт дагалцан явна. Гекvv энд vлдвэл vлдэг. Гэж хэлvvлэхэд нь ойн эмс бvгдээрээ эгчмэдээ дагана гэж нэгэн дуугаар дагав. Гекvv, байдал ийм болсонд машид ичингvврэн уйлж, буруугаа хvлээн Шонхолойг гуйж өчрvvн :

- Ах, намайг хvлцэж хайрла. Би муу санаа агуулж, ганцаары тань хаях гэж огт бодоогvй, гагцхvv энэ ойн эмсийн нэгэнд сэтгэл санаатай болоод зарим нь энэ газар, хэл аялгуу нэвтрэлцэх хvнийг бараадан vлдэнэ гэхэд, санамсаргvй дагаж vлдэх бодол төрсөн билээ. Ачтан хvний тэнхрvvлэн тэтгэснийг мартан гээж, тус хvргэсний хариуд ус хvргэх гэсэн санаа огт бус. Би vxэвч ахын дэргэд, ахыг хамгаалсаар vxнэ. Гөрөөсний янзага эхийгээ дагадагтай адил ахыг дагаж, зовлон жаргаланг хамт хуваалцана. Ах надад бvv муу сана. Намайг битгий буруушаа. Далайсан газар тань далд орж, далласан газар тань гарч ирсvv. Догшин араатнаас халхлаж явсуу,

нойрсох цагт сахиу явсуу гэхэд нь Шонхолой яаран урагш давшиж Геквүг тайтгаруулан, ойн эмсийн зүг

- Та нар дур сонго оо. Эндээ влдпе гэвэл влд, алсын их хол замын бэрхийг бэрхэд вээхгүй бол манай Чонос мэнд хүрвэл тань та нарыг өөрийн хүн адил вэнэ. Геквү өөрөө л мэд. Манай нутаг усанд хүрвэл манайхан чамайг өөрий л хүн гэж вэнэ. Эндээ влдэх нь дээр гэж вэвэл би ер чангааж татгалзахгүй гэхэд нь бүгдээрээ өдгөө хүртэл хамт явсан бид, нутагт тан хүрч, отогт тань багъя. Гэж цөмөөрөө урд адил нэгэн сэтгэлээр хамт аялан явахаар боллоо.

Твймэр гарсан бололтой гэж Шонхолой салхи внэрлэн, униар татасан зүг зовнисхийн харж, газрын байдлыг вэвэл, салаар явахдаа тулалдаж гарсан газар айсажбайвнам. Бидэнтэй байлдсан аймгийнхан гал алдаж харлав уу даа? гээд мөрөн өөд алсыг ширтвээс хээрийн ан амьтан урьдынхаас арай олон вээгдэж, цөм нэгэн зүг уруудах бөгөөд огторгуйд шувуу бас олон болж дуу чимээ нь ерийн цагаас ондоо ажээ. Одоо тэгээд яахав, яваад л байх уу? гэж Залуудайн асуухад нөхөдтэйгөө зөвшилдөө гээд завиа эргийн зүг залан хойноос нь дагаж яваа Үхvv, Геквү хоёрыг завиа эргэд дөхvvл гэж дохиод, эргээр өгсөж яваа ойн эмсийн эгчмэдийг дуудаж яавал дээр вэ ? гэж бүгдээрээ зөвлөлдөөд, газраа хороож, твймэр ойртоод ирэхийн вес ямар нэг аятайхан газар олж буухаар тогтлоо. Наран шингэх вес утаа униар бүр ч ихдэж, орчин тойрон бүрэнхүй болж, нар нэг хүрэн улаан төгрөг юм шиг вээгдэх боллоо. Эртхэн шиг буух газар хайж, харсаар, твймэрт хөөгдсөн ан амьтан дайран сандраахгүй, нэг эвтэйхэн газар олоод :

Явган яваа ойн эмэгтэйчvvдийг завиараа усны нөгөө талд гаргаж, мөрөнд гал тулан ирэхэд хүрвэл аюулгүй болгож, бүгдээрээ эртхэн шиг хоног буудлаа засаж, твймэр өнгөрөхийг хвлээлээ. Үхvv, Геквү хоёр завиараа мөрний нөгөө талд гарч, гөрөөлөөр одоод, асар удалгүй нижээд тарган ооно харван унагаж, буцаж ирэхдээ зээр маш олон твймэрт сочин хэлмэгдээд, нум суманд харвуулж вээггүй тул сум тусам газар ойртоход ер хүнээс айхгүй байна гэж ирэв. Зээрээ өвчин эвдэж, хоол хийж идсээр байтал нар ч шингэж харанхуй болоход твймэрийн гал сүрхий тод харагдаж, тун сүртэй . Мөрний тэртээ олон гөрөөс ан амьтан бий болж, түрvvч нь тургиж барьж, ус гатлан гарч байгаа чимээ үргэлж гарах боллоо. Чингэвч гал твймэрээс нэгэнт зайлж байгаа амьтан анчны галыг хараад огт ойртон хавьдахгүй өнгөргөөж байлаа. Шөнө дундын хэрээс твймэр улам ойртож, хүй хүй халуун салхи саохилах болж, алсаас хөөгдөн зайлж яваа амьтны хөл чиг их боллоо. Үүр цайхад бүр ч дөхөж, талын их твймэрийн хуйларсан галын байдал чимээ тун сүртэй болоод, хөнгөн хөлт хурдан ан амьтан хэдийн мөрөн гаталж, шөнөдөө өнгөрсөн аваас том биет нүсэр амьтан арга буюу явсаар твймэрт гүйцэгдэх шахам хөөгдөж, хулан тахь сүрэг сүргээр алсаас дахин ирж, унгалдах дуу чимээ, нүсэр том том арслан заан сүртэй их дуугараад, урамдан дуугарч, тэмээн гөрөөс буйлан мөрний усанд шахалдан орж, цовхчин хөвж яваа амьтан мөрнөөр дvvрч, твймэр аймаар хурдан энд тэнд бөөн гал харваж, галт хуй салхи хуйлран нэн ч бэрх болсонд ойн эмс машид айн эмээж, дуу шуу болсонд Шонхолой тайтгаруулан тогтоож, маш айван тайван байдалтай байх тул сандарсан эмс түвний самбаатай уужим байдлыг хараад, бас зүрхээ дарж, шуугилдан сандчих нь гайгүй болж, хадын тавцан дээрээс дорно мөрний хоёр захаар бүжигнаж байгаа

амьтныг харцгаан сууж байтал твймэр ч бвр ойрхон хврч, халуун амьсгал нь тэсэхэд бэрх боллоо. Чингэж байтал Залуудай дорогш гараар заан нэг юм хэлсэн нь шуугианд дуулдсангвй. заасан звг харваас нилээд хэдэн хвн усны эрэгт хврч ирээд, усанд орохоос айн эрэг дээр байхад твймэр нэн хэцвв тул цаашаа наашаа хашигчин гвйлдэж байтлаа арга буюу усанд орж, Толгой нь цухалдан харагдаж байтал сvvлчийн ан гөрөөс дээрээс нь хамаагвй дайран орж, нэг эмэгтэйн ардаа vvрсэн жаал хvvхэд эхийн хvзvv тэвэрснээ алдаж, усанд хоёр нэг цухалзаад далд ороход эх нь vрийнхээ хойноос тэвдэж арваганасаар байгаад нэг бух гөрөөсөнд дайруулан далд оров. Твймэрийн халуун илч амьсгал нэн хэцвв болсонд аянчин бvгдээр чулууны нөмөрт хоргодон нэг хэсэг юу болж байгааг харахын аргагвй амьсгалахад ч хэцвв болж, харанхуй утаа татаж, их галын шуугих чимээ, мөрний тэртээгээс дуулдан, наад талд нь олон амьтны дvрвэж, давхих чимээ усан дунд унгалдах, урхирах, майлах, буйлах, орилох, хашиграх элдэв дуу шуугиантай холилдон нийлж жигтэйхэн юм болов. Хад хагарч ан цав гарсан чулууны завсар хоргодон шургасан аянчин твймэрийн халуун хийд, их мөрний захад байгаа чулуунд халхдагдан хэвтэж байгаа учир гайгвй боловч, хвй хвй утаа цохин амьсгалахад хэцвв. Чингэсээр хичнээн удсаныг аянчин мэдсэнгвй. Галын сврт чимээ нь арай намдах шинжтэй болж. Салхи мөрөн уруудвал агаар ч баахан цэвэршиж, нуугдсан газраас бултайн харваас усны захад тулаад, мөрөн өргөн учраас нөгөө талд ашгвй гал туссангвй, уруудан өнгөрч мөрний баруун талын уулс усанд ойртон ирсэн газар ургац тачир, салхигвй тул, уулын энгэрт тулбаас намжих шинжтэй vзэгдлээ. Твймэр өнгөрсөн газар мөрний захын бургасуудын салаа найлзуур нvцгэрэн нарийн vзvvр нь утаа уугиж, твймэрт хөөгдөн ус гаталсан олон тураг анд нарийн бvдvvн бургас, улиас хуга нуга дайруулж, мөрний наад талын шугуй ч бас тас гишгvvлж, хөө чандруу болоод, мөрний тэртээх халиурам тал тас хар болж, энд тэнд хааяа твймэрт гвйцэд эдvvллээгвй чийгтэй газар шар ногоо толботой харагдаж, утаа суунагласхийн буй их талд усны ойр энд тэнд галд гвйцэгдэн бvтэж vхсэн амьтан хуйхлагдан харагдаж их талын байдал нэг мөсөн өөр болж свртэй. Алсад салхинаа vнс чандруу хуйлран, нvд алдам газар мөрний нэг тал нь свртэй хар нөгөө тал нь шар ногоон харагдах ажээ. Усны тэртээ эргийн захад хэдэн vнсэн тураг анд гишгvvлэн vхсэн хvний хvvр vзэгдэн, зарим нэг нь цээж нь усны захад, бөгсөн бие нь усанд хэвтэж байгаа хvн vзэгдэн, ганц нэгэн хvvхэдтэй эмэгтэй бололтой хvн, уснаас арай чvv гэж гараад, нойтон голтой нэг юм, нялцайтал дэвтсэн саарин хувцас нь биенд нь наалдан, маш цөхөрсөн байдалтай сууж байгаа нь vнэхээр өрөвдөлтэй тул, Шонхолой Үхvvг дагуулан, чулууны ард хуоаасан нэг vйсэн завиа авч усанд тавиад мөрний тэртээ сэлж гараад тэр хэдэн эмэгтэйн зvг одвол тэр хэдэн эмэгтэйчvvл, vl таних хоёр хvнийг хараад огт дуугарахгвй тэнхэл тамир нь тасарч, гайхах баярлах шинжгвй уруу царайлан суунам. Хэдэн багацуул, Шонхолой Үхvv хоёрыг хараад нvvрээ далдлан, эхдээ наалдан, нэгэн эр хvн, чих сэтэрхий, сорви нь суманд харвуулсан байдалтай бөгөөд, машинд алжаан цуцсан байдалтай боловч, Шонхолой Үхvv хоёрыг хараад, царайд нь тэсгэлгвй эмээсэн шинж тодорч, аман дотроо нэг юм өгvvлэн, хvзvv сунган, амь гуйх мэт. Ажин vзвээс өнөөх салаар байлдан явахад чихий нь сэт харвасан хvн мөн бололтой. Тамирдсан тул, дайсан итгээд хврч ирлээ гэж vхэхийг хvlээн буй бололтой. Шонхолой өрөвдөөд, эелдэг найрамдуу, айван тайвнаар тэр хvнд

- Тулах нэг цаг байхад, туслах нэг цаг байдаг шvv дээ. Эр хvн , эр хvндээ хайртай. Чи надаас бvv ай, гээд завиа зааж, мөрний тэртээ гаргая гэж заан дохиод, уух унд, идэх хоол өгнө гэж дохиод тэр хvн дохиогий нь ухаарч, нvд нь сэргэн гялалзаад, Шонхолойд гараа сарвайн, хоёр гараараа гарыг илэн талархал илэрхийлээд, дэргэдэх эмэгтэйчvvлдээ хэдэн vг хэлэхэд тэд нь бас нойроос сэрсэн адил, хөдөлцгөөж, хөө шавар болсон царайд нь баярлан мишээх байдал тодров. Чингээд Шонхолой тэр эмэгтэйг тvшин босгож, нэгэн эмэгтэйн хамт завьдаа суулган Үхvvгээр мөрний тэртээ гаргуулаад, ойн эмсийг гал тvлж, өчигдрийн гөрөөсний махнаас vлдсэнийг хоол хийж, тvймэрийн авулд эрдсэн эднийг хооллуулан, өл залгуул гэж vхvvгээр захиулаад , бас нэг завиа гаргаж, эснийг Гекvвтэй элбэж, усны цаад талд гаргая гэж явуулав. Тэр эрэгтэй эмэгтэй хоёрыг усны цаад талд гаргаад vлдсэн хэдэн эмэгтэйг амьд гарсан хvvхэд шуухадтай нь хоёр завиар гаргахад , ойн эмс тосон угтаж, шарж борлуулсан шvvрхийхэн махнаас өгч идvвлэв. Аюулд нэрвэгдэгсэд, санамсаргvй туслан тэнхрvллэх хvнтэй уулзаж, өл валгуулаад, дотор нь онгойж сэргээд мөрний тэртээхийг зааж юм хэлэх боловч, vг нэвтрэлцэхгvй ганц нэгэн vг нь хааяа мэдэгдэх тул, хvvхэд шуухадтай олонхи нь усны цаана тvймрээс зайлан гарч чадалгvй vхсэн гэж байгаа бололтой . Тэр сэтэрхий чихт хvн, нэгэн эмэгтэй хvvхэд хоёрыг заан , өөрийн гэргий хvvхэд хэмээн дохином бөгөөд, хуруу заан мөрний тэртээх харлан буй тvймрийн цурамыг заах нь хэдэн хvнээ галын аюулд алдсан хэмээж буй бололтой. Нvднээс нулимас дусаан аман дотроо юм өгvллэх нь тун уяралтай бөгөөд Шонхолойн гарыг байн байн илнэ. Төрөл саднаа алдсан тvвнийг хөөрхийлэн, санаагий нь засах vг хэлсv гэхэд vг нэвтрэлцэхгvй тул , арга буюу хариу гары нь илэн ьолгой дохиж, өрөвдөх сэтгэлээ илэрхийллээ . Мөрний тэртээ тvймэрт цуцан гvйцэгдээд vхсэн тураг ан энд тэнд хэвтэх тул , Залуудай, Үхvv Гекvв гурвыг завиар явуулж, тэр тvлэгдэж vхсэн ангийн махнаас авцруулахаар одуулаад, гал өрдөж, мах шаруулж бvгдээрээ хооллов. Тэр сэтэрхий чихт хvн, гал заан , чулуугаар галын цог авч явах сав хийнэ гэж дохисонд Шонхолой цахиур гаргаж, гал хавиран гаргахыг vзvvлсэнд маш гайхаж, ёстой гал шиг юм болов уу гэж Шонхолойн цахиж vлээсэн галд өөрөө мөчир зомгол , өвс хийж vзээд , эмэгтэйчvvддээ юм хэлж, тэр цахиур цахисан галыг заасанд Шонхолой цахиураар хэрхэн цахиж гал асаахыг заан vзvvлэв. Чингээд саарын хэтэвчнээсээ бас хоёр цахиур гаргажурьд базааж бэлдсэн уулнаасаа нэгэн атга өгөөд , уул хийх аргыг заан vзvvлж таниулав. Ямар юмаар уул хийдгийг харуулахад тэр сэтэрхий чихт хvн ухаарч, нэн баярлан толгой дохиж, өөрөө цахиуры нь авч хавирсаар , оч уулд нь тусч утаа уугихад хашигран баярлаж Шонхолойд нэг олон юм хэлэв. Эмэгтэйчvvд нь тэр хvний дахин дахин цахиур цахиж, уул уугиулан , хялгана цагаалж өвсөнд гал асаахыг их л бишрэн харж, Шонхолойд vг хэлэн дохином бөгөөд хvvхдээ Шонхолойгоор vнсvллэх хvсэлтэйгээ дохин илтгэхэд, бэлэгшээж байгаа юм байна гэж тэр хэдэн хvvхдийн халтар халтар хацры нь vнсэн таалж, тогойгий нь иллээ. Чихэндээ сэтэрхийтэй өнөөх хvн , хvзvvнээсээ баавгайн соёо хэлхсэн сондор чимгийг vзvvлэхэд саадгvй нэвтрvллэн туслана гэсэн дохиогий нь ухаарч, хариу талархан, хvзvvндээ зvvлээ. Тэр чих сэтэрхий хvн, тvймрийн аюулд хэдий эртсэн боловч, бvдvvн хийцтэй чулуун сvхээ амин лугаа сацуулан гараасаа сураар оосорлож авч явснаа заан, баавгайн соёот сондорыг заан, дахин дахин дохиж, тэр сондор vзсэн хvн ёvх бороохойтой vл довтлохыг илэрхийлж, Шонхолойн гарыг илэв. Чингээд

Шонхолой нөхөд сэлт, завиар явах нь завиндаа юмаа ачиж, эргээр явах ойн эмс эргээр явах гэж алсын зам чиглэхэд, тэр твймэрт эрссэн хvmvvc маш найрсгаар үдэн гаргаж, өөрсдөө их талын зvг гар дохин одов.

Шонхолой нар хэдэн хоног явж, сайя твймэрт идэгдсэн газраас холдов. Их мөрний нэг тал нь шарлан халиурч байгаа өвс ногоотой, нөгөө тал нь твймирийн хар цурам байсаар ан амьтан нь твймэрт идэгдсэн газар огт vзэгдэхгvй гагцхvv тас, бvргэд ёл, элээ зэргийн махчин шувуу хуйхлагдан vxсэн тураг ангийн сэг дээр хуримлах ажээ. Мөрний нөгөө талд харин ч ан амьтан олширсон байдалтай. Завь сэлэх хатгахад заримдаа хоёр Хумкаа шонхолойд туслалцан, заримдаа ойн эмсээс завид сууцгаан, дөрвөн анчин эргийн дагуу явгалан гөрөөлсөөр өдрийн хоол, бор хоногийн идэх юм бэлдэж явдаг байлаа. Ойн эмс бас зам дагуу идшинд хэрэглэн нэмэрлэх төмс ногоо, мойл, долоогоно, нэрс, vрил зэргийг вйсэн саваар тvvж, идэх юмаар хамтын хvчээр дутмаггvй явжээ. Эмэгтэйчvvд бас ангийн арьсаар чархи, бойви хийж, ясан шөвөг зvvгээр ханзарсан хагарсан юмыг оёх шидэхдээ чадамгай тул, дөрвөн анчинд бас их тус нэмэртэй бөгөөд оройн хоногт хоолоо идээд, гал тойрон сууцгааж, байх вес Шонхолой, Залуудайдаа бид эдэнд туслаагвй бол, эд зvдэрч аягвйдвэл амь зууж чадахгvйд хvрэх байж, эд биднийг тvшин амьдарч явахад бид дөрөв ч бас замын бэрхэд хvч бvлтэй болж, дөрвvвлээ чадахгvй юмыг бvгдээрээ нийлж хирийн юмыг дөнгөх болж байна шvv. Цувж явсан бараас цуглаж явдаг шаазгай дээр гэдэг нь энэ дээ гэж хvvдээ нөхрийн тусыг бvтээж явахыг vргэлж сануулан хэлж, нэг хvний давахгvй юмыг бvгдээрээ санаа хvч нийлбэл давдаг юм гэж ярьдаг байжээ. Ойн эмсийн дотор Бияа гэдэг нэгэн охин, царай зvс нь бусдаасаа нилээд цэвэр бөгөөд Гекvvгийн сэтгэл зvрхний хvн байжээ. Завиар явахдаа мөн орой хоног буудалд оролдсоор Гекvv тvрvvн алсан барын соёо саврыг нvхлэж, шөрмөсөөр хэлхээд сондор чимэг хийснээ нэгэн орой гvйцээж Бияад бэлэглэн өгөх санаатай, ойн эмсийн эгчмэдээс зөвшөөрөл гуйхад нь сондор бэлэглэнэ гэдэг, даруй төрөл барилдана гэсэн vг. Шонхолой ахын отог нутагт мэнд хvрсэн цагт эр эм болохыг зөвшөөрсв. Наана нь сvй тавьсан бэлэг болгож өгвөл өг л дөө Бияа тогтоодог юм бол чиний хэрэг бvтнэ. Эс тогтоовол, би хашин баалж чадахгvй шэсэнд Гекvv баярлан :

- Эгчийн vгийг сонсов уу? Би чамд vvнийг бэлэглэнэ гэхэд охин ичингvврсхийвч, vг дуугарсангvй, бэлгийг хvлээн тогтоожээ. Гекvv баярласандаа хэдэн хоног дархалсан нэг хавчаахай нум, хэдэн сумын хамт завинаасаа гаргаж,
- Бидний эр хvйстний ах зах нь Шонхолой ах аваас эмсийн ах их зах нь эгчмэд мөний тул, чадлаа гаргаж хийсэн энэ нум сумыг барья. Мэргэн харваач болтугай гэхэд нь ойн эмсийн эгчмэд нь дуртайяа тэр зэр зэвсгийг хvлээн авч, угаас нилээд чийрэг бөгөөд бяраар яасан ч Гекvvгээс дутуугвй чийргийн дээр Шонхолой нарын харвахыг сонирхон ажиж явсан тул, барилыг тун амархан сурч, эхлээд хур, сойр, ятуу зэргийн шувуу, чингээд туулай чандага, удалгvй бор гөрөөс, зээр агнах боллоо. Чингээд гараар шидэх чулуу, богино жадтай зvйрлэвэл дагуулахгvй хол тусгалтай сайхан зэмсэг юм байна гэж нумаар сум гэдэг жижиг жад чавхдан харван сvрхий амьтан гэж агнах бvр ангийнхаа цусаар мялаадаг болсны нь Залуудай нэгэн өдөр юунд чингэж байгааг нь асууваас, ойн эмсийн эгчмэд

- Дээжий нь амсуулж байхгүй бол гомдож магадгүй хичнээн хvн гаргаж, энэ хөнгөн жижиг жад чавхдан гөрөө хийж, олз олоод байхад эс амсуулбал, гомдоод онохоо байж магадгүй гэв. Эгчмэдийн хамт таван харваач хvн болж, ан гөрөө хийхэд улам ч олзтой болж, идэх хоолоор тасалдахгүй элбэг дээрээ элбэг боловч, хэрэглэх хэрэгцээнээс илvv агнадаггүй ёсоо алдалгүй баримтлан явжээ. Ялангуяа Шонхолой тэр ёсыг маш чанд баримтлуулан идэж барахгүй бол амьтны амь тасалсны хэрэггүй. Хурдан зэвсэгтэй боллоо гээд зоригоор хядаж болохгүй. хорхой чгэсэн аминдаа хайртай байхад, халуун амьтай бвлээн цустай амьтныг хэлээд яахав гэдэг байжээ. Чингээд нэгэн өдөр вдлэн буугаад, хоолоо хийж байтал, боролж шугуй дотроос жад бороохой, чулуун сvх барьсан арваад хvн гарч ирээд, аянчныг вzmэгц бөөгнөрөлдөж юм зөвлөцгөөх мэт болоод, нэг хvн урагш давшин, буудлын зvг айсуй. Ойртосхийгээд, жадаа дорогш талбин, гараа өргөж элэгсэг найртайэ байдал вzvлсээр дөхөхөд нь Шонхолой Үхvv хоёр, бас зэмсэггүй, өөдөөс нь очиж, хоёр талаас уулзаад vг хэлэлцэхэд, Хумкаа Үхvvгийн vгийг нэвтрэх хvн байв. Тэр хvн, аянчнаас хаанаас хаашаа зорьж байгаа хэн гэдгийг асуугаад, өөрсдийг ойн хvн гэдэг. Өвөл энэ хавиар агуйд өвөлждөг, зун намар ан дагаж мэхээр, ямаахай, ойн жимстэй газар хэрэн бидэж явдаг. Өвөлждөг агуй маань тэр. Саяхан агуйгаа эргэж вztэл, агуйг баавгай эзэлсэн тул хvч tvрэн эзэлсэн баавгайтай байлдах гэж явна гэж нөхдөө заалаа. Эрэгчин эмэгчин хоёр баавгай, хоёр бамбарууштай, манай өвөлжөөний агуйг саявтар эзэлжээ. Бид баахан хvч бвл цөөн боловч, агуйгаа алдах дургүй, вzэлцэх гэж явна. Бидэнд хvчин нэмэрлэж өгнө vv. Гэхэд нь Шонхолой гал дээрээ урин аваачив. Тэр баавгайтай байлдах гэж яваа хvн, нөхдөө даллан дуудаж, мөрөөрөө эргэж, буцан газар тавьсан жадаа аваад, Шонхолойн хойноос даган ирэв. Оройн хоолонд хэрэглэнэ гэж Шонхолой нар замдаа өглөөнөөс агнаж, модны захаас таван харваач нийлж хоёр гөрөөс агнаж, завьдаа нэг хэсэг махы нь ачиж нэг хэсгий нь ойн эмс vvрэн явснаа хоол хийж байхад, баавгайтай тулах ойн хvний тэр бөлөг дайчин хvрч ирсэнд, арга буюу орой идэх гэсэн махнаасаа шаралцаж, бvгдээрээ идлээ. Хоол идээд, ойн хvний тэргvн нь шонхолойг энэ хэсэг улсын ахмад нь юм байна гэж хvч нэмэрлэхийг дахин гуйсанд, шонхолой, хамт яваа ойн эмсийн эгчмэдээс яахав бид ? гэж асууваас

- Баавгайн хvч их эдний хvч нэмгэн. Туслалцах нь хоёр хөлтний ёс биз дээ. Туслан хамжиж взые гэхэд нь, манай олонх нь туслахыг зөвшөөж байгаа учраас эрэгтэй бид чvгвй гэхгүй. Танай эмэгтэйчvvд яасан бэ ? гэж асууваас ойн хvний тэргvн нь

- Манай ойн хvний эмэгтэйчvvд нь өвөлжөөн дээрээ бууж ирдэг, тэр хvртэл тус тусдаа. Эрчvvл нь эрчvvлтэйгээ, эмс нь эмсvvдтэйгээ урин дулааны цагт анги анги явдаг заншилтай юм даа гэлээ. Баавгайг хамтын хvчээр агуйгаас зайлуулах гэж тогтоод, бvгдээрээ зэр зэмсэгээ барьцгаан, тэр агуйн зvг чиглэж, асар холгvй тул, ойр нь хvрч очоод, замдаа хэлэлцсэн ёсоор олонхи агуйн амсарын дээд талд гарч, доош нь унагах чулуу бэлдэж, бас хоёр гараар дааж, доош нь хаяж болох чулуу зэхэцгээж, хvн хvн зогсох газраа хэд хэдэн том чулуу овоолоод, өнхрvллэх том чулуу tvлхэн унагах хvн, чигий нь тэр агуйн амсраас баавгай гарч ирэхэд дээрээс нь ойчих багцааг тааруулан барагцаж, тэр самбаанд хоёр хvн агуйн амсарт, заншлаар олох болов. /

заншилах гэж сэм мэдээ сурвалжлан тагнах гэсэн үг / . Шонхолой хvнээ дагуулж яваагийн хувьд тэр заншлах хvний нэг нь болсу гэж ойн хvний тэргvнтэй хоёулаа агуйд баавгайг заншлаар одох болж, доошоо буугаад, агуйн амсарт ойртон, дотроос нь чимээгvй тул аяархан дотогшлож vзвээс, амсрын орчим том хөндийд хориод хvн багтам зайтай, голд нь гал тvлж байсан vнстэй, тойроод чулуугаар хашсан өртэй бөгөөд цаашаа хошоод салаа болон нарийссан харанхуй хонгил vзэгдэв. Голомтын өрийг хашсан чулууг хөдөлгөж, vнсийг онгичсон бөгөөд том гэгч амьтны мөр ул vнс шороон дээр vзэгдэв. Зvн талын хонгилоос араатан том амьтны vнэр гарч, эзэнтэй агуй гэж мэдэгдэв. Манай хоёр анчин энэ агуйн амсар сахин модонд хоноод баавгайг байна гэж мэдээ хvргэсэн юм. Одоо чбайх шиг байна гэж ойн хvний тэргvн хойноос нь хvрч ирсэн Үхvд шивнэн хэлж, гурвуул шинэ мөрийг ажваас орсон гурван мөр, гарсан нэг том мөр байв. Төдий агуйн амсраас сэмхэн холдон гарч, нөхөд дээрээ очоод, хэрхэхийг зөвлөн хэлэлцэж, нэгий нь эзгvй хооронд бусды нь өдөөн гаргаж vзэхээр тогтоод, агуйн амсар боох гэхэд ичээд ороогvй баавгай юу хийж , хvлээж хэвтэх аж. Нэг шаламгай анчнаа амсарын зvг явуулж, баавгайг өдөөн гаргахаар боллоо. Нэг завшааниай зvйл нь агуйн амсарын хоёр талаар дээрээс унасан хадны хэмхэрхий том чулуу босоо хvнээс өндөр бөгөөд агуйн амсарын өмнө хvзvvч хашлага шиг тогтсон тул тэр хоёр , хоёр том чулуун дээр бас хэд хэдэн том жадтай анчин баавгай цохих том том чулуу өргөн дамжилж, сураар татан гаргаад тулалдахад зэхмэгц, нэг чийрэг залуу анчин, агуйн амсарт очиж, хараан зvхэж, агуйн зvг :

- Хvний өвөлжөө эзэдсэн ёсон бус муу хар гөрөөс гарч ир. Голы чинь таслаж, зvрхий чинь сугална. Гараад ир гээд чулуудав. Агуй дотроос чимээ гарахгvй тул ыас хараан зvхэж, хvний өвөлждөг агуй хулгайлан эзлээд, эзнээс нь айж байна уу ? бушуу гарч ирж амиа тушаа гэж хараан зvхэж, хашигран чулуудтал агуй дотроос баавгайн дуу гарч, хир баргийн амьтан халдахгvй их чадалтайгаа мэдсэн нэг том гэгчийн эм баавгай гэрэлд гялбасхийсэн байдалтай яаралгvй гарч ирээд, агуйн амсар, тэрний дэргэдэх ургаа том чулуу хоёрын хооронд хvн багтахаас, агуйн том баавгай багтахгvй завсарт зайлан орсон өнөөх өдөөгч анчин, хойноос аажуухан алхаж, нгаа гэж амаа ангалзан, гялалзсан соёо шvдээ ярзайлгаж, шиншилтэл тэр анчин ам руу нь жадаа тэнхээ мэдэн шааж орхив. Баавгай хойд хоёр хөл дээрээ урхиран бостол, дээрээс нь жадлах нь жад чулуудан жадлаж, том том чулуу буулган чулуудахад, урагшаа ухасхийтэл хэдэн анчин нэг том чулууг тvлхэн унагасан нь яг тэр баавгайн зоон дээр лvс хийтэл тусаад , хэдий маш их бял тэнхээтэй сvртэй амвтан боловч, vхрийн дайтай том чулуу ар зоо дээр нь цохисон тул нэг муухай дуугараад, хойд хоёр хөл нь мэдээгvй болж, бөгсөө чирэн, цусаар бөөлжин урхираад дэмий л дэргэдээ ойчих чулуу алгадав. Тэр завсар агуй дотроос хоёр арай бага баавгай гарч ирээд нэг нь толгой дээрээ том чулуугаар цохиулж, толгойгоо сэгсрэн эргэлдтэл, нөгөө нь агуйн амсрын хажууд буй өндөр чулуун дахь анчин авиран асаж, савраараа чулуу харчигнатал маажлан vсрэн дайрсан хvчиндээ, цээжин бие нь чулуун дээр гараад иртэл, чулуун сvхээр толгой дээр нь нэг хvдэр анчин буулгаж, хоёр талаас нь жадаар чичин хатгаж, агуйн амсар дээр болон хоёр талын чулуун дээр байсан анчин цөм өндөр дуугаар, бие биеэ зоригжуулан хашигралдаж, хадтай хөндийд цуурайттал барихралдав. Баавгай урхиран савардангуут, нэг анчны гуя хага татан унагасанд Гекvв шvврэн тогтоож, доош нь унагасангvй барьж авав. Тэр самбаанд ойн анчны нэг

нь том бороохойгоор шуугитал буулган, баавгайн торгон хоншоор дээр цус цацартал няц цохиж, баавгайг доош нь унагав. Чингээд дээрээс нь том том чулуугаар агуйн амсарт байгаа баавгайг цохилж хашигралдаж байтал ойн анчны ахмад нь том мазаалай ирлээ гэж маш өндөр дуугаар шуугианыг даран хашиграсан нь цөм заасан звг тийш харваас, модны захаас том гэгчийн баавгай маш хурдлан айсаж байгаа нь тийм том амьтан гэхэд тун ч хөнгөн шаламгай всрэн давхиж дайран орох гэж яваа нь үнэхээр сүртэй. Сум тусан газар ойртоод ирэхэд Шонхолой нар тавуулан харваж эхэлвээс, алдалгвй сум шигдэн орж байгаа нь харагдавч үхэх шарх олгож чадахгвй, сайн моринд ташуур өгсөн адил, баавгайн довтлоход улам ч эрч оруулсан адил шуугин орж иртэл, нэг сум яг нүдэнд нь шааж, баавгай цог тусаад хөлөөрөө нүдээ арчин, сумыг хуга татаад урхиран дайрав. Ойн анчин тал талаас нь жад шидэж, зарим нь баавгайн биенд шаавч, ширvvхэн давхиж, яваа баавгайн ухас ухасхийхэд шархнаас нь сугаран ойчиж, хариугий анчин дээр тулан дөхөж ирэхэд нь бороохойтой нь бороохойгоороо цохиж, жадтай нь жадаараа жадлан, жадны иш хугарах чимээ гарч,

- Нүдгвй талаас нь дайр, нүдгвй талаас нь дайр гэж ойн анчны тэргvvн хашгирч, улаан суга руу нь жадлатал, жадны иш нь баавгайн ширvvн эргэхэд хугарч, анчны тэргvvн баавгайн хөл дор ойчоод өглөө. Олон анчин тал талаас баавгайн звг дайран орсонд тэр том мазаалай хойд хоёр хөл дээрээ босон, олон шархнаасаа цус цувруулж, звг звгээс чичих жадыг ширвэн алгадаж, урагш урхиран алхтал, нэг залуу анчин элгий нь жадалж, Шонхолой сүхээрээ ар зоонд нь тэнхээ мэдэн цавчтал, мазаалай жадны нөгөө зvvрийг газар тулсан тэр залуу анчныг ширэлдсэн үснээс нь савардаад жадыг тас хийтэл хугалан ойчив. Залуудай хаш сүхээрээ мазаалайн хоёр нүдэн хооронд яс шархиртал цавчиж, олон анчин тийчлэн самардаж байгаа мазаалайг хашигран жадалж дайснаа дараад, агуйн амсарт буй гурван баавгайн звг дайран шуугив. Аврага мазаалайн хvvрийн дэргэд элгий нь жадлаад ойчсон залуу анчин өндийн сууж, анчны тэргvvний зэрэг хоёр гурван баахан бэртэсхийсэн хvн хоцроод, Шонхолойг дагасан ойн эмэгтэйгээс хэд нь тэднийг сувилаар үлдээд, бусад нь шархдан муудсан нөгөө гурван баавгайг дараар одов. Удалгвй олон анчин тэр гурвыг алаад, бөөн баяр хөөр болж, алсан баавгайнхаа арьсыг өвчөөд, толгойгий нь огтлож, бэртсэн шархтсан хvнээ сувилан, балар эртний баавгайн сvнсийг хорлон өшиж магадгвй гэж бодох тул эвлэрэх найр хийхийг зэхэв. Чулуугаар агуйн амсарт ширээ засан, дэс дэсээр нь баавгайн огтолсон толгойг тэр ширээн дээрээ тавиад, шархны цусы нь угааж, арчаад аманд нь цэцэг жимс хийгээд, махнаас нь шарж, бvгдээрээ найрлаад, тойрон суугаад, анчны тэргvvн нь баавгайн арьсан дээр урд нь суугаад нэг хижээл анчин, загасны мах өөх барин дуудруун :

- Хонгил агуй хоногтой
Хол ойрын их гvйдэлтэй
Гал хэрэглэхгвй дахтай
Ганцаараа явах чадалтай
Сvх хэрэглэхгвй бяртай
Сvр их тэнхээ тамиртай
Жад хэрэглэхгвй савартай
Жаварт даарахгвй үстэй

Өтгөс их мазаалай сонс
Өшөө өвөрлөөгвй байтал
Өвөлжөөний маань агуйг
Булай их хвчиндээ эрдэж
Булааж авсанд чинь бид
Эзэгнэж байсан агуйгаан
Эргүүлэн аьах гэж туллаа
Эр чадлаа үзсэн тулаанд
Эргэж хонзогнох ёсгвй шvv
Эртнээс манай байсан агуйгаа
Эргүүлж авсан бид нар бvгд
Идээнийхээ сайхнаар чамайг
Ид чадалтайгий чинь бахдаж
Эндүүрэм нэгэн цагт халдсаныг
Эргэж муу санахгвй зочилном
Тунгалаг мөрнөөс барьсан
Тулын мах өөхөөр бялнам

гээд тулын мах тосоор баавгайн амы нь чимх мялаагаад, өндөр дуугаар,

Хvний сайнаар зочилсон
Хvндий маань хвлээн тогтоо
Ах дvv олондоо нийлж
Агуйд маань битгий халд
Өтгөс хvн ёс сахидаг шvv
Өвөлжөөнд маань битгий халд
Буруугаа мэдвэл дахидаггвй шvv
Буцаж манай агуйд бvv халд
Бусад олон өтгөдөө захиж
Буруу замаас татан зайлуул
Халдан ахиж дайрдаг юм бол
Хамаг олноороо тулна шvv бид
Хvч сvрээрээ дайлган халдвал
Хvй олноороо тулна шvv

бид гэхэд нь ойн анчин босон харайж, жад бороохойгоо барьцгаан баавгайн толгой тавьсан чулуун ширээг гурвантай зэвсгээ далайлган ваа ваа хэмээн дайчин уриагаа хашгиралдан тойрч сүрдүүлэн бvжив.

Өнчин өрөөсөн гэж биднийг голбол
Өвгөн олон буурал аав сахиустай шvv
Нvцгэн ядуу гэж биднийг басвал
Нvд гялбам туяат галтай шvv

гэхэд нь зэхэж бэлдсэн галдаа өөх тос хийж, хуурай шилмvvстэй твлээ хийсэн гал нь дүрэлзэн асаж, олон анчин баавгайн толгой гал хоёрыг тойрон ваа ваа хэмээн

хашгиралдан , жад бороохойгоо далайцгаан бvнжиж, өчиг дуудагчийн дохиход зогсоцгоож, Анчны тэргvн дахин дуудруун :

Тулаанд олсон шарханд чинь
Тулын өөх тосон түрхэн эдгээ
Шарх олсон дайчин эрсдээ
Шарсан махаар чинь эмнэж
Агуйгий маань эргvлж өгөөд
Алаг махаа шагнасний чинь
Амаараа гартал идэн цэнгэж
Атаа өшөөгvй боллоо бид
Арвайсан гараараа барьсан
Амтат идээгий маань идээд
Өшөө жөтөөгөөн мартаж
Өвөлжөөнд маань ч сахиул бол
Өвлийн бэрх хvйтэнд
Өөх тосоор бvн тасалдуул
Хаврын тажир хатуу цагт
Халуун хоолоор бvн тасалдуул

гээд тулын махнаас баавгай тус бvрийн аманд зуулгаад, баавгайтай эвлэрэх ёслолоо гvйцээгээд , бvгдээрээ махнаас нь шарцгаан , гэдэс гартлаа идэцгээж, тулалдаанд хvний амь үрэгдсэнгvй, бага сага цохиулсан , савардуулсан зvйлийг юмнаа тоохгvй хатуужилтай улс тул, тоо бvрэн толгой мэнд уг агуйдаа дахин эзэн болсондоо бөөн баях болж, хvч нэмэр болсон Шонхолой нарт баавгайн махнаас дааж ядтал нь vүрvүлж, салах ёс хийлээ. Завиндаа хvрч, юм хумаа ачиж зэхээд аялан хөдлөх гэж байтал, ойн анчны тэргvн нь хvрч ирэн, та нарын нисдэг жадын арга, тураг анд их анд тусгvй мэт санагдавч, шувуу гөрөөс агнахад таатай хоёр хөлтийн дайрахад аминд тустай юм байна гэж бодон бодсоор ам нээн гуйх зvрх олдсонгvй. Та нарын явсан хойно санан санан бодож, нvүрээ зузаалж гуйх гэж ирлээ гэхэд нь Шонхолой нум яаж нийдгийг зааж, яаж харвадагийг vзvүлээд байдлы нь мэдсэн тул өөрсдөө санаачлан оролдож vз гэж тэр ойн анчны тэргvнээр хэдэн сум тавиулаад, өөрөө харвалаа vзvүлсэнд , тэр чийрэг эр тэсгэлгvй баярлаж, одоо манай гар урт боллоо гэж баярлан талархаж, бусад дээрээ баярлан буцав.

Тэндээс нилээд хэдэн хоног их мөрнөө өгсөн аялж, явсаар Шонхолой уулаас уран бөгөөд, газар их vзэж, ажиж сурсан юм их тул, загасаар элбэг их мөрөн загасчлахад хэрэглэх сэрээ хийж, хамт дагалдан яваа ойн эмсийн олонхи нь загас сэрээдэхдээ чадамгай учир, загасаар тасалдахгvй, таван харваачин, нум сум vзээгvй ан амьтан хоёр хөлтийг он тусам газар ажиггvй ойртуулдаг дээрээс загасны мах, ангийн мах ээлжлэн хэрэглэж, хирдээ жаргалтай, гэдэс цатгалан явж намрын оготор шар наранд, заримдаа мөрөн дагуу жимсчилж, айван тайван явахад, ойн эмс анхныхаас байдал нь шал өмнөө, сэтгэл санаа амар, идэх хоол элбэг, түшиг өмөг сайтай болсондоо зvс царай амарлингуй тайван , сэтгэл дvүрэн болсондоо бие бялдар нь ч аятайхан болж ирлээ. Үгтэй, яриатай дуутай хөөртэй ч боллоо . Үхvv, Гекvv хоёр ч

тэдний аялгуунд чих нь дасаж, харилцан нэвтрэлцэхдээ сайн болж, ойн эмс бүрхий сэргэлэн авхаалжтай замын уртад маш тустай нөхөд боллоо. Завиар аялахад, явган явах хүмүүс арай гавшгай тул, Залуудай, Үхvv, Гекvvгийн нэдэн эмстэй түрvvлэн явж, замын дагуу байдлыг ажиж явдаг журамтай болж, тэр завсар эргээр яваачин нь үдлэх хоноглох газар хэрэглэх хүнсний зvйл бас самбаачлан агнах журам аяндаа тогтжээ. Чингэж явах үес Залуудай, тэдгээр ойн эмсээс мөн Үхvv, Гекvv хоёроосоо хэрэгтэй юм их сурч, хоног буудал дээр эцэг нь бас туршил, ажиглалаасаа ярин танилцуулж, явдаг байлаа. Нэгэн өдөр Залуудай, Үхvv хоёр түрvvлэн явтал алсаас баахан шуугиа чимээ гарах мэт болсонд тэр зvг давшин сэм ажин харваас усны хавьд нэгэн бөлөг хүн бужигнан вймэлдэж, ямархан нэг том амьтныг цохилон дайрч байгаа шинжтэй. Олон хүний овооролдон, бужигнаж байгаа газраас арслан зааны урхираэ буйлах дуу дуулдаж байгааг сонсон ажиж арслан заан агнаачинтай дайралдсанаа яаран эргэж, Шонхолойд мэдэгдлээ. Ан хийж байгаа хүнд тусладаг ёстой тул, тэдэн дээр очиж туслалцах нь зvйтэй болно гэж Шонхолой тэр анчин тушаа завиараа хүрмэгц завиасаа гарч, бvгдээрээ тэдгээр анчны зvг чиглэлээ. Заан агнаачин, хүн нэмэн ирснийг үзээд, хэдэн хүн урдаас нь угтан тосож, найрсаг байдал үзvvлэн ойртоод, гартаа барьсан чулуун гилбэртэй жадаа газар талбин, найртай нөхөрсөг байдлаа үзvvлэн юм хэлэхэд, Үхvv, Гекvv хоёр баярлалдан, бид vгий нь мэдэж байна гэж Шонхолойдоо хэлээд, тэдний зvг бас зэвсгээ талбин, найрсаг байдалтайгаар чиглэн одоод, харилцан танилцаж, vг солилцоод, Шонхолойг ойн эмсийн хамт хүрч ирэхэд арслан заан нүхэнд оруулж агнан буй хүн болохыг ярьж, могой алахад мод нэмэр, заан агнахад жад нэмэр гэж урьж байна гэж заан гөрөөлөөчний vгийг уламжлан хэлсэнд бvvгдээрээ тэр анчин дээр хүч туслахаар одлоо. Тэдгээр анчин, арслан заан явах замд гvн нүх ухаж, дээрээс нь гишvv мөчир, өвс ногоогоор хучаад, нүх гэж мэдэгдэмгvй болгосонд намагтайшуу тэр газар огт тийм там малтаж хийснийг, халдах дайсан ховор учир хардан ажигхvй явсан нэгэн арслан заан хоёр хөлтийн мэхэнд унасан байжээ. Олон анчин ус нэвчсэн нүхэн тамд унасан арслан зааныг том том чулуугаар цохих нь чулуугаар цохиж, бороохой модоор цохих нь модоор балбаж, жадлах нэг нь чулуун гилбэртэй жад шидэн чичиж, бяра тэнхээ ихтэй, зузаан гэгчийн арьс ширтэй том гэгчийн тэр амьтан нүхэн тамд унан шигдсэн боловч амиа тэмцэн тулах зориг төгөлдөр тул, сүрдvvлэн урхирч, ойртсон нэгийг урт хошуугаараа шvvрэх гэж нүдээ улаанаар эргvvлэн, хоёр үзvvр нь гадагшаа мушгирсан соёотой толгой нь нүхэн тамаас сүртэйеэ бумбалзан харагдаж аман тушаа нь нэг анчин хүний vхсэн амьд нь мэдэгдэхгvй хэвтэж байгаа нь Залуудайн нүдэнд юуны өмнө тусан элгээрээ хэвтэж байгаа нь амьсгал тасраагvй мэт. Арслан заан, дэргэдээ амьтан хавьтуулахгvй, тамаасаа ус шавар үсэргэн урт хар хошуу, нь хар могой шиг ийш тийшээ годолзон, жад бороохой ойртвол шvvрэх гэж үе үе буйлан, нурууны нь үс, сөхvйн босож, энд тэнд жад шигдсэн боловч маш их бярайт, тун ч бөх голтой амьтан тул, өвчvv хэнхдэгээрээ дайран давшин зvтгэсээр бас хоёр хөлөөрөө цавчсаар, тэр тамаас гарах санаатай зvтгэх ажээ. Залуудай тэр хэвтэж байгаа хүний тунаа эь очоод, зааны суга татаж хаясан навсар навч намаатай зулзган хус авч, зааны хошуу хүрэх газар ойртоод очмогц бургасы нт шvvрэн булаалаа. . тэр самбаанд нь бөхөс хийгээд, өнөөх газар хэвтэж байгаа хүний хөлөөс шvvрэн татаж, шvvрэн татаж, зааны хошуу хүрэхгvй газар агшин дотор зайлуулж, авлаа. Дэргэд нь байсан хэдэн анчин баярлалдан хашгирч, тэр зааны

соёо хошуунд эрстсэн хvнээ сувилаар ухасхийсэн байдлыг vзвэл , жирийн анчин биш ахмад тэргvвлэгч нь бололтой. Тэр завсар Шонхолойтой ирсэн ойн эмс, арслан зааны ар зоо уруу нь жад чулуудах нь жад чулуу авцран чулуудаж байтал олон хvний жадлах шийдэмдэх, чулуудахад зааны тэнхээ тамир муудсаар, ядрах шинж мэдэгдэнгvвд, олон анчны шуугилдан дайрах нь улам ширvвн болж, нvхэн там доторх ус шавар нь олон шархнаас цуварч байгаа цусанд улаан өнгөтэй болж ирлээ. Зааны урхиран рөдлөх нь арай зөөлөн болж, тун ч амьсгаадаж байгаа тэмдэг ороож, хэнхдэг нь оволзон, шуухинатал амьсгалж, гагцхvв нvд нь маш догшноор эргэлдэн, хоёр том чих нь чичив татав хийх ажгуу. Чингэж байтал, ар талаас нь жадлах нь цохих улам ширvвн болж, зааны бөгсөн бие мэдээгvй болсон учир доошоо намсхийх шиг боллоо. Тэр байдлыг мэдэнгvвт, олон анчин там тойрон хашигралдаж, цөм нэгэн зvгээс жадлах цохилох болсон нь тэр заанд штрvвлэн унасан анчин, Залуудайгаар суга татуулснаас хойш сэхэрч ухаан ороод, олон анчнаа тэг ингэ гэж заан удирдаж, хамаагvй тал талаас шахцалдан дайрч, бие биендээ саад хийхий нь зогсоожээ. Тэгсээр байтал заан улам муужирч, ширvвн хөдөлдөг хар хошуу нь годгонон гялалзахаа байж догшин нvдээ улаанаар эргvвлэхээ байж, тамдаа доошоо аажуухан шигрдэж эхлэхэд, олон анчин, тэр хvчирхэг амьтан тамирдаж, жадлан чулуудах нь улам ширvвстэл, гэнэт тэр арслан заан сvвлчийнхээ хvч шавхан гэнэтхэн цоройж, хоёр урд хөл нь тамаас гарахын хамт , хошуугаараа нэг анчныг шvвртэл, Залуудай чулуун сvхээрээ хошуугийн нь хага цавчсанд , анчныг дээш нь өргөтлөө алдав. Заан агнаачны ахмад нь тэр залуу анчныг шvврvвлэхэд ц арай нь vнсэн хөх болж, яаран урагш давштал, тэр залуу газар ойчиж, Залуудай газраас нь татан заанаас холдуулж авлаа. Сvвлчийн тэр vсрэн ухасхийсэндээ зааны тэнхэл тасарч, хоёр хөл нь зөлгөнд шигдэн , хэнхдэг нь тамын амсар дээр тээгдээд, тас цавчуулсан хошуунаас нь хар цус олгойдон цацаж, том нvсэр бие нь чичив, татав нийж амь нь тасарлаа. Олон анчин тvвнийг vзээд, баярлалдан, хашигралдаж, бороохой ,жад , сvхээ далайн дэвхцэж бvжив. Тэр том амьтны цээжин бие нь нvхэн тамаас хагас цухуйн гарч vхсэн нь татаж гаргахад их дөхөмтэй болсон бөгөөд, их л бэлэгтэй сайн тэмдэг боллоо гэж баярлалджээ. Чингээд эвдэхдээ тун чадамгай тул, хэдэн хvн чулуун сvхээрээ бөгсөн бие гуяы нь салгаж, тамаас сураар татаж гаргаад халуун цуснаас нь тэр дороо ууцгааж, нvвр ам нь улаан нилээ болцгоон, заанаа эвдэж, гэдэс дотры нь цэвэрлэн, элгий нь тvвхийгээр хуваан идэж, аль амттайгаас нь Шонхолой нарт барив. Зааны хошуунд мах чихэж, галд болгоод, нарийн сайхан хоол гэж дээжжий нь Залуудайд барихдаа тэр анчны ахмад нь хvвгийн минь амийг аварсан сайн хvвд сайхан ерөөл тавина гээд дуудруун :

Алс холоос ирээд
Арслан заан агналцаж
Алаг vрий минь амийг
Авран баярлуулсан
Ачит залуу эр чамд
Залуугийн цог төгс
Заан Залуудай гэж
Алдар дээр чинь
Алдар нэмэн дуудсуу

Чадал дээр чинь
 Чадал улам нэмж
 Чамбай сайн эр болж
 Чацуулан тэнцэх хvнгvй
 Чадалтны манлай болоорой
 Хvчин дээр чинь
 Хvч их тэнхээ нэмж
 Хvчтэй сайн эр болж
 Хvзvvгээр булих хvнгvй
 Хvчитний манлай болоорой
 Ан хийхдээ азтай
 Аянд явахдаа олзтой
 Арслан заан шиг сvртэй
 Аймаг олондоо хайртай
 Заан Залуудай нэртэй
 Заяа их хувьтай эр болж
 Урт гэгчийн насалж
 Удаан гэгчийн жаргаарай

гээд арслан зааны хошуунд нарийн мах чихэн болгосон идээнийхээ сайнаас Залуудайд барин, амы нь өөхөөр тосдож, гары нь арслан зааны цусаар мялааж, гарах бvр ангийн олзтой болоорой гэж , гадаад хормойгий нь арслан зааны цусаар будаад, дотор чинь хэзээд цатгалан дvврэн яваг гэж дотоод хормойд нь өөх тос тvрхлээ. Шонхолой хvнгээ цол цоллццлж, нэр нэрлvvлж байхыг вэээд баярлаж, олон анчны хамт арслан зааны махнаас цадатлаа бvгдээрээ идэцгээж, хувь махаа завиндаа хийж, цаашаа аялан мордохоор болохдоо, харвалаа вэvvлэнсонирхуулбал, арслан зааны тэдгээр анчин, хэдий урьд вэээгvй сонин юм вээвч, уулаас арслан заан гөрөөлж явдаг заншилтай тул, тийм нарийхан жад нисгэж, ийм том арслан зааныг агнаж болохгvй осолтой зэвсэг байна. Бид арслан заан дагаж амь зуудаг улс. Зааныг нvхэн тамд унаган алдаг. Мод ихтэй газар чулуун сvхээр модны ёроолоос хөлийн шөрмөсийг тас цавчин агнадаг билээ. Зааны соёогоор хийсэн жадаар заан болон хирисийг ч жадлан шархлаж, эр зориг чадал тэнхээгээ сорин вэvvлдэг зуршилтай заан агнаачин билээ. Эмс охид маань бор гөрөөс, буга хандгай жадлан гөрөөлж , усны захаар галуу нугасны дэгдээхэй агнадаг ийм улс.энэ нисдэг жад тань, манай эмсийн зэмсэг болохоос, заан агнадаг хvний зэмсэг биш гэжээ. Гал асаахдаа галын мод гэдгийг хэрэглэж, хоёр мод vрж гаргадаг тул харин Шонхолой цахиур хавирч гал гаргахыг сонирхож, галын мод хур бороотой цагт чийг зуудаг нэг гэм буй тул ямарч чийг усанд чийг зуух гэж байхгvй цахиур чулуугаар гал бий болгох энэ арга тань билэнл хэрэгтэй юм байна гэж цахиур хавирах аргыг заалган сурч аваад, маш найрсгаар хагцан саллаа. Нум сумыг эмсийн зэмсэг гэж тоохгvй тэр чийрэг анчин аймагтай уулзан дайралдсандаа Залуудай их сонирхож, бас Заан цолтой болсондоо бахархан, заан агнаачны ахмадаас бэлэглэн өгсөн зааны соёогоор хийсэн жадны том гилбэрийг арслан зааны савгаар сvлжсэн гэртэй өгсний нь сонирхож, Чоносыхны хэрэглэж вэээгvй сvлжмэлийг таашаан бахархав.

Шонхолой дагаж ирсэн их мөрний аль талаас ямар ус цутган орсныг Бух өвгөнийг үдэн очих замдаа тэмдэглэн зурсан тоймоороо, бас ан аян хийж юм ажихдаа сүрхий дадлагатай тул буцах замдаа мөрөн их усаа барин огт төөрөлгөй явсаар намрын сэрвү орсон нэгэн өглөө мөрөн өгсөж явтал нэгэн өргөн дэнж дээр, галын утаа, олон хvн харагдсанд , юухан болж улс амьтан цугладаг билээ гэж эргээр явсан ойн эмстэйгээ бvгд нийлэн зөвлөлдөж, мөрөн өгсөн явахад, дэнжийн тэр улс яасан чиг хvн явахыг андахгвй харна. Усныхаа нөгөө талд гарч вээх вv? Халдан дайрах гэвэл, ус гаталтал бас зайтай бий гэж хэлэлцээд, ус гарч завдтал, өндөр дэнжийн улс, хэдийн ажиглаж нэг хэдэн хvн гар даллан өөдөөс нь чиглэв. Гартаа зэр зэмсэггвй, даллах байдал найрсаг тул, арай ч дайсагнан халдах шинжгвй бололтой гэж зөвлөн хэлэлцээд, Шонхолой, Үхvв хоёр тэр чиглэн айсаж яваа хэдэн хvний урдаас зорин одов. Ойртоод ирэхэд тэр айсуу хvмvвс, найрсаг сайхнаар ёслож, амар мэндийг асуугаад, биеэ цөөвөр омогтон гэж vг аялгуу нь нэвтрэлцэм ойр хэлтэн байлаа. Шонхолой хаанаас хайшаа зорьж явааг асуугаад, тэр цөөвөр омогтны нас ах нэг нь өгvвлрvн :

- Манай отгийн ахмад, нас дээр гарч, тэнхэл тамир дорой боллоо. Ан хийж чадахгвй нvд шvд муудлаа. Шөрмөс шандас суларч уул өөд мацан явж ан гөрөө хийж чадахгвй боллоо. Отог олондоо тээр төвөг болох нь. Танагтай байгаа дээрээ та бvхэнтэйгээ нэг хуримлаад гэдэс цатгалан санаа амар байдлаар уулынхаа өвгөд, өтгөстэй золгож, ач vрдээ шvтээн сахиус болсу гэсэнд нь буурал аавынхаа захиа дагаж, өнөөдөр бид хад тvшvвлэх хурим хийх гэж өндөр дэнж дээр цуглан бэлдэж байтал, алсаас та нарын айсуу ирэхийг хараад өвгөн аавыг үдэх хуримд өлзийтэй гийчин ирлээ гэж та нарыг урих гэж яаран хvрч ирлээ. Хутагтай хуримд маань суулцаж хуучид болох гэж байгаа буурал аавы маань баярлуулан үдэлцэх биз гэж горьдоно гэхэд нь Шонхолой учры нь мэдэж,

- Би нөхөд дээрээ очиж, бvгдээрээ хамт явсуу. Хутагт хуримд тань хувиа оролцуулж арслан зааны махнаас барилцъя гэхэд нь тэр цөөвөр хvн арслан зааны мах гэхийг сонсоод тэсгэлгвй баярлан,

- Юун сайн юм бэ . Манай буурал аав, арслан зааны мах амсаад нvдээ аних юмсан гэж билээ. Бидний хvч мөхөс тул тийм том амьтан агнах хvчин чадал хvрэхгвй тул, захиагий нь гvйцэтгэж чадаагвй юмсан. Бид vврэн явна. Та нарыг чилээхгвй гээд, яаран Шонхолойг даган нөхөд дээр нь хvрэлцэв. Шонхолой хамт яваа ойн эмсийн зvг Үхvвгээр хэлvвлэн, Цөөвөр омгийн хvн, өвгөд аавыгаа хад тvшvвлэх хурим хийх гэж байгааг таниулж, явган хэрэн яваг гөрөөчин омгийн хvмvвс, отог олондоо тус нэмэр болох наснаас хэтэрч, төвөг тойв болохын өмнө хуримлан найрлаад vхлэг ёс бийг хэлvвлсэнд, тийм ёс тэр вeд тvгмэл тул огт гайхсангвй, уем хуримд оролцохоор арслан зааныхаа махнаас vврэлцэн одов. Залуудай насан бага бөгөөд тийм хурим урьд өмнө вээгвй , гагцхvв отог буудал дээрээ нэг идэх хоолтой, дэргэдээ галтай хоцорсон хvнийг вэсэнээс биш, хад тvшvвлэх хурим гэж сонсоогвй учир эцгээс асууваас,

- Өтгөсийн гэдсийг цатгаад, отог дээр нь vлдээхийг чи тvрvн мэдсэн. Бас гэдсий нь цатгаад, төрлийн хvнээс ач нь жадалж, хад тvшvвлэх ёс бий. Өөх vнхvвлж амы нь

барих ёс бий. Одоо энэ ямар ёс хэрэглэхийг би мэдэхгүй байна. Газар газрын ёс ондоо. Чи тэнд очоод гайхсан байдал битгий үзүүлж, хvн өбитгий гомдоогоорой. Ер олон аймаг ясанд олон зvйлийн ёс бийг өөр аймаг ясны хvн хориглон өөрчилж дийлэхгүй тул газрын ёс дагахаас өөр аргагүй боллоо шvв гэж хvндээ сэмхэн захиад, бvгдээрээ тэр Цөөвөр хvний хамт өнөөх өндөр дэнжийн зvг одлоо. Шонхолой нарыг угтан тоссон Цөөвөр хvний нэг нь яаран гvйж, өтгөс аавын хvссэн юмтай сайн гийчин айсуйн мэдээ хvргэхээр одсонд, дэнжийн олон бvгдээрээ угтан бууцгааж, Цөөвөр отгийн хад тvших гэж байгаа өтгөс ч баярласандаа, нэг чийрэг залуу эрээр vрвүүлэн бууж ирээд гийчнийг ёслон, эсэн мэндий нь асуугаад,

- Сайн хvний санаагаар гэж та нар, өтгөс миний энэ зовлого биеэ гээхийн өмнө хvссэн юмтай хvрэлцэн ирсэнд ихэд баярлан бэлэгшээж ач vр минь амны хишигтэй юм байна гэж баярлаж байна. Багынхаа дуртай нэг юм амсаад хад тvшихэд надад ч сайхан завшаан боллоо гэхэд нь гөрөөсний цагаан vстэй элэгний арьсаар хад тvших цагаан өмсгөл хийлгэж өмссөн, буурал vстэй, цэцэн харцтай, тэр өтгөсийг хараад, элэг нь эмтэрч ихэд өрөвдөвч газрын ёс дагахаас өөр аргагүй гэж эцгийн захисныг санан сvвлс алдлаа. Тэр өвгөн , vхэхийг унтахын төдий бодох зоригтой хvн бөгөөд энэ намар маш сайхан тул ач vрдээ өвөл хаврын цагаар тээр төвөг таталгvй, цагийн сайханд уул тvших гэж санаа нэгэнт шулуудлаа. Хутагтай хуримд минь холын зочин гийгvүлэн ирсэнд vрчлээт магнай минь тэнийж, баяртайяа нvд анин өтгөс дээдэстэйгээ золгон, vр садандаа өлзий болох энэ өдөр өтөлсөн муу би баярлаж байна гэж Шонхолойд хэлээд бvгдээрээ өндөр дэнж дээр гарваас, тэнд Цөөвөр отгийн анчин эрс, бор гөрөөс, буга, хар сvүлт зэргийн мах хэдийн эвдэж, шарах чанахад бэлдэн, бас хорхог хийх гэж зэхсэн байжээ. Эмс хоолны хоршид ногоо жимс хэдийн базааж бэлдсэн тул, зочид хvрэлцэн ирэхэд зээр гөрөөсний элэгний цагаан vстэй, цагаан гудас дээр өвгөнөө тvшин суулгаад, Шонхолой Залуудай, , Үхvв , Гекvвг өтгөсний баруун талд дор нь суулган, эрэгтэйчvүд зочдын дор нь баруун талд дэс дэсээр сууцгаан, настай эмс зvүн талаар ньдоогуур нь залуус сууцгаан хоол хийх хэдэн эрс, эмс гал тvүдгийн дэргэд хоол бэлдэн завдах зуур, нэгэн чийрэг Цөөвөр анчин хад тvших гэж байгаа өтгөсийн дээдэс өвгөдийн эрэлхэг зоригтой явдлыг тоочин хvүрнээд, дараагаар нь хад тvших гэж байгаа өвгөний эр зоригт явдлаас нь магтан өгvүлэхэд, Цөөвөр эр маш хичээнгvйлэн сонсоцгоож, суув. Чингэж байтал , хоолны тvрvүч нь ч болж дээжээс нь өтгөсийнхөө өмнө тавиад, өвгөний ач нэгэн залуу Цөөвөр эр, аль л амттай өөхтэй мах идээнээс сонгон цахиур чулуун хутгаар огтолж, өтгөс хоёр гараараа өарив. Чингээд өтгөс өмнө тавьсан махнаас хувь хишгээ тvгээнэ гэж хvн бvхэнд нэг нэг хэсэг мах өгсөнд цөм маш хvндэтгэн , тэр махнаас нь авч, эмэгтэйчvүд, нялх хvүхэд багацуулдаа аманд хийж хөхvүлэв. Хад тvших өтгөсийн дэргэд суусан ач нь хоол бvхнээс өтгөстөө амсуулан идvүлж бvгдээр Шонхолой нөхөд сэлтийн авч ирсэн арслан зааны махнаас аль амттайгий нь хад тvших өвгөндөө барихад, тэр өтгөс баярлаж

Сайхан vгээ хэлж
Садан олонтойгоо
Хагацан салах ёс
Хамтын дунд хийж

Хад түших цаг
Хариугүй туллаа
Цаашлаж болдоггүй
Цаг минь боллоо
Хойшлож болдоггүй
Хоног минь ирлээ
Чимээгээ намдаж
Чихээ тавь, та минь
Ууланд цуурайтдаг
Урьдын хоолой байхгүй
Заан цочоодог
Залуугүйн хоолой байхгүй
Шивнэж хэлэх үгий минь
Шил сайт үр сад минь
Сонор чихээрээ сонсон
Сонин болгож тогтоогуй
Сулхан дуутай үгий минь
Сургаал болон сонсогуй

гэхэд нь бүгдээрээ чимээ авиагүй нам гүм болов. Өтгөс үргэлжлэрвүн :

Агуйн баавгайтай тулж
Арслан заан агнаж явсан
Идэр нас минь өнгөрч
Идээний тулам боллоо
Чадал ихтэй бие суларч
Чамбай гар салга боллоо
Хиншүү хоолтой
Хий биетэй болох
Цаг минь болж
Цаашлахын аргагүй
Өвгөн буурай бие минь
Өтгөсийн ёс дагаж
Халуунаас хагацаж
Хад түших цаг боллоо
Садан олондоо би тань
Сахиус болон тэтгэсүү
Сүүлтийг гөрөөлөхөд
Сүүдэр мэт дагасуу
Ан агнахад тань
Алдуулалгүй тусласуу
Атаатан тохиолдоход
Айлган сүрдүүлсүү
Ач үр та нарынхаа
Амийг хамгаалан сахисуу

Ганц хvн , хvн болдоггvйв шvv
Ганц цучил, гал болдоггvйв шvv
Эцгийн олон та нар хэзээд
Эвдрэшгvй эв нэгтэй явагтун
Эхийн олон та нар эгнэгт
Элэг нэгтэй явагтун
Дугтарвал хvч нэгтэй
Дуугарвал санаа нэгтэй
Хар амиа бодолгvй
Хамаг олноо бодогтуй
Отог омогтоо эвтэй бол
Огторгуйн одноос олон болно та
Отог омог дотроо эвдрэлдвэл
Огт өөдлөхгvй сөнөнө та
Үвлэн завсрын наран хурц
Үхэх хvний ухаан хурц
Үгий ми нь сонсон тогтоож
Үүрд эвтэй сайхан явагтуй
Үгээ захин хэлсний минь
Үргэлж бодож явагтуй

гэхэд нь бvгдээрээ – бодож явнаа . захиагий тань даганаа. Буурал аав маань биднээ харж яваарай. Гэж дуугаралдав. Өвгөн хоолойгоо засаад, Үг тэнь сайхан байна, сонслоо Үнэр тэнь сайхан байна vнэссvv гээд, отгийнхоо олныг цөмий нь vнсээд, ачдаа дохиж,

Амы минь барих
Ач минь наашаа
Хайртантайгаа хуримлалаа
Хадаа тушсvv одоо би тэнь
Найрт минь ирсэн гийчин
Намайгаа vдэлцсэнд баярлалаа
Алсынхаа замд саадгvй
Амар мэнд яваарай та минь
Хад тvших хуримд минь ирж
Хамт найрласан гийчин минь
Халуундаа мэнд хvртvvгэй
Арслан зааны мах амсуулсан та нар
Аян хол замдаа сайн явах болтугай
Алаг ачминь амсуулдаг юмаа аваад ир
Амы минь барьж намайгаа хад тvшvvл

гэхэд ач нь угалзын ууцны өөх бариад өтгөсийн аманд хийн чихээд шаат чөмөг шаажхахуулаад амы нь барив. Өтгөс хэд арваганаад амьсгал тасарч, амь алдав.

Отог олон нь тийм юманд дасал болсон тул, ёстой юм ёсоороо гэж ахмад өтгөсөө сайхнаао хуримлуулан баясгалаа гэж үзэх, үүнд гагцхүү Залуудай , урьд өмнө ан амьтны алагдан үхэх, мөн тулаанд дайсны үхэхийг үзэвч найрлан хуримлаж, нэгийгээ өөх үмхүүлэн хахааж, амы нь барин үхүүлэхийг үзээггүй тул дотор нь их л аягуй. Тэр өтгөсийн нэнд өрөвдөн, эцсийн захиа үг захиж байгаа нь чихэнд дуулдаад байх шиг хачин санаггдаж байлаа. Цөөвөр отгийнхон, өтгөсөө хад түшүүлэх гэж хэдийн зэхэж бэлдсэн дамнуурга авцраад, цагаан үстэй зүймэл хувсар гэдэг гудсы нь дэвсэн, цагаан хувцаст нөгчсөн өтгөсөө завилуулан суулгаад, ахмад настан нэгэн хүн, өтгөсийн дээл , сөөхий гутал, хувцсы нь цахиур чулуун хутгаар эзнээ дага гэж өгүүлэн хэрэглэж байсан зэр зэмсэгт нь бас үхүүлэн ирт юмаар эмтэлж, сүнсий нь эзнээ дагуулан одох болгож дэргэд нь тавиад, ээлжлэн дамнасаар , энгэрийн нэгэн хаданд түшүүлэн, хувсар дээр нь суулгаад, ахмад нэгэн анчин салах ёс гүйцэтгэж дуудруун :

Хайртай буурал аавыгаа
Хаданд түшүүлэн суулгалаа
Хамаг олноороо хуримлаж
Хагацахын ёс гүйцэтгэлээ
Цөөвөр буурал аав нартайгаа
Цөмөөрөө биднээ тэтгэн сахи
Онгон буурал сахиус болж
Отгийнхоо олныг ивээн хар
Хиншүү идээгий чинь таслахгүй
Хичээж явна шүү бид бүгдээрээ
Араатан, атаатны аюулаас
Амий минь хамгаалж яв
Эв санаа нэгтэй биднээ
Эвэр зовлонгүй явуул
Хол ойрын нүүдэлд биднээ
Хоолоор бүү тасалдуул
Хотол олон бидэндээ өмөг бол
Хохирол зовлон бүү учруул
Мөнх хад түшсэн өтгөс аав
Мөнхөд бидэндээ түшиг бол

гээд урд нь чулуун ширээ зэхсэн дээр нь арц ага ганга уугиулж ёслол мөргөөд бүгдээрээ эргэж харалгүй буцав. Чингээд Шонхолой нөхөд сэлтийг нэн элэгсэг найртайгаар үдэн гаргаж өгөв .

Ойн эмсийн нэг нь сарны тэргэл үеэр унаж дусдаг нойр дундаа босон давхидаг Усихаа гэдэг нэг охин байжээ. Хад түших хурим тохиолдсоноос хойш нойр муутай болж, шөнө босоод явах гэхэд нь найз нар нь тайтгаруулан тогтоож, дундаа хэвтүүлэн явдаг байжээ. Нэгэн шөнө , тэргэл сарны гэрэл маш саруул. Гекүүгийн нойр дунд хүн босох шиг болсонд, анзааралгүй хэвтэтлээ, бас дахин нэг хүн босон явах шиг санагдсанд өнөөх Усихаа л босоод явснаа буцаж ирэв үү гэж бодоод ,

ажиггвй унттал хичнээн болсныг мэдсэнгвй, нэгэн эмэгтэй хвний сандан хашиграх дуу дуулдах мэт болж, Бияагийн дуутай тун төстэй тул, яаран өндийж үзвээс Усихаагийн хэвтэж байсан газар хвнгвй. Бас Бияа байхгшвй тул, хайртай охин үгвй болсонд тэвдэж дуу алдсанд нь бусад нөхөд нь сэргээж, хоёр хвн байхгвй юу болов ? гэж цөм сандарлаа. Чих соргог тул , бvгдээрээ Бияагийн хашгирах дууг нойр дундаа сонссон тул, тэр зvгт дуу нь дуулдсан гэж бvгдээрээ яаран зэр зэмсгээ шvvрэн барьцгааж, сарын гэрэлд хяруун дээгvvр хоёр мөр үзэгдэн буйг хөөсөөр ойрхон байсан модонд орвоос, олон хвний сөр үзэгдэж, нэг газар хвн ноцолдсон байдалтай. Цөмөөрөө сандарцгааж, яаран тэр мөр хөөвөөс Гекvv, тэр олон хвний мөр дундаас Бияагийн мөр энэ байна. Өрөөсөн өсгйдөө шинэ нөхөөс тавьсан мөр нь тов тодхон байна гэж танив. Хоёр хвн ноцолдон чирvvлсэн мөр үзэгдэж, хааяа хааяа ноцолдсон шинжтэй. Чингэж явтал Бияагийн дуу нэг дуугарах шиг болоод, амы нь барьсан шиг гэнэтхэн тасрав. Бас нэг эмэгтэй хвний дуу гараад, муухай ёолох чимээ гараад нам гvм болсонд Гекvvгийн зvрх тvгшиж, Усихаа алуулжээ гээд сандран ухасхийх гэтэл, Шонхолой тогтоон, бvгдээрээ бөөн явахгвй бол горьгвй гэж тайтгаруулан, халуун мөрөөр нь хөөв.

- Дуу чимээ гарч дайсанд сэжиг төрvvлж хэрэггвй. Сэмхэн мөрөөр нь хөөе гэж Шонхолой, нөхдөө дагуулан шамдваас Гекvv бачимдан яарч, Бияагаа дайсанд амь алдуузай гэж тэвдэв. Хөөж ширvvлэн явсаар нэгэн газар хвн унасан байдалтай. Өвс хяруу дээр цус харлан харагдаж, баахан явтал цус болсон Усихаагийн өрөөсөн сөөхий олдлоо. Мөрий нь мөшхөж явсан ойн эмс, нэг газар зулзган мод унагаж авсан ором өвс хяруун дээр нэг хвн хэвтvvлж, модонд хвлэн дамнасан байдал үзэгдсэнд, Усихааг модонд дамнасан авч явсныг мэдлээ. Модон дунд мөрий нь хөөсөөр явбаас, явдал дундаа ээлжлэн дамналцаж, бас Бияаг чирэн явсан мөр сарны гэрэлд модны завсар цоорхойд тодхон үзэгдэв. Шонхолой дайсан сэрэмжлэж магад хэмээн, өөрөө тvрvvлэн, бусад нь цуван дагаж, мөр мөрөө гишгэн аль болхоор чимээ гаргахгвйг хичээж мөшхөн хөөж нилээд явтал , өөдөөс нь салхинд тэдгээр үл таних хвний үнэр сэнгэнэх болсонд, шөнө халдсан дайсан ойртлоо гэж маш болгоомжлон , модны сvvдэр дагаж нуугдан, Ганц Шонхолой, Залуудай, Гекvv гурав мөрөөр нь ил явтал, алсаас модон дунд гал харагдах шиг боллоо.

- Хоёр охиныг халдан олзолсон дайсан буудаллаж, гал твлэн, хоолоо хийх гэж байгаа мэдээд, машид сэрэмжлэн, тун нууцгайгаар салхины нь дороос отог буудалд нь ойртохоор шийдээд, Шонхолой ойн эмсийн эгчмэдийг намайг дайран орохоос өмнө гар хөдлөж болохгвй гэж захиад, Залуудай, Үхvv, Гекvv гурвыг дагуулан сэм ойртоход, дайсны үнэр улам их болсоор, галын гэрэл чих болж, бvр ойртосхийж очоод модны цаанаас ажин харахад, Бияа ам нь таглаастай, хоёр гар нь араадаа хвлээстэй, галын хажууд сууж байв. Нилээд хэдэн гvжирмэг эрс гал тойрон сууж, хоёр хвн чулуун сvхээр Усихаагийн биеийг завчин эвдэж байгаа нь тvvдгийн сvvмэлзэх гэрэлд үзэгдэв. Ойн эмсийн эгчмэд нь Шонхолойн дэргэд аяархан хvрч ирээд, дайсны тоо нь миний хоёр гар, хоёр хөлийн хуруун дээр бас гурван хуруу нэмсэнтэй таацах олон хvнтэй юм байна гэж тооллоо гэхэд нь Шонхолой,

- Олондоо найдаад сэрэмжгүй явж байгаа юм байна. Бидний нум сумтайг хараахан мэдээгүй тул, цочмог дайран ороход, урьдаар харван сөнөөж цөөрүүлэн цочооно. Бид тав ойртосхийж очоод, модны цаанаас харвая. чингээд сандран тэвдэхэд нь бүгдээрээ хашгиран сүрдүүлж, бид тав харвасаар, бусад маань тойрон бүслэж, дутаасан нэгий нь дайр. Сум тоолон унагана шүү. Тэгээд сүхтэн жадлана. Бид хочр удаа алдалгүй харавбал дайсан биднээс цөөн болж, цочмог дайруулсандаа эрхгүй дарагдана. Ганц Бияагаа мэдэж байгаарай. Дарагдах болсондоо өширхөж, охины аминд хор хийгүүвэй гэхэд Гекүү,

- Би дайран орсуу гэхэд нь Шонхолой тогтоож,

- Чи яаран дайрч, амь үрэгдвэл тусгүй. Чин зориг барьж, самбаатай тул гээд улам ойртосхийтэл, галын гэрэлд үзвээс хөөрхий Усихаагийн гавлыг хага цохиж, тархий нь гаргаад, хоёр нүдий нь ухаж, ахмад нэгэн чийрэг хүнд дээж болгон идүүлж байгаа нь харагдаж, түүний элгий нь огтчин идэж махы нь галд шарж эхлэв. Намайг харвахад нэгэн зэрэг харваарай. Бусад нь яаран гарч, дайсанд биднээс урд үзэгдэж болохгүй гэж тушаагаад, таван харваачин сэмхэн бас урагш давшиж, модны нөмөрт хоргодон, нэгэн зэрэг харвахад таван хүн суманд оногдож, алдлан унав. Гал тойрч суусан хүмүүс машинд сандарч тэвдтэл бас дөрвөн хүн ойчиж, нэг хүн өрөөсөн гартаа сум шигтгээстэй босон харайж, модон зүг дутаах гэтэл, ойн эмс хашгаралдан зам хөндөлсөж, тэр хүнийг цохин унагасанд, Шонхолой хашгиран дайраад, Үхүү, Залуудай, Гекүү дагалдан гүйж, явдал дундаа харван бас гурав дөрвөн хүн суманд шархдан унав. Чингэтэл ойн эмс муухай дуу тавин жад шийдмээ эргүүлэн дайрч орвоос амьд үлдсэн дайсан, дайран орсон хүний олонх нь эмс байгааг үзээд, хэдий тэдний тоо давуу боловч, эм хүйстэй гэж ороод зориглон тулалдав. Таван харваачин ойн эмсийн бороохой жаданд нь нэмэр болгож тэдний өөдөөс дайран орсон дайсныг харавсаар сум барагдаж, сүх жадаа барин их түүдгийн гэрэлд тулалдав. Гекүү яаран Бияагийн дэргэд гүйж очоод хүлээсий нь огтчих гэж оролдож байтал баруун хөхөн тушаагаан сум хадаастай тэр махчны ахмад маш чийрэг эр өндийн босоод Гекүүгийн араас жадлах гэтэл, Залуудай яаран ухасхийж, сүхээрээ тэр чийрэг эрийн эгмийг тас цавчтал, араас нь нэг хүнд юм лүсхийж буугаад, дээрээс нь нэг хүнд зөөлхөн юм дараад унах шиг болж, даруй нүд харанхуйлан ухаан алдав. Хичнээн хэвтсэнийг бүү мэд, нэг мэдэхнээ, түүдгийн дэргэд хэвтэж, хажууд нь нэг үхсэн дайсан алдан сунаад, Шонхолой, ойн эмсийн эгчмэд, Үхүү гурав тэнхрүүлэн илж суунам. Энд тэнд гал тойрон унаж дуссан дайсны хүүр үзэгдэн, хэдэн эмс шархаа боож суунам. Гекүү газар сууж, дэргэд нь Бияа сувилан оролдож байгаа бололтой, нуруу зоогий нь барьж байнам. Элгэндээ үстэй, хувцас хунар нь ноцолдон урагдсан хүйтэн хөх царайтай, муухай харцтай дөрвөн махчин, гар нь ардаа хүлээстэй нэтийн сууж, маш уруу царайлсан байдалтай. Үхүү Залуудайн ухаан орсонд баярлаж, маасагнан инээж, дун цагаан шүдээ гялалзуулан :

- Дайснаа дарлаа ... Дөрвий нь олзлож, бусад нь хөөрхий Усихаагийн сүнс дагалдан одлоо. Манайхнаас хэдэн эмс хөнгөн шарх олж, бусад нь гэмгүй. Гекүү та хоёр л ухаан алдатлаа цохиулснаа одоо сэхлээ гэж, Гекүүг заав. Залуудай, Гекүүг жадлах гэсэн махчин ахмадыг сүхдэлтэл, хойноос нь нэг махчин бороохой далайн буулгаж, ойн эмсийн эгчмэд ойр байснаа Залуудайд үхэх аюул тохиосонд яаран ухасхийж,

тэр махчныг шилэн хэвдгий нь нугас тасартал жадлаж, Залуудай дээр буух бороохойн хвчийг сулруулан, хувгийн амийг аварсан байжээ. Тэр завсар нэг махчин эгчмэдийг өрөөсөн гары нь халт жадлаад Шонхолойд сүхдүүлэн унасан байжээ. Амьсгалаа дарж баахан амсхийгээд, дайсанд эвдүүлж муугаа үзсэн хөөрхий Усихаагийн үе мөчөөр нь салган сэглэсэн, биеий нь байдаг ёсоор нь эвлүүлээд, хага цохисон гавал толгойгий нь дайсны сармай хувцаснаас тастаж, эвлүүлэн тааруулж, биед нь наалдуулан оргож, заалсан эрвүгий нь боож тогтоогоод, модны холтос дээр хуврий нь талбин, ойн эмсийн заншил ёсоор модны гишүүнээс өлгөн оршуулаад, дайсны хуврийг олзолсон дөрвөн махчнаар үүрүүлэн нэг газар овоолон хаяултал үүр хариугүй цайлаа. Тэр завсар Залуудай, Гекүү хоёрын бие ч залуугийн чадал их тул явж чадахаар болж тэнхрээд, олзолсон дөрвөн махчнаа яахав? гэж бүгдээрээ зөвлөлдлөө. Тэднээс үг асуухад, хэл нь мэдэгдэхгүй хэл буруутан байв. Ойн эмсийн эгчмэд нь хорт могойг эрээн гэж басаж болохгүй, дайсныг цөөн буурай гэж басаж болохгүй. Ижилд нь нийлүүлэн цохиж алмал таарна гэж санал гаргаад, ойн эмс бүгдээрээ тэх нь зөв гэж шуугилдав. Тэр дөрвөн махчин хэдий хэл мэдэхгүй боловч, дууны өнгө, царайн байдлаар шинжлэн, алуулдаг цаг ирлээ гэж мэдээд, гурав нь тун ч урамгүй шалчгар бололтой, ахмад бололтой нэг нь нөгөө гурвыгаа зэмлэсэн байдалтай үглэж байв. Үхүү, Гекүү хоёр, бас өстөн дайснаа өрлөвөл таарна гэж ойн эмстэй санал нийллээ. Шонхолой, олны санал сонсоод, толгой сэгсрэн:

- Бид махчин биш. Махчны ёс дагавал бидэнд зохихгүй. Хүний үнэр алдаагүй цагт бид хүн шиг байх ёстой. Алалдан тулалдаж, амиа хамгаалахад дайсны амь бодохгүй нь зүйтэй. Гартаа орсон дайсны муугий нь үзэж, амий нь таслаад яахим. Бидэнд хор хийхээс энэ дөрөв өнгөрсөн. Суллан тавья. Тавилангаараа болог. Эднийг алаад яахам. Хорхой чгэсэн аминдаа хайртай шүү дээ. Эднийг хороогоод Усихааг босгодогсон бол нэг хэрэгсэн. Тэгж чадахгүйгээс хойш, улай дээр гаргаад юу хийхэв. Тавья. Хайшаа л явдаг бол яваг гэхэд нь ахалж явсан хүнийхээ амыг бүгдээрээ дагаж, тэр дөрвөн махчны хүлээс тайчин тавьсанд, амьд гарснаа итгэхгүй, яаж маныг алах нь бол гэсэн шиг айж эмээсээр холдоод хойноос нь нэхэж хөөхгүйг үзээд, яаран далд орлоо.

Их мөрөн өгсөн явсаар нэгэн өдөр уудам цагаан талын захаар хоёр завиндаа ээлжлэн сууж, сэлэх газар сэлж, хатгах газар хатгаж явтал нэгэн эрэг бүүргийн хавьд айстал, нилээд олон хүн зэллэн сүрэг олон тахийн зүг чиглэж явах нь үзэгдлээ. Танихгүй газар, танихгүй олон хүн үзэгдэхэд, эргийн дагуу явсан эмэгтэйчүүд, Шонхолойгоос яадаг билээ гэж асууж, бүгдээрээ усны нөгөө талд гарах уу гэлцэж байтал, тэр олон хүнээс хоёр хүн, аянчны зүг гар даллан алхлаа. Хоёрхон хүн юм байна. Уулзаж, учры нь мэдье дээ гэж Шонхолой хүлээтэл, тэр хоёр хүн ч ойртон ирлээ. ХҮрч ирээд эсэн мэндийг асуулцваас үг аялгуу нь төлөв мэдэгдэх тул, хаанаас хайшаа явж байгааг харилцан мэдэлцэв. Тэр хоёр хүн, отог олноороо намрын аь хийх гэж гарсан. Тахь хөөж эрэг бүүргийн зүг хөөн гаргаад, доош нь унаган агнах гэж байгаа. Дор нь отгийн өтгөс, эмс хүүхэд хүлээн тосч байгааг хэлээд, нэгэн мөрний тусламж гуйсанд бүгдээрээ зөвшөөрч, нөгөө олон дээр хүрэлцэн одов. Анчинтай амар мэндээ мэндэлцээд, зэллэн тархаж, тахийн сүргийг аяархан тэр эрэг бүүргийн зүг хашин явахад, тэр зэллэн яваа анчин хавирган сар мэт хашин хүрээлж ойртсоор, тахь ч тэднээс аажимхан зайлж, хөөсөн зүг тийш хумигдан туугдав.

Дагасан анчин улам бие биедээ ойртон хумисаар тахийг шахахад, түрүүчийн тахь нь тэр өндөр эрэг бүүргийн захад хүрээд, баахан бачимдах байдал мэдэгдэн эргэж, буцахад нь гөрөөчин, хэдийн модонд тостой өвс уяж, бамбар хийснээ асааж, галтай бамбараар даллан гууглаж, олон хүнд шахагдсан тахь тэр доошоо ханан хад болсон эрэг бүүргийн орой дээр овооролдон, азарга нь унгалдаж, унага, даага, гvv цөм бие биедээ шахалдан, хүний үнэр, тостой бамбарын утаа хиншүүнд сүрдэн сандарч овооролдлоо. Тахь хөөгөөч анчин, ахар жад, бороохой зэвсэгтэй бөөгөөд, жад шидэж болох газар ойртох гэж хашгиран ойрттол, Шонхолой тэргүүнтэй таван харваачин сумны тусгал нь гараар шидэх жаднаас арай тусгал холтой тул, тавуулан зэрэг харван, бөөгнөрсөн тахийн тавыг харван оносонд, өвдөн сандарсан тахь ухасхийж сүрэг дотроо шургалан орох гээд, цаана нь халилын ирмэг дээр байсан хэдэн тахийг доош нь түлхэн унагалаа. Тэгж байтал, харван айстал, жадтай анчин ч жад тусам газар ойртож, бусад нь хашин шахахад олон хүний хашгирах, жадлах, харвахад бие биеэ түлхэн урагш ухас хийсэн тахь хадан ханил уруу нэг нэгнээ түлхин унагаж, зарим шарх олсон нэг нь сандран тэвдсэндээ өөрсдөд доошоо харай, олон анчин гууглан хашгирсаар, улам хумин шахахад, дуу чимээ галт бамбараас айн сүрдсэн тахийн олонхи нь доошоо харайлан ойчиж, үлдсэн хэдий нь цагаан талын зүг зайлан гарах замыг анчин шахан хаасан тул, цөмөөрөө хадан халил руу үсрэн далд орлоо. Шонхолой нөхөд сэлтээр хадан халиллын ирмэг дээр хүрч доош үзвээс, тэр сүрэг тахь цөм өндөрөөс ойчин үхэх нь үхэж, зарим нэг нь хөлөө хугалж, унгалдан тийчилж байтал тэр хавьд нь хоргодон тосож байсан эмс, өтгөс, жад бороохойгоор амьд тахийг цохилон нүдэж, бужигнан үймэлдэж байв. Хадан налилын ирмэг дээр өнөөх тахь шахсан олон анчин цуглаж, ав урагштай боллоо гэж баярлан хашгиралдаж байтал, шугуйн бургаснаас нэгэн бөлөг хүн жад бороохой барин гарч ирсэнд, дээр байсан анчин тэднийг хараад дор байгаа хүндээ мэдэгдэж хашгиралдан, баахан сандарсхийсэн байдалтай, эрэг бүүргийг тойрон буух зам эрэн гүйлдэв. Анчны ахмад нэгэн чийрэг эр, том гэгчийн бороохой атган, Шонхолойн зүг айсан хүрч ирээд,

- Манай олз булаах атаатан хүрч ирлээ. Тулах цаг боллоо. Та нар минь туславал их л сайн байна. Гагцхvv аяны явуул хүн болох тул хоёр омгийн эвдрэлдэж, олз булаалдах тулаанд орох нь та нарт харамсалтай юм уу даа. Гэвч, бид хамтын хүчээр нийлбэл та нарын мөрөн өгсөх замд тосон халдах дайсан энд дарагдвал, та нарт ч бас хэрэг болох асан байх. Та нар бидэнд бас тэр хол тусгалт багаж жадаараа нэмэр тус үзүүлбэл сайн л юм асан гэхэд нь Шонхолой ойн эмсийн зүг харваас, эгчмэд нь :

- Нөхрийн тус бүтээлвэл, өөрийн тус бүтнэ. Үзэлцээд алдья. Бид тулахад бэлэн гэж нумаа өргөн далайхад, ойн эмс жад бороохойгоо далайцаган, уриагаа хашгирсанд, Шонхолой, тэр анчны ахмадын зүг толгой дохин зөвшөөрч, хойноос нь даган яаран доошоо бууцгаав. Доор байсан эмс өтгөсийн зүг ахмад нь хэдэн үг хашгиран дохиод, сандан мэндэн бусдынхаа хойноос хар эрчээрээ гvйн гvйцэж бүгдээрээ доошоо бууж, эрэг бүүргийн ёроолын захад хүрч одвоос дор байсан өвгөд эмгэд, эмс охид, хvvхэд шуухад нь цөм тэр гэнэт халдсан дайснаас зайлан, идэр чийрэг анчнаа хүрэлцэн ирэхийг хүлээн бөөгнөрөөд байлаа. Дээрээс буусан анчин хүрч ирээд,

унасан олон тахийн дэргэд хврч ирсэн тэр тонуулчныг үзвээс, тоогоор бараг ойролцоо бөгөөд, дээрээс яаран бууж амьсгаадсан анчныг бодвол, гвиж цуцаагви, ханаран жагсаад, гууглан хашгиралдаж, олзоо өгөх шинжгви, халдвал тулна гэсэн байдалтай, жад бороохойгоо далайн хашгиралдаж, муу свр үзүүлэн авай. Зарим нэг нь урагш давшин богино жадаа шидэх лврэм үзүүлэн байтал, Шонхолой нумтай дөрвөө нөхдөө харав гэж тушаагаад өөрөө түрүүлэн харвасанд, нум сум үзээгви тэдгээр дээрэмчин, огт ажиггви ханхалзаж байтлаа, гэнэт таван хвн суманд шарх олж ойчиход, машид гайхан сочиж, унасан хвнийхээ дэргэд овооролдтол бас таван сум хврч ирэн шигдэхэд, сандран хашгиралдаж, бууруултал тахь агнаачин, жад шидэх газар давшин хврч ирээд, хэдэн хвнийг унагаж дайсны сандарсанд зоригжин, эр эмгви хашгиран дайрч орвоос унаж, шархтай болсон үхсэн хвнээ чирэн дамжилж ухарцгаахад, харваачин хойноос нь харван хөөж тархаан сарниулав. Сандан тутаасан дайсан, дамжилж явсан зарим хвнээ унаган гэж, мэндэн гвйлдэж мөрний бжргасанд далд орох санаатайг анчны тэргвн мэдээд, замын нь хөндөлсөн боох идэр анчин явуулахад Үхvv, Гекvv хоёр Хумкагийнхаа дайчин уриа хашгиран, хойноос нь ойн эмсийн эгчмэд, жадтай эмсээ дагуулан гвицгээв. Залуудай бас нөхдөөсөө хоцрохгви гэж эцгийн өөдөөс харваас дохин зөвшөөрсөн тул бас хурдлан шамдаж, тэр дайсны зам боож, залуу гавшгай анчин, өнөөх тутаасан дайсныг цагаан тал уруу хөөн одов. Ухран тутааж яваа халдагсдын дунд шарх олсон хэдэн хвнийг бусад нь твшин авч явахдаа хурдлан зайлж чадахгви, нэг хэсэг хвнхоцросхийн гвицэгдэх болсонд бусад нь тэдэндээ туслаар эгтэл нум сумтай Үхvv, Гекvv, Залуудай, Эгчмэдийн суманд тусандан унаж байгаа нь холоос илхэн харагдаж нэг том хвн алдлан ойчиход, бусад нь твнийг тойрон овооролдоод, анчныг ойртон бvслэхэд зэвсгээ хаяцгааж, сөгдөх нь сөгдөж гараа өргөн амь гуйх нь гуйж байгааг Шонхолой хараад, лав ахмад эрхэм нь шарх олж бусад нь дагаж оров бололтой гэж бодтол тахь агнаачны тэргвн баярлан,

- Дайсан отгийн тэргвн шарх олж, тутаан зайлж чадахгви болоход, бусад нь бууж өглөө. Хвн яаж ахгви, дээл захгви байхав дээ, гэж гуяа алгадан дэвхцэж, одоо тэргвнтэйгээ бууж өгсөн хойно бидэнд халдахгви нь лавтай боллоо. Энэ бол, та нарын гайхамшигт зэвсгийн свр гавъяа, манд тэр гайхалтай зэмсгийн хишиг хвртээн хайрлаа гэж Шонхолойг тэврэн, тэсгэлгви элэгсэг найртайгаар гуйлаа.

- Болно гэж Шонхолойн хариулахад тэр отгийн тэргвн тал өгч баярлан ёслоод, дайнаа дарсан анчнаа хвлээх завсар өтгөс эмс хадан халил аас ойчин үхсэн тахийг өвчиж, улирал сэрвн тул, агуйн хвйтэн хонгилд вvцлэн хадгалахы нь ялган, нэг хэдэн тахийг оройн хурим идэхэд бэлдэн ажиллав. Тэр завсар дайснаа хөөж олзолсон анчин, зэр зэвсгий нь вvрэн, шархтай дайсныг бусдаар нь вvрүүлэн дамжуулж хврэлцэн ирлээ. Отог омог дотроо маш шудрага винэнч ьөгөөд, харь отог омгийнхонтой хардах санаа дайсагнах довтлох вес их тул, тахь агнаачдын тэргвн Шонхолойд элэгсэг итгэж, энэ дайсны тэргвнийг олзлосон завшаанд тэдний зврхийг үхүүлэн, та гайхамшигт зэвсгийнхээ чадлыг бас нэг үзүүлэн сvрдvлж, дахин бидэнд халдахгви болгож өгнө вv? гэж гуйлаа. Шонхолой зөвшөөрч, ямар омгийн хвн болохыг асууваас, Гахан омогтны Бодонгууд отгийн хвн хэмээв. Чингээд, Шонхолой

завиасаа нэг нум авчруулж, анчныг цуглуулан , анд бололцох ёс гүйцэтгэж, олон гахай гэсэн Гахан омгийн Бодонгууд омгийн Бодон тэргүүлэгчтэй анд болж, бvсээ солилцон, нумаа хэдэн сумтай нь агсан зvвлгэсэнд , Бодон тэргүүлэгч, хариу бvсээ арслан зааны соёолт гилбэр бvхий урт жадаа өгч, тэврэлдэн ёслож, галд тахийн өөх тос өргөж, анд бололцов. Гахан омгийн Бодонгууд отгийн хvн бvгд , анд болсон Шонхолойд цөм ёслон сөгдөж, бvгдээрээ маш баярлалцав. Чингээд , Шонхолой, тахийн арьс бурнасанд тэлvвлж, тавин нумны газраас сум тоолон оноход, бvгдээрээ гайхан хашгиралдаж, дэвхцэн баярлалдав. Дараагаар нь Залуудай, Үхvв, Гекvв, Эгчмэд харвалаа гайхуулан vзvвлэхэд, Бияа Гекvвгийн онох тусам алга ташин маш баярлан жаргасан байдалтай, бахархан бахархан харахад Гекvв харавлаа гайхуулах гэж бас арван нум ахиулан хэдэн сжм харваад Бодонгуудын анчныг манай харвасан газраас та нар жадаа шидэн онож vз гэхэд, тийм холоос жад шидэн онох хvн байхгvй гэж өчив. ОЛзлогдсон дайсан, Шонхолой нарын харавлыг нэнд гайхан харж, Бодонгуудтай анд болох ёслол гvйцсэн хойно, хоорондоо шивнэлдээд шарх олсон тэргvвн нь ичих зовох байдал хvрэн улаан царайд нь мэдэгдэн, нэгэн цагийн мунхгаар олзонд шунаж халдсан буруугаа хvлээн өчөөд, vврд найрсаг болохыг хvсэн гуйсанд, Гахан омгийн Бодонгууд отгийн Бодон тэргvвлэгч, дотроос маш баярлавч, царайг төв болгон, ихэмсгээр өгvвлрvвн :

- Халдсан буруу илэрхий боловч , өнөөдөх Чонос баатар омог, Гахан омог анд болсон баяр тул, бурууг хэлтрvвлж, ял асуухгvй. Бас та нарын дотроос халдан довтолж, шарх олсон vхсэн хvн буй тул, тvвгээр шийтгэл болгосуу. Бид өшөө нэхэж, хонзон санаа агуулахгvй. Та нарын санаа vнэн аваас, манай отгийн галд мөргөн , vврл найрсаг явахын тангараг өргө гэхэд олзлогдсон омгийн тэргvвн, галд өргөх тахийн өөх мөөх гуйж , гартаа барин босоод, голын өмнө очиж дуудруун :

Увачаан омгийн бидэн
Уулгуулсан буруугаа хvлээн
Улайж ичсэн царайгаар
Уруу буруу болсноо энд
Илэн далангvй хvлээж
Илэрхийлэн тангараглам
Чон чулуун зэвсэгтэй
Чонос омгийн дайчин
Гахан омгийн Бодонгуудын
Галын өмнө батлан хэлсvв
Цвачаан Гахан хоёр омог
Урт удаан найрамдаж
Уулын гөрөөс, талын тахь
Хамт хvчээр агнан гөрөөлж
Халдах дайсныг хамтаар
Хамх дарж явсугай
Үеийн вед верхэж
Үврд найртай болсуу

Цэгээн чулуу хамхарч
Цээл ус ширгэтэл
Тангаргийн энэ угс
Тасрашгвй бат амуу
Баа, ваа , ваа

гэж омгийнхоо дайчин уриа хашгирахад Увачаан омгийн эрчүүд бvгд Баа, ваа ,ваа гэж омгийнхоо уриа хашгиралдан, баруун гараа өргөцгөөн ёслов. Снамсаргвй ингэж найртай болсонд Гахан омгийн олон цөм баярлалдан бvгдээр хуримлан, хэдэн тvндэг гал өрдөж, гал тойрон хатирах наадам хийж, шөнөжин бvжив. Увачаан омгийн хэл аялгуу нь ойн эмсийн аялгуутай нийлэх зvйл улэмж байсанд ойн эмс Увачаан тэсгэлгвй баярлалдаж, хурим найр, бvжиг дуу маш хөгжилтэй болж хоёр өөр омогтон харилцан найртай болсон нь Чонос Шонхолойн ач гэж тэсгэлгвй элсэглэв. Чингээд өглөөний өөд улаан нарнаар Гахан омгийн нэгэн өтгөс санаа дээшлvүлж хоёр омог vүрд найртай болсон баярт, намрын тахьавладаг энэ ханан хаданд бэлэгтэй зураг зурж, хамт авлан хуримлаж ёслосуу гэхэд бvгд баярлалдан зөвшөөж тэр өтгөс уран хvн тул, тахийн өөх тос хоршин нухсан зусаар ханан хаданд олон тахь хөөж яваа анчин дvрслээд, нум сумтай таван хvн зуралцсан нь Шонхолой тэргvүтэй таван харваачин анх ирж, Гахан омгийн хvнийг нум сумтай болгосныг vүрдийн дурсгал болгож, өөх тосоор зургийг мялаан ёсолж, бvгдээрээ Шонхолой нарыг маш найрсгаар vдэн ёсолж завинд нь тахийн махнаас хийж алсын замд ерөөн явууллаа.

Их мөрөн өгсөж, нилээд олон хоног явтал, нэгэн өдөр уудам цагаан тал хаашаа л харвал , намрын хагд цагаалж халиуран , алс хол тахь, зээр, хааяа хааяа хоёр эвэрт хирис, сvрэг арслан заан vзэгдэх боллоо. Аянчны олонхи нь явгалан аялж яваа бөгөөд зөм гудас жимс мэхээр зэргийг тvүж, хоолны хийцэнд зориулан алсын бараа харж намрын шар наранд таатайхан явтал, эрэг нь аажууханаар өндөрсөж нөгөө талын эрэг нь нам болж ирлээ. Шонхолой өглөөнөөс завиа хатган жолоодож явсан тул, баахан явгалан явж гараа амраасуу гээд рйн эмсийн нэг чийргий нь завиндаа суулгаж, бусдын хамт явгалан явж, улам өндөр болж байгаа эргийн өөд аажуухан алхалцгаатал, хvн шуугилдах чимээ гарсанд бvгдээрээ чих талбин , тэр зvг харваас , жад бороохойтой нилээд олон хvн тэр өндөр эргийн таг тавцан дээр vзэгдэн гарч ирлээ. Дунд нь гурын арьс нөмөрсөн хоёр хvн толгой дээрээ бор гөрөөсний арьс эвэртэй нь өвчиж хийсэн малгайтай болотой, цовхчин бvжиж нэг нь тал хэнгэрэг шиг юм тvн тvн цохилон хоёул тэр хэнгэрэгийн цохилд хөлөө нийлvүлэн vсэрсээр гарч ирлээ. Чингээд хоёр талаасаа бие биеэ vзэцгээж урагш ахихыг зогстол, өнөөх хоёр хvн дэвхцэн бvжсээр нэг нь хэнгэрэгийн цохилтод нийлvүлэн юм хашгиран дуудаж буй мэт.

- Энэ арзайсан олон хvн нэгэнт биднийг vзсэнээс хойш ухран зайлбал гэмтэй. Учран золгож л нэгийгээ vзэх ёстой боллоо гээд Шонхолой, тэдний зvг зориглон алхлаа. Цаадуул ч аянчныг хараад нэг хэдэн хvн айсан дөхтөл, хацартаа сорвитой нэгэн хvн тэдний дундаас Шонхолой нарыг ширтээд, сочин гайхсан мэт зогслоо. Шонхолой ч тэр хvнийг салаар уруудах вес тулалдсан хvний нэг нт мөн байна гэж таниад , Үхvв,

Гекvvгийн зvг харваас бас л хэдийн таньсан тул , царайд зовних байдал мэдэгдэж, Үхvv шивнэн өгvvлрvvн :

- Миний суманд харвуулсан хvн явж байна. Одоо яана ? Эд лав бидэнд өшөөтэй байх гэхэд нь Шонхолой,

- Эмээснээ мэдэгдэн хормойчирснээ vзvvлбэл, хэрэг биш болно. Зоригтой бай гээд , урагш давшив. Ойн эмсийн эгчмэд, бусдаа дагуулан, Шонхолойн хойноос жадаа атган алхтал тэр хацартаа сорвитой хvн нөхдийнхөө зvг нэг юм хэлээд бор гөрөөсний эвэртэй малгат хоёр хvний зvг гvйн одлоо. Шонхолой нум, сумаа барин, нөгөө дөрвөн харваачнаа нум сумаа наймайг харвахад хvрвэл шvvрэн авч харваарай. Наана нь болохгvй. Айж эмээсэн байдал яасан ч гаргаж болохгvй гэхэд ойн эмс газар тэнгэр нийлсэн чбид дуу алдаж ахын vг захианаас зөрөхгvй гэлээ. Аянчны өөдөөс чиглэн ирж яваа хэдэн хvн , нөгөө хvнээ ирэхийг хvлээн зогстол, Шонхолой годоль харвам газар хvрч очоод, зэмсгээ газар талбин найрсаг байдлыг vзvvлбээс , өнөөх олон дээрээ гvйн одсон хvн, тэр эвэртэн дээрээ хvрч очоод наашаа дохин дохин дэвхцэж, юм хэлж байгаа бололтой. Чингээд цаад олон нь эвэртэнээр удирдуулан , жад бороохойгоо далайн далайн наашаа яаран алхлаа. Наана нь тосон зогссон хvмvvс тэндээ хvрч ирэхийг хvлгэлзэн зогсож байснаа наад аянчны зvг баахан дайсагнах байдалтай жад бороохойгоо дайран ороход зэхэн зогсов. Шонхолой ч хэрэг биш болсныг vзээд, нум сумтай хvн цөм алдалгvй харвахад дохио өгмөгц бэлэн бай гэж захиад , бvгдээрээ бас зогсов. Чингэж байтал эвэртэй малгайтай хоёр хvний дохиогоор жад бороохойтой олон хvн хашгиран дайрав. Годоль харвах газар гvйн ойртосхийж, Шонхолой нумаа барин зэхтэл, гэнэт нар халхлагдаж, эхлэх мэт боллоо. Дээшээ харваас тэнгэр маш цэлмэг нэг ч vvл байхгvй. Гэтэл нарны гэрэл улам бvдэг болж, гялбам хурц гэрэлтэй нарны нэг захад хар сvдэр мэт юм vзэгдэж, дайран орж явсан хvмvvс, тэнгэрийн тэр vзэгдэлд хэлмэгдэн социж, зог тусан, өнөөх гөрөөсний эвэртэй хоёр удирдагчид нь ч тэсгэлгvй эмээсэн бололтой , нэг нь тал хэнгэрэгээ сандран цохиж, нөгөө нь нарны зvг хандан юм дуудаж хашгирлаа. Наран улам гэрэл муутай болж агаараар нисэн хальж байсан элээ бvргэд хагшин дуугарцгааж, өргөн цагаан талын зvгээс ан амьтны эмээн сандарч заан хирисийн урхирах дуун дуулдлаа. Нарны мандал улам халхлагдсаар хvн амьтны царайн өнгө vнсэн хөх мэт тун хачин болж, орчин тойрны уул тал бас жигтэй өнгөтэй болж ирлээ. Өнөөх хашгиран дайрсан олон ч сандарцгаан тэвдсэндээ зарим нь сөгдөн нарны зvг гар сунган мөргөх аж, зарим нь зоомол чулуу шиг зогсон тэнгэр газрын өнгө сvртэй сонин болсонд эмээн айжээ. Ойн эмс сандран тэвдтэл, Шонхолой та нар битгий ай, Бид айх ёсгvй. манд халдсан дайсан айн сочиж байх тусам бид зоригтой зvрхтэй байж, тэдний адил эмээн сочих байдал огт vзvvлж болохгvй гэж тайтгаруулахад Шонхолойн байдал нэн тайван тавиун vг дуу нь хvний зориг сэргэмээр тогтуу сайхан тул, ойн эмс зориг орж сэтгэл дотор нь уужирлаа. Тэр завсар нарны мандлын даруй нэгэн дундуур нь хар сvдэр мэт юманд халхлагдан, цагаан талын зvгээс айж хэлмэгдсэн ан амьтны дуу чимээ улам их боллоо. Өнөөх гурын эвэртэй малгайтан ч нэн мэгдэж, хэнгэргээ хаяад дэмий л сөхрөн мөргөж, бусад нь тэдний нэгэн адил сөгдөцгөөн ам амандаа юм хашгирах ажээ. Тэднийг дайран довтлоход тун ч амархан дээрээ хvрсэнд ойн эмс зориг орж, Шонхолойг энэхэн завсар дайснаа дайран дарцгаая гэхэд нь Шонхолой

хориглож, дэмий алалдаад яахав. Айж эмээхгвй байдлаа тэдэнд vзvvлбээс манаас тэсгэлгвй эмээх болно гээд аажуухнаар урагш давшлаа. Ойн эмс араас нь даган нарны мандал, бараг халхлагдан, дэлхийн өнгө байдал нэн чсvртэй , аягвй болоод, жихvvн салхи сэнгэнэн сэрvvн хvйтэн амьсгалтай болж ирлээ. Чингээд нарны гэрэл улам улам бvдэг болсоор, огторгуйд олон одон жарав, жирив гялалзсанд , цагаан талын зvгээс vй олон ан амьтны сандарсан дуу бvр ч их болж, аянчныг дайран халдах гэж явсан олны машинд айн мэгдэж, бэндэн хашгирах чимээ нь орчин тойрны шуугиан чимээн дээр улам ч чимээ нэмэгдэж ирлээ. Дайсагнан халдах санаа нь хэдийн vгвй болж, Шонхолой нарын айван тайван байгааг хараад, гурын арьсан өмсгөлт, эвэртэй малгайтай багтан хоёр хvн яаран урагш давшиж, чичрэн дагжин Шонхолойн өмнө сөгдтөл, нар бvрнээ хиртэж, гэгээн цагаан өдөр байснаа гэнэт хав харанхуй шөнө болж, талын олон амьтан сочин эмээж шуугилдах нь улам ч их болж ирсэнд Шонхолойн нөхөд мөн айсан бловч, ахлан тэргvvлсэн хvн , нэгэнт битгий айсан байдлаа мэдэгдэж сандар гэж захин сануулсаны нь бодоцгоон, Шонхолойг тойрон нэг нь мөрөн дээр нь гараа тавиад , бусад нь дам дамаа бие биеэсээ барилцаж Шонхолойн чимээгвй байхад хатуужин зогсож байлаа. Наран бvр мөсөн хиртэхийн өмнөхөн хоёр тэргvvлсэн хvнээ даган ухасхийж арл нь сөгдөцгөөсөн өнөөх халдах гэж сvр бадруулж байсан ястан цөмөөрөө амь наана гэж тэргvvлэгчээ даган бархиралдаж, нэн ч бачимдав. Огторгуйд нарны мандал голдоо төгрөг хар, тойрон дөлтсөн байдалтай нэн аймаар сvртэй харагдаж байсаар аажуухнаар нэг захаасаа гэрэл харван, маш харанхуйд гэгээ тусах мэт болж, урхирах, бархирах чимээн дундуур баярлалдан хашгирах дуу гарч, эмээн сvрдсэн тэр vl таних аймгийн хvмvvс, эьэртэй багтай хоёр тэргvvлэгч нь цөмөөрөө Шонхолойн зvг дохин мөргөж ам амандаа юм шулганалдлаа. Ойн эмс ч баярлалдан , Шонхолойгоо огторгуйн наран халхлаж, дайсныг сvрдvvлэх чадалтан хvн юм байна . Дайсны сvрдэн айж, гуйн мөргөхөд нь нар халхласнаа тавьж байна гэж vнэн голоосоо итгэцгээн, Үхvv, Гекvv хоёр ч бас Шонхолойг айхтар чадалтан хvн юм байна гэж маш бишрэн бахархсан байдалтай зогсож байхад нөгөө халдан довтлох гэж байгаад наран хиртэхэд айн сvрдсэн омгийн хvмvvс ч Шонхолойн нөхдийнг огт ажигвй , ард нь зогсоцгоон царайд нь ялгуулсан баярын шинж тодрон буйг нарны гэрэл гэгээ нэмэгдэн буй сонин хачин өнгөт бараг сvдэр сvмэлзэн жихvvн салхи сэнгэнэн буй вес ажин ахрж барьсан жад шийдмээ хэдийн хаяцгааж сөхөрцгөөн дохиж байхад Шонхолой нарны мандал цухуйж хар сvдэр нvvн зайлж байгааг дагуулан гараараа занган дохисонд суллан тавьж байна гэж ухаараад , дэвхцэн баярлалдаж, өргөн талд ан амьтны сандран урхирах, буйлах, мөөрөх , улих чимээ ч намдан нарны мандал улам тодорсоор хvйтэн салхи сэнгэнэхээ ч байж, дахин цэлмэг тунгалаг сайхан өдөр боллоо. Шонхолойн зvг мөргөн юм тамлан дуудаж байгаа нөгөө эвэрт багтын хоёр хvний vг хэл нь огт мэдэгдэхгвй боловч, Шонхолой тэднийг хэлдэг дууддаг юмаа гvйцээн чимээгвй болсонд өндөр дуугаар эхлээд баахан зандах байдалтай сvлд нь дууныхаа өнгийг найрсаг эелдэг болгон :

Хамаагвй хvнийг
Халдан дайрдаг
Хvчээрээ тvрэн
Хvнийг довтолдгоо

Тэвчин ая даа
Тэвчин ая даа
Эцгийн олон
Эв нэгтэй
Эхийн олон
Элэг нэгтэй
Эсэн мэнд
Энх жаргацгаая

гэхэд нь хэлий нь эс нэвтрэвч анхандаа буруушаагаад сүүлдээ лав л өршөөн хэлтрүүлэх шиг боллоо гэж ухаарч дохиогоор босоцгоогоод эвэртэй багт нэг удирдагчийн үгээр хэдэн хvн гэдэргээ гvйн буцаад, удалгvй нэгэн зээрийн мах тахийн өрөөлийн хамт ацраад, Шонхолойн хөлийн өмнө тавилаа. Чингээд Шонхолой нарыг завинд нь хвртэл үдэж ус өгсөн чвахад нь дохин ёслож хоцорлоо. Залуудай эцгийн дэргэд зогсоод эргийн дагуу хатгаж завиа ус өгсүүлэн явах зуур, Нар халхлагдан харагдахгvй болоход бид маш их айлаа. Та огт зовохгvй байсан учир юу билээ ? Дайсныг айн сүрдүүлэх гэж зориуд нар халхлав уу ? гэж асуутал, Шонхолой,

Нар чухам яагаад тийм болдгийн учрыг би мэдэхгvй. Сар шингэхийг би олон үзсэн. Өмнө газар явахдаа нэгэн удаа нар ийм болохыг үзсэн тул удахгvй дахин урьдын хэвээр болдгийг мэддэг боллоо. Тэгээд айж, эмээхгvй, харин ч халдан довтолсон дайсныг сүрдүүлж, манд маш завшаантай боллоо гэж бодож байлаа. Эс ийм тохиол учирваас, бид хvн цөөн дийлэх дийлдэх нь мэдэгдэхгvй хэцүү байдалд орсон байлаа шvv. Хvv минь юу юуны өмнө санамсаргvй тохиолдмон бэрх байдалд айж сандран тэвдэхгvй зоригтой самбаатай байвал таардгийг хожим хойшид марталгvйгээр бодон хчээж яваарай даа гэсэнд нь залуудай тэр эцгийн захиа сургаалыг хичээнгvйлэн сонслоо. Чингээд асууруун :

Аав, та тэднийг манай vг нэвтрэлцэхгvйг мэдсээр атлаа, тэдэнд vг хэлсэн учир юу билээ ? гэхэд, хvни йдууны vг буруушаасан зvхсэн байдлыг хvн байтугай адгуус ч мэдэж, буруу юм хийсэн бол, гэмээ мэддэг тул буруугаа мэдээд, тэдэнд муу санахгvй, өшөө өвөрлөхгvй гэсэн байдлыг бас дууны өнгөөр мэдэх тул өөр vг хэлтэй ч гэсэн учир бий юм шvv гээд хvвгийн гараас хатгадаг моды нь авч сэлбэн хатгалаа.

Цаашлан аялсаар их мөрөнд цутган орсон нэгэн том гол тохиолдсонд Шонхолой, зосоор тоймлон зурсан их мөрний хоёр талаас цутган орсон олон гол бvхнийг тэмдэглэмнээ байцаан шалгаж, газрын байр байдал нь уруудан ирсэн гол мөн болох тул тэр цутгалан голоор өгсөж явтал, тэнгэр бvрхэг шувуу булжуухайн болон ан амьтны байдлыг ажваас, тэнгэр муухай болж, цас шуурга зөгнөсөн шинжтэй болж ирлээ. Шонхолой тэр байдлыг ажин, баахан санаа зовнисхийж, эргийн байдлыг харж явсаар нэгэн газар завиа залан,

- Одоо энэ хавьд эртхэн бууя. Тэнгэрийн байдал нэг л биш боллоо. Шувуу гөрөөс лөв л цасан шуурга зөгнөж байх шиг байна. Тvлш базааж, завиа татан гаргаж, цас шуурганаас хоргодох арга бодож үзсүү хэмээн эргийн ойр нэгэн хадны нөмөрт хоёр завиа хөмөргөн чулуу мод ивээд гурван талаас хаяагий нь манаад, ойн эмсийн

хоргодох газар засаж, хаданд мод налуулан түшүүлж бургас мөчрөөр хучаад салхинаас хамгаалан чулуугаар даруулаад түлш базаалган бэлдүүлж байтал, тэнгэрийн байдал бүр ч муухай болж эхлэв. Түлээ түвж байсан эмс ууланд ганц нэг хүн үзэгдэж, шугуй бургасан дунд бас хүний бараа мөр дайралдсаныг хэлж ирсэнд Шонхолой ойн эмсийн сэтгэлийг засаж манд халдахгүй биз ээ. Тэнгэр ийм муухай болж байхад аягүйдвэл бидний энд хүрч ирэн цас шуурганаас амь хоргодох юуны магад. Идэх уух юмаа эртхэн хийж амжилттай хэмээн гал түлж хоолоо хийгээд дөнгөж идэж гүйцтэл салхи хөдлөөд цас лавсан орж эхэллээ. Чингээд шуугинан хуйлрах салхины хүч улам ч ширвүн болж, хад чулуунд салхины чимээ маш их болсоор, цас орох нь бас их болж нүдгүй шуурга тавилаа. Завинд бэлгийн бэлэн дулаан хувцасны дээр ойн эмсийн завсар чөлөөндөө зам гудас агнасан ангийн арьсаар хийсэн хувцас буйг цөмөөрөө хэдий өмссөн тул, эртлэн завдаж салхи цаснаас хорогдох газартаа зарим нь завь дор, зарим нь ханан хаданд түшүүлэн босгосон хорго дотроо орж, бургасны мөчир, , хөвд, ангийн арьс дэвссэн дэвсгэр дээрээ хэвтэцгээн тэр ширвүн цас шуурга өнгөрөхийг гэдэс цатгалан мөр удаан хүлээн хэвтэв. Залуудай, эцгийн дэргэд хэвтээд, гаднах салхи шуургын чимээ чагнан байтал, цас ихээр унаж, завь нь цасанд дарагдаад, зүүрмэглэн хэвттэл, чих дадсан салхи шуурганы шуугнах чимээн дундуур ямархан нэгэн хүүхэд эмэгтэй хүн хоёрын уйлах чимээ үе үе дуулдах шиг. Түүнийг нойр дундаа чагнан хэвтэж, нэг ойртосхийн, нэг холдосхийн дуулдаж байтал, зэргэлдээ ойн эмсийн хорогдон хэвтэж байгаа саравчлан барьсан хорго өмбөл дотроос эмэгтэйчүүдийн дуугаралцах чимээ гарах шиг. Бас хөлийн үзүүр тушаа ханан хаданд түшүүлэн налуулж хураасан бургас модны тэнд хүн гишгэн цас шажигнуулах чимээ дуулдахад нүд нээвээс, хааяа манасан зөвийн дор хав харанхуй тул хажуудаа байсан нум сумаа тэмтэртэл Шонхолой хүүгээ :

- Хэвтээд бай. Манай ойн эмсийн өмбөлд нэг хүүхэдтэй эм орж ирсэн болотой. Түлшээ ханан хаданд түшүүлсэн дор бас нэг хүн, салхи цаснаас хоргодон орлоо. Бодвол, тэр хүүхэдтэй эмийн нөхөр, садан нь юм байлгүй дээ. Бидэн дээр орж ирэхээсээ эмээн төвөгшөөсөн байж болно. Салхи шуурга тогтоход нүүр нүүрн харалцана даа. Хэвтэж бай хүв минь, санаа битгий зов гэхэд эцгийн тэр тайтгаруулсан үг сонсоод, дэргэд нь хэвтэж байхдаа юу юунаас ч аймгүй сайхан бодогдож, хэвтсээр бөх гэгцээр унтжээ. Хичнээн болтол унтсаныг мэдсэнгүй, нэг сэрхнээ, нойтон цас унах унах мэт чимээ гарч, гаднаас гэрэл орох мэт болсонд нүдээ нээвээс, цас арилган хаяаг нээсэн тул үдийн нарны гэрэл тусч, сэрвүн амьсгалт сэнгэнэх ажээ. Гадагш гарваас, нүд гялбам цагаан цас, уул шугуй, хөндий тал бүрхэж, их цасанд улиас, бургас бөхийн дарагдаж, зарим мод нойтон цас даахгүй хуга нуга дарагджээ. Ойн эмс, Шонхолой Залуудайн чимээ сонсоцгоож, нөгөө завийн ддороос Үхvv, Гекvv үл таних эмэгтэй жаал хүүхдээ дагуулан гарч ирсэн нь ширэлдэн даахирсан үстэй бөгөөд хувцас уранхай навтас болсон гурын арьс, царай эцэнгэр жигтэйхэн халтар, хүүхэд нь танихгүй эрцүүдийг үзээд эхийн хормойгоос барин нүүрээ халхлан зогсжээ. Чингээд ийш тийш нүд гялбан аньсхийн хараад эхээсээ,

- Аав маань хаана байна ? гэж асуутал ханан хаданд твшүүлсэн бөгөөд цасанд хучигдан дарагдсан бургас твлээн дороос нэг хврэн бор царайтай намхан хвн нар туссан цасны гэрэл туяанд онигор нүдээ гялбан анивчилж гарч ирээд, олон хвнээс баахан эмээсхийн байдалтай зогстол жаал хvvхэд, эцгийгээ vзээд, халтар нvvрт нь баярын шинж тодрон нүд нь гялалзав. Твлээний цаанаас гарч ирсэн тэр хвн , Шонхолойг ахмад нь юм байна гэж гадарлаад,

- Бид нүдгвй шуурганд сандрахдаа танай энд хоргодлоо. Та нарын энд бууж, шуурганаас өмнө отог буудлаа засахыг бургас модон дотроос харсан боловч зврхлэж ойртсонгвй.Цас шуурга ихдэхэд аргагвй, манай энэ хоёр танай эмэгтэйчvvдийн тэнд зврхлэн очиж хоргодлоо. Би та нар дээр орохыг зврхэлсэнгвй тул твлээн дор тань орж хонолоо. Манайхны бас хоёр нэгэн хвн энэ хавиар байх ёстой. Би тэднийг дуудвал, та нар уурлах вгвй болов уу ? гэхэд Шонхолой :

- Хаанаас бид уурлахав ? Дууд , дууд . Бvгдээрээ нийлж хоол унд хийе гэхэд нь тэр хвн баярлаж, бие эцэнгэр намхан атал дуу нь нь сврхий. Маш өндөр дуугаар хэд гууглан дуудтал алсаас хариу дуу дуулдаж, удалгвй гялалзам цастай хөндийд хоёр хвн айсах нь vзэгдлээ.

- Манайхан гэж тэр твлээн дороос гарсан намхан хвн баярлан өгvvлээд Шонхолойгоос та нар аль газрын хвн, хайшаа явж байна ? гэж зврх орж асуусанд Шонхолой :

- Бид хэдэн омгийн хвн нийлээд явж байна. Эндхийн хвн биш, алс холын улс. Би Чоносын Шонхолой, энэ миний хvv. Залуудай. Бусад нь замд нийлсэн манай нөхөд. Чиний нэр хэн бэ ? гэхэд тэр хвн вг аялгуу баахан өөр боловч, төлөв мэдэгдэх бөгөөд хариу өгvvлрvvн :

- Би хурдантуур гэдэг.Тэх ястан. Тэр айсаж яваа хвн бас манай Тэхнэр. Энэ миний хvv Инзага. Эх нь Улар гэдэг нэртэй. Бид хэдvvл зvдэрсэн ядарсан амьтан аа. Ах минь бодонд хадруулаадхоцорсноос хойш одоо огторгуйн сар хоёр vзэгдэж байна. Ахын эмийг хвн гөрөөс бидэнд халдаж булаан аваачаад, бид яаж ч чадсангвй. Бас манай Тэхийн нэг сайн хвн, сахчинд баригдаж вгвй болсоор гурав бас гурав нэг хоног болж байна Үлдсэн хэдэн өөдгвй бид амь зулбасаар энд хврч ирээд, бид гурав бас наашаа айсаж яваахоёр л манай Тэхээс байгаа хвн болно. Бусад Тэх хвн хаана явж байгааг мэдэхгвй.Бугын орооны цагт Тэх хвн цуглардаг ууланд махчин орж ирсэн тул, бид нийлэн цуглах газраа алдаад, талын нэг хоёроор тарчихлаа гэтэл нөгөө хоёр хвн хврч ирээд, Хурдантуурыг айван тайван байж байгаад зоригшиж, эцэж зvдсэн царайд нь баярын шинж тодорлоо. Залуудай тэдний ядуу зvдvv жцсэн зvдэрсэн байдал, бороохой галд vзvvрий нь твлж шорлосон жады нь vзээд өрөвдөн хавчаахай нум, хатуу чулуун сvxээ харахдаа тэдний дэргэд давагдашгвй зэр зэвсэгтэйгээ бахархлаа. Шинэ ирсэн хоёр хвн ч Шонхолой нарын дулаан хувцастай, чулуун глбэртэй жад, сврхий сvx бас вл таних бөгөөд хавирга мэт матигар сонин зэвсэгтэйг гайхан харж байв. Тэр завсар Үхvv, Гекvv хоёр хавтгай чулуугаар дарж, далдласан мах тдшээ гаргаж эмэгтэйчvvд твлээгээ авцран гал твлэхэд бэлдсэн Хурдантуур туслалцах гэж твлээний өмнө явган суугаад бvснээсээ нэг уутанд хийн

звссэн галын хоёр мод гаргаж хоёр алган хоорондоо эрчлэн эргүүлээд утаа уугуулан шvvтэй хөвд мэтийг хэрэглэж, гал асаасанд Шонхолой тvvнийг сонирхон харж Залуудай арай цахиур хавирахаас цдаан юм байна гэж Хурдантуурын дэргэд явган сууж харваас Хурдантуур чингэж сонирхуулсандаа баярлан:

- Манай Тэх хvн ингэж гал асаадаг гэж бахархан өгvvллээ. Тэр завсар Үхvv, Гекvv хоёр хөдлөсхийсэн махаа эвдэж бас хэдэн том тул гаргаж, чулуун хутгаар зорж хжлдvv зууш хийж, мах шарах галд халаасан хавтгай чулуунд хавчин болгохын хооронд өл валган идэх юм ойн эмсийн хамт бэлдэцгээн, дvржигнэтэл ассан галаа тойрон бvгдээрээ идэцгээхэд, өлсч ядарсан Тэх нарын идэх нь тун чих. Царайд нь өнгө орж, галын халуун нөлөөнд дулаацан бие сэтгэл амарсан байдалтай суув. Янзага хоолонд цадаад, галд дулаацаад, эхийнхээ өвөр дээр нэг их жаргасан царайтай. Эх нь хvvгээ тэврэн аман дотроо :

Бөн бөн туулай,
Бvжинхэн туулай
Хаагуур харайжээ
Яагуур всэрчээ
Бөн бөн бөмбөрчээ
Бөндгөр туулай
Болдог билээ чи
Бөн бөн туулай
Хадаар яваасуу
Харцага шvvрнэ л
Модоор яваасуу
Могой сорно л
Эргээр яваасуу
Элээ шvvрнэ л
Бөн бөн туулай
Бvжинхэн туулай
Хаагуур харайжээ
Яагуур всэрчээ
Бөн бөн бөмбөрчээ
Бөндгөр туулай
Болдог билээ чи
Бөн бөн туулай

гэж аяархан дуулахад нь Залуудай Булжуухай эмээгийнхээ өвөр дээр өрх гэрийнхээ галын хажууд эвтэйхэн таатайхан хэвтээд бvvвэйлэн аяархан дуулдгийг санаад , өрх гэр нь нvдэнд vзэгдэх шиг боллоо.

Тэх Хурдантуур нөхөдтэйгээ Чонос Шонхолойн өргөн цээж, өндөр суганд тvшинэ гэж нэгэн сэтгэлээр тогтож, Шонхолойтой хvн бvл нэмэгдэн аялж, Гекvv хурц хар нvдтэй, Бияа охинд чадлаа гаргаж нум сум хийж өгөөд, замын уртад харван сургасан нь

авьяас сэргэлэн охин , хэнээс ч дутуугүй харваач болоод, Шонхолойгоор удирдуулсан аяны эрчүүд цөм яваандаа нум сумтай болцгоож, ойн эмсийн ихэнх нь бас харван сурцгаан, хурдан зэвсэгт болсон учир ан амьтан агнах, араатнаас амь биеэ хаацайлахад санаа хвчин нийлсэн бөгөөд хашир сэцэн Шонхолойгоор ах зах болгосон аянчин хоол ундаар дутааж, гачигдалгүй хир баргийн дайсан эсэргүүцлийг нум сумын давуу чадлаар биедээ халган хавьтуулахгүй, аялан явсаар нутаг усандаа нилээд ойртлоо. Цаг ч улам улам сэргүүн болж, өдөр чулам богинослоо. Голын хоёр захаар мөс хацарлан хөлдөж, завиар явахад төвөгтэй болоод, бас хүн бүл нэмэгдсэн тул бүгдээрээ явган явах боллоо. Нэгэн өдөр Үхүү, Гекүү хоёр Хурдантууртай гурвуулаа гөрөөнөөс отог дээрээ буцаж ирэхдээ, бугын мах үүрэн хүрч ирсэн нь баахан санаа зовиуртай, Шонхолойд яаран мэдэгдсэн нь ,

- Буга харван , гурвуул нэгэн зүг сум тавьж, тураг анг унагасанд ойртон очиж, үзвээс дөрвөн сум оносон байлаа. Гурван сумаа таниад авахад, нэг сум огт танигдахгүй бөгөөд шархын цус нөжирсөн байдлыг үзвэл, өөр ямар нэгэн анчин тэр бугыг харваад, дутаалган алдсан байжээ. Шонхолой тэргүүтэй бүгдээрээ тэр үл таних анчны сумыг дамжуулан үзэж, бугын хавирган завсар туссан тэр сумны ором шархыг ажиг нягтлаж, энэ хавьд ер нум сумтай хүн баймааргүй юм сан. Ямар гэгчийн улс омог тийм зэвсэгтэй болж, энүүгээр үзэгддэг болов гэж Шонхолой зовнисхийн гайхав. Залуудайгаас бус хүн цөм Байкул одох буцах замд нийлсэн тул энэ газар явж үзээгүй анх удаа явж энэ тухай мэдэх зүйлгүй учир хавь ойр гарзар огт үзэгддэггүй нум сум чухам хэн хэрэглэх болов ? гэж Шонхолой баахан гайхлаа. Чингээд Үхүү, Гекүү , Хурдантуур гурваас хүний мөр бараа дайралдав уу ? гэж асууваас, ер тийм зүйл эс үзэгдэв хэмээн өчлөө. Ойн эмс, Тэх нар хоёр Хумкаа цөм Чонос Шонхолойг итгэн түшиж дадсан нь, хүүхэд эцэгдээ түшиж, дэргэд нь юунаас ч айхгүй айван тайван байдаг лугаа адил , Шонхолой ахын дэргэд байгаа цагт ямар ч нум сумтан үл таних отог омгоос айх зүйлгүй. Тэр байтугай бэрх юмнаас даван гарч байсан удаа гэж Үхүү, Гекүүд , Хурдантуур гурав Шонхолой ахдаа гайхан сэжиглэсэнээ хэлээд хойчийн холбогдол, ямар болох тухай санаа зоволтгүй болж, ойн эмсийн хамт нийлэн хоолоо хийж эхэллээ. Бияа нэг охинтой гөрөөнд явснаа бас нэг бор гөрөөс харван унагаж, хоёул дамнан хүрч ирээд, ажиг сэжиг бүхий юм огт дайралдсангүй. Аймаар араатны ул мөр ч үзэгдсэнгүй. баавгайн нэг хуучин мөр л дайралдсан гэж хэлж ирсэнд Шонхолой юу ч болсон нумтай анчин энэ хавьд хүрч ирээгүй юм бололтой гэж бодовч хоногийн газрыг сонгон өөрчлөн араас халдахгүй ханан хадны ёроолд, өврөөс халдахгүй тэгш газарт, хүн мөлхөн ойртож болох бут сөөгийг түлшиндээ түвлгэн зайлуулаад, ханан хадны нөмөрт хоног буудлаа эртхэн засуулж авлаа. Ханан хадны элгэн дэх нэг аятайхан тавцан дээр Хоёр хүн хэвтэх зайтай газар бургасны нарийн мөчир , өвс хагд дэвсүүлж, дээр нь ангийн арьс дэлгүүлж, шөнө даан , алсын зүг ажиг манах хоёр хүний хэвтэх хэвтэр засуулан, Гекүү Хурдантуур хоёроор бусдыг унтсаны сүүлээр ээлжлэн унтаж, манан хонохоор болгож, нум сумтай үл таних омогтны гэнэт халдахаас цагдуулахаар боллоо. Гал тойорн сууж, эмэгтэйчүүдийн хийж байгаа халуун бүлээн ундаанаас ууж суутал, Залуудай өрх гэрээ сахидаг анч нохойгоо санаад,

- Нохойноосоо нэгийг нь ч дагуулан бидэнд санаа амар , соргог манаа юмсанж ээ гэхэд нь Хурдантуур асууруун :

- Хээрийн нохой яаж хvний манаа болдог юм бэ ? гэж Тэх нар тэжээдэг нохойгvй тул гайхжээ. Нохойг хvн гал гроломт манах заяатай юм гэж урьдын улс хэлэлцдэг асан гэж Шонхолойн хариулахад, Үхvv сонирхож, шөнийн уртад ах та бидэнд тэр домгоо хэлж өгнө vv ? гэлээ. Шонхолой гал сэргээн засаад, арслан зааны сvvчний хонхороор хийсэн аягандаа халуун унд нэг балгаад, толгой дохин :

- За би та нарт, урьдын улсын хуучны домгийг хэлж өгсvv. Манай Чонос омгийн дээдсийн хэлэлцдэг нь :

- Дээр тэнгэр, нартын амьтан олныг бий болгоод хамгийн сvvлд хvнийг заяасан юм гэдээг. Эр эм хоёр хvнийг бvтээгээд бас нохойг эзэн чинь энэ хоёр болох юм . Гал голомты нь сахин манаж байх чамд вс хэрэгvй. Галын дэргэд дулаан бvлээн хэвтэх тул, чамайг нvцгэн болголоо. Энэ хоёр эзэн хvн чинь амь зуух, гөрөө хийх, жимс идээ тvvх гэж хонон өнжин явах тул хvйтнээс хамгаалж, сахлаг vстэй болголоо энэ хоёр эзний чинь. Би юм идээд ирсэн хойноо энэ хоёры чинь амилж өгнө. Эзэн чинь болох энэ хоёроо чи миний эзгvй хойгуур сахихын сайнаар сахиж, бузар буг булай юм битгий ойртуул гээд яваад өгчээ. Тэр завсар муу зvгийн бузар буг юм ирээд, нохойноос :

- Энэ хоёр чинь ямар амьтан болох гэж байгаа юм бэ ? би нэг сонирхон vзээд орхивол яана гэхэд нохой :

- Энэ хоёр бол миний эзэн болох заяатай хvн гээч дээ .Заяадаг тэнгэр нь идээ ундандаа яваад , намайг эзэн болох хvнээ сахин манаж , муу муухай бузар буг юм битгий ойртуул гэж захиад явсан билээ. Чи холдож зайл. Би зуудаг, урж тасддаг, шvдэрхэг, идэрхэг манаа шvv гэхэд нь тэр булай буг нохойноос :

- Өнөөх тэр сvрхий заяадаг тэнгэр чинь, өөрөө юм идэх уух гээд яваад өгөхдөө чамд идэх уух юм өгсөн vv ? хоосон нойтноор мандуулж байгаа хэрэг vv ? гэж асуухад нохой гэнэн тул :

- Үгvй, би амьтай болсоор амандаа юм амсаагvй, хэлэн дээрээ юм тавьж vзээгvй гэлээ. Өнөө булай буг инээж, гэнэн сэтгэлтэй нохойд идэх мах өгсөнд, нохой тэсгэлгvй баярлаад цадталаа иджээ. Тэгээд өнөө булай буг нохойг :

- Би тэр эзэн болох амьтны чинь нэг ажиж vзсvv гэхэд нохой намайг амьтай болгосон цагаас амсаагvй юмыг амсуулсан энvвнийг одоо яаж vгvй гэхэв, vзэх дуртай бол vзээд бай . Би тvр зайлаад өгсvv гэжээ. Тэр самбаанд нь өнөөх булай буг тэр амьлаагvй хоёр хvний биен дээр нь зад шээгээд, за би vзэн сонирхолоо гээд яваад өгчээ. Удалгvй өнөөх заяадаг тэнгэр хvрээд ирж, хоёр хvнийг амьлах гэтэл булай бугын vмхий , самхай, муухай шээсэнд нь бузартаж, их муухай vнэртэй болчижээ. Нохойг дуудаад , чи яагаад миний захьсан vг дагасангvй бузар булай бугт эзнээ бузарлуулав гэж загнахад , нохой :

- Амьтай болсон цагаас хойш одоо хvртэл та надад юм амсуулаагvй, хоосон нойтон байлгасан мөртөө өөрөө юм идэх уух гээд яваад өгсөн билээ. Тэгтэл тэр булай буг

гэдгийн тэнь ачаар би гэдэс гарч, идээгвйгээ идэж, цадаагвйгээ цадаж авлаа. Таньд л булай буг болохоос биш надад тэр тань ачтай сайхан амьтан байж л. Эзэн болох хвний чинь вээн сонирхсуу гэхэд нь вээхэд нь вгвй болох, хархад нь хасагдаж хоргодох юм биш гэж вэ дээ гэж вэввлсэн минь внээн гэж гэнэ. Тэнгэр хилэгнээд хутга гаргаж, булай бугын шээстэй всийг хусан арилгаж, тэр бузар болсон всий нь нохойд тохоод :

- Эзнээ булай бугт бузарлуулснаар чи одоо ввнээс хойш, тvvнээс цааш энэ бузар всий нь тохож, босгы нь алхах эрхгвй, хаяанд нь хэвтэж, халуунд халж, хвйтэнд даарч хэвтэх болно гэсэн юм гэж урьдын өвгөд өтгөс хэлдэг асан. Ийм л домогтой юм даа гэхэд нь бvгдээрээ сонирхон сонсоцгоолоо. Чингээд унтах цаг болсонд Шонхолой цаг орой боллоо. Унтах нь унтацгаа. Манаа хийх хвн манааныхаа газар очиж, ээлжлэн манацгаа. Бvгдээрээ унтах газартаа очигцоон хэвтлээ. Үврээр Хурдантуур тавцан дээрээсээ бууж, Шонхолойн дэргэд хврч ирэн, хоёх гурван газар чоно улих шиг болоод сайн ажиглавал, хвн юм уу гэмээр санагдлаа. Тэгж байтал хэдэн хвн айсах мэт болсон тул би Гекvвдээ захиад , өөрөө сэм бууж, нуун мөлхөж, тэдгээр айсан буй хвнийг ажваас нум сумтай хвн айсаж буй тул яаран тэдэнд мэдэгдэлгвй ирж, ахад мэдэгдэж байна гэхэд нь Шонхолой яаран босоод сусдаа сэрээн, вvрийн вvрэнхвйгээр цөм нум сум, жадаа барьцгаан вл таних нум сумтны гэнэт халдахаас сэргийлтэл, тэдгээр нумтан улс Шонхолой нарыг нум сумгвй гэж бодсон бололтой, вvслэх байдалтай ойртсонд Шонхолой тэдний өөдөөс өндөр дуугаар :

- Та нар юун улс вэ ? гэж хашгирваас, Шонхолой гэж нэг өтгөн дуутай чийрэг нумчин бархиран баярлаж, яаран урагш давшваас Залуудай баярлан Мазаалай ах байна гэж аавдаа хэлээд , өөдөөс нь би Залуудай байна гээд ухасхийхэд Мазаалай тэсгэлгвй баярлан өөдөөс нь гвйв. Вvслэн айсаж байсан хvmvvc Шонхолой, Залуудай, Мазаалайн дуу сонсоод баярлан хашгиралдаж, тэмцэлдэн гвйж ирээд, тэврэлдэн санамсаргвй халууныхаа хvнтэй уулзсандаа Чоносууд маш хөгжилдөж, бvгдээрээ бөөн баяр хөөр боллоо. Мазаалай тэргvвтэй Чоносын нэгэн анчин өчигдөр вvрээр нэг буга харваад, халуун мөрөөр нь хөөж явтлаа тэр бугы нь хэдэн хвн вvрч явсан мөртэй дайралдаж , бvгдээрээ тэр мөрөөр хөөн, шөнө орой ханан надны ёроолд гал тvвдгий нь хараад, манай буга авсан хvmvvc тэнд хонож байнам гэж вvрээр ойртон хврч, вvслэн тойроод, дайсан аваас тулна гэж явсан учраа хэллээ. Чингээд Чонос отгийн анчин цөм намрын анд гарснаа ярьцгаатал, анч нохойгоо вл мэдэгдэх хvmvvcст хуцан чимээ өгч мэдэгдэхээс болгоомжлон хөтөлсөн хвн ч хврэлцэн ирж, бvгд нийлэн анчны отог дээр хврэлцэн, намрын ан хийж, өвөлжөө өрхөндөө хам буцацгаахаар тогтлоо. Нутаг усандаа хврч ирээд халуун төрлийнхөө хvнтэй учран золгосон Залуудай, тэсгэлгвй баярлавч, алс хол Байкул их нуур, далайн хөвөөнд влдсэн нарийхан чилгэр, гоо сайхан биетэй, хврэн улаан царайтай, хонгор сайхан Баргужингоо охин сэтгэлд нь орж, усны урт, замын холыг хожим туулж учрах цагийг бодон явахдаа анх нутгаасаа гарсан гэнэн хонгор жаал байснаа, алсын хол аян замд, араатан болон аюулт дайсантай учралцан тулалдаж, бэрхийг даван, хал вээж, хашир таниснаараа эрийн цээнд хврч бие чиг чангарч, зориг ч хатан болж, магина тvвдэг жаалхvv байснаа махчин араатантай тулдаг анчин залуу боллоо гэж санахад нь

сонихон бөгөөд цэцэн мэргэн царайтай, эцгийнхээ чийрэг биеийг бахархан харж, унасан газар угаасан ус ойртох тусам өргөн голын дэнж дээрхи өрх гэртээ бушуухан хүрэх асан гэж сэтгэл нэн яаравч, нөхдөө хаяад гүйж болохгүй, бас ахмад хүний айван тайван алхаж явахад, бушуул гэж шаардан шавдаж болохгүй, эцэгтэйгээ зэрэгцэн дугай явлаа.

Хэмээсэн үүнийг 1965 оны намар төгсгөн бичлээ.

Заан Залуудай энэ хоёрдугаар хэсгийг жаран таван оны долоон сард Хануулын Их тэнгэрийн амнаа эхлээд, Чехословак улсын Карловы Вары гэдэг рашааны газар бие сувилуулах зуур үргэлжлэн бичсээр, Баян -өлгийн аймгийн төвийн зочид буудалд есөн сарын хорин дөрвөнд гүйцээн бичлээ. Маркс, Энгельсийн шинжлэлд хүн төрөлхтний эл нэн дээр эртний үеийг тун сайхан үгээр бадруулан дурдсан зүйлийг санан санан бодож, манай уншигч нарт, манай дээд өвгөс эцгэс, чулуун зэвсгийн үеэс үүсгэж, ямар шүү байсныг дүрслэн үзүүлбээс, сонин юмсанж гэж цуврал романыхаа эхний эл эрт балрын чулуун зэвсгийн үеэс үүсгэж, үүрийн туяа гэдэг адагт нь хүртлэх хоорондохыг амжвал гүйцээх санаа бий. Дээр эртний чулуун зэмсгийн үеийн тухай дэлхийн уран зохиолд роман тууж болгож бичсэн зүйл нэг их олон үгүй, Францын уран зохиолч Их рони Жосеф гэдэг хүн «Галын тэмцэл», «Агуйн арслан», гэдэг хоёр тууж зохион бичсэн нь орос хэлнээ орчуулан гарсныг зөвлөлтийн дундад сургуульд суралцаж байх үеэс амтархан уншиж, Америкийн зохиолч Лондон Джегийн зохиолд ыас «Адамаас өмнөх» гэж чулуун зэвсгийн үеийн тухай бичсэн нэгэн зүйлийг хорин найман онд монгол болгох гэж оролдож байгаад гүйцээж чадаагүй, хожим гүйцээх зав ч олдолгүй өнгөрсөн билээ. Чингээд «Шинэ толь» гэдэг сэтгүүл үүсгэн гаргах үеэс монгол уншигч нартаа сонирхуулах асан гэж Английн нэрт зохиолч Үэлс Хэр эртийн «Угломи, Уяа хоёр», гэдэг балар эртний туужаас орчуулан нийтэлж байснаа гүйцээн гаргаж чадсангүй билээ. миний олж сонирхон үзсэн балар эртний чулуун зэвсгийн үеийн тухай зохиолын зүйл бараг энэ хэдийн төдий бөгөөд, Их Ронийн «Галын тэмцэл», «Агуйн арслан» зэргийг үзэхэд хэдийгээр үйлс явдлыг чадамгай зохиолч нар бичсэн тул уншигч хүнд маш сонин мэт санагдавч, ганц сонирхолыг голлоод цааш нь эрт балрын хүний аж байдал, соёл боловсрол, зан заншил, үзэл мэдэц, ертөнцийг үзэх үзлийн хүрээ, хэмжээ зэргийн байдлыг үзүүлэх гэж зорьсонгүй нь тэдгээр зохиолч нарын үед эртний судлал, угсаатны судлал, ардын билигзүй зэргийн судлал буюу хүн төрөлхтний олон аймаг угсаатны соёл боловсрол, зан заншил, зан үйл, аман зохиол, жич эртний булш, агуй мэтээс эртний хүний үлдээсэн эдийн боловсролын түүхт зүйл, Ази, Африк, Европ, Америк, Австралийн эрт өдгөөгийн олон угсаатан ястны соёл түүхийн зэрэг зэрэг зүйлийг нарийвчлан судалсан зүйл хараахан бүрдээгүй буюу байсны нь тэр бүр нягтлан судлах зав бололцоо ч гараагүй, эсхүл нэгийн зэрэг тууж бичихэд авдар шүүгээгээр ном уудлан судлах, эрэн сурвалжлах, зав зай чбайхгүй зэргийн учраас гагцхүү уншигчийн сонирхол татахямар нэгэн явдал, зодоо, нүдээ, дайсагнах аймаг болон араатан, эмс охид булаалдсан элдэв сонин адал явдлын төдийхнийг сэдэвчлэн бичжээ. Үүнд гагцхүү Зөвлөлтийн Леонтьев гэдэг нэгэн зохиолч «Чулуун номын хуудас» гэдэг мөнхүү эрт балрын хүний аж амьдралыг харуулсан тууж, Онег нуурын хавийн эртний хүний дурсгал, хад чулууны бичиг зэогийг эртний судлал,

угсаатны судлалын зүйлтэй нийцүүлэн бодож зохион бичсэн нь надад, миний урьд өмнө сонирхон үзсэн зохиолоос илүүц нударгатай санагджээ. Манай залуу орчуулагч нар, тэр Леонтьевын « чулуун номын хуудас » гэдгийг монгол үгээр орчуулж монгол уншигч олондоо сонирхуулбал бас л сайхан юмсанж. Чингэвэл, чулуун зэвсгийн үеийн хvн гэхэд газар газар, угсаа хэл өөр учир, тус тус өвөрмөц сонин байсан юм байна гэдгийг мэдэж авахад хэрэгтэй юм санж. «Заан Залуудай» тэргvн хэсгийг хар бар жилийн намар бичиж дуусгаад, дараачийн харагчин туулай жил (1963 он) хэвлэлд шилжих үеэс хаврын тэргvн сард оршил бичиж өгөөд, 1964 оны хөх луу жилийн намар Зөвлөлт Украинын Трускавец гэдэг аршаан хотноо бие сувилуулах үеэс , санамсаргvй Леонтьевын « Чулуун номын хуудас»гэдэг зохиолыг олж, номын мухлагаас сонирхон аваад, тэр туужийг дөчөөд жил боловсруулан бичсэн зохиолчийн арга барил минийхтэй төстэй болсонд нэн сонирхсоо билээ. Ингэхэд миний бие « Заан Залуудай», манай өвгөд дээдсийг үзvvлэх гэж оролдсон тул орон газар цаг үе, хэл байдал vндэс гарал өөр болсон бөгөөд нийлэх нь гэвэл чулуун зэвсгийн тухай орчин үеийн шинжилгээний зохиол үзсэний хувьд миний бие ч тэр, «Чулуун номын хуудас»гэгчийн зохиолч ч гэсэн тор холбогдох зvйлээ олдсоны хирээр үзсэн бололтой.Эртний чулуун зэвсэг гэдэг эртний чулуун зэвсэг буюу эртний чулууны үе, дундад чулууны үе, шинэ чулууны үе хэмээн ялган үзэх зvйл бий бөгөөд, нарийвчлан задруулбаас дотор нь бас ялгах үе шат байдаг байнам. Энэ тухай би орос, чех, словак, герман, франц, англи, польш хэлээр чулуун зэвсгийн тухай судалсан зvйл, эртний чулуун зэвсгийн хvний суурин, булш, дархны газар зэргийн тухай шинжилсэн зvйл үзэж, Зөвлөлт улс, Мажар улс, Чехословак улс, Энэтхэг улс, Дундад улсын музейн цуглуулгын зvйлийг сонирхон үзэхдээ, «Заан Залуудай» гэдэг зохиол бичнэ гэж төслөн бодоогvй боловч монгол хэлний шинжлэл аман зохиол,угсаатны судлал, ардын билигзvйн судлалд хэрэгтэй бөгөөд, олон улсын эртний хvний соёл боловсрол зэргийн байдлыг танин мэдэх нь монгол хэлний зvй, монгол vгийн гарал, монгол vгийн язгуур, vндэс, дагавар зэргийн утга учрыг судлан таньж мэдэхэд, сэтгэхvйлvгээ холбоотой хэлний vгийн гарал vүслийг тэр бvх зvйлийн мэдлэгийн зvйлгvйгээр шинжин онож болохгvй тул, монгол хэл, vг, сэтгэхvйн зvйлд гардаг зvйлийг бусад хэлтэн, өөр ёстон, өөр соёлтон улс аймгийн хэл соёлд байгаа зvйлтэй харшуулан үзэхэд ямар байна гэж танин мэдэхvйн хэрэгцээгээр үзсээр монгол хэл заншил, , ёс горимд орчин тойрны ертөнцийг үзэх vзлийн эртний баримтын зvйлд тусдаг үзэгдэл нь монгол хэл бичигт буюу аман уламжлалд тайлбар нь олдохгvй аваас, бусад улсын гэрч баримтаас тайлбар нь гарах буюу бусад улсын бичиг судар , булш , хад чулууны бичиг олдоцоос гарсан зvйлийн учир утга нь эс мэдэгдэх ину, даруй монгол хэлзаншлаас тайлбар нь гарах жишээтэй зvйл үзэгдэх нь учиртай бөгөөд их л сонин сургамжтай санагдсаар монгол хэл зvй , угсаатны судлал, ардын билигзvй судласаар ирсний улмаас « Заан Залуудай» гэдгийг бичих санаа төрсөн билээ. Тэгээд монгол хэл зvй, монгол хэлээ шинжлэх ухааны vүднээс судлан таних гэж, хэл судлахад холбогдолтой утга соёл , эдийн боловсролын тvvхтэй холбогдох шинжлэл судлалыг үзсээр голлон зорьсон хэлнийхээ, шинжлэлд хэрэглэх гэсэн тэр бvх материал минь «заан Залуудайг » бичихэд гол зvйл нь болж өгсөн билээ. Эртний хvний сэтгэхvй, орчин тойрныхоо юмыг ,байгалийн тvmэн үзэгдлийг хэрхэн үзэж юу гэж тайлбарлаж байсан зэргийг хvн төрөлхтний хамгийн эрт балрын шашин болох бөөгийн шашны ёс заншил, шvтлэг тахилга зэргийн зvйл нь надад их

сонин олон юмны твлхввр нь болж, ардын аман зохиол, билигзвй зэргийн олон баримт байдлын учры нь тодорхой болгож, аман зохиол угсаатны судлал, ардын билигзвй, хэлний шинжлэл зэргийг тусгайлан хэлний тухай тvvн дотроо монгол хэлийг гол болгон , монголтой төрөл төс түрэг хэлтэн, хамниган хэлтэн жич, эл, монгол, түрэг, хамниган гурван хэл буюу алтай овог хэл гэдгийнхний хэл угсаатны судлал, ардын билигзвйг, уралын овог хэлтэн гэдэг мажар, фин, эсти, болон слав, герман угсаатны мөн эл звйлтэй хэлзвн шинжлэлийн вvднээс голлож судалснаараа жич монголын аман зохиол, туульс, бөөгийн дуудлага, зан вйл тэргvвтнийг 1927 оноос «Заан Залуудайг » бичиж эхэлсэн 1962 он хvртэл оролдсоор монголын хэл соёлын тухай судалгаа хийж, цуглуулсан хэрэглэгдэхvн минь «Заан Залуудай » гэдэг балар эртний тvvхэн романыг бичихэд нэн их тус болсон билээ. Заан Залуудай гэх нэртэй хvн байгаагvй байж болно. Гэвчдээр эрт цагт монголчууд бидний өтгөс дээдэс байсан нь аргагvй внэн болно. Хэл нь эл Заан Залуудай гэдэг романд гардагаас өөр байж болноо, байхаар барахгvй, шал өмнөө хэл байсан ч байж болно. Наад захы нь хэлэхэд , аргын улиралын он тоолдог ёсноос цаана эхлэн нэр гарсан хvн улсын хэлнээс их хол өмнөх вейн хэл болох тул одооны уншигч хvнд тэр вейн хэил байтугай жинхэнэ нууц товчооны вг дундад эртний монголын хэл аялгуу хvртэл сайн ойлгогдохгvй нокод калавуд кожи, улас тутам конши уд, хюнжи влэс, тутум хюнши, вд хюнистэлэ табиба.

Тийм учраас , хааяа ганц нэг вг, төв хавийн аялгуунаас баахан өөр боловч хvн утгы нь мэдэхээр байдалтайгаар :

Ураг элгэний ураг гэдгийг баруун манай ойрад монгол аялгуугаар, Увс, Ховд, БАян - өлгийн монголчуудын элкэн гэж дууддаг байдлаар хэрэглэв. Эртний хvний ертөнцийг взэх нь бөөгийн ёс заншил гэдэг хvн төрөлхтний хамгийн эртний шvтлэгийн байдлаас илэрхий болно. Иймд тэр тухайн явдалтай холбогдолтой зvйлийг зохиомол юм гэж огт вээж болохгvй. Тэр чбайтугай, одооны вeэс дөчөөд жилийн тэртээхийн ёс заншил эртний уламжлалын байдлыг мэдэх хvн уран зохиолдоо ямар нэгэн хvн дөчин жилийн өмнө юм уу, тvvнээс ч цааш шарын шажин эхлэн дэлгэрч байсан вeд, вvдэн шvд уначихлаа гэж зvvдлээд, муу ёрын зvvд, төрөл садны хvнд вхэл зовлон учрана гэсэн ёр байна гээд лам багшид айлтгаж, муу зvvдний хариулага хийлгэлээ гэвэл, тийм юмыг худлаа. Зохиолч худлаа зохиосон . Монгол хvн шvд уналаа гэж зvvдлэхдээ дөчин жил буюу дөрвөн зуун жилийн өмнө муу ёр гэдэггvй байсан гэж хэлэх хvн байх уу? Гэр дээр нь шар шувуу шөнө дуугарлаа гэж зохиолынхоо нэг хvнийг (ардын хувьсгалын өмнө, гамингийн вeдгамингийн везд байсан хvн гэж бодьё л доо) их л айж сандарч, лам багшаас аврал эрлээ гэж нэгэн өгvvллэгэнд бичвэл, тэр өгvvллэгэнд гарсан хvн, внэндээ байхгvй байж болно. Тэр зохиолд шvд минь уналаа гэж зvvдэлсэн хvн внэндээ байхгvй байж болно л доо.Тэгэвч тийм зvvдийг тухайн вeд муу ёр гэж вздэг ёс, шар шувуу гэр дээгvвр нь шөнө нисэн дуугарвал муухай гэгчийн ёр гэж сандран вздэг ертөнцийн взэх ёс тухайн вeд байж уу гэвэл, аргагvй внэн болно. Ийм учраас Заан Залуудай гэдэг романыг бичихдээ миний бие эрт балар манай дээр цагийн манай өвгөд дээдэс, тухайн тийм байдалд , тэгдэг бас заншилтай байсан, ертөнцийг взэх взэл нь тvvнээс вндэслэн, орчин тойрны байгаль ертөнцийн тvmэн взэгдлийг чингэж ухаарч, хариуд нь чингэж байдаг асан гэдгийг взvvлэн эрт дээр цагийн хvний дуо байдал, зовлон жаргал, баяр гаслан зэргий нь харуулж взсvв гэхдээ, олон зvйлийн судлалын юмнаас вндэслэхийж сэтгэн

бодсоноо бичсэн билээ. Шүлгийн зүйлийг гиншин дуудах байдалд ардын аман бичгийн хэл, тууль, дууны байдлаас авч хэрэглэсэн нэгэн зүйл гэвэл эгшигээр төгссөн үгийн сүлд эгшгээр эхэлсэн үг залгалдахад, хоёр эгшиг тааралдах нь аялан дэждэх зэргийн зүйлд эвгүй байдаг нь хүн төрөлхтний хэл бүхэнд байдаг үзэгдэл бөгөөд, монгол хэлэнд ийм зүйл гарахад дэлхийн бусад олон хэлтний нэгэн адил, тийн хvv үг төгсгөлийн эгшиг дараачийн үгийн эхний эхний эгшиг хоёрын хооронд жийргийн гийгvvлэгч оруулан аргалдаг ёс байна. Монгол хэлнээ ийм зүйлд гийгvvлэгч, уг чанар байдлаараа жийрэг болох явдалд тун тохиромжтой санагддаг учраас ялангуяа хэмлэлт шүлэг мэтийн аман зохиолд, дуудан эгшиглэхдээ «н» гийгvvлэгчийн эгшгээр төгссөн үгийн хойно залгалдан орох бөгөөд эгшгээр эхэлсэн үгийн эхэнд нь залган дууддаг байна. Тэр монгол зөв дуудахуйн ёсыг би энэ «Заан Залуудай» хоёрдугаар хэсгийн шүлэгт хэрэглэлээ. Эхтэй нөөхөн гэх мэт Ардын дуунд : алдаа нүгвй, мэдээ нүгвй гэх мэт «нүгвй» гэдгийн эхэнд «н» ордог жишээтэй ёс, олон улсын шинжлэлийн бичигт байдаг тул, тэр ёсыг дагуулан, жижиг үсгээр хоёр үгийн хойтохи үгний эхэнд тавилаа. Бас нэгэн зүйлийг дурдахыг хvсэх нь :

Чулуун зэвсэг хэрэглэж байсан үеийг нягталж үзвээс, газар газар адилгүй, хөгжилтэй байсан нь, нэг газар эртний чулуун зэвсэгтэй байхад, нөгөө нэг газар нь дундад чулууны үед хүрч байсан буюу нэг газар чулуу мод хавирч галтай байх үед нэг газар, тэр аргыг мэдэхгүй, галаа манаж аргалан, манасан галаа унтраавал, гал алдах зэргийн адилгүй боловсролтой байсан тул, тэдгээр байдлыг бас тусган үзvvлэх гэж, нэг газар хавчаахай нумтай болоод байхад, нэг газар бороохойгоос цааш ахиж чадаагүй мэт байдлыг үзvvлэх гэж оролдлоо. Тэр эртний үе байтугай, одоо ч нэг хэсэг улс, атом задлан хэрэглэж байхад, нэг хэсэг газар хавчаахай нум, хулхавч нумтай хэвээр одоо ч гэсэн байгаа шvv дээ. Зарим хvмvvс, Заан залуудайн эхний хэсэгт бэрх явдалтохиолдоод байтал% сvvлийн хэсэгт амар тайван найрлаж, барьж байгаа явдал гардаг нь балар эртний цагт байж боломгүй мэтээр бодогчид буй. Хаврын тарчиг цагаараа адгуус хүртэл эцэж турдаг, зовж үдэрдэг байтлаа, намрын тэнvvн цагт гэдэс гарч, тосон таргатай болж, цатгалан тайван цаг үе байдаг атал, дээр цагийн чулуун зэвсэгийн хүн, ан адгууснаас дор, хавар чvхэж, намар ч хахаж байсан гэж үзэх баримт үгүй. Тэр чбайтугай, эрт балар чулуун зэвсгийн хүний үлдээсэн зураг дүрс, баримал мэтийг үзэхэд, найрлан цэнгэж, бүжин наадаж байсан байдлыг дүрс зураг, хөрөг баримал манай үед уламжлан ирсэн зэргийн зүйл буйг товч дурдвас зохих байнам. Энэ мэтийн зүйлийг өи хир чадлаараа тусгахыг мэдцийнхээ хирээр, одоо байгаа чадлынхаа хэмжээгээр оролдсоныг дурьдаад, оносон зүйл буй аваас төдий л буй заа. Алдсан зүйл байвал гvн мэдлэгтэн заан засаж, уучлан үзмvv хэмээн буурай зохиогч би тэнь өчнөм.

Билгийн улирлын хөхөгчин могой жилийн өвлийн эхэн сар.

Улаанбаатар хот.

Эх сурвалж:
Формат, фонт зэргийг бага зэрэг янзалж pdf
хэлбэр уруу хөрвүүлсэн:

www.elibrary.mn
The Weatherman
<http://weatherman.blog.baniig.net/>